



**ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА  
ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИЙН АВЛИГЫН ЭСРЭГ СҮЛЖЭЭ**

## **Авлигын эсрэг шинэчлэл**

## **Монгол улс**

## **Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг дэх болон хоёр дахь үнэлгээ**

Энэхүү тайланг 2015 оны 10-р сарын 9-ний өдөр Парис хотноо болсон Зүүн Европ, Төв  
Азийн Авлигын эсрэг сүлжээний уулзалтаар батлав

### **Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тухай**

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нь форум бөгөөд уг форумаар дамжуулан улс орнууд өөрсдийн бодлогыг харьцуулж, санал солилцож, шинээр гарч ирж буй сорилуудын талаар сайн туршлагауудыг олж тогтоон, амьдралын түвшинг дээшлүүлэх бодлого боловсруулах шийдвэр, зөвлөмжийг дэмждэг билээ. Тус байгууллагын үндсэн зорилго нь дэлхий дахины хүмүүсийн эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх бодлогыг дэмжиж, сурталчлах явдал юм. Тус байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосноос авна уу: [www.oecd.org](http://www.oecd.org).

### **Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний тухай**

Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ нь 1998 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд тус байгууллагын үндсэн зорилт нь гишүүн улс орнуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааг дэмжих явдал юм. Уг байгууллага нь бүс нутгийн хэмжээний хэлэлцүүлэг, семинар, харилцан суралцах хөтөлбөрүүд болон сэдэвчилсэн төслүүд зохион байгуулдаг бөгөөд эдгээрээр дамжуулан авлигатай тэмцэх үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл, туршлага солилцох болон хандивын үйл ажиллагааг явуулдаг. Түүнчлэн Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ нь Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэгч байгууллага юм. Тус байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосноос авна уу: [www.oecd.org/corruption/acn/](http://www.oecd.org/corruption/acn/).

### **Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай**

Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний хүрээнд 2003 оноос хэрэгжиж эхэлсэн бүс нутгийн хяналт, үнэлгээний хөтөлбөр юм. Тус хөтөлбөр нь Армен, Азербайжан, Гүрж, Киргизстан, Казахстан, Монгол, Тажикистан, Украин, Узбекистан улсуудын авлигын эсрэг шинэчлэлийг дэмждэг бөгөөд үүний хүрээнд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон бусад олон улсын стандарт, сайн туршлагыг оролцогч улс орнууд өөрийн оронд хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянан шалгадаг билээ. Тус байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосноос авна уу: [www.oecd.org/corruption/acn/istanbulactionplan/](http://www.oecd.org/corruption/acn/istanbulactionplan/).

Энэхүү тайланг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын ерөнхий нарийн бичиг гаргаж байгаа бөгөөд уг тайланд тусгагдсан аливаа үзэл санаа, тайлбар дүгнэлт нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн улс, орнуудын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Энэхүү баримт бичиг болон үүнд тусгагдсан газрын зураг нь аливаа улс орны хил хязгаар болон түүний бүрэн эрхт байдал, олон улсын хил хязгаар, аливаа газар нутаг, хотын нэртэй холбоотой аливаа эрхийг хөндөөгүй болно.

© Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага 2015 он

## АГУУЛГА

<b>ТОВЧ ДҮГНЭЛТ .....</b>	<b>4</b>
Авлигын эсрэг бодлого .....	5
Авлигыг гэмт хэрэгт тооцох.....	6
Авлигаас урьдчилан сэргийлэх .....	7
<b>МОНГОЛ УЛСЫН ХЯНАЛТ.....</b>	<b>10</b>
<b>УЛС ОРНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>12</b>
Нийгэм-эдийн засгийн байдал .....	12
Улс төрийн тогтолцоо .....	12
Авлигын хандлага .....	13
<b>ТОВЧЛОЛ.....</b>	<b>19</b>
<b>1. АВЛИГЫН ЭСРЭГ БОДЛОГО .....</b>	<b>20</b>
1.1.-1.2. Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг бодлогын баримт бичгүүд .....	20
1.3. Авлигын талаарх судалгаа.....	25
1.4.-1.5. Авлигын эсрэг олон нийтийн оролцоо, соён гэгээрүүлэх ба олон нийтийн боловсрол.....	28
1.6. Авлигын эсрэг тусгай бодлого болон уялдуулан зохицуулах байгууллагууд ..	31
<b>2. АВЛИГЫГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ НЬ .....</b>	<b>37</b>
2.1-2.2 Зөрчил болон зөрчлийн бүрэлдэхүүн.....	37
2.3. Албан тушаалтны тодорхойлолт .....	51
2.4. - 2.5. Ял шийтгэл болон хөрөнгө албадан хураах .....	54
2.6. Халдашгүй дархан байх эрх болон хөөн хэлэлцэх хугацаа .....	60
2.7. Олон улсын хамтын ажиллагаа болон эрх зүйн харилцан туслалцаа .....	67
2.8. Хуулийн хэрэглээ, тайлбар, журам .....	72
2.9. Авлигын эсрэг мэргэшсэн хууль сахиулагч байгууллага .....	75
<b>3. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ .....</b>	<b>78</b>
3.2. Төрийн албаны шударга байдал .....	78
3.3. Ил тод байдлыг хөхиулэн дэмжих ба төрийн албаны үзэмжээр хандах явдлыг бууруулах.....	90
3.4. Төрийн санхүүгийн хяналт ба аудит .....	93
3.5. Төрийн худалдан авалт .....	98
3.6 Мэдээллийн хүртээмж .....	108
3.7. Улс төрийн авлига.....	115
3.8. Шүүх байгууллагын шударга зарчим .....	124
3.9. Хувийн хэвшил .....	130
<b>ДҮГНЭЛТ ХҮСНЭГТ .....</b>	<b>135</b>

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Трансперенси Интернешнл байгууллагаас гаргасан 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, Монгол Улсын үзүүлэлт.....	14
Хүснэгт 2. Сүүлийн гурван жилийн Монгол Улсын авлигын байдал өөрчлөгдсөн эсэх талаарх ойлголт.....	14
Хүснэгт 3. Ирэх гурван жилд Монгол Улсын авлигын байдал өөрчлөгдсөн эсэх талаарх ойлголт.....	14
Хүснэгт 4. Монгол Улс дахь авлига, байгууллагаар, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр.....	15
Хүснэгт 5. Монгол Улс дахь хамгийн их авлигатай таван байгууллага.....	15
Хүснэгт 6. Авлигын туршлага, салбараар, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр ...	16
Хүснэгт 7. Авлигын шалтгаан, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр .....	16
Хүснэгт 8. Авлигын шалтгаан, Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа.....	16
Хүснэгт 9. Авлигатай тэмцэх үйл ажиллагааны иргэний оролцоо, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр .....	17
Хүснэгт 10. Авлигын туршлага, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр .....	17
Хүснэгт 11. Авлигын талаар мэдэгдэх, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр.....	17
Хүснэгт 12. Авлигын талаар мэдэгдэх, олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа ....	17
Хүснэгт 13. Засаглал, Монгол улсад бизнес хийх орчны талаарх олон улсын үнэлгээ.....	18
Хүснэгт 14. Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу авлига болон авлигатай холбоотой гэмт хэргүүдэд оногдуулах ял.....	55
Хүснэгт 15. Авлигатай холбоотой гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа.....	64
Хүснэгт 16. Монгол улсын хөрөнгө, орлогын мэдүүлгийн гаргалт.....	86
Хүснэгт 17. Худалдан авалттай холбоотой гомдол шийдвэрлэсэн тоон мэдээлэл .....	103

## ДҮРСЛЭЛ

Дүрслэл 1. Трансперенси Интернешнл байгууллагын авлигын индексийн Монгол Улсын үнэлгээ.....	13
Дүрслэл 2. Байгууллагад итгэх олон нийтийн итгэл.....	34
Дүрслэл 3. АТГ-т итгэх итгэл.....	35
Дүрслэл 4. Судалгаа: “АТГ шударга хуулийн хяналтын байгууллага гэдэгт та итгэлтэй байна уу?” .....	35
Дүрслэл 5. Худалдан авалтын электрон системийн ашиглалт .....	105

## ТОВЧ ДҮГНЭЛТ

Монгол Улс нь хурдацтай хувьсан хөгжиж буй залуу ардчилал билээ. Монгол Улс өөрийн ашигт малтмалын их нөөцийг ашиглаж эхэлсэн нь тус улсад засаглал болон авлигатай холбоотой асуудлуудыг ихээхэн дордуулсан. Монгол Улс нь авлигатай тэмцэх үй ажиллагаа зэрэг олон чухал шинэчлэлүүдийг эхлүүлсэн боловч эдгээр шинэчлэлүүд тогтвортой үр дүн хараахан авчраагүй байна. Монгол Улсын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг дэх болон хоёр дахь үнэлгээнд тус улсын авлигын эсрэг хөгжил, явцыг үнэлж цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

### Авлигын эсрэг бодлого

Монгол Улсын авлигын эсрэг сүүлчийн стратеги, хөтөлбөр нь 2010 онд дуусгавар болсон бөгөөд үүнээс хойш авлигын эсрэг шинэ бодлого батлаагүй байна. Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг бодлогын төсөл бэлдэж, тус төслийг Засгийн газар Улсын их хуралд ("УИХ") 2015 оны хавар өргөн барьсан. УИХ уг авлигын эсрэг бодлогын төслийг бичгийн агуулгаас нь бус, Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхийг нэмэгдүүлсэн гэх шалтгаанаар буцаасан. Энэ нь харамсалтай явдал бөгөөд шинээр боловсруулсан стратеги болон түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг дэмжиж байна. Монгол Улсад авлигын эсрэг үйл ажиллагааг явуулах дээд байгууллагын түвшинд хамтын ажиллагаа байхгүй бөгөөд авлигын эсрэг стратеги, хөтөлбөрийн төсөлд үүнийг тусгаагүй байна.

Монгол Улс авлигатай холбоотой олон асуулга, судалгааг тогтмол явуулдаг. Тэдгээрийн олонхийг засгийн газар эсхүл түүний даалгасан байгууллага авч хэрэгжүүлдэг. Энэ нь их сайшаалтай туршлага юм. Гэвч асуулга, судалгаанаас олж авсан мэдээлэл нь авлигын эсрэг бодлогод аливаа авлигын эсрэг арга хэмжээ болж тусгалаа олдоггүй. Авлигын эсрэг асуулга, судалгааг явуулах нь зорилго биш, харин тухайн асуулга судалгааг Монгол Улс дахь авлигын нөхцөл байдалд нийцсэн авлигын эсрэг бодлогыг хөгжүүлж, хэрэгжүүлэхэд ашиглах арга хэрэгсэл болгож ашиглах нь зүйтэй гэж үзэж байна.

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улс дахь авлигатай тэмцэх цорын ганц байгууллага хэвээр байна. Тус байгууллага нь авлигатай тэмцэх, авлигын талаар судлах, авлигын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, боловсролыг дээшлүүлэх, авлигын зөрчлийг судлах, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах зэрэг ихээхэн өргөн хүрээний чиг үүрэгтэй ажиллаж байна. Энэхүү чиг үүрэг нь одоогийн Авлигатай тэмцэх газарт өргөдсөн гэж үзэж байна. Авлигатай тэмцэх газар өөрийн хүч нөөцийг зөвхөн дээд түвшний авлигыг судлахад анхааруулах эсхүл тус газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Харамсалтай нь Авлигатай тэмцэх газрын хүчин чадал, хараат бус байдлыг сайжруулах тал дээр ямарваа арга хэмжээ аваагүй, өөрөөр хэлбэл тус газрын салбарыг орон нутгуудад байгуулаагүй. Авлигатай тэмцэх газрын нөөц, хүчин чадал нь тус газрын олон чиг үүргийг биелүүлэхэд хомсдох учир тус газар өөрсдийн үйл ажиллагааг тодорхой чиглэлд хумих шаардлагатай. Мөн түүнчлэн Авлигатай тэмцэх газар улс орон, орон нутгийн түвшинд хамтран ажиллах төрийн байгууллага олж тэдгээрийг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хамруулан оролцуулах хэрэгтэй байна. Авлигатай тэмцэх газрын манлайлалд аливаа хэлбэрийн улс төрийн нөлөө орж болохгүй гэж үзэж байна.

## **Авлигыг гэмт хэрэгт тооцох**

Монгол Улсын Эрүүгийн хууль нь авлигыг гэмт хэрэгт тооцдоггүй, энэ талаар олон улсын стандартад нийцэхгүй байна. Одоо хүчинтэй байгаа Эрүүгийн хуулинд авлигын эсрэг хэд хэдэн чухал зүйл заалт дутуу бөгөөд авлига санал болгох, амлах эсхүл эдгээрийг хүлээн авах, хүсэхийг гэмт хэрэгт тооцох тухай өөрчлөлт хийх; авлига гэдэгт биет бус ашиг орлого, мөнгөн бус хэлбэрийн ашиг орлогыг хамруулж тодорхойлох; хувийн хэвшил дэх авлигыг зохих ёсоор, тодорхой байдлаар гэмт хэрэгт тооцож, нөлөөллийг хянах, хуулийн этгээдийн үр дүнтэй хариуцлагыг нэвтрүүлэх замаар өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийг өөрчлөх талаар хэлэлцэж байгаа бөгөөд энэ боломжийг ашиглан дээд дурдсан авлигатай холбоотой дутагдлыг авч үзэн, Эрүүгийн хуулинд авлигын зөрчлийг оруулан бэхжүүлэх хэрэгтэй. Үнэлгээний баг Эрүүгийн шинчилэсэн найруулгын төслийг нягтлан үзсэн бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн дутагдалыг засаж залруулахын тулд уг төсөлд ихээхэн өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна. Эрүүгийн хуулийн төсөл нь авлигын зөрчилд хүлээлгэх пропорцтой (харилцан тэнцвэртэй), авлигын зөрчлийг багасгахуйц санкцуудын зөвлөмжийг бодолцох шаардлагатай.

Монгол Улсад халдашгүй эрхийн хүрээ нь өргөн байгаа нь - халдашгүй эрхтэй албан тушаалтнуудын тооны хувьд, мөн тухайн албан тушаалыг дагалдаж ирэх эрх ямбын хувьд - авлигын зөрчлийг яллахад хүндрэл учруулж байна. Халдашгүй эрх эдэлдэг албан тушаалтнуудын халдашгүй байдлыг цуцлах үр дүнтэй журам байхгүй бөгөөд халдашгүй байдлыг цуцлах эрх бүхий байгууллагууд аливаа хүсэлт, өргөдөлд өөрийн дур зоргоор шийдвэрлэдэг. Халдашгүй эрх нь аливаа нөхцөл байдалаас хамаарч цуцлагдах, хэвээр үлдэх чадвар муутай. Иймээс Монгол Улсад авлигыг шалгаж, яллахад халдашгүй эрхийн зохицуулалт ихээхэн саад болж байна. Цөөн хэдхэн дээд түвшний авлигын хэргийг шалгасан байгаа нь магадгүй үүнтэй холбоотой байх. Өргөн хүрээний халдашгүй эрх нь шударга ял шийтгэл оноож чадахгүй байдал авчирдаг бөгөөд энэ нь хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагааг муутгадаг. Эдгээрийг даруй өөрчилж олон улсын стандарт, сайн туршлагад нийцүүлэх нь зүйтэй.

Монгол Улсад авлигыг яллахад саад болж байгаа бас нэгэн хүчин зүйл нь хөөн хэлэлцэх хугацаа юм. Холбогдох хөөн хэлэлцэх хугацаа нь маш богино байдаг бөгөөд энэ нь аливаа хэргийг хянан шалгаж, шүүхэд өгөх хангалттай хугацаа өгдөггүй, ялангуяа нарийн төвөгтэй хэргийн хувьд (ихэнх ноцтой авлигын хэргүүд нь нарийн төвөгтэй байдаг). Хөөн хэлэлцэх хугацаа нь хэрэг үүсгэх, хариуцлага хүлээлгэх болон бусад процессын арга хэмжээ авах хугацаа болон тухайн хүн халдашгүй эрхтэй байх хугацааг оруулж тооцдог.

Үнэлгээний тайланд тусгагдсанаар Өршөөлийн хууль нь ихээхэн санаа зовоосон зүйл болоод байна. Хэрэв Өршөөлийн хууль батлагдвал, Авлигатай тэмцэх газраар шалгагдаж буй ихэнх авлигын хэргүүд цуцлагдана. Энэ нь авлигын хэрэгт холбогдсон хүмүүсийн хариуцлагаас зугтах гэж хийж буй үйлдэл шиг харагдаж байгаа бөгөөд ингэх нь Монголд хандлага болж байна. Энэ нь Авлигатай тэмцэх газрыг дордуулж байгаа бөгөөд холбогдох этгээдүүд үүнийг анхаарах шаардлагатай. Иймээс яллах ажиллагаанаас чөлөөлөх аливаа халдашгүй эрх олгосон, эсхүл шалгагдаж буй хэргүүдийг цуцалсан аливаа өршөөлийн хуулийг буцаах хэрэгтэй гэж зөвлөж байна.

## Авлигаас урьдчилан сэргийлэх

Хяналтын тайланд тусгагдсанаар Монгол Улсад төрийн алба улс төржсөн хэвээр байгаа бөгөөд улс төрийн болон мэргэжлийн ажилтан нарыг зааглах шугам практикт байхгүй байна. Төрийн албаны ажилтныг албан тушаал дэвшүүлэхдээ ажлын үр дүн, ур чадварт суурилах аргачлалыг хэрэгжүүлэхгүй байна. Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнд санаа зовниж байна. Ажлын урамшуулал өгөх илүү тодорхой, нээлттэй зааварчилгааг батлах шаардлагатай байна. Монгол Улс авлигатай тэмцэх хязгаарлалт, хориглолт болон сонирхлын зөрчил, хөрөнгийн мэдүүлэгтэй холбоотой өргөн хүрээний хууль, тогтоомжийг батлан гаргасан. Гэсэн хэдий ч эдгээр хууль, тогтоомж нь уялдаа холбоо бага бөгөөд нэгэн цогц болгох шаардлагатай. Авлигатай тэмцэх хоёр хуулийг (*Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль*) шинэчлэн найруулж, боломжтой бол нэг хууль болгож холбогдох хязгаарлалт, үүрэг, журам, хориглолтын тодорхой систем бий болгохыг зөвлөж байна.

Мөн **хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийг** хялбарчилж, Авлигатай тэмцэх газарт мэдүүлэг, мэдүүлгийн хяналтыг төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүгдийг нь эсхүл ихэнхийг онлайнээр буюу интернетээр нийтлэх ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй. **Сонирхлын зөрчлийн** тодорхойлолтыг олон улсын стандартад нийцүүлэн өргөжүүлэх шаардлагатай.

Авлигатай тэмцэх ажлын үнэлгээ нь одоогийн болон шинээр бичигдэж буй хуулиудад тусгагдаж байгаа нь таатай байна. Гэвч эдгээр зүйл заалт нь хүчинтэй болон шинээр бичигдэж буй эрх зүйн актыг бүгдийг нь авлигатай холбоотойгоор бүгдийг нь шалгах боломж олгодоггүй. Захиргааны хэргийн талаар гаргасан гомдлыг шийдвэрлэх төрийн захиргааны журам, шүүхийн хянан шийдвэрлэх журмыг тусад нь гаргахыг зорьсон нь таатай хэрэг. Энэ нь **төрийн захиргааны журам** болон холбогдох гомдлыг шийдвэрлэх механизмыг тодорхой, бүтээмжтэй болгох байх.

Төрийн санхүүгийн хяналт, аудитын хувьд Монгол Улс төрийн санхүүгийн удирдлага, хяналтын үр нөлөөтэй системийг бий болгож чадсан. Үндэсний аудитын газар нь бие даасан, сайн ажиллагаатай байгууллага бөгөөд бие даасан байдлыг өшөө илүү баталгаажуулахыг зөвлөж байна. Бүх яамдуудад аудитын нэгж, дотоод аудитын хороог байгуулсан. Сангийн яам нь дотоод аудитын аудаторуудыг ажлын арга зүй, зааварчилгаагаар хангах үүрэгтэй. Засгийн газрын үүнтэй холбоотойгоор "Дотоод аудитын дүрэм" зэрэг шаардагдах дүрэм, журмыг баталсан. Хэдий эдгээр амжилтад хүрч чадсан ч Монголын төрийн дотоод аудит нь хөгжлийн эхэн үе шат дээр байгаа бөгөөд цаашид энэхүү функцийг хөгжүүлэхэд ихээхэн зүйл хийх шаардлагатай байна. Дотоод аудитын тухай хууль гарган батлахыг зөвлөж байна.

Төрийн худалдан авах үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжид тодорхой өөрчлөлтийг хийж авлига гарах боломжийг хаах шаардлагатай байна. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хуулийн зүйл заалтууд нь төрийн болон төрийн гэрээлэх бүхий л үйл ажиллагаа нь өрсөлдөөнд суурилсан байх журмыг хангах хэрэгтэй. Үүнд Монгол Улсын Хөгжлийн банкаар санхүүжиж буй болон нэмэгдэл төсвөөр санхүүжиж буй төрийн худалдан авалтууд болон зам барихтай холбоотой худалдан авалтууд орно. Монголд төрийн худалдан авалттай холбоотой авлига, ялангуяа томоохон дэд бүтцийн төслийн хүрээнд авлига их өргөн хүрээтэй тархсан байна. Энэ нь мөн төр, хувийн хэвшлийн түншлэл болон концессын хэлэлцээрт хамаарна. Засгийн газрын Худалдан авах ажиллагааны газрыг бүрэн эрхийн

хувьд болон хүн хүчний хувьд хүчин чадлыг нь нэмэгдүүлэх шаардлагатай. Монгол улсын худалдан авах үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үнэлж байгаа бөгөөд төрийн худалдан авалтын бүх үе шат ийнхүү нээлттэй, цахим систем рүү шилжэхийг дэмжиж байна. Хяналтын механизмыг бэхжүүлэх хэрэгтэй, ялангуяа гомдол хянах байгууллагуудыг цөөлж, тэдгээрийг төрөөс хараат бус байх нөхцөлийг хангах хэрэгтэй.

Монгол Улс Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс боловсруулсан зөвлөмжүүдийн **мэдээллийг хүртээмжтэй байлгахтай** холбоотой хэсгүүдийг хэрэгжүүлж чадаагүй. Монгол Улсын мэдээллийн олж авахтай холбоотой эрх зүйн актад холбогдох өөрчлөлтийг хийж олон улсын стандарт, сайн туршлагад нийцүүлэх хэрэгтэй. Монгол Улсад төрийн албан тушаалтан хүний мэдээлэл олж авах эрхийг зөрчихөд оноох захиргааны санкц, шийтгэл нэвтрүүлээгүй бөгөөд зөвлөмжийн дагуу мэдээлэл олж авах эрхийг хангах хараат бус хяналтын механизмыг бий болгоогүй. Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу хүний нэр төр, алдар хүндийг нь гутаах нь гэмт хэрэгт тооцогддог. Шилэн дансны тухай хууль нь эерэг өөрчлөлт бөгөөд бусад оронд үлгэр жишээ болж болно. Энэ хуулийг зохистойгоор, бүрэн гүйцэт хэрэгжүүлэх хэрэгтэй. Монгол Улсын хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдалд анхаарлаа хандуулахыг хүсэж байна - хэвлэл мэдээллийн эзэмшлийг ил тод болгох талаар холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг хийхийг зөвлөж байна. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь хэвлэл мэдээллийн аж ахуйн нэгж, компаниудын хэвлэл мэдээллийн эцсийн эзэмшигч, (шууд болон шууд бус) томоохон хувьцаа эзэмшигчдийн зэрэг эзэмшлийн бүтцийг ил тод болгох хэрэгтэй.

Монголын улс төрийн намын санхүүжилтийн талаарх журам нь маш сул бөгөөд бүрэн дагаж мөрдөгддөггүй. Улс төрийн намын санхүүжилтийн үр дүнтэй хяналтгүй байдал нь улс төрийн авлигыг дагуулдаг бөгөөд төрийн байгууллагуудыг хувийн ашиг сонирхлын нөлөөнд оруулдаг. Одоо хүчинтэй байгаа улс төрийн намын санхүүжилтийн талаарх хууль тогтоомж нь хэрэгждэггүй бөгөөд тэдгээрийг тойрч гарахад ч хялбар. Улс төрийн намын санхүүжилтийг хянах ямарваа төрийн байгууллага байхгүй. Сонгуулийн ажлын санхүүжилтийн шаардлагууд мөн үр дүнгүй байдаг бөгөөд Сонгуулийн ерөнхий хороонд эдгээр шаардлагуудыг дагаж мөрдүүлэх хүчин чадал дутмаг. Улс төрийн намын санхүүжилттэй холбоотой хууль тогтоомжийг бүхлээр нь шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна. Иймээс улс төрийн намын санхүүжилтийн талаар хууль боловсруулах ажлыг дэмжиж байна. Тус хуулийг боловсруулах ажил нь олон нийтэд нээлттэй байдлаар, иргэний нийгмийн оролцоотой явагдах нь зүйтэй.

Монголын шүүхэд авлига, улс төрийн нөлөөлөл, хамаатан саднаа албан тушаалд томилох явдал байсаар л байна. 2013 онд хийсэн шүүхийн системийн шинэчлэл чухал шинэчлэл байсан хэдий ч хангалттай байж чадаагүй. Зөвхөн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар байгуулалтын өөрчлөлтийг хийж чадах бөгөөд ялангуяа улс төрийн этгээдийг шүүх байгууллагад ажиллах байдлыг хязгаарлах эсхүл хориглох замаар өөрчилж болно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай байна. Ерөнхийлөгч болон УИХ нь шүүгчийг томилох, чөлөөлөх ажиллагаанд оролцохгүй байх хэрэгтэй. Шүүгчдийг ур чадвар, ажлын үр дүнд үндэслэн тушаал дэвшүүлэх ажил нь хэрэгжилтийн эхэн үедээ байгаа бөгөөд үүнийг цааш нь хөгжүүлэх шаардлагатай байна - холбогдох журмыг хялбаршуулж, бүх үе шатыг ил тод, шударга болгох хэрэгтэй байна.

Бүс нутгийн бусад улс орнуудын адил, **хувийн хэвшлийн шударга зарчим** нь Монгол Улс ад харьцангуй шинэ ойлголт юм. Авлигатай тэмцэх хөтөлбөрийн шинэ төсөлд хувийн хэвшлийн авлигын их эрсдэлтэй хэсгүүд болон ер нь хувийн хэвшлийн талаар ямарваа чиглэл, арга хэмжээ тусгагдаагүй байна. Авлигатай тэмцэх газрын хүсэлтийн дагуу явуулсан төрийн өмчит компанийн үнэлгээ болон уг үнэлгээг үндэслэж гаргасан компанийн ил тод данс, худалдан авалтын талаарх зөвлөмжийг дэмжиж байна. Эдгээр зөвлөмжийг



хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна. Хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийг ил тод болгохтой холбоотойгоор ямарваа арга хэмжээ авагдаагүй.

## МОНГОЛ УЛСЫН ХЯНАЛТ

Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2003 онд баталсан. Энэ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний дэд бүсийн гол санаачилга юм. Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд Армен, Азербайжан, Гүрж, Киргизстан, Казахстан, Монгол, Тажикистан, Украин, Узбекистан хамрагдаж байгаа ба Төв азийн бусад орнууд хэрэгжүүлэх ажиллагаанд оролцоно. Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хамрагдаж байгаа улс орнуудын авлигатай тэмцэх хуулийн болон бүтцийн байгууллагуудын системтэй, тогтмол шалгалтууд орж байгаа болно.

Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол улс 2012 оны 9 дүгээр сард нэгдэн орсон. Монгол Улсын анхны үнэлгээ нь 2013-2014 онуудад явагдсан. Энэ нь 2013 онд хүргүүлсэн Монгол Улсын өөрт хийсэн үнэлгээ дээр суурилсан юм. Тайланг хянах баг бэлэн мэдээлэл дээр үнэлгээ хийж Үнэлгээний Тайланг боловсруулсан. Энэхүү тайланг Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний бүрэн бүрэлдэхүүнтэй хурлаар 2014 оны 4-р сарын 18-ны өдөр баталсан.

Монгол Улс нь Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд бусад оролцогч улсуудаас хамгийн сүүлд элссэн учир анхны Үнэлгээний тайлан нь нэг дэх болон хоёр дахь үнэлгээний хамт гарч байгаа юм. Монголын холбогдох төрийн байгууллагууд Монгол улсад зориулсан асуулгын хариуг, бусад холбогдох баримт бичгүүдийн хамт 2015 оны 4-р сард хүргүүлсэн. 2015 оны 6-р сарын 2-оос 5-ны өдрийг хүртэл Улаанбаатар хотод газар дээр нь зочилсон. Газар дээр нь зочилсны дараа Монголын төрийн байгууллагууд нэмэлт шаардлагатай мэдээллийг явуулсан.

Үнэлгээний багыг Дмитро Котяр (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зөвлөх, Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний нарийн бичгийн газар) удирдсан бөгөөд тус баг нь дор дурдсан хүмүүсээс бүрдсэн:

- Елена Консевикиүтэ, Олон улсын харилцааны ажилтан, Тусгай мөрдөн шалгалтын алба, Литва
- Лилит Петросян, Байцаагч, Дээд албан тушаалтны ёс зүйн хороо, Армени
- Самир Махмудов, Прокурор, Авлигатай тэмцэх хэлтэс, Ерөнхий прокурорын газар, Азербайжан
- Евгений Смирнов, Ахлах зөвлөх, Худалдан авах үйл ажиллагааны бодлогын газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк
- Бадамчимэг Дондог, Санхүүгийн удирдлагын шинжээч, Засаглалыг дэмжих хөтөлбөр, Олон нийтийн нөөцийн хөдөлгөөн, удирдлага, Дэлхийн банк
- Брүүкс Хикман, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний нарийн бичгийн газар
- Ольга Савран, Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний менежер, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний нарийн бичгийн газар

Монгол Улсын үндэсний координатор нь Авлигатай тэмцэх газар байв. Монгол Улс, Авлигатай тэмцэх газрыг төлөөлж Буджавын Бат-Отгон, Сономын Галбадрах нар ажилласан.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын нарын бичгийн газар иргэний нийгэм, бизнес, олон улсын байгууллагуудтай тус тусад нь уулзалт хийсэн. Төрийн бус байгууллага болон бизнесийн төлөөллүүдтэй хийсэн уулзалтийг Монгол Улс дахь Азийн сан

хамтран зохион байгуулсан. Харин олон улсын байгууллагын төлөөлөгч нартай хийх уулзалтыг Монгол Улс дахь Их Британи Умар Ирландын Нэгдсэн Вант Улсын Элчин сайдын яам, Нэгдсэн үндэсний байгууллага ("НҮБ"), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран зохион байгуулсан.

Үнэлгээний баг Монгол Улсын Засгийн газарт, тэр дундаа Авлигатай тэмцэх газрын хамт олонд, үнэлгээний явцад хамтран ажилласанд гүн талархсанаа илэрхийлье. Мөн үнэлгээний баг Монголд байх хугацаанд төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудад нээлттэй, үр бүтэмжтэй хэлэлцүүлэг хийсэнд талархснаа илэрхийлэе. Эцэст нь Монголд ажиллах явцад туслалцаа үзүүлсэн Монгол Улс дахь Их Британи Умар Ирландын Нэгдсэн Вант Улсын Элчин сайдын яам, НҮБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Азийн сан, ТиАй Монголиа, Азийн хөгжлийн банк, Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчийн сайдын яам, Монголын бизнесийн зөвлөлд талархснаа илэрхийлэе.

Мөн Дэлхийн Банкны Монгол дахь Суурин Төлөөлөгчийн Газар, ялангуяа **Дондогын Бадамчимэг** (Санхүүгийн хяналт шалгалт, аудитын хэсэг), **Цэрэндагвын Гэрэлгуа** (Төрийн худалдан авалтын хэсэг) нарт, Монгол улсад хийсэн айлчлалд туслалцаа үзүүлж, зохион байгуулж, Үнэлгээний Тайланг бэлтгэхэд тусласанд талархал илэрхийлэе.

Энэхүү тайланг Монгол Улсын Засгийн газрын асуулгад ирүүлсэн хариулт, үнэлгээний багын айлчлалын үр дүнд олж мэдсэн мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллагуудын өгсөн нэмэлт мэдээлэл, үнэлгээний багын судалгаа, бүрэн бүрэлдэхүүний уулзалтын үед хүлээж авсан мэдээлэл дээр үндэслэн бэлдэв.

Энэхүү тайлан нь Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ болон Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний Парис хотод зохион байгуулагдсан 2015 оны 10-р сарын 9-ний өдрийн бүрэн бүрэлдэхүүний уулзалтаар батлагдсан болно. Үүнд Үнэлгээний тайлангийн Монгол Улсад өгсөн зөвлөмжтэй холбоотойгоор дор дурдсан биелэлтийн оноог өгсөн болно: Монгол Улсын хувьд өгсөн нийт 19 зөвлөмжийн, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 12 зөвлөмжийг хагас хэрэгжүүлсэн, 3 зөвлөмжийн ихэнх хэсгийг хэрэгжүүлсэн байна. Аль ч зөвлөмжийг бүрэн дүүрэн хэрэгжүүлээгүй. Нэг дэх болон хоёр дахь үнэлгээний тайлан нь дөрвөн ширхэг шинэ зөвлөмж өгсөн бөгөөд урьдны 15 зөвлөмжийг хүчинтэй хэвээр үлдээсэн.

Энэхүү тайлан нь уулзалтын дараа олон нийтэд нийтлэгдэнэ, энэхүү цахим хуудсыг оролцуулан: [www.oecd.org/corruption/acp](http://www.oecd.org/corruption/acp). Монгол Улсын төрийн байгууллагууд энэхүү тайланг боломжит хэрээр түгээхийг хүсэж байна. Монгол Улсын нэг дэх болон хоёр дахь үнэлгээний үр дүнгийн хэрэгжилтийг танилцуулах, сурталчлах зорилгоор Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний нарийн бичгийн газар нь Монгол Улсад айлчлал зохион байгуулж, үүний хүрээнд төрийн байгууллагууд, иргэний нийгэм, бизнес, олон улсын байгууллагуудын төлөөлөгч нартай уулзалт хийнэ. Монгол Улсын Засгийн газар Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний бүрэн бүрэлдэхүүний уулзалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээний талаар тогтмол мэдээллэж байхыг хүсэж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Зүүн Европ болон Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ, Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээг Америкийн Нэгдсэн Улс, Швейцарийн Холбооны Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

## УЛС ОРНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

### Нийгэм-эдийн засгийн байдал

Монгол улс Төв Азид орших ба ойролцоогоор 3 сая хүн амтай (2015 оны байдлаар). Нийт 1,564,116 хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Монгол Улс нь далайд гарцгүй бөгөөд Орос, Хятад улсуудтай хиллэдэг.

Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын асар их нөөц баялгийг \зэс, нүүрс, молибден, цагаан тугалга, вольфрам, алт\ ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт ихээхэн өөрчлөлт гарч байгаа. 2011 онд уул уурхайн салбар нь Монгол Улсын нийт экспортын 90 шахам хувь, уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалт улсын төсвийн орлогын бараг 50 хувийг бүрдүүлсэн байна. 2014 оны байдлаар уул уурхай салбар Монголын ДНБ-ний 18.5 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 58.7 хувь, төсвийн орлогын 17.5 хувийг тус тус эзлэж байна<sup>1</sup>. Оюу толгойн алт, зэс олборлох төсөл нь 2020 он гэхэд Монголын ДНБ-ний гуравны нэгийг эзлэнэ гэж төлөвлөгдөж байгаа<sup>2</sup>. Уул уурхайн салбар дахь их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр дүнд Монгол Улс нь дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засгийн нэг болсон юм<sup>3</sup>.

Эдийн засгийн өсөлт нь 2014 онд 7.8 хувь байхаар тооцоологдож байгаа. Энэ нь 2010 оны 6.4 хувьтай харьцуулбал өндөр тоо ч гэсэн 2011 оны өсөлтийн дээд цэг болох 17.5 хувь болон 2013 оны 11.6 хувийн өсөлттэй харьцуулбал бага тоо юм<sup>4</sup>. 2014 оны байдлаар нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 12,063 ам.доллар байна. Энэ нь 2013 оны 11,191 ам.доллар, 2012 оны 7,552 ам.доллартай харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Хятад нь Монгол Улсын нийт экспортын 90 гаруй хувийг хүлээж авдаг ба Монголын хамгийн том нийлүүлэгч юм. Эрчим хүчний хувьд Монгол Улс нь Оросоос хамааралтай бөгөөд 2013 онд нийт бензин, дизель шатахууны 75 орчим хувь болон цахилгааны нэлээд хувийг Оросоос худалдан авсан.

Сүүлийн арваад жилд, ядуурал буурах хандлагатай болж ирсэн. Хамгийн сүүлийн үеийн байдлаар 2010 онд 38.7 хувьтай байсан бол 2012 онд 27.4 хувь болж буурсан.

### Улс төрийн тогтолцоо

Монгол Улс нь парламентийн засаглалтай бүгд найрамдах улс. Ерөнхийлөгч болон УИХ нь шууд сонгуулиар сонгогддог. Хууль тогтоох дээд байгууллага нь УИХ бөгөөд УИХ нь нэг танхимтай, 76 гишүүнээс бүрддэг. Ерөнхий сайдыг УИХ томилдог ба засгийн газрын бусад гишүүдийг Ерөнхий сайдын санал болгосноор, Ерөнхийлөгчтэй зөвшилцөж УИХ томилдог. Монгол Улсад улс төрийн олон нам бий бөгөөд тэдгээрээс хамгийн том нь Монголын Ардын нам болон Ардчилсан нам болно.

Монгол улсын ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж \хоёр удаа Ерөнхий сайдаар ажилласан, Ардчилсан намын гишүүн байсан\ 2013 оны 6 дугаар сарын 26-нд хоёр дахь удаагаа Монгол

<sup>1</sup> Эх сурвалж: <http://eiti.org/Mongolia, www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/EITIMWorkReport2014en.pdf>.

<sup>2</sup> Эх сурвалж: [www.worldbank.org/en/news/feature/2012/03/16/mongolia-strikes-balance-between-development-environmental-protection](http://www.worldbank.org/en/news/feature/2012/03/16/mongolia-strikes-balance-between-development-environmental-protection).

<sup>3</sup> Эх сурвалж: IMF Country Report No. 15/109, 2015 оны 4-р сар


<sup>4</sup> Эх сурвалж: World Bank, 2014, [www.worldbank.org/en/country/mongolia/overview](http://www.worldbank.org/en/country/mongolia/overview).

Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон. УИХ-ын сонгууль хамгийн сүүлд 2012 оны 6 дугаар сард явагдсан ба сонгуулийн үр дүнд Ардчилсан нам – 34 суудал; Монгол Ардын нам – 26 суудал; Шудрага ёс эвсэл – 11 суудал; Иргэний зориг-Ногоон нам – 2 суудал; бие даагчид – 3 суудал тус тус авсан. 2012 оны сонгуулиар парламентийн сонгууль анх удаа дийлэнх олонх, пропорционал тогтолцоогоор явагдсан. 2014 оны 11-р сард Засгийн газрыг шинээр байгуулсан.

## Авлигын хандлага

Монгол Улсад авлига өргөн цар хүрээтэйгээр тархсан байна. Ашигт малтмалын ашиглалттай холбоотойгоор Монгол Улс их хурдацтай өөрчлөгдөж байгаа нь засаглал болон авлигын сорилтуудыг бий болгож байна. Доорх зураглалаас Монгол Улс дахь авлигын ойлголт, туршлага, сайн засаглалын талаарх Трансперенси Интернешнл байгууллагаас авсан асуулгын дүн болон үнэлгээг харна уу.

### Дүрслэл 1. Трансперенси Интернешнл байгууллагын авлигын индексийн Монгол Улсын үнэлгээ



Оноо: 0 = өндөр хэмжээний авлигатай, 100 = авлига байхгүй, маш цэвэр

Эх сурвалж: Трансперенси Интернешнл, Авлигын индекс, 2010-2014 он, [www.transparency.org/research/cpi/](http://www.transparency.org/research/cpi/)

## Хүснэгт 1. Трансперенси Интернешнл байгууллагаас гаргасан 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, Монгол Улсын үзүүлэлт

Сүүлийн гурван жилийн хугацаанд Монгол улсад авлигын түвшин хэр их өөрчлөгдсөн бэ?			Танай улсын төрийн салбарт авлига хэр их асуудлыг бий болгож байна вэ?	Төрийн салбартай холбоотой үйл ажиллагаанд хувь хүний харилцаа холбоо хэр чухал вэ?	Энэ улсын засгийн газар цөөх томоохон этгээдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргах байдал хэр вэ?	Танай засгийн газрын үйл ажиллагаа авлигатай тэмцэхэд хэр үр дүнтэй вэ?		
Буурсан	Өөрчлөгдөөгүй	Ихэссэн	1-с 5 хүртэлх хэмжээсээр (5 – маш том асуудал)	Чухал эсвэл маш чухал (асуулгад оролцогчдын хувь)	Ихээхэн нөлөөлдөг (асуулгад оролцогчдын хувь)	Үр дүнтэй	Үр дүнгүй	Аль нь ч биш
19%	32%	48%	4.8	73%	12%	25%	39%	36%

**Эх сурвалж:** Трансперенси Интернешнл, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, [www.transparency.org/gcb2013](http://www.transparency.org/gcb2013)

## Хүснэгт 2. Сүүлийн гурван жилийн Монгол Улсын авлигын байдал өөрчлөгдсөн эсэх талаарх ойлголт

Сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол улсад авлигын түвшин өөрчлөгдсөн үү? (Асуулгад оролцсон хүмүүсийн хувь)	2012 оны 11 сар	2013 оны 3 сар	2013 оны 9 сар	2014 оны 3 сар	2015 оны 5 сар
Буурсан (их / бага)	13.8	17.6	27.5	26.3	14.0
Ижил түвшинд байгаа	25.8	34.1	31.5	33.8	26.9
Нэмэгдсэн (их / бага)	60.4	48.3	41.0	39.9	59.0

**Эх сурвалж:** Азийн сан, Сант-Марал Сан (2015 оны 6-р сар), "Авлигын талаарх олон нийтийн мэдлэг тогтоох судалгаа: Монгол Улсад ил тод байдлыг дэмжих төсөл", 4.1-р зураг, 20-р хуудас ([www.asiafoundation.org/publications/pdf/1513](http://www.asiafoundation.org/publications/pdf/1513))

## Хүснэгт 3. Ирэх гурван жилд Монгол Улсын авлигын байдал өөрчлөгдсөн эсэх талаарх ойлголт

Ирэх 3 жилд авлигын түвшинд өөрчлөлт орно гэж бодож байна уу? Авлига (Асуулгад оролцсон хүмүүсийн хувь)	2012 оны 11 сар	2013 оны 3 сар	2013 оны 9 сар	2014 оны 3 сар	2015 оны 5 сар
Буурсан (их / бага)	44.6	48.8	52.5	45.8	27.4
Ижил түвшинд байгаа	28.9	31.1	27.1	30.8	37.5
Нэмэгдсэн (их / бага)	26.5	20.1	20.3	23.4	35.2

**Эх сурвалж:** Азийн сан, Сант-Марал Сан (2015 оны 6-р сар), "Авлигын талаарх олон нийтийн мэдлэг тогтоох судалгаа: Монгол Улсад ил тод байдлыг дэмжих төсөл", 4.2-р зураг, 20-р хуудас ([www.asiafoundation.org/publications/pdf/1513](http://www.asiafoundation.org/publications/pdf/1513))

#### Хүснэгт 4. Монгол Улс дахь авлига, байгууллагаар, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр

Асуулгад оролцогчдоос эдгээр байгууллагууд хамгийн их авлигад өртөгддөг гэж хариулсан байна

Улс төрийн намууд	УИХ	Цэргийн хүчин	Төрийн бус байгууллагууд	Хэвлэл мэдээлэл	Шашны байгууллагууд	Бизнесийн байгууллагууд	Боловсролын байгууллагууд	Шүүх байгууллагууд	Эрүүл мэндийн байгууллагууд	Цагдаагийн байгууллагууд	Төрийн албан тушаалтан
65	63	27	16	39	11	45	63	73	71	66	77

Эх сурвалж: Трансперенси Интернешнл, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, [www.transparency.org/gcb2013](http://www.transparency.org/gcb2013)

#### Хүснэгт 5. Монгол Улс дахь хамгийн их авлигатай таван байгууллага

Огноо	Зэрэглэл 1 (хамгийн өндөр)	Зэрэглэл 2	Зэрэглэл 3	Зэрэглэл 4	Зэрэглэл 5 (хамгийн бага)
2011 оны 4 сар	Газар ашиглалт	Уул уурхай	Шүүгчид	Гааль	Улс төрийн намууд
2012 оны 11 сар	Газар ашиглалт	Уул уурхай	Орон нутгийн худалдан авалтын тендерүүд	Мэргэжлийн хяналтын газар	Улс төрийн намууд
2013 оны 3 сар	Газар ашиглалт	Төрийн уул уурхайн байгууллага	Орон нутгийн худалдан авалтын тендерүүд	Улс төрийн намууд	Гааль
2013 оны 9 сар	Газар ашиглалт	Төрийн уул уурхайн байгууллага	Орон нутгийн худалдан авалтын тендерүүд	Улс төрийн намууд	Уул уурхайн салбарын хувийн компаниуд
2014 оны 3 сар	Газар ашиглалт	Төрийн уул уурхайн байгууллага	Орон нутгийн худалдан авалтын тендерүүд	Шүүгчид	Гааль
2015 оны 4 сар	Газар ашиглалт	Улс төрийн намууд	Уул уурхай	Засгийн газар	УИХ Хууль тогтоох байгууллага

Эх сурвалж: Азийн сан, Сант-Марал Сан (2015 оны 6-р сар), "Авлигын талаарх олон нийтийн мэдлэг тогтоох судалгаа: Монгол Улсад ил тод байдлыг дэмжих төсөл", 3.1-р хүснэгт, 17-р хуудас ([www.asiafoundation.org/publications/pdf/1513](http://www.asiafoundation.org/publications/pdf/1513))

## Хүснэгт 6. Авлигын туршлага, салбараар, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр

Сүүлийн 12 сард танай гэр бүлийн хэн нэгэн эдгээр үйлчилгээг авахын тулд авлига өгсөн үү?  
(тухайн үйлчилгээг авсан хүмүүсээс асуулгын дүнг гаргав), %

Боловсрол	Шүүх	Эрүүл мэндийн үйлчилгээ	Цагдаа	Бүртгэл, нийлмөрийн зөвшөөрлийн үйлчилгээ	Нийтийн хангамжийн үйлчилгээ	Татвар, гаалийн үйлчилгээ	Газартай холбоотой үйлчилгээ
34	35	35	39	19	8	22	21

Эх сурвалж: Трансперенси Интернешнл, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, [www.transparency.org/gcb2013](http://www.transparency.org/gcb2013)

## Хүснэгт 7. Авлигын шалтгаан, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр

Авлига өгсөн хамгийн түгээмэл шалтгаан юу вэ?  
(асуулгад оролцогчдын хувь %)

Бэлэг болгож, эсвэл талархалаа илэрхийлж	Илүү хямд үйлчилгээ авахын тулд	Үйл явцыг хурдлуулахын тулд	Авлига өгч байж л үйлчилгээ авах боломжтой байсан
23	10	38	28

Эх сурвалж: Трансперенси Интернешнл, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, [www.transparency.org/gcb2013](http://www.transparency.org/gcb2013)

## Хүснэгт 8. Авлигын шалтгаан, Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа

Авлига өгсөн шалтгаан	2012 оны 11 сар	2013 оны 3 сар	2013 оны 9 сар	2014 оны 3 сар	2015 оны 4 сар
Өөрт оногдсон үйлчилгээ авахын тулд	55.6	63.0	58.7	65.0	67.4
Эрх бүхий албан тушаалтнуудтай үүсэх асуудлаас зайлсхийж	24.9	19.3	16.3	16.5	16.3
Авлига өгөхийг шаардсан учраас	16.6	8.4	20.2	13.6	15.2
Дээрхийн аль нь ч биш	3.0	9.2	4.8	4.9	1.1

Эх сурвалж: Азийн сан, Сант-Марал Сан (2015 оны 6-р сар), "Авлигын талаарх олон нийтийн мэдлэг тогтоох судалгаа: Монгол Улсад ил тод байдлыг дэмжих төсөл", 9.4-р зураг, 37-р хуудас ([www.asiafoundation.org/publications/pdf/1513](http://www.asiafoundation.org/publications/pdf/1513))



## Хүснэгт 9. Авлигатай тэмцэх үйл ажиллагааны иргэний оролцоо, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр

“Та дараахын аль нэгийг хийх үү?”

(дараахын аль нэгийг хийх хүмүүсийн хувь)

Засгийн газрыг авлигын эсрэг илүү тууштай арга хэмжээ авахыг шаардсан хүсэлт цуглуулах	Авлигын эсрэг тайван жагсаал цуглаанд оролцох	Авлигын эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагын идэвхтэй гишүүн болох	Авлигаас ангид байдаг компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд илүү үнэ төлөх	Нийгмийн сүлжээгээр дамжуулан авлигын талаарх асуудлыг түгээх
80	55	47	57	70

Эх сурвалж: Трансперенси Интернешнл, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, [www.transparency.org/gcb2013](http://www.transparency.org/gcb2013)

## Хүснэгт 10. Авлигын туршлага, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр

Авлига өгөхөөс татгалзах

Таниас өмнө нь авлига өгөхийг шаардаж байсан уу?		Шаардсан тохиолдолд та авлига өгөхөөс татгалзсан уу?	
Тийм	Үгүй	Тийм	Үгүй
41	59	31	69

Эх сурвалж: Трансперенси Интернешнл, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, [www.transparency.org/gcb2013](http://www.transparency.org/gcb2013)

## Хүснэгт 11. Авлигын талаар мэдэгдэх, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр

Та авлигын тохиолдлыг мэдэгдэх үү? (%)		Хэрвээ тийм бол, ямар байгууллагад мэдэгдэх вэ? (%)					Хэрвээ үгүй бол, шалгаан нь... (%)			
Тийм	Үгүй	Шүүр байгууллагад	Засгийн газрын мэдээлэх утас	Бие даасан ТББ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Бусад	Хаана мэдэгдэхээ мэдэхгүй байна	Эргэж холбогдоход үүсэх айдас	Мэдэгдсэнээр байдал өөрчлөгдөхгүй	Бусад
78	22	23	50	5	20	2	15	29	55	1

Эх сурвалж: Трансперенси Интернешнл, 2013 оны Дэлхий нийтийн авлигын барометр, [www.transparency.org/gcb2013](http://www.transparency.org/gcb2013)

## Хүснэгт 12. Авлигын талаар мэдэгдэх, олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа

Дараах байгууллагад мэдэгдэнэ	2012 оны 11 сар	2013 оны 3 сар	2013 оны 9 сар	2014 оны 3 сар	2015 оны 4 сар
Менежмент	29.5	27.5	18.2	29.5	22.0
АТГ	53.7	52.6	62.9	52.3	50.0
Цагдаа	7.5	4.7	6.9	9.1	9.0
Хэвлэл мэдээлэл	7.9	14.7	11.3	8.5	5.0
Засгийн газрын утас (“11-11”)	Сонголт байгаагүй	Сонголт байгаагүй	Сонголт байгаагүй	Сонголт байгаагүй	14.0

Эх сурвалж: Азийн сан, Сант-Марал Сан (2015 оны 6-р сар), "Авлигын талаарх олон нийтийн мэдлэг тогтоох судалгаа: Монгол Улсад ил тод байдлыг дэмжих төсөл", 9.2(a) болон 9.2(b) -р зураг, 36-р хуудас (2015 оны 4-р сарын мэдээлэл)

**Хүснэгт 13. Засаглал, Монгол улсад бизнес хийх орчны талаарх олон улсын үнэлгээ**

<b>Индекс ба байгууллага</b>	<b>Монгол улсын зэрэглэл</b>	<b>Индексд орсон улсууд</b>
Бизнес эрхлэх нь, 2015, Дэлхийн банк	135 (2014 онд 139)	189
Эдийн засгийн чөлөөт байдлын индекс 2015, Херитэйж Сан	96 (2014 онд 98)	178
Дэлхийн өрсөлдөх чадварын индекс 2014-2015, Дэлхийн эдийн засгийн форум	98 (2013-2014 онд 107)	144
-Засгийн газрын хэт зохицуулалт	114 (119)	
- Өмчийн эрх	100 (110)	
-Засгийн газрын бодлогын ил тод байдал	87 (105)	
-Хууль бус төлбөр, авлига	82 (94)	
-Шүүх байдлын бие даасан байдал	108 (111)	
-Засгийн газрын албан тушаалтнуудын шийдвэр гаргалт	125 (132)	
-Гаалийн үйл ажиллагааны дарамт	115 (135)	
Дэлхийн засаглалийн үзүүлэлтүүд, Авлигын хяналт, 2013 он, Дэлхийн Банк	40 <sup>7</sup> (2008 онд 30)	215

## ТОВЧЛОЛ

АДБАХ	Аудитын Дээд Байгууллагуудын Азийн Холбоо
АДБОУХ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Холбоо
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
АДБ	Аудитын Дээд Байгууллага
АЭУОЕЗ	Авлигын Эсрэг Улс Орнуудын Европын Зөвлөл
ЕАБХАБ	Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага
МУАГ	Монголын Үндэсний Аудитын Газар
МХХЗГ	Мэдээлэл Харилцаа Холбооны Зохицуулах Газар
МХЭХ	Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо
НЗТ	Нээлттэй Засгийн Түншлэл
ОУИС	Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачлага
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ТАТХ	Төрийн Албаны Тухай Хууль
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТТХ	Төрийн Албаны Тухай Хууль
УИХ	Улсын Их Хурал
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХАТХ	Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хууль
ХАҮТ	Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
ХБ	Монгол Улсын Хөгжлийн Банк
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий Зөвлөл
ШМХ	Шүүхийн Мэргэшлийн Хороо
ЭБШХ	Эрүүгийн Байцаан Шийтгэх Хууль

# 1. Авлигын Эсрэг Бодлого

## 1.1.-1.2. Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг бодлогын баримт бичгүүд

*Зөвлөмж 1.1.-1.2.*

- 1) Дэвшүүлж байгаа зорилго, зорилт, тусгайлан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжилтийг хэмжиж болох үзүүлэлтүүд, хариуцах эзэн эсхүл байгууллага, хугацаа, хэрэгжилтэд хяналт тавин зохицуулах механизм, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр зэргийг тодорхой тусгасан авлигын эсрэг үндэсний шинэ стратеги, хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг аль болох хурдан батлах. Бодлогын шинэ баримт бичиг нь авлигын байдал, хандлагад хийсэн гүнзгий бодит дүн шинжилгээ, өмнө нь авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээ болон тэргүүлэх гол асуудлуудад тулгуурласан байх шаардлагатай.
- 2) Засгийн газраас ангид бие даасан, авлигын эсрэг бодлогын зохицуулалт, хэрэгжүүлэлтийн үр нөлөө бүхий өндөр түвшингийн механизм (жишээ нь үндэсний зөвлөл) байгуулах шаардлагатай ба бүрэлдэхүүнд нь иргэний нийгмийн төлөөлөл оролцох ба чадварлаг ажиллагсадтай, зохих хөрөнгийн эх үүсвэртэй байх; авлигын эсрэг стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тогтмол гаргаж, нийтэд мэдээлж байх.
- 3) Авлигад өртөх эрсдэл өндөр салбаруудын авлигын эсрэг стратеги буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах асуудлыг анхаарах

*1) Дэвшүүлж байгаа зорилго, зорилт, тусгайлан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хэрэгжилтийг хэмжиж болох үзүүлэлтүүд, хариуцах эзэн эсхүл байгууллага, хугацаа, хэрэгжилтэд хяналт тавин зохицуулах механизм, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр зэргийг тодорхой тусгасан авлигын эсрэг үндэсний шинэ стратеги, хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг аль болох хурдан батлах. Бодлогын шинэ баримт бичиг нь авлигын байдал, хандлагад хийсэн гүнзгий бодит дүн шинжилгээ, өмнө нь авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээ болон тэргүүлэх гол асуудлуудад тулгуурласан байх шаардлагатай.*

2014 оны Үнэлгээний тайланд дурдаж байснаар 2002-2010 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дуссанаас хойш авлигатай тэмцэх шинэ стратеги боловсруулах хүртэл багагүй хугацаа болсон байна. Ажлын байранд хийсэн уулзалтын явцад эрх бүхий албан тушаалтнууд хугацаа хожимдсон шалтгаан нь УИХ-ын тогтворгүй байдал, өөр улс төрийн намууд болон засгийн газрын байгууллагууд авлигын эсрэг хөтөлбөрийн бай болж магадгүй, мөн авлигатай тэмцэх хөтөлбөрийн хүрээнд Авлигатай Тэмцэх Газрын эрх мэдэл нэмэгдэх магадлалтай гэж бодсоноос болсон хэмээн хэлж байсан.

Монгол улсын эрх бүхий албан тушаалтнуудын мэдэгдсэнээр Ерөнхийлөгчийн тамгын газраас авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Авлигатай тэмцэх газар, иргэний нийгэм болон бизнес эрхлэгчид үүнд оролцож байгаа.

Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг Монгол улсын их хурлын тухай хуулийн 43.1-р зүйл болон Авлигын эсрэг хуулийн (2014 оны 1 сард хүчин төгөлдөр болсон) 2<sup>1</sup>-р зүйлд үндэслэн боловсруулсан. Удаах зүйлд “Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална” гэж заажээ. Энэ хуульд төрийн байгууллага болон төрийн албан хаагчид хуулийн дагуу үндэсний хөтөлбөрийг мөрдөж ажиллах талаар ерөнхий заалт оруулсан байна. Түүнчлэн хөтөлбөрийн төсөлд УИХ-ын Хууль зүйн байнгын хороо болон Монгол улсын Засгийн газар, АТГ үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж УИХ-д танилцуулж, батлуулна гэж заасан байна.

Монгол улсын эрх бүхий албан тушаалтнуудын тайлбарласнаар авлигын эсрэг хөтөлбөрийн үнэлгээний багийг бүрдүүлж Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо (МХЭХ) –д хүргүүлж улс даяар зарлуулсан. МХЭХ улс орон даяар маш өргөн хэмжээний хэлэлцүүлгийг өрнүүлж аль болох олон бүс нутгийн засгийн газрын байгууллагууд, орон нутгийн байгууллагууд, ТББ-ууд, хувийн хэвшил болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаас саналыг нь авсан. 4,000 гаруй санал ирсэн бөгөөд саналуудыг хураангуйлан нэгтгэсэн. Хөтөлбөрийн илүү нарийвчилсан хэсэгт (жишээлбэл худалдан авалт, санхүүгийн данс, тооцоо, барилга, уул уурхайн салбар г.м) холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран холбогдох салбарын авлигын эрсдэлийн эсрэг арга хэмжээг боловсруулсан.

Засгийн газраас шинэ хөтөлбөрийг баталсаны дараа УИХ-ын хаврын чуулганаар батална. Монгол улсын эрх бүхий албан тушаалтнуудын хэлж байгаагаар шинэ хөтөлбөрийг буцаасан бөгөөд дахин өөрчлөлт оруулахаар Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн. Ажлын байран дээрх уулзалтын явцад үнэлгээчид Ерөнхийлөгч хөтөлбөрийн төслөөс онцгойлсон асуудалтай зүйл илрүүлсэн үү гэж асуухад ярилцагчдын зарим нь УИХ хөтөлбөрийн үндсэн мөн чанарыг хэлэлцээгүй, УИХ-ийн хэд хэдэн гишүүд АТГ-д шалгагдаж байгаа ба АТГ-ын эрх мэдлийг нэмэгдүүлэх аливаа зүйлийн талаар хэлэлцэхээс зайлсхийж байгаа гэж мэдэгдсэн юм.

АТГ-аас мөн улсын баруун болон зүүн хэсэгт бүс хариуцсан нэгж байгуулж, алслагдсан газруудад үүсэх авлигын асуудлыг илүү богино хугацаанд шийдвэрлэж байх хүсэлт гаргасан ч хүсэлтийг хэзээ ч зөвшөөрөөгүй. Монгол улс төсвийн хуваарилалтыг орон нутгийн засаг захиргаанд шилжүүлж байгаа учраас хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд АТГ болон түүний нэгжүүд илүү эрх мэдэлтэй болно гэсэн айдас эрх мэдэлтнүүдэд байсан.

Хөтөлбөрийн үндсэн зорилгыг Монгол улс олон улсын нийгэмлэгийн өмнө хүлээсэн авлигатай тэмцэх үүргээ биелүүлж, Монгол улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөж хэмээн тодорхойлсон байсан бөгөөд ардчилал болон эрх зүйт засаглалыг сайжруулж, нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, засгийн газар дахь олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх зэрэг зорилгууд хойгуур тавигдсан байсанд үнэлгээчдийн гайхширлыг төрүүлсэн. Учир нь энэ хөтөлбөрийн үндсэн сэдэл нь гадаад улсуудын шахалт бус, улс өөрийн авлигатай тэмцэж, үйл явцад хяналт тавих чин эрмэлзлэл байсан юм. Ерөнхийдөө зорилго болон зорилтуудыг тодорхойлсон хэсэг нь маш ерөнхий бөгөөд электрон үйлчилгээ нэвтрүүлэн, зохицуулалтыг сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг хүлээгдэж буй үр дүнд бус үйл ажиллагаанд төвлөрсөн байна.

Хөтөлбөрийн үндсэн чиглэлүүдэд: Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албаны байгууллагыг бэхжүүлэх, төсөв, санхүү, аудитын ил тод байдлыг хангах, худалдан авах ажиллагааны нээлттэй, үр ашигтай, шударга, ил тод байдлыг нэмэгдүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагуудын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, улс төрийн шударга байдлыг хангах, иргэний нийгмийг хөхиүлэн дэмжих, хэвлэл мэдээллийн

хэрэгслийн мэргэжлийн ёс зүйг сайжруулах, авлигатай тэмцэх боловсрол, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах. Гэсэн хэдий ч санал болгосон арга хэмжээнүүдийг муу бүтчилсэн (жишээлбэл төрийн үйлчилгээний шинэчлэл нь хувийн салбарынх байх г.м), зарим нь тодорхой биш, зарим нь хэтэрхий ерөнхий (жишээлбэл, баялагийн шударга хуваарилалтыг хангах, хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх) бөгөөд хэрэгжүүлэх хугацаа, хариуцсан байгууллага, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд байхгүй байна.

Хөтөлбөрт ТББ, эрдэмтэд, бизнесийн байгууллагууд хамрагдаж байгаа нь үнэлгээчдийн зүгээс сайшаалтай зүйл боловч эдгээр өөр өөр бүлгүүд хэрхэн хөтөлбөрт тусгагдсан (жишээлбэл, бизнесийн байгууллагуудыг бизнесийн ёс зүйтэй болгохын тулд бэлтгэж, ёс зүйн дүрэм баталж, мөрдүүлэх хэрэгтэй, нийгмийн хариуцлагыг сайжруулах, ТББ-ууд ёс зүйн дүрмийг мөрдөх, чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл бий болох г.м) холбогдох үйл ажиллагаагаа хийж байгааг засгийн газраас баталгаажуулах нь тодорхойгүй байна.

Авлигын эсрэг хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, хяналттай холбоотойгоор төсөлд улсын, орон нутгийн болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ гэж заасан нь эерэг заалт юм. УИХ болон өөр байгууллагын баталсан ямар ч хөтөлбөрт хэрэгжүүлэх механизмын тодорхой заагаагүй, эсхүл шаардлагатай санхүүжилтыг хэрхэн төвлөрүүлэхийг тодорхойлоогүй бол энэ хөтөлбөрийг хэн ч хэрэгжүүлэхийг хүсэхгүй бөгөөд эцэст нь хоосон мэдэгдэл, тунхаг болох магадлалтай байдаг.

Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн төслийг батлаагүй байгаа учраас хэрэгжүүлэх төлөвлөгөө нь тодорхой биш байна. Авлигын эсрэг хөтөлбөрийн төсөлд авлигын эрсдэл өндөртэй салбарын 9-11 төлөөлөгчдөөс бүрдсэн түр хороо байгуулна гэж заажээ. Хорооны гишүүдийг УИХ-аас томилно.

Харамсалтай нь үнэлгээний багт Улаанбаатар хотын эрх бүхий албан тушаалтнуудын ажлын байранд хийсэн уулзалтын явцад хэрэгжилтийн талаар ярилцаж, баримт цуглуулах боломж олдоогүй. Тиймээс Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй энэ стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө нь авлигатай тэмцэх чиглэлээр бодит үр дүнд хүрч байгаа эсэх, мөн бусад орон нутгийн удирдлагууд хэрэгжүүлэх жишиг болж чадах талаар үнэлгээний баг дүгнэлтэд хүрэх боломжгүй байна. Тиймээс Засгийн газарт Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй авлигын эсрэг баримт бичиг, хэрэгжилттэй дэлгэрэнгүй танилцаж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах зөвлөмж гаргаж байна.

**2) Засгийн газраас ангид бие даасан, авлигын эсрэг бодлогын зохицуулалт, хэрэгжүүлэлтийн үр нөлөө бүхий өндөр түвшингийн механизм (жишээ нь үндэсний зөвлөл) байгуулах шаардлагатай ба бүрэлдэхүүнд нь иргэний нийгмийн төлөөлөл оролцох ба чадварлаг ажиллагсадтай, зохих хөрөнгийн эх үүсвэртэй байх; авлигын эсрэг стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тогтмол гаргаж, нийтэд мэдээлж байх.**

Стратегийн төсөлд тусгасан хяналтын механизм нь тодорхой бус, мөн үр дүнгүй харагдаж байна. УИХ-ийн холбогдох хороо стратегийн хэрэгжилтийн тайланг шалгах хэрэгтэй. Ерөнхийлөгч болон түүний захиргаа стратегийн хэрэгжилтийг зохион байгуулах хэрэгтэй бөгөөд үүний тулд олон салбаруудын төлөөлөл бүхий түр хороо байгуулах хэрэгтэй. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс (Ерөнхийлөгч, Ерөнхий Сайд болон УИХ-ын Даргаас бүрдсэн 3 гишүүнтэй зөвлөл) энэ хороог дэмжих хүлээлттэй байна. Мөн Засгийн газраас бүх хэсгүүдэд гүйцэтгэлийн нэгдсэн удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хэд хэдэн төрийн байгууллагууд удирдах дээд байгууллагадаа (Ерөнхийлөгч, Засгийн газар болон УИХ) стратегийн хэрэгжилтийн талаар тайлагнана. Ажлын хэсэг эсхүл түр хороо

эдгээр тайлангуудыг нэгтгэж өөрийн үнэлгээ, зөвлөмжийн хамт УИХ-д танилцуулна.

Үндэсний Зөвлөл шиг ижил төрлийн дээд түвшний механизмтай болохыг санал болгож байна. Эрх бүхий байгууллагуудын мэдэгдсэнээр Үндэсний Зөвлөл 2002 оноос 2010 оны авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хяналтыг хэрэгжүүлж байсан. АТГ хэмээн тусгай байгууллага байгуулсаны дараа улсын авлигатай холбоотой асуудлыг хариуцаж ажиллах зохих эрх бүхий байгууллага болсон учраас Үндэсний Зөвлөлийн энэ үүргийг цуцалсан.

Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлж, хэрхэн хяналт тавих талаар тодорхой болгоогүй байгаа нь үнэлгээний багт харамсалтай байна. Тиймээс үнэлгээний багаас өмнө дурдсан зөвлөмжийг дахин гаргаж байна. Монгол улсын авлигын эсрэг хүчин чармайлттай уялдах дээд түвшний механизм бүрдүүлэх хэрэгтэй бөгөөд энэ нь бие даасан, үр дүнтэй арга хэмжээ авахын тулд засгийн газраас хараат бус байх хэрэгтэй. Авлигын эсрэг арга хэмжээ явуулахын тулд шаардагдах санхүүжилт төвлөрөөгүй тохиолдолд санхүүжилтыг бий болгох явцыг түргэсгэж, шүүмжлэлтэй хандах хэрэгтэй. Түүнчлэн олон нийтийн дуу хоолойг хүргэх иргэний нийгмийн гишүүдийн оролцоотой байх хэрэгтэй. Мөн энэ нэгж нь шийдвэртэй алхам хэрэгжүүлэх, хэрэгжүүлэлтийн хугацаа, асуудалд хандах, асуудлыг тодорхойлох мөн залруулах арга хэмжээ авч, зөвлөмж гаргах зэргээр үйл ажиллагаа явуулах хангалттай санхүүжилт, хүнийн нөөцийн чадамжтай байх нь чухал юм. Хяналтын байгууллагын хувьд энэ байгууллага нь шийдвэртэй үр дүнд хүрч, үүний талаар олон нийтэд ойлгомжтой, цаг хугацаа алдалгүй хүргэдэг байх хэрэгтэй. Үнэлгээний баг ярилцлага хийх явцад дараах мэдэгдлийг сонсож байсан: Хэдийгээр засгийн газрын хэд хэдэн байгууллагууд мэдээллийн олон нийтэд нээлттэй гаргадаг боловч мэдээлэл нь ихэвчлэн ойлгомжгүй, ойлгоход хүндрэлтэй, шинжилгээ хийгээгүй эсхүл ямар үр дүнд хүрсэн талаар тайлбарладаггүй. Үнэлгээний багийн бодлоор олон нийтэд хүргэж байгаа мэдээлэл нь ил тод, ойлгомжтой, ач холбогдолтой мөн ойлгоход хялбар байх хэрэгтэй юм.

### ***3) Авлигад өртөх эрсдэл өндөр салбаруудын авлигын эсрэг стратеги буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах асуудлыг анхаарах.***

Өнөөг хүртэл салбарын төлөвлөгөөг боловсруулаагүй байна. Мөн хөтөлбөрийн төсөлд ч энэ төрлийн төлөвлөгөө боловсруулах талаар дурдаагүй байна. Эрсдэлийн үнэлгээнд дурдсан салбарууд, жишээлбэл эрүүл мэнд, боловсруул, татвар, хянан шалгалт, гааль, орон нутгийн удирдлага, газар өмчлөл, лиценз зэрэгт зориулсан тусгай үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах нь эерэг нөлөөтэй байх болно.

Зөвлөмжид тусгасны дагуу салбарын төлөвлөгөөг боловсруулаагүй боловч АТГ-аас салбарын судалгаанд үндэслэн хэд хэдэн алхмуудыг авч хэрэгжүүлсэн. Жишээлбэл, “Бие даасан судалгааны байгууллага” ТББ-ын хийсэн “Эрүүл мэндийн салбарын авлига” судалгааны үр дүнд тулгуурлан Азийн Сантай хамтарч АТГ аймгуудын 9 эмнэлэг, нийслэлийн 8 эмнэлэг, дүүргүүдийн 4 эмнэлэгт авлигын эсрэг хяналт, мөн хэрхэн урьдчилан чиглэлээр сургалт зохион байгуулж эмнэлэгийн байгуулсан 5 гэрээг, 6 журмыг хүчингүй болгож, 4 ажилтанд хариуцлага тооцож, удирдлагуудад зөвлөмж гаргасан.

Мөн Монгол улсад олон чанартай судалгаа хийгддэг бөгөөд зарим нь 2006 оноос хойш тогтмол хийгдсээр байгаа нь улсын авлигын нөхцөлд харьцуулсан шинжилгээ хийх нөхцөлийг бий болгож байгааг дурдах хэрэгтэй. Ялангуяа Азийн сангийн санхүүжилттэй Авлигын талаарх олон нийтийн ойлголт болон мэдлэг тогтоох судалгаа болон бусад судалгаануудад авлигад хамгийн их өртсөн нэгжүүдийг тодорхойлсон байна. Монгол улсын хүн амын хувьд авлигад дараах байгууллагууд хамгийн өртөмтгий болохыг тогтоосон: газар ашиглалт хариуцсан албан тушаалтнууд, гааль болон уур уурхай хариуцсан албан

тушаалтнууд, шүүгчид, засгийн газар болон УИХ. Иргэдийн зүгээс өнгөрсөн 10 жилд үүссэн хамгийн санаа зовоосон асуудлуудыг тодорхойлсон боловч яагаад шийдвэрлэх арга хэмжээ аваагүй нь тодорхой биш байна.

Үнэлгээний баг зөвлөмжийн энэ хэсэгт зохих анхаарал хандуулна гэдэгт итгэж байна. Учир нь ямар ч улсын хувьд авлигад хамгийн өртөмтгий хэсгүүддээ хэмжигдэхүйц, үр дүнтэй алхам хэрэгжүүлж, хамгийн ач холбогдолтойгоос нь эхлэх нь чухал байдаг. Ач холбогдолыг тодорхойлолгүйгээр Монгол улс авлигатай тэмцэхийн тулд өөрийн нөөц боломжоо хаана, юу хийхэд төвлөрүүлэх шаардлагатай гэдэг чиглэлээ алдана. Монгол улсын эрх бүхий байгууллагууд орон нутгийн засаг, захиргаа болон бусад оролцогчдыг оролцуулж авлигад өртөж болох онцгой хэсгүүдэд шийдвэртэй алхам авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

### *Дүгнэлт*

Монгол улс авлигатай тэмцэх шинэ хөтөлбөр батлаагүй бөгөөд яригдаж байгаа төсөл нь хэрэгжүүлэлтийн хувьд сул, хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаагүй байна. Түүнчлэн бодлогын уялдааг хангах дээд түвшний механизм байхгүй хөтөлбөрийн төсөлд ч ийм механизм оруулаагүй байна. Хэдийгээр өмнө нь хөтөлбөрийн талаар олон нийтийн дунд ярилцлага хийсэн ч УИХ шинэ хөтөлбөрийг батлах эсэх талаар тодорхой байдалгүй байсаар үйл явц тасалдсан байна.

Монгол улс Зөвлөмж 1.1. – 1.2. –ийг **хэрэгжүүлээгүй** бөгөөд зөвлөмж хүчинтэй хэвээр байна.



### 1.3. Авлигын талаарх судалгаа

#### Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 1.3.

- 1) *Авлигын судалгааг үргэлжлүүлэн тогтмол хийж байх, судалгааг тодорхой салбаруудад олон нийтийн итгэл, авлигын нөхцөл байдал ба туршлагад төвлөрүүлэх. Судалгааны тодорхой хэсгийг өрсөлдөөнт шалгаруулалтаар сонгосон бие даасан байгууллагуудаар хийлгэх.*
- 2) *Судалгааны үр дүнг авлигын эсрэг бодлого боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах болон хэрэгжилтэд хяналт тавих ажилд ашиглах. Судалгааны үр дүнг олон нийтэд мэдээлэх.*

Монгол улсын эрх бүхий байгууллагууд 2014 онд АТГ улс төр, хууль хяналтын байгууллагууд болон засгийн газрын байгууллагуудын (боловсрол, эрүүл мэнд, бүртгэл, цагдаа, гааль, татвар, нийгмийн халамж, даатгал, мөрдөн байцаах, газрын алба зэрэг 10 салбарын байгууллагуудад) мөн хүүхдийн шударга байдлын түвшинд судалгаа хийсэн гэж мэдэгдсэн. Мөн АТГ 2015 онд Монголын Авлигын Индекс, Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээндэх авлигын талаарх төсөөллийн судалгаа болон Хүүхдийн шударга байдлын судалгаа хийхээр төлөвлөж байна. Энэхүү судалгааг Үндэсний Статистикийн Хороотой хамтран хийх юм.

Монгол улсын авлигын индексийг эцсийн байдлаар дуусгасан даруйд жил бүрийн 12 сарын 9-нд олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад сувгаар дамжуулан нийтэлдэг. Тайлангуудыг мөн биет байдлаар хэвлэж, электрон хувилбарыг АТГ-ын веб хуудсанд байршуулж, CD-гээр мөн тараадаг.

Тухайлсан салбарт явуулсан судалгааг жишээ болгон авбал, АТГ-н Урьдчилан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэс 2014 оны үйл ажиллагааны тайландаа АТГ болон IRIM бие даасан судалгааны байгууллага хамтран эрүүл мэндийн салбарын авлигын түвшинд судалгаа хийсэн бөгөөд Нийслэлийн Эрүүл Мэндийн Газартай хамтран судалгааны явцад илэрсэн зөрчлүүдийг арилгах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргахаар ажиллаж байна гэжээ.

АТГ 2013 болон 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө мөн АТГ нь Трансперенси Интернешнл, Глоб Интернэйшинл, IRIM, Пресс Институт, Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо, Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн болон бусад ТББ-тай ойлголцлын санамж бичиг зурсанаа дурдсан байна. Хамтарсан үйл ажиллагааны хүрээнд гарын авлага бэлтгэх, сургалт явуулах болон олон нийтийн судалгаа хийх зэрэг орсон байна.

Монголын эрх бүхий байгууллагуудын хэлж байгаагаар холбогдох мэргэжилтнүүдтэй зарим ТББ-уудыг Хүүхдийн шударга байдал зэрэг судалгаа авахад томилдог. Учир нь эдгээр байгууллагууд илүү бүтээлж болон шинэлэг санаатай байдаг гэжээ.

Бусад судалгаануудыг дурдвал: АТГ-ын санхүүжилтээр “Сонгогчдын боловсрол төв” ТББ-аас “Сонгуулийн санхүүжилт: Сорилт ба арга зам” судалгаа хийсэн. Судалгаа нь сонгуулийн санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулахад зөвлөмж гаргах зорилготой байсан. Судалгааны дараа УИХ-ын холбогдох хороо, АТГ болон “Сонгогчдын боловсрол төв” ТББ хамтран 2015 оны 5 сард энэ сэдвээр олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлсэн. АТГ-ын мэдээлж байгаагаар шинэ Сонгуулийн тухай хуулийн төсөл болон шинэ Улс төрийн намын тухай хуулийн төсөлд судалгааны үр дүнг тусгасан байна.

АТГ мөн “Үндэсний Аюулгүй Байдал Ба Өндөр Түвшний Авлига” сэдэвтэй судалгаа явуулсан. 2014 оны 11 сард УИХ-ын Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо, АТГ, Азийн сан хамтран “Авлига үндэсний аюулгүй байдлын заналхийлэл” сэдэвтэй хэлэлцүүлгийг өрнүүрж оролцогчдын санал, зөвлөмжүүдийг нэгтгэсэн.

АТГ-ын үйл ажиллагаанд тусгагдсан сургалт, судалгаа хийх төлөвлөгөө нь тусдаа санхүүжилттэй байдгийг дурдах хэрэгтэй. Монгол улсын Авлигын эсрэг хуулийн 15.2-р зүйлд зааснаар АТГ Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэсийн харьяа Судалгаа, шинжилгээний хэлтэсийг байгуулсан. Хэлтэс урьдчилан сэргийлэх, боловсрол, судалгаа хариуцсан 15 ажилтай.

Ерөнхийдөө Монгол улс Азийн сан болон АНУ-ын олон улсын департаментийн агентлаг, МерсиКорп болон бусад олон улсын хандивлагч байгууллагуудын хамтын санхүүжилттэй зорилтот бүлгийг чиглэсэн цогц, харьцуулсан судалгаанаас ихээхэн ашиг тус олж авдаг. Эдгээр судалгааны заримыг хагас жил тутам явуулдаг бөгөөд хэд хэдэн салбаруудын авлигын талаарх төсөөлөл, туршлага хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар маш тодорхой зураглал бий болгодог.

Авлигын талаар маш олон судалгаа ойр ойрхон хийгддэгт үнэлгээчид сайшаалтай хандаж байсан. Энэ туршлагыг бусад улсуудад ч мөн жишиг болгох нэвтрүүлэх хэрэгтэй. Гэсэн хэдий ч судалгааны үр дүн засгийн газрын төлөвлөгөөнд буухгүй байна. Ажлын байран дээр хийсэн ярилцлагын явцад Монголын эрх бүхий албан тушаалтнууд зарим судалгааны үр дүнг (жишээлбэл: Авлигын индекс болон Дэлхийн Авлигын хэмжүүр г.м) үндэсний стратегийг төсөл эсхүл орон нутгийн байгууллагын стратегид тусгасан, гэхдээ шууд холбоосыг олоход амаргүй гэж байсан юм. Мөн эрх бүхий албан тушаалтнуудын хэлж байгаагаар тухайлсан салбарын судалгааг холбогдох засгийн газрын байгууллага хийдэг. Мөн түүнчлэн судалгааны үр дүнг Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд гүйцэтгэлийн түвшинг сайжруулах зорилгоор Монголын эрх бүхий байгууллагууд авч ашигладаг хэмээн дурдаж байсан.

Нөгөө талаас гаалийн газарт мэдээллэснээс үүдэж авлигын асуудалтай холбоотойгоор даруй авсан арга хэмжээ нь “ил тод байдлыг нэмэгдүүлэх мөн аргачлалыг сайжруулах” судалгаа явуулсан байдал нь үнэлгээчдийг ихээхэн төөрөгдөлд оруулсан. Шинэ судалгаа явуулах, эсхүл аргачлалд өөрчлөлт оруулах нь тухайн нөхцөлд авлигатай тэмцэх үр дүнтэй арга эсэхийг үнэлгээчид гайхаж байсан юм. Үүнээс гадна бусад ярилцагчдын гомдоллож байснаар эрх мэдэлтнүүд авлигын тал дээр “ам дагуулж” байгаа бөгөөд бодит байдалд юу ч өөрчлөгдөөгүй гэж байсан юм. Аль ч тохиолдолд нөхцөл байдлыг өөрчлөхийн оронд зөвхөн үнэлэх байдалд хэт анхаарч байгаа нь авлигын асуудалд олон нийтийн итгэлийг алдах магадлалтай.

### *Дүгнэлт*

Монгол улс авлигын судалгааг ойр ойрхон явсан хэвээр байна. Засгийн газраас санаачлан олон судалгаа хийдэг бөгөөд хэд хэдэн ТББ –ууд ч судалгааны ажилд ихээхэн оролцдог. Судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн хэвлэж, авлигатай тэмцэх хөтөлбөрийн төсөлд дурдсан байгаа. Гэвч авлигын өндөр эрсдэлтэй салбарууд гэх мэт судалгааны үр дүнг хөтөлбөрт хөндөөгүй бөгөөд бодлогын цаашид ямар алхам авч хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Тиймээс чанартай хийгдсэн олон тооны судалгаануудад дурдагдсан асуудлуудыг хэрхэн арилгах талаар шийдвэртэй, үр дүнтэй алхам хийгдэхгүй байна. Авлигын эсрэг судалгаа нь зорилго бол тодорхойлогдохоос илүүтэйгээр эдгээр судалгаанууд нь Монгол улсын авлигын

нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх авлигын эсрэг бодлого боловсруулж, батлахад чухал хэрэгсэл болох юм.

Ерөнхийдөө, Монгол улс Зөвлөмж 1.3-г **хэсэгчлэн биелүүлсэн** бөгөөд зөвлөмж хүчинтэй хэвээр байна.

## **1.4.-1.5. Авлигын эсрэг олон нийтийн оролцоо, соён гэгээрүүлэх ба олон нийтийн боловсрол**

*Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 1.4.-1.5.*

- 1) Соён гэгээрүүлэх болон олон нийтийн мэдлэг боловсролын ажлыг чамбай төлөвлөж, авлигын эсрэг хөтөлбөрт заасан зорилтуудтай нягт уялдуулах; зорилтот бүлэг, гол асуудал болон гарах үр дүнг нарийвчлан тодорхойлох.*
- 2) Соён гэгээрүүлэх болон олон нийтийн мэдлэг боловсролын үйл ажиллагааны үр дүнд тогтмол үнэлгээ хийж байх, хөндлөнгийн бие даасан үнэлгээ хийлгэх асуудалд анхаарах.*
- 3) Иргэний нийгэм, ТББ бусад байгууллагын төлөөллийг авлигын эсрэг бодлогын арга хэмжээг боловсруулахад бодитой татан оролцуулах, үүнд соён гэгээрүүлэх, олон нийтийн мэдлэг боловсролын ажлыг боловсруулах, хэрэгжүүлэх болон үнэлгээний ажил хамрагдана.*

*1) Соён гэгээрүүлэх болон олон нийтийн мэдлэг боловсролын ажлыг чамбай төлөвлөж, авлигын эсрэг хөтөлбөрт заасан зорилтуудтай нягт уялдуулах; зорилтот бүлэг, гол асуудал болон гарах үр дүнг нарийвчлан тодорхойлох.*

Хяналтын асуултын хариулт болгож Засгийн газраас 2014 оны 4 сараас хойш олон нийтэд чиглэсэн хоёр ажиллагаа явуулсан байна: (а) Улаанбаатар хотын төрийн албан хаагчдад зориулан зохион байгуулсан “Хамтдаа” арга хэмжээ (б) 2014 онд Эрдэнэт хотод зохион байгуулсан “Шударга нийгмийн төлөө хамтдаа” арга хэмжээ. “Шударга нийгмийн төлөө хамтдаа” хоёрдахь арга хэмжээг Улаанбаатар хотод 2015 оны 9 сараас 12 сарын хооронд зохион байгуулахаар төлөвлөсөн байна. АТГ эдгээр нийтийн арга хэмжээг ажлын хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн бөгөөд зорилтот бүлэг болон үйл ажиллагаа нь тодорхой байсан. Монголын эрх бүхий албан тушаалтнууд хэлэхдээ АТГ 1 жилд 62 сая төгрөгийг (ойролцоогоор 28,650 евро) авлигын эсрэг аян болон соён гэгээрүүлэх арга хэмжээнд зарцуулдаг. Үүнээс гадна ТББ-уудаар дамжуулан олон улсын хандивлагч байгууллагууд АТГ-г аян хийх, гарын авлага бэлтгэх, телевизийн хөтөлбөр болон бусад дүрсжүүлсэн материал бэлтгэхэд тусалдаг.

*2) Соён гэгээрүүлэх болон олон нийтийн мэдлэг боловсролын үйл ажиллагааны үр дүнд тогтмол үнэлгээ хийж байх, хөндлөнгийн бие даасан үнэлгээ хийлгэх асуудалд анхаарах.*

2014 оны 7 сард “Хэвлэлийн Хүрээлэн” ТББ АТГ-ын урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх болон харилцах үйл ажиллагаанд үнэлгээний тайлан бэлтгэсэн. Энэхүү тайланг Азийн сангаас санхүүжүүлсэн.

Үнэлгээний тайлан дараах үр дүнд хүрсэн:

- АТГ-ын Урьдчилсан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэсийн 15 ажилтны 6 нь л авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Ийм цөөн тооны ажилчид Монгол улсын алслагдсан бүсүүдэд хүрч, хийгдэх шаардлагатай ажлыг бүрэн биелүүлэх боломжгүй байна;

- АТГ-ын урт болон богино хугацааны хоёр төлөвлөгөө олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх системчилсэн аргачлалаар дутмаг бөгөөд үйл ажиллагааны үр дүн тодорхой биш байна;
- Гаргаж буй тайлангуудын зорилго нь удирдлагад зөвхөн одоог хүртэл ямар байгааг бус энэхүү дутагдалыг хэрхэн арилгахад чиглэх хэрэгтэй;
- Хэлтэсийн хийх сургалт болон хэвлэмэл материалууд нь илүү ойлгомжтой бөгөөд төрийн албан хаагчдыг бус олон нийтэд чиглэх хэрэгтэй. Одоогийн байдлаар сургалтыг лекц хэлбэрээр оролцох боломжтой аль болох олон хүнд (ойролцоогоор 50-100 хүнд) хийдэг бөгөөд сургалтыг хэлбэрийг илүү анхаарал татахуйц байдлаар өөрчлөх хэрэгтэй.

Ажлын байран дээр хийсэн уулзалтын үеэр АТГ 2012 оноос хойш нийт 120 гаруй засгийн газрын байгууллагуудад (ил тод шийдвэр гаргалт, сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжүүлэлт, мэдээллийн тухай хуулийн эрх, шилэн дансны тухай хуулиар) авлигын эсрэг ажлын үнэлгээ хийсэн болохыг үнэлгээний багт мэдэгдсэн. Үнэлгээг ихэнх тохиолдолд АТГ-ын боловсруулсан аргачлалын дагуу хуулийн фирм хийдэг. АТГ-ын Урьдчилан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэс-тэй хамтран хуулийн фирмүүд авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ өгөхийн тулд Өмнөд Солонгос улсаас авсан аргачлалын дагуу шалгах хуудас бэлтгэдэг. Энэхүү баталгаажуулах аргачлалын зорилго нь мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг бий болгож, олон нийтийн оролцоог дэмжиж, шударга байдлыг нэмэгдүүлэх боломжийг бий болгож, төрийн эрх бүхий байгууллагуудаар өөрсдийн үйлдлийн хариуцлагыг хүлээлгэх зэрэг болно. Үнэлгээний үр дүнг гаргасны дараа АТГ үр дүнд тулгуурлан төрийн байгууллагуудад холбогдох зөвлөмжийг өгдөг.

Эдгээр үнэлгээнүүд нь сайн зүйл юм. Засгийн газрын байгууллагуудын нээлттэй, ил тод байдлыг үнэлэх аргачлал нэвтрүүлсэн, мөн АТГ-ын соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гадны үнэлгээ хийж эхэлсэн зэрэгт Монгол улсын эрх бүхий байгууллагуудыг сайшаах хэрэгтэй. Мөн түүнчлэн илэрсэн бүх сул тал болон эмзэг байдлыг харгалзан үзэж, нөхцөл байдлыг залруулах арга хэмжээ авах нь чухал юм.

***3) Иргэний нийгэм, ТББ бусад байгууллагын төлөөллийг авлигын эсрэг бодлогын арга хэмжээг боловсруулахад бодитой татан оролцоулах, үүнд соён гэгээрүүлэх, олон нийтийн мэдлэг боловсролын ажлыг боловсруулах, хэрэгжүүлэх болон үнэлгээний ажил хамрагдана.***

Өмнө дурдсаны дагуу Монгол улсын эрх барих байгууллагууд ТББ, орон нутгийн холбоод, ХАҮТ, Хөдөлмөрийн Эвлэл болон олон улсын оролцогч талуудтай хийсэн ойлголцлын санамж бичгийн урт жагсаалт байгаа талаар үнэлгээчдэд хэлсэн. Монгол улсад ойролцоогоор ямар нэг байдлаар авлигын эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 20 ТББ байдаг талаар үнэлгээчдэд мөн дурдсан. Зарим ТББ-ууд нь улс төрийн эрх, оролцоотой байдаг учраас АТГ улс төрийн нэмэлт дарамтаас зайлсхийхын тулд эдгээр ТББ-аас татгалздаг.

Мөн түүнчлэн олон аянг орон нутгийн түвшинд зохион байгуулдаг бөгөөд ТББ-ууд алслагдсан бүс нутагт хүрч ажиллах талаар илүү идэвхтэй, тусламж, дэмжлэг үзүүлдэг. Монголын эрх бүхий байгууллагууд мөн авлигын эсрэг үйл ажиллагааны тогтмол үнэлгээний аргачлалаар засгийн газрын байгууллагууд ТББ-тай идэвхтэй хамтын ажиллагаа байхгүй тохиолдолд АТГ-ын Урьдчилан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэс хасах үнэлгээ өгдөг. Энэ туршлага нь эерэг зүйл юм.

Төрийн бус байгууллагуудын ярилцагчид засгийн газар авлигын эсрэг болон бусад чиглэлд иргэний нийгэмтэй хамтарч ажиллах тал дээр шүүмжлэлтэй байдаг талаар дурдсан. Ярилцагчдын зарим нь иргэдийн жинхэнэ оролцоо байхгүй болсон бөгөөд 2012 оноос хойш байнга муудаж байгаад нь ихээхэн сэтгэл дундуур байгаагаа хэлж байсан юм. ТББ-ууд энэ хоосон орон зайг нөхөх гэж оролдож байгаа боловч амжилтанд хүрэхгүй байна. Энэ байдлыг ч шинэ авлигын эсрэг үндэсний хөтөлбөрөөс харж болно: энэ хөтөлбөрт оролцоог чухалчлаагүй бөгөөд төслийн эцсийн хувилбарыг л олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Үндэсний хэлэлцүүлгийн аянг ТББ-р хийлгэсэн нь эерэг алхам боловч үр дүнд нь бий болсон төслийг Ерөнхийлөгчийн тамгын газар хүлээн авахаас татгалзсан. Хожим нь Ерөнхийлөгчийн дэвшүүлснийг хууль тогтоох байгууллага хүлээн авахаас татгалзсан. Үр дүнтэй хамтын ажиллагааны бас нэгэн саад нь мэдээллийн хүртээмжтэй байдлын хязгаарлалт болоод байна.

### *Дүгнэлт*

Харьцангуй богино хугацаанд АТГ хоёр олон нийтийг хамарсан арга хэмжээ зохиосон бөгөөд дахин нэгийг зохиох төлөвлөгөөтэй байгаа нь амжилт юм. Эдгээр аяны зорилтот бүлэг нь хүн амын дийлэнх хувийг эзэлж байгаа залуу иргэд болон хотуудын төрийн албан тушаалтнууд юм. ТББ-тай хамтын ажиллагаатай байгаа нь сайн бөгөөд цаашид ч хөгжүүлэх хэрэгтэй.

Монгол улс Зөвлөмж 1.4.-1.5. –ийг Урьдчилан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэс бөгөөд зөвлөмж хэвээр байна.

## **1.6. Авлигын эсрэг тусгай бодлого болон уялдуулан зохицуулах байгууллагууд**

### **Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 1.6.**

- 1) Институци, эрхлэх ажил үүрэг, санхүүгийн бие даасан байдлыг баталгаажуулах замаар авлигын эсрэг мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх; дээрээс ирэх шахалт, авлигыг мөрдөн шалгах болон яллах ажиллагаанд хэтэрхий хөндлөнгөөс оролцох явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй механизмыг бий болгох; АТГ-ын үйл ажиллагааг бүсүүдэд бэхжүүлэх, тухайлбал газрын салбар албадыг орон нутагт байгуулах асуудлыг анхааралдаа авах.**
- 2) Авлигын мэргэшсэн байгууллагын дарга, дэд дарга нарыг өрсөлдөөнт, ил тод, үр чадварт суурилсан зарчмаар сонгон шалгаруулдаг болох; агентлагийн ажилтнуудыг үр чадварт суурилсан, өрсөлдөөнт шалгаруулалтаар авч ажиллуулах тодорхой шалгуур, журмыг тогтоон хэрэгжүүлэх.**
- 3) Жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах асуудлуудыг ач холбогдлоор нь эрэмблэх, төлөвлөгөөнд тусгаж байгаа ажлуудын агуулга, зорилт, гарах үр дүн, хугацааг нарийвчлан тодорхойлох, төлөвлөгөөний хэрэгжилт болон гүйцэтгэлд хяналт тавих, хэмжиж болох үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх асуудалд гол анхаарал хандуулах замаар Авлигатай тэмцэх газрын жилийн ажлын төлөвлөлтийг сайжруулах.**

**1) Институци, эрхлэх ажил үүрэг, санхүүгийн бие даасан байдлыг баталгаажуулах замаар авлигын эсрэг мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх; дээрээс ирэх шахалт, авлигыг мөрдөн шалгах болон яллах ажиллагаанд хэтэрхий хөндлөнгөөс оролцох явдлаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй механизмыг бий болгох; АТГ-ын үйл ажиллагааг бүсүүдэд бэхжүүлэх, тухайлбал газрын салбар албадыг орон нутагт байгуулах асуудлыг анхааралдаа авах.**

Авлигатай Тэмцэх Газар Монгол улсын авлигын эсрэг цогц үйл ажиллагаа явуулж буй ганц байгууллага юм. Үнэлгээний тайланд дурдсанаар Авлигын эсрэг хуулийн 15-р зүйлд Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэгтэй байгууллага хэмээн тодорхойлсон байдаг.

Эрүүгийн Байцаан Шийтгэх Хуулийн (ЭБШХ) 26 болон 27-р зүйлд зааснаар АТГ нь ЭБШХ-ийн 263-р зүйл (Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах), 264 (Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх), 265 (Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах), 266 (Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх), 268 (Хээл хахууль авах), 269 (Хээл хахууль өгөх), 270 (Хээл хахууль зуучлах), 270<sup>1</sup> (Хууль бусаар хөрөнгөжих) болон 166 (Татвар төлөхөөс зайлсхийх)-тэй холбогдсон хэргийг мөрддөг.

Ажлын байранд хийсэн уулзалтаар Монголын эрх бүхий албан тушаалтнууд АТГ хэргийн

хэлбэр, цар хүрээнээс үл хамааран авлигатай холбоотой бүх хэрэгт шалгалт хийдэг хэмээн үнэлгээчдэд хэлсэн. Мөн цагдаагийн байгууллага авлигын хэрэг илрүүлсэн тохиолдолд мөн хэргийг АТГ-т шилжүүлдэг.

АТГ энэхүү өргөн цар хүрээтэй эрх мэдлээ хэрэгжүүлэхийн тулд нийт 162 ажилтантай (2014 онд 192 байсан) бөгөөд үүний 30 нь хянан шалгагч юм. Эрүүгийн Байцаан Шийтгэх Хуулийн 2014 оны 5 сарын 20-нд хүчин төгөлдөр болсон 2014 оны 1 сарын нэмэлт найруулгаар Улсын Ерөнхий Прокурорын Газрын хууль, хяналтын ажилтнууд, шүүгчид болон прокурорын авлигатай холбоотой хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй байсан Мөрдөн Шалгах Хэлтэсийг АТГ-т шилжүүлсэн. найруулгаар Улсын Ерөнхий Прокурорын АТГ-ын мөрдөн шалгах үйл ажиллагааг хянах үүрэг хэвээр үлдсэн.

Авлигын эсрэг хуульд зааснаар АТГ нууц үйл ажиллагаа явуулах ихээхэн эрх мэдэлтэй. Энэ тайланд дурдсанаар АТГ-ын зарим нэг мөрдлөг нь хүний эрхийг зөрчиж байна гэсэн шүүмжлэл дагуулсан. Хэдийгээр ажлын байранд хийсэн ярилцлагын явцад энэ мэдэгдэлтэй холбоотой нотлох баримтыг үзүүлээгүй ч бусад улсуудад ч байдаг нууц үйл ажиллагаа явуулдаг хууль сахиулах байгууллагуудын эрх мэдлээс гадна АТГ аж ахуйн нэгж, байгууллагад (Авлигын эсрэг хуулийн 24.1.3-р зүйл) урьдчилсан тусгай зөвшөөрөл авалгүйгээр шалгалт хийж, үйл ажиллагааг түр зогсоож, банкны данс, иргэний болон бизнес, аж ахуйн нэгжийн гүйлгээг зогсоох (тухайн хуулийн 24.1.4) эрхтэй. Ажлын байранд хийсэн уулзалтаар яагаад энэ үйл ажиллагаа нь бизнес, аж ахуйн нэгжид чиглэгдсэн, мөн яагаад шүүхээс тусгай зөвшөөрөл авах хэрэггүй байдаг талаар тайлбар өгөөгүй.

АТГ-ын санхүүгийн бие даасан байдлын хувьд Монголын эрх бүхий албан тушаалтны мэдэгдсэнээр байгууллагын жилийн төсөв ойролцоогоор 4.1 сая евро байдаг бөгөөд төсвийн хэмжээнд хууль тогтоох байгууллага баталгаа гаргасан байна (Авлигын эсрэг хуулийн 29.3-р заалт). Хуульд зааснаар тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглосон. Харин Хуулийн 29.6-р зүйлд АТГ-ын ажилтнуудын цалин, нэмэгдэл, урамшууллын хэмжээг УИХ-с тогтооно гэж заасан учраас санхүүгийн хямралтай холбоотойгоор АТГ-ын ажилчдын цалинг бусад төрийн албан хаагчид, прокурор болон шүүгчдийн адил хассан байна. Монголын эрх бүхий байгууллагуудад энэ асуудлыг анхаарч үзэж, хэрвээ АТГ-ын цалинг хасах тохиолдолд шударга байдлын зарчмыг баримталж төрийн албан хаагч, прокурор, шүүгч, Засгийн газар болон УИХ-ын гишүүд зэрэг бусад төсвийн ажилчдын цалинг мөн хасах хэрэгтэй гэсэн зөвлөмж гаргасан.

Эрх бүхий байгууллагын мэдэгдэж байгаагаар АТГ-ын ажилчдын цалин харьцангуй өндөр бөгөөд төрийн албан хаагчдын цалингаас 25-30 хувь илүү (Шүүгчдийн цалинтай харьцуулахад 50%-аар бага юм). АТГ-ын ажилчдын сарын дундаж цалин 900,000 төгрөг (ойролцоогоор 450 евро) бөгөөд Монгол улсын сарын цалингийн доод түвшин 350,000 төгрөг (ойролцоогоор 175 евро) юм.

АТГ-ын ажилчдын урсгалын хувьд бусад төрийн байгууллагатай харьцуулахад харьцангуй тогтвортой боловч засгийн газрын агентлаг эсхүл яамны удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд дээд албан тушаалнаас эхэлж дахин томилгоо хийгддэг. Ажлын байранд хийсэн ярилцлагын явцад Засгийн газрын агентлагийн эсхүл яамдын хуучин болон шинэ удирдлагын улс төрийн намын харьяаллаас үл хамааран төрийн албаны ажилтныг бүхлээр нь сольдог хэмээн мэдэгдсэн. Харин энэ байдал нь АТГ-т хамааралгүй гэсэн боловч зарим ярилцагчид эсрэгээр нь хэлж байсан.

Өмнөх үнэлгээний тайлангаас хойш АТГ-ын бие даасан байдалтай холбоотой зохицуулалтын өөрчлөлт хийгдээгүй байна. Авлигын эсрэг хуулийн 17-р зүйлд ямар ч өөрчлөлт ороогүй нь үнэлгээчдэд харамсалтай байсан. Хуулийн 17-р зүйлд УИХ АТГ-ын



ажилтан болон байгууллагын бүтэцийг батална гэж заасан байдаг. УИХ-д энэ хэмжээний эрх мэдэл олгож, мөн Хуулийн 15.3-р зүйлд зааснаар байгууллагын татан буулгах эрхтэй байгаа нь АТГ аливаа улс төрийн нөлөөгүй бие даан үйл ажиллагаа явуулахад маш том эрсдэл болж байна.

Ярилцагчид мөн байгууллагын дарга бүх ажилчдыг томилдог бөгөөд ур чадварт суурилсан зарчим үйлчилдэггүй талаар дурдаж байсан. Ажилчдын олонхыг бусад хууль, хяналтын байгууллагаас (цагдаа, аюулгүйн алба г.м) шилжүүлэн ажиллуулдаг нь бие даасан байдалд нөлөөлж байна.

Хэдийгээр өргөн эрх мэдэлтэй, тусгай чиглэл бүхий байгууллага байгуулсан нь авлигын эсрэг хийж байгаа дэвшилтэт зүйл мэт боловч, зарим улстай адил, АТГ улсын авлигатай холбоотой бүх тохиолдолд хүрч ажиллаж чадахгүй учраас энэ сорилт нь АТГ дангаар шийдвэрлэн ажиллахад хэтэрхий том байна. Түүнчлэн АТГ-ын гүйцэтгэх үүрэг, хариуцлага хэтэрхий их учраас тухайн асуудал ач холбогдолтой эсэхээс үл хамаарч оролцогч тал ямар ч ялгаваргүй хандах эрсдэлтэй.

Тиймээс Авлигын эсрэг хуулийн 27-р зүйлд заасны дагуу Олон нийтийн зөвлөлийг Ерөнхийлөгчийн тушаалаар 2014 оны 5 сард байгуулсан нь сайшаалтай зүйл юм. Олон нийтийн зөвлөл нь авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог хангах, олон нийтийн үзэл, зөвлөмжийг Авлигын эсрэг хуулийн хэрэгжүүлэлт, нөхцөлд тусгах үүрэгтэй юм. Олон нийтийн зөвлөл 15 гишүүнтэй бөгөөд гишүүдийг их сургууль, иргэний нийгэм, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, худалдаа аж үйлдвэрийн танхим, байгаль орчны холбооноос сонгож 4 жилийн хугацаатай томилдог.

Ажлын байран дээр хийсэн уулзалтын явцад үнэлгээчдэд Олон нийтийн зөвлөл нь авлигын эсрэг чухал санаачлага гаргахад гол үүргийг гүйцэтгэж болно хэмээн хэлж байсан. Жишээлбэл, авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг батлуулахад чухал үүрэгтэй, учир нь бодлого зохицуулагчид үүнийг заналхийлэл гэж харахгүй.

Анх АТГ-ыг Хонг Конгийн загварын дагуу байгуулсан бөгөөд энэ байгууллагаас маш өндөр хүлээлттэй байсныг дурдах хэрэгтэй. Цаг хугацаа өнгөрөхөд энэ байгууллага авлигыг арилгаж чадна гэсэн итгэл бага багаар алга болсон. Азийн сан Сант Марал сантай хамтарч 2015 оны 4 сард олон нийтийн дунд судалгаа явуулсан бөгөөд энэ судалгаа нь мөн өмнөх жилүүдийн тоон мэдээллийг харьцуулсан судалгаа байсан юм. Судалгаанаас сонирхолтой үр дүн гарсан. Судалгаанд оролцогчдын хувьд авлигын эсрэг тэмцэлд манлайлах байгууллага 2012 оноос ерөнхийдөө өөрчлөгдөөгүй. Хамгийн өндөр санал авсан байгууллага нь АТГ байсан бөгөөд 2015 оны 4 сарын байдлаар нийт сонгогчдын 37.8 хувь нь сонгосон. Засгийн газар 2014 оны 3 сарын байдлаас хэдэн хувь унаж 14.2 хувь болсон бол Иргэний нийгэм гуравт байсан юм. АТГ-т итгэх итгэл 2013 оны 3 сард 46.5 хувь байсан бол 2015 оны 4 сард 39.2 хувь болж, шударга байдалд итгэх итгэл нь 2014 оны 34.7 хувь байснаас 2015 оонд 21.7 хувь болж буурсан ч санал асуулгад оролцогчдоос хамгийн их санал авсан байгууллага болсон юм.

Ийм учраас АТГ-ын санхүү, институци, улс төрийн бие даасан байдлыг хадгалах нь илүү чухал юм. Энэ байгууллага нь олон нийтийн итгэлийг олж авахын тулд илүү их зүйл хийх хэрэгтэй. Түүнчлэн АТГ нь дангаар авлигын эсрэг үйл ажиллагааг хариуцах ёсгүй. Засгийн газар болон орон нутгийн удирдах байгууллагуудын түвшинд бусад тоглогчид байх нь чухал үүрэгтэй юм. Мөн Монгол улс шиг өргөн уудам газар нутагтай улсын хувьд АТГ өөр бүсд өөрийн салбартай болох нь авлигын асуудлыг шуурхай шийдвэрлэхэд чухал юм.


Монголын эрх бүхий байгууллагууд АТГ бүсийн салбартай болох хүсэлтээ УИХ-д өргөн

мэдүүлсэн боловч, татгалзсан хариу авсан хэмээн мэдэгдсэн. Хэдийгээр үр дүн нь сөрөг байсан боловч салбартай болох хүсэлт мэдүүлсэн нь зөвлөмжийн дагуу байна. (АТГ-ын бүс нутагт хянан шалгах чадамжийн талаар Зөвлөмж 2.9-с харна уу.)

Ажлын байран дээрх уулзалтын үеэр АТГ хувийн эсхүл улс төрийн зорилгоор үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хянан шалгалт нь “хүний эрхий зөрчил”-тэй байдаг талаар хяналтын баг хэд хэдэн удаа сонссон. Эдгээр мэдэгдлийн талаар ямар ч баримт, нотолгоог үнэлгээчдэд үзүүлээгүй. АТГ-ын Дотоод Хяналтын Хэлтэс нь 2007 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүсгэн байгуулагдсан цагаас эрүүгийн мөрдөн байцаалтын явцад хүний эрхийн зөрчилтэй холбоотой зүйл илэрч байгаагүй хэмээн мэдэгдсэн. Эдгээр мэдүүлгийг АТГ-ын мөрдөн байцаах үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус байдаг одоогийн болон өмнөх улс төрчид тарааж байж магадгүй юм. Жишээлбэл, 2015 оны 6 сард Монгол улсын Ерөнхий сайд асан АТГ-ийг татан буулгах талаар санал гаргаж байсан.

Хэдийгээр АТГ-т итгэх олон нийтийн итгэл сүүлийн үед буурч байгаа ч энэ байгууллага нь авлигын эсрэг тэмцэлд манлайлах үүрэгтэй оролцох олон нийтийн итгэлийн хүлээсэн ганц байгууллага хэвээр байна.


## Дүрслэл 2. Байгууллагад итгэх олон нийтийн итгэл



**Эх сурвалж:** Азийн сан / Сант Марал сан (2015 оны 6 сар), “Авлигын төсөөлөл болон мэдлэгийн судалгаа: Монгол улсад ил тод байдлыг сайжруулах төсөл”, Дүрслэл 5.3, Хуудас 23 ([www.asiafoundation.org/publications/pdf/1513](http://www.asiafoundation.org/publications/pdf/1513)).

Гэсэн хэдий ч АТГ-т итгэх олон нийтийн итгэлийн талаарх судалгаа өөр дүр зураг харуулж байна:


### Дүрслэл 3. АТГ-т итгэх итгэл



Эх сурвалж: Азийн сан / Сант Марал сан (2015 оны 6 сар), “Авлигын төсөөлөл болон мэдлэгийн судалгаа: Монгол улсад ил тод байдлыг сайжруулах төсөл”, Дүрслэл 5.6, Хуудас 24 ([www.asiafoundation.org/publications/pdf/1513](http://www.asiafoundation.org/publications/pdf/1513)).

Эцэст нь олон нийт АТГ-г шударга хуулийн хяналтын байгууллага хэмээн үзэхгүй байна.

### Дүрслэл 4. Судалгаа: “АТГ шударга хуулийн хяналтын байгууллага гэдэгт та итгэлтэй байна уу?”



Эх сурвалж: Азийн сан / Сант Марал сан (2015 оны 6 сар), “Авлигын төсөөлөл болон мэдлэгийн судалгаа: Монгол улсад ил тод байдлыг сайжруулах төсөл”, Дүрслэл 5.7, Хуудас 25 ([www.asiafoundation.org/publications/pdf/1513](http://www.asiafoundation.org/publications/pdf/1513)).

**2) Авлигын мэргэшсэн байгууллагын дарга, дэд дарга нарыг өрсөлдөөнт, ил тод, ур чадварт суурилсан зарчмаар сонгон шалгаруулдаг болох; агентлагийн ажилтнуудыг ур чадварт суурилсан, өрсөлдөөнт шалгаруулалтаар авч ажиллуулах тодорхой шалгуур, журмыг тогтоон хэрэгжүүлэх.**

Зөвлөмжийн энэ хэсэгтэй холбоотой ямар нэг алхам хэрэгжүүлээгүй байна. Ажлын байран дээр хийсэн ярилцлагын явцад АТГ-ын дарга болон дэд даргын томилгоонд ямар нэг байдлаар асуудалгүй байдаг, учир нь эдгээр албан тушаалтнуудыг Ерөнхийлөгчийн санал болгосноор УИХ-аас 6 жилийн хугацаатай сонгодог бөгөөд Ерөнхийлөгчийн болон УИХ-ын сонгууль нь албан тушаалын томилгоотой давхцдаггүй. Харин АТГ-ын ажилтнуудын хувьд өмнө дурдсан сорилт байсаар байдаг. Түүнчлэн бусад ярилцагчдын хэлж байгаагаар Засгийн газар солигдоход АТГ-ын хуучин дарга албан тушаалаас бууж засаг барьж буй улс төрийн намтай ойр байдаг хүн даргын албан тушаалд шинээр томилогддог. Хэдийгээр үнэлгээчдэд бодит нотлох баримт үзүүлээгүй боловч энэ байдал нь улс төрийн нөлөөний үр дүн гэдэгт ярилцагчид итгэлтэй байсан юм. Хэрвээ энэ үнэн бол энэ байдал нь үнэхээр сөрөг хөгжил юм.

**3) Жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах асуудлуудыг ач холбогдлоор нь эрэмбэлэх, төлөвлөгөөнд тусгаж байгаа ажлуудын агуулга, зорилт, гарах үр дүн, хугацааг нарийвчлан тодорхойлох, төлөвлөгөөний хэрэгжилт болон гүйцэтгэлд хяналт тавих, хэмжиж болох үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх асуудалд гол анхаарал хандуулах замаар Авлигатай тэмцэх газрын жилийн ажлын төлөвлөлтийг сайжруулах.**

Асуулгад өгсөн хариултуудаас харахад Төсвийн тухай хуульд төрийн байгууллагуудыг үйл ажиллагаагаа төсөвтэй уялдуулах талаар заасан байдаг. Үүний үр дүнд АТГ боломжит төсөвт өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүрэн дэмжлэг авахын тулд төлөвлөгөөндөө илүү бодитоор хандах болсон. Хэдийгээр АТГ-ын 2015 оны төлөвлөгөө нь товч бөгөөд тодорхой боловч хөтөлбөрийн төслийн эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон улс төр, газар, уул уурхай гэх мэт авлигын эрсдэл бүхий салбаруудад хангалттай анхаарал хандуулаагүй байна. Мөн олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх арга хэмжээний зорилтот бүлгийг бүрэн тодорхойлоогүй байна.

### **Дүгнэлт**

АТГ-ын чадамж болон бие даасан байдлыг сайжруулах алхам хийгдээгүй байна. Байгууллагын жилийн төлөвлөгөө сайжирсан боловч санхүүгийн бодит байдлын хувьд л сайжирсан байна. Бүсийн салбаруудыг байгуулаагүй байна. Хүний эрхийн зөрчилтэй холбоотой мэдэгдлийг худал гэдгийг батлах тулд илүү зүйл хийх хэрэгтэй. Тусгай мөрдлөгийн аргачлал, эрэн сурвалжлах болон хураах ажиллагаануудыг шүүх байгууллагын зөвшөөрлөөр хийдэг болох хэрэгтэй. АТГ оногдсон бүх үүргээ биелүүлж чадахгүй учраас өөрийн ажлыг ач холбогдлын хувьд дарааллуулах хэрэгтэй. Мөн засгийн газар болон орон нутгийн түвшинд хамтарч ажиллах байгууллага хайж, өөрсдийн үйл ажиллагааг авлигын эсрэг идэвхтэй хандуулах хэрэгтэй. АТГ-ын удирдлагын томилгоо нь улс төрийн оролцоогүй байх хэрэгтэй.

**Монгол улс Зөвлөмж 1.6-г хэсэгчлэн биелүүлсэн бөгөөд зөвлөмж хэвээр үлдэнэ.**

## 2. АВЛИГЫГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ НЬ

### 2.1-2.2 Зөрчил болон зөрчлийн бүрэлдэхүүн

Үнэлгээний тайлан 2.1.-2.2.-ийн зөвлөмжүүд

- 1) *Хээл хахуулийн санал, амлалт, хээл хахуулийн санал болон амлалтыг хүлээн зөвшөөрсөн үйлдэл болон хээл хахуулийн хүсэлтийг бүгдийг төгссөн гэмт хэрэгт тооцох, гуравдагч этгээдээр дамжуулан эсхүл гуравдагч этгээдийн ашиг тусын тулд хээл хахууль өгөх, авах үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчлах замаар идэвхитэй болон идэвхигүй хээл хахуулийн үйлдэл эс үйлдэхүйг олон улсын стандартад нийцүүлэх.*
- 2) *Мөнгөтэй холбоогүй буюу хуульд нийцээгүй бус давуу талыг хамруулсан "Хээл хахууль"-ийн тодорхойлолтыг хуульчлан тогтоох.*
- 3) *Хувийн хэвшил дэх хээл хахууль болон хууль бус нөлөөлөлд олон улсын хамгийн сайн стандартад нийцсэн хариуцлагыг нэвтрүүлэх, хээл хахууль авахаар хүсэлт гаргасан, далайлган сүрдүүлсэн үйлдлийг нь хээл хахууль өгөгч хууль хэрэгжүүлэх байгууллагад мэдэгдсэн бол олон улсын сайн туршилагад нийцүүлэн тухайн этгээдийг идэвхитэй хээл хахуулийн гэмт хэргийн ялаас чөлөөлөх асуудлыг авч үзэх.*
- 4) *Хуулийн тодорхой байдлыг хангахын тулд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, мөнгө угаах гэмт хэрэг зөрчилд ашиглагдаж байгаа тэр томъёог тодорхой болгох, хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж, практикт өөрчлөлт оруулах замаар мөнгө угаах гэмт хэрэг үүсгэн шалгахад заавал суурь гэмт хэргүүдэд холбогдсон байх шаардлагагүй гэдгийг тодорхой тусгах.*
- 5) *Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын 20 дугаар зүйлд нийцүүлэх зорилгоор "Хууль бусаар хөрөнгөжих" зөрчлийг дахин авч үзэх.*
- 6) *Хяналтын үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс гэмт хэрэг үйлдэгдэх боломжийг бий болгосон үйлдэлд хариуцлага хүлээлгэх, хуулийн этгээдийн хариуцлагыг тухайн хэрэгт шалгагдаж байгаа хувь хүний хэргийн илрүүлэлт, яллах ажиллагаа болон хэрэгт холбогдсон байдлаас үл хамааран бие даасан байлгах зэргийг оролцуулаад тэнцвэртэй, залхаан цээрлүүлсэн ял шийтгэл оногдуулах замаар авлигын гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулах үр дүнтэй хариуцлагыг бий болгох.*

2014 оны 4 дүгээр сард анхны үнэлгээний тайланг гаргаснаас хойш Монгол Улсын Эрүүгийн хуульд ямар нэг өөрчлөлт ороогүй гэж Монгол Улсын Засгийн газар мэдээлсэн (Эрүүгийн хуулийн заалтуудыг хавсралтаас харна уу). Мөн түүнчлэн Хууль зүйн яам нь Шинэчилсэн эрүүгийн хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан гэдгээ мэдэгдсэн. Энэхүү хуулийн төслийг нийт 3 жилийн хугацаанд боловсруулсан бөгөөд өргөн барьсан төсөл нь хуулийн тав дахь хувилбар юм. Хууль зүйн яамны мэдэгдсэнээр энэхүү хуулийн төслийг УИХ-ын холбогдох байнгын хороо хянаж үзсэн бөгөөд 2015 оны намрын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн юм байна.

1) *Хээл хахуулийн санал, амлалт, хээл хахуулийн санал болон амлалтыг хүлээн*

*зөвшөөрсөн үйлдэл болон хээл хахуулийн хүсэлтийг бүгдийг төгссөн гэмт хэрэгт тооцох, гуравдагч этгээдээр дамжуулан эсхүл гуравдагч этгээдийн ашиг тусын тулд хээл хахууль өгөх, авах үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчлах замаар идэвхитэй болон идэвхигүй хээл хахуулийн үйлдэл эс үйлдэхүйг олон улсын стандартад нийцүүлэх.*

Хээл хахуулийн санал, амлалт, тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн үйлдэл, хээл хахуулийн хүсэлт (далайлган сүрдүүлэх гэмт хэргийн шинжгүйгээр) зэрэг нь Монгол Улсад төгссөн гэмт хэрэг болж хуульчлагдаагүй байна. Монгол Улсын Эрүүгийн хуулиар төгсөөгүй гэмт хэрэгт (гэмт хэрэгт бэлтгэх, завдах) ял оногдуулдаг боловч эдгээр төгсөөгүй үйлдлүүдийг олон улсын стандарт болон Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөнд заасантай адил хэмжээнд авч үзэж чаддаггүй. Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөний улсууд төгсөөгүй гэмт хэрэг нь дээр тодорхойлсон үйлдлүүд (санал, амлалт гэх мэт)-ийг хамааруулсан байдаг учир тусад нь хуульчлах шаардлагагүй гэж үздэг. Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөний болон өөр бусад хяналт (Авлигын эсрэг улс орнуудын европын зөвлөл, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, ВиЖиБи гэх мэт)-ын механизм энэхүү үзлийг хэд хэдэн шалтгааны улмаас хүлээн зөвшөөрдөггүй.

Нэгдүгээрт, авлигын гэмт хэргийн завдалт нь тухайн этгээд гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл эс үйлдэхүйг хийсэн боловч тухайн этгээдийн удирдаж чадахгүй хүчийн зүйлийн улмаас төгсөөгүй үед бий болдог. Цаашилбал, Монгол Улсын Эрүүгийн хууль гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзсан буюу авлигын гэмт хэрэгт бэлтгэсэн завдсан үйлдлээ өөрийн хүслээр зогсоосон бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг зохицуулалттай. Жишээ нь авлига авах, өгөх хүсэлт гаргасан боловч хүсэлтээсээ татгалзсан бол тухайн этгээд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө. Үүнтэй адилаар авлига авах боломжтой этгээд хоёрдмол утгагүйгээр шууд татгалзахаас өмнө авлигын санал эсхүл амлалтаасаа татгалзвал тухайн этгээд эрүүгийн хариуцлагаас мултарна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу төгсөөгүй гэмт хэрэгт оногдуулдаг ял нь хөнгөн бөгөөд тухайн төгссөн гэмт хэрэгт оногдуулахаар заасан аль хүнд төрлийн ялын хоёрны нэгээс (бэлтгэсэн үйлдэлд) эсхүл (завдсан үйлдэлд) гуравны хоёроос хэтэрч болохгүй. Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөний хоёрдугаар хяналтын тайланд дурдсанчлан энэ мэт "хөнгөлөлт" нь санал эсхүл амлалтын хэлбэрт байгаа тухайн авлигын гэмт хэргийн хүнд хөнгөний хэр хэмжээтэй харилцан тэнцвэртэй байж чаддаггүй (учир нь энэ нь тухайн гэмт этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас төгсөөгүй авлига өгөх шууд санаатай завдалтыг авч үздэг).<sup>5</sup>

Гуравдугаарт, хээл хахууль өгөх амлалт болон саналд хариуцлага хүлээлгэх нь тэдгээр үйлдлийг төгссөн гэмт хэргийн завдалт гэж үзэхээр хичээхээс илүү үр дүнтэй байдаг. Тухайн этгээдийн хүсэл зоригоос үл шалтгаалан биелэлээ олоогүй хээл хахууль өгөх гэсэн санаачилгыг батлахыг оролдохын оронд шууд санаатай хээл хахуулын амлалт болон саналыг батлахад л хангалттай. Үүнтэй адил зарчмыг хээл хахууль өгөх амлалт болон хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн үйлдэлд ч ашиглах боломжтой.

Эцэст нь, хээл хахуулийн хүсэлт, амлалтыг төгсөөгүй гэмт хэрэг гэж яллах нь практикт үүсэх бүхий л нөхцөл байдлыг хамарч чаддаггүй. Жишээ нь хээл хахууль өгөхөөр бэлтгэсэн буюу завдсан ямар нэг үйлдэлгүйгээр хээл хахууль өгөхийг амлах нь хээл хахууль өгөх хүсэл зоригийг нь бататгах боловч эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

Айлчлалын үеэр хяналтын баг энэхүү зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой ямар нэг

<sup>5</sup> IAP Second Round report on Kazakhstan, p. 29, available at [www.oecd.org/dataoecd/17/28/48908325.pdf](http://www.oecd.org/dataoecd/17/28/48908325.pdf).

шинэчлэл ажиглаагүй бөгөөд холбогдох өөрчлөлтүүд одоо хэрэгжиж буй Эрүүгийн хуульд тусгалаа олоогүй байсан. Мөн үед үнэлгээний багийн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад өгсөн дүгнэлт нь Монгол Улсын төрийн байгууллагууд зөвлөмжийн энэхүү хэсгийг хуульчлахаар илэрхий их хичээл зүтгэл гаргасныг харуулсан. Нэгдүгээрт, хээл хахуулийн амлалт болон санал нь хоёул авлига өгөх гэмт хэрэгт (Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 22.5 дугаар хэсэг) тусгагдсан байсан. Хоёрдугаарт, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь хээл хахуулийн хүсэлт (эсхүл шаардлага)-ийг хээл хахууль авах гэмт хэргийн объектив тал болгож тусгасан (22.4 дүгээр хэсэг).

Хэдийгээр хээл хахууль өгөх санал болон амлалтыг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга тусгасан байгаа эсэх нь тодорхойгүй ч тус хуулийн төслийн 22.4 дүгээр хэсэгт албан тушаалтны "хээл хахууль шаардах, авах, хүлээн зөвшөөрөх" үйлдлүүдийг эрүүгийн гэмт хэрэг болгож тусгасан. Гэсэн хэдий ч хангалттай тодорхой биш байгаа учир хээл хахуулийн амлалт болон саналыг хүлээн зөвшөөрөх үйлдлийг тодорхой тусгаж өгвөл зохино.

### **Шууд буюу шууд бус арга зам**

Монгол Улсын Эрүүгийн хуулийн идэвхитэй авлигын заалт нь шууд бусаар хээл хахууль авахыг тодорхой тусгасан ("өөрөө, эсхүл бусдаар дамжуулан") боловч тус хуульд идэвхигүй авлигын тухай ямар нэг заалт байхгүй. Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь хээл хахууль зуучилсан үйлдэлд хариуцлага хүлээлгэдэг байсан боловч 2012 онд тус зүйл хүчингүй болсон.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22 дугаар зүйл "Хээл хахууль авах" гэмт хэргийн 22.4 дэх хэсгийн 1 дүгээр заалтад шууд бусаар хээл хахууль авах үйлдлийг тусгаагүй. Тус заалт нь "хууль, захиргааны акт болон захиргааны гэрээний дагуу эрх олгогдсон этгээд"-ийн идэвхигүй хээл хахуулийг хуульчилсан заалт юм. Гэхдээ "төрийн албан тушаалтнууд"-ын тухай заасан тус заалтын 2 дугаар хэсэгт "шууд болон шууд бус" гэх үйлдлийн шинжийг тусгаж өгсөн. Энэхүү жигд биш томъёоллыг адилтгах шаардлагатай.

Идэвхитэй хээл хахуулийг бодолцож үзэх юм бол хуулийн төсөл боловсруулагчид нь тун тодорхой биш томъёолсон байна: "шилжүүлэх замаар эрх мэдэл буюу өөр бусад өөр ашигтай нөхцөл байдал үүсгэхийн тулд хийсэн аливаа үйлдэл ...". Шууд бус байдлаар ашиг олох нь "аливаа үйлдэл" гэдэг ойлголтод багтах эсэх нь тодорхой биш. Ямартаа ч энэхүү томъёолол нь хуулийн тодорхой байдлыг хангахгүй байгаа бөгөөд олон улсын стандартад нийцсэн гэж үзэх боломжгүй юм.

### **Гуравдагч этгээд ашиг олох**

Монгол Улсын эрүүгийн хуулийн идэвхитэй болон идэвхигүй гэмт хэргүүд нь гуравдагч этгээдэд ашигтай байх тохиолдлыг үйлдлийн шинжид тусгаагүй байдаг. Иймд хэрвээ тухайн албан тушаалтнаас өөр иргэн, хуулийн этгээдэд хээл хахууль өгсөн бол гэмт хэрэгт тооцогдохгүй. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга ч гэсэн энэ шинжийг тусгаж өгөөгүй.

### ***2) Мөнгөтэй холбоогүй, биет бус давуу тал олгосон "хээл хахуулийн" шинэ тодорхойлолтыг хуульчлан батлах***

2014 оны анхны Үнэлгээний тайланд дурдсанчлан гэмт хэргүүдээр эрүүгийн хэрэгт шалгахад ашиглагдаж буй "хээл хахууль" гэх нэр томъёо нь Монгол Улсын эрүүгийн хуульд тодорхойлогдоогүй. Гэсэн хэдий ч тус ойлголт нь Монгол Улсын дээд шүүхийн 2009 оны

дугаар сарын 24-ний өдрийн "Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" тогтоолд тодорхойлогдсон байдаг. Тус тогтоолд 268 дугаар зүйлд заасан "хээл хахууль" гэдэгт "хууль бус зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд өгсөн эдийн болон эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрх, төлбөргүй буюу хөнгөлөлттэй үзүүлсэн аливаа ажил үйлчилгээ зэргийг хамааруулан үзнэ" гэж тодорхойлсон. Хэдийгээр тус тодорхойлолт нь "эдийн бус" ашиг тусыг тусгасан боловч тус зүйлийг тодорхойлолхдоо "баялаг" гэсэн ерөнхий нэр дор тодорхойлсон бөгөөд баялаг нь мөнгөөр илэрхийлж болох биет зүйлсийг илэрхийлэх боломжтой. Айлчлалын үеэр судалгааны багтай ярилцсан зарим нэг хүн Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар нь зөвлөмжийн шинжтэй, оролцогчид (шүүгчид, прокурорууд, байцаагчид гэх мэт) заавал дагаж мөрдөх албагүй гэж мэдэгдсэн. Гэсэн хэдий ч Монгол Улсын Хууль зүйн яам Үндсэн хуулиас иш татаж, Улсын дээд шүүх нь хууль зөв хэрэглэх албан ёсны тайлбар гаргах эрхтэй бөгөөд практикт Улсын дээд шүүхийн шүүхийн шийдвэрүүдийг нь тодорхой дагаж мөрддөг хэмээн санал зөрөлдсөн.

Ийм учраас "хээл хахууль" гэх нэр томъёог Эрүүгийн хуулинд шууд тодорхойлж, тухайн тодорхойлолтдоо биет бус (өөрөөр хэлбэл биет зүйлээр илэрдэггүй, тодорхой хэмжүүрээр хэмжиж боломжгүй) болон мөнгөн биш (өөрөөр хэлбэл мөнгөтэй холбоогүй буюу мөнгөөр илрээгүй) үр ашгийг шууд тусган оруулахыг зөвлөсөн байдаг. Анхны Үнэлгээний тайланг харна уу (26 дугаар хуудас).

Монгол Улсын төрийн байгууллагууд Авлигын эсрэг хуульд заасан "ашиг хонжоо" гэх нэр нэр томъёоны тодорхойлолт нь биет бус, мөнгөтэй холбоогүй давуу талыг хамруулдаг гэж маргадаг. Цаашилбал тэд хээл хахуулийг хууль бус зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд өгсөн эдийн болон эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрх, төлбөргүй буюу хөнгөлөлттэй үзүүлсэн аливаа ажил үйлчилгээ гэж тодорхойлсон Улсын Дээд шүүхийн тайлбарыг иш татдаг.

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлд "ашиг хонжоо" гэх ойлголтыг "энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдал" гэж тодорхойлсон. Тус зүйлд "давуу байдал" гэх ойлголтыг тусад нь тодорхойлсон боловч тус тодорхойлолт нь хээл хахууль өгөгчөөс авсан авлигын хариуд үйлдсэн албан тушаалтны үйлдлийг тодорхойлсон учир энэ нь хамааралгүй юм. Монгол Улсын Дээд шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаар тогтоолд зааснаар "ашиг хонжоо" гэж Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлд заасныг ойлгоно гэж заасан боловч энэхүү тайлбар нь зөвхөн 265 дугаар зүйл (Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах)-д хамааралтай хийгдсэн болно. Нөгөөтэйгүүр Эрүүгийн хуулийн 268 болон 269 дүгээр зүйлүүдэд "ашиг хонжоо" гэх ойлголтыг дурддаггүй.

Хэдийгээр Авлигын эсрэг хуулийн "авлига"-ын тодорхойлолт нь Улсын дээд шүүхийн тогтоолд заасан тайлбараас илүү дэлгэрэнгүй боловч хангалттай тодорхой биш байна. Мөн түүнчлэн "авлига" гэх тодорхойлолтод мөнгөн бус, биет бус давуу тал олгохыг хамааруулж байгаа гэдгийг тогтоох шүүхийн жишиг эрх зүй бий болоогүй байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь "авлига" гэх ойлголтыг тодорхойлсон боловч тус тодорхойлолт нь тодорхой биш. 22 дугаар зүйлийн 22.5-д заасан идэвхитэй хээл хахуулийн гэмт хэрэг нь "эдийн болон эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн, төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн, эсхүл эдгээрийг амласан, санал болгосон" үйлдлийг авч үздэг. Тус заалт нь зөвхөн "эдийн бус баялаг"-ийг тусгасан тул мөнгөн биш давуу тал болон баялаг гэж үзэж болохооргүй давуу талыг хамаарч чадахгүй. "Баялаг" нь ямар нэгэн аргаар хэмжиж болох үнэ цэнэ бүхий зүйл гэж ойлгогддог бөгөөд тус тодорхойлолт нь илүү дэлгэрэнгүй байх ёстой байсан ба ямар нэгэн зах зээлийн үнэгүй, эсхүл



бүр үнэлж болохгүй (жишээ нь: хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах, тушаал дэвшүүлэх, төлбөргүй дадлагад гаргах, цол өгөх гэх мэт) тэдгээр ашиг тус (давуу тал)-уудыг оруулсан бүхий л ашиг тусыг хамруулан томъёолох шаардлагатай юм.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 22.4 дүгээр хэсэгт заасан идэвхигүй авлигад дээр дурдсан "авлига"-ын тодорхойлолт хэрэглэгдэж болно гэж ойлгогдож болох юм. Гэхдээ хуулийн төсөл боловсруулагчид 22.5 дугаар хэсэг болох авлига өгөх гэмт хэрэгт "авлига" гэх нэр томъёог хэрэглэлгүй зөвхөн үйлдлийн шинжийг тодорхойлсон нь гол асуудал болж байгаа юм. Цаашилбал "авлига" гэх нэр томъёог 22.5 дугаар хэсэгт тусгасан байлаа ч гэсэн тус гэх ойлголтыг бүхий тохиолдолд адил утгаар ойлгоно гэсэн зүйл заалт, тайлбар байхгүй. Ийм тайлбаргүйгээр тус тайлбарыг бүхий л гэмт хэргийг зүйлчлэхдээ ашиглавал энэ үйлдэл нь эрүүгийн хуулийн зүйл заалтын үг хэллэгийг таамаг болон урьдчилан мэдэж болохооргүй тайлбар ашиглан хууль хэрэглэхийг хориглодог хууль тодорхой байх суурь зарчимтай зөрчилдөнө. Мөн энэхүү үйлдэл нь Эрүүгийн хуулийн 3.2 дугаар хэсэгт заасан хууль төсөөтэй хэрэглэхийг хориглосон заалттай зөрчилдөнө.

### ***3) Хувийн хэвшил дэх хээл хахууль болон хууль бус нөлөөлөлд олон улсын стандартад нийцсэн хариуцлагыг нэвтрүүлэх***

#### **Хувийн хэвшил дэх хээл хахууль**

Монгол Улсын төрийн байгууллагууд "албан тушаалтнууд"-ыг авлигын гэмт хэрэгт хамааруулж үздэг. Тэдний тайлбар ёсоор 268 дугаар зүйлд заасан албан тушаалтан гэдэгт "төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагч"-ийг хамааруулна. Эрүүгийн хууль нь хээл хахуулийг хувийн хэвшилд болон нийтийн салбарт хувааж ангилдаггүй.

Гэхдээ төрийн байгууллагуудын хэлсэн тодорхойлолт нь Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд байдаггүй. Харин 263 болон 265 дугаар зүйлүүдийн доор байх тайлбарт тодорхойлсон байдаг:

"Энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна."

"Энэ бүлэгт дурдсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан гэдэгт төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна."

Хувийн хэвшлийн болон нийтийн салбарын албан тушаалтнуудыг бүгдийг хамруулан авлигын ерөнхий заалтад тусгах замаар хувийн хэвшил дэх авлигыг гэмт хэрэгт тооцох нь хэлбэрийн хувьд олон улсын стандарттай зөрчилдөхгүй. Гэхдээ энэ нь тодорхой байх, шууд харагдах тал дээр асуудал үүсгэдэг. Хувийн хэвшил дэх авлигыг хуульчилж өгсөн бие даасан заалт нь олон нийтийн бус албан хаагчдын авлигын асуудлыг илүү сайн тодорхойлдог.

Авлигын эсрэг улс орнуудын европын зөвлөл (цаашид "АЭУОЕЗ") Азербайджан Улсын тухайд өгсөн гуравдахь үнэлгээний тайландаа тус улсын эрүүгийн хуулинд хувийн хэвшил дэх авлигын талаар тодорхой зүйл заалт оруулахыг санал болгосныг дурьдах нь зүйтэй. Авлигын эсрэг улс орнуудын европын зөвлөлийн үнэлгээ нь хувийн хэвшил дэх хээл хахуулийг тусгайлан дэлгэрэнгүй тодорхойлсон, бие даасан зүйл ангийг нэвтрүүлж, Авлигийн эсрэг эрүүгийн конвенцын<sup>6</sup> 7 болон 8 дугаар зүйлтэй адил болгосноор нийт

<sup>6</sup> Эх сурвалж: GRECO Third Round Evaluation Report, 2010 оны 10 дугаар сар, [www.coe.int/t/dghl/monitoring/greco/evaluations/round3/GrecoEval3\(2010\)2\\_Azerbaijan\\_One\\_EN.pdf](http://www.coe.int/t/dghl/monitoring/greco/evaluations/round3/GrecoEval3(2010)2_Azerbaijan_One_EN.pdf). Гэсэн хэдий ч АЭУОЕЗ нь өөрсдийнх нь зөвлөмжийг үл харгалзан өөр төрлийн гэмт хэрэг болгож хуульчилсан

системд ашигтай байх болно гэсэн байр суурьтай байна.

Гэсэн хэдий ч АЭУОЕЗ Литва Улсад гаргасан тайландаа хувийн хэвшлийн, төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, хараат бус зөвлөх нарыг нэг зүйлд заах хандлагын давуу талыг тэмдэглэсэн байдаг бөгөөд ингэснээр нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн байгууллага болон холимог хэлбэрийн гэх мэт байгууллагатай холбоотой ойлгомжгүй байдал, практик асуудлууд гардаггүй юм<sup>7</sup>.

Энэхүү хандлага нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгалаа олоогүй. Цаашлаад хээл хахуулийн гэмт хэргийн заалтууд болох 22.4 болон 22.5 дахь хэсэгт "хууль, захиргааны акт, гэрээний үндсэн дээр үүрэг хүлээсэн этгээд<sup>8</sup>" гэх нэр томъёог ашигласан бөгөөд хувийн хэвшил дэх хээл хахуулийн талаар бие даасан заалт тусгаагүй. Хяналтын багт өгсөн хуулийн төсөлд энэхүү нэр томъёоны тайлбар тусгагдаагүй байсан. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22.11 дүгээр хэсэгт "хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан" гэх нэр томъёог ашигласан.

### **Хууль бус нөлөөлөл**

Анхны Үнэлгээний тайлан гарснаас хойш хууль бус нөлөөллийн гэмт хэрэг Монгол Улсад хуульчлагдаагүй.

Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын 18 дугаар зүйлд заасны дагуу хууль бус нөлөөллийг заавал гэмт хэрэг гэж үзэх шаардлагагүй. Гэсэн хэдий ч Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь Авлигын эсрэг конвенц болон түүний зайлшгүй тусгавал зохих заалтуудаар хязгаарлагдахгүй. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөө нь олон тооны стандартуудад үндэслэсэн бөгөөд тэдгээр стандартуудын нэг нь Авлигын эсрэг конвенц юм. Өөр бусад олон улсын стандартуудад зааснаар эрх мэдлээ хэтрүүлэх (хууль бус нөлөөлөл) нь зайлшгүй байх ёстой гэмт хэрэг юм. Жишээ нь Авлигын эсрэг европын эрүүгийн хуулийн конвенц (12 дугаар зүйл)-д заасан байдаг. Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь хэлбэрийн хувьд тодорхой нэг конвенцод баригдаагүй бөгөөд олон тооны авлигын эсрэг стандартуудыг хамруулж чадсан учраас 2009-2013 оны Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөний тайланд дурдсанчлан (77 дугаар хуудас) Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөнд оролцсон улс орон бүр хууль бус нөлөөлөллийг гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрсөн.

Айлчлалын үеэр Монгол Улсын төрийн байгууллагууд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь хууль бус нөлөөлөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа тухай мэдэгдсэн. Шинэчилсэн найруулга (22.2 дугаар хэсэг) нь албан тушаалын нөлөөллөө хэтрүүлснийхээ хариуд авлига өгөхийг шаардах, авах үйлдлийг тусгасан. Гэсэн хэдий ч хуулийн төсөл боловсруулагчид авлига авах хүсэлтийг зөвхөн удирдах албан тушаалтнуудад хамааруулан хуульчилж, ерөнхий заалтад тусгаагүй орхисон нь ойлгомжгү үйлдэл болсон (22.2 дугаар хэсгийн 1 дэх заалт). Үүнтэй төстэйгөөр шууд бус авлига авах хүсэлт болон хууль бус нөлөөллийн дагуу хууль бус давуу тал олж авах гэмт хэрэг нь зөвхөн удирдах албан тушаалтнуудад л хамааралтай. Шинэчилсэн найруулгын төсөл нь хууль бус

---

Азербайджаны шийдвэрт сэтгэл хангалуун байгаа. Азербайджаны төрийн байгууллагууд хувийн хэвшил дэх авлигын хэргийн ялласан олон тохиолдлын статистик мэдээг гаргаж өгсөн. Эх сурвалж: Compliance Report, 2012 оны 10 дугаар сар, 6 дугаар хуудас,

[www.coe.int/t/dghl/monitoring/greco/evaluations/round3/GrecoRC3\(2012\)12\\_Azerbaijan\\_EN.pdf](http://www.coe.int/t/dghl/monitoring/greco/evaluations/round3/GrecoRC3(2012)12_Azerbaijan_EN.pdf).

<sup>7</sup> Эх сурвалж: GRECO Third Evaluation Round Report on Lithuania, 2009 оны 7 дугаар сар, 21 дүгээр хуудас, [www.coe.int/t/dghl/monitoring/greco/evaluations/round3/GrecoEval3\(2008\)10\\_Lithuania\\_One\\_EN.pdf](http://www.coe.int/t/dghl/monitoring/greco/evaluations/round3/GrecoEval3(2008)10_Lithuania_One_EN.pdf).

<sup>8</sup> Айлчлалын үеэр Монгол Улсын төрийн байгууллагууд “албан тушаалтан” гэх нэршил нь төрийн албан хаагч, хувийн хэвшлийн албан хаагч, гадаад байгууллагын ажилтнууд болон хоёрдугаар ажилтнууд гээд хөдөлмөрийн гэрээгээр үүрэг хүлээсэн бүхий л этгээдүүдийг хамааруулан ойлгоно гэж мэдэгдсэн.

нөлөөлөлтэй холбоотой авлига өгөх санал болон амлалтыг хуульчлан тусгаагүй. Ерөнхийдөө 22.2 дугаар хэсэг нь ойлгомжгүй бөгөөд хууль бус нөлөөлөлтэй холбоотой олон улсын хэм хэмжээнүүдээр шаардагдах бүхий л элементүүдийг тусгаж чадаагүй. Үүний оронд холбогдох олон улсын хэм хэмжээнүүдийн заалтыг тэр чигээр нь авч хуульчлахыг Монгол Улсад санал болгож байна (жишээ нь: Европын авлигын эсрэг эрүүгийн конвенц).

***Олон улсан хамгийн сайн туршилагын дагуу авлига өгөгч нь авлига авах хүсэлт гаргасан, далайлган сүрдүүлсэн үйлдлийг нь зохих төрийн байгууллагад мэдэгдсэн бол идэвхитэй авлигын эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зохицуулалт хуульчлахыг бодолцож үзэх***

Монгол Улсын төрийн байгууллагууд аливаа этгээд авлига авсан, өгсөн, зуучилсан үйлдлээ сайн дураар зохих төрийн байгууллагад мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэдгээ баталсан. Тэд гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлийг заасан: “Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдэж, сайн дураараа хэргээ илчилж ирсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно”. Гэсэн хэдий ч тус зүйл нь авлига авахаар далайлган сүрдүүлсэн, хүсэлт гаргаснийг нь мэдээлсэн авлига өгөгчдийн үйлдлийг дэмжсэн зөвлөмжийг шууд тусгаагүй. Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйл нь үүнтэй яг адилхан биш боловч төсөөтэй: “Хээл хахуульд зуучилсан этгээд өөрийн үйлдлээ сайн дураараа зохих төрийн байгууллагад мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.” Гэсэн хэдий ч тус зүйл нь 2012 онд хүчингүй болсон.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22 дугаар зүйлийн 22.5-д сайн дураар татгалзах зарчим орсон:

“-хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, төрийн албан хаагчийн хууль ёсны дагуу албан үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

“-хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй. Хахууль өгсөн хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн нь түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл болно.”

Энэхүү сайн дураар татгалзсан үйлдлийг дэмжих заалт нь авлигыг мэдээллэж, авлига авсан төрийн албан хаагчийн хувьд хэрэг үүсгэн шалгах боломжийг олгодог (тус гэмт хэргийг зарим улсад идэвхитэй хээл хахуулиас аюултай гэж үздэг) гэдгийг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд үүнийг урвуулан ашиглах боломжтой. 2009-2013 оны Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөний тайланд дурдсанчлан хамгаалалт автоматаар үүсэж бий болж, тухайн нөхцөл байдлын талаар үнэлгээ хийх боломжийг шүүгч, прокурор нарт олгохгүй үед урвуулан ашиглах боломж бий болдог. Авлига өгөгч нь илүү их давуу тал олж авахын тулд авлига авагчийг дарамталж, дарамт шахалт үзүүлэх, эсхүл гэмт хэрэг үйлдсэнээс хойш урт хугацааны дараа хууль сахиулагчид өөрсдөө гэмт хэргийг илчлэх боломжтой болох үед гэмт хэргийг сайн дураараа мэдээллэх замаар тус хамгаалалтыг буруугаар ашиглах боломжтой.<sup>9</sup>

2009-2013 оны Истанбулын авлигын эсрэг төлөвлөгөөний тайлан энэхүү хамгаалалтын талаарх олон улсын стандартуудыг дараах байдлаар нэгтгэн дүгнэсэн:

- энэхүү хамгаалалтыг автоматаар хэрэглэж болохгүй – шүүх харилцан адилгүй нөхцөл байдлуудад буюу гэмт хэрэгтний хүсэл зоригт үнэлэлт өгч, дүгнэх боломжтой байх ёстой.

<sup>9</sup> Эх сурвалж: ACN/IAP Summary report for 2009-2013, Anti-Corruption Reforms in Eastern Europe and Central Asia, Progress and Challenged, 76-77 дугаар хуудас, [www.keepeek.com/Digital-Asset-Management/oecd/governance/anti-corruption-reforms-in-eastern-europe-and-central-asia\\_9789264201903-en](http://www.keepeek.com/Digital-Asset-Management/oecd/governance/anti-corruption-reforms-in-eastern-europe-and-central-asia_9789264201903-en).

- гэмт хэрэг үйлдсэнээс хойш богино хугацааны дараа мэдээлвэл хүчинтэй байх ёстой бөгөөд ямар ч тохиолдолд хууль сахиулагчид өөр эх сурвалжаас мэдээлэл авсны үндсэн дээр хэрэг үүсгэхээс өмнө мэдээлсэн байх ёстой.
- гэмт хэргийн талаар мэдээлсэн хээл хахууль өгөгч хууль сахиулагчидтай хамтран ажиллах ёстой бөгөөд авлига авагчийн хэрэг дээр дэмжлэг үзүүлэх ёстой.
- Авлига өгөгч өөрөө тус хэргийг санаачилсан байвал тус заалтыг ашиглаж болохгүй.
- Тухайн гэмт хэрэгт өгсөн авлигыг авлига өгөгчид буцааж олгохгүйгээр хураах<sup>10</sup> шаардлагатай.

Дээр дурдсан зөвлөмжүүдийн зарим нэг нь л шинэчилсэн найруулгад тусгалаа олсон. Хуулийн эцсийн найруулгад хайхрамжгүй алдаанууд нь засагдсан байх ёстой.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын WGB нь сайн дураараа мэдээллэхийг гадаадын авлигын гэмт хэрэгт ашиглахыг шүүмжилсэн. Дотоодын авлигын хэрэгт сайн дураараа илчилснээр авлигын үйлдлийг илрүүлж, авлига авсан албан тушаалтанд хэрэгтнийг яллаж болох ч гадаад улсын албан тушаалтан авлига авсан тохиолдолд тухайн албан тушаалтанд хэрэг үүсгэж, яллана гэсэн баталгаа байхгүй. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын WGB-ийн хэлснээр “хэрвээ сайн дураараа илчилсэн иргэдийг хариуцлагаас чөлөөлөх нь ямар нэг үр дүнгүй байвал гэмт хэрэг ил болсон ч хэрэг үйлдсэн этгээд хариуцлага хүлээхгүй, шударга ёс оршин тогтнохгүй.<sup>11</sup>” Ийм учраас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 22 дугаар зүйлийн 22.6 “Гадаад улсын, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах” гэмт хэрэгт энэхүү хамгаалалтыг ашиглахгүй байж болно.

**4) Хуулийн тодорхой байдлыг хангахын тулд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, мөнгө угаах гэмт хэрэг зөрчилд ашиглагдаж байгаа тэр томъёог тодорхой болгох, хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж, практикт өөрчлөлт оруулах замаар мөнгө угаах гэмт хэрэг үүсгэн шалгахад заавал суурь гэмт хэргүүдэд холбогдсон байх шаардлагагүй гэдгийг тодорхой тусгах.**

### **Эрх мэдлээ урвуулан ашиглах**

Монгол Улсын төрийн байгууллагууд Эрүүгийн хуульд заасан “төрийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах” гэмт хэргийн заалт нь Нэгдсэн үндэстний байгууллагын авлигын эсрэг конвенцын шаардлагад нийцсэн гэж мэдэгдсэн. Тус конвенцын 19 дүгээр зүйл тус гэмт хэргийг төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа өөртөө болон гуравдагч этгээд буюу хуулийн этгээдэд хууль бус давуу тал бий болгож өөртөө ашиг олох сэдэлтээр албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргах гэж тодорхойлсон байдаг. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл төрийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчилсан байдаг бөгөөд энэ нь иргэдийн эрх ашигт үлэмж хэмжээний хохирол учруулсан байхыг шаарддаг.

Монгол Улсын Дээд шүүхийн 23 дугаар тогтоол тус зүйлд заасан богино нэр томъёоны дэлгэрэнгүй тайлбарыг агуулсан байдаг. Тогтоолд “албан эрх мэдэл” гэдгийг сонгууль

<sup>10</sup> Өмнөх хэсэгт дурдсан.

<sup>11</sup> эх Сурвалж: OECD WGB Phase 2 report on Slovakia, §160, [www.oecd.org/daf/anti-bribery/anti-briberyconvention/35778308.pdf](http://www.oecd.org/daf/anti-bribery/anti-briberyconvention/35778308.pdf).

болон томилолтын албан тушаалтанд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрх, үндсэн чиг үүргийн нэгдлийг, “албан тушаалын байдал” гэж албан тушаалтны хэрэгжүүлж байгаа эрх үүрэгт хамааралгүй боловч тухайн албан тушаалтай холбоотой нэр хүнд, нөлөөг, “урвуулан ашиглах” гэдгийг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар тус тус ойлгож хэрэглэнэ гэж заасан байдаг. Авлигын эсрэг хуульд зааснаар “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг ойлгоно.

Анхны Үнэлгээний тайлан нь хуульд “ашиг олох” буюу “өөр бусад хувийн сэдлээр” гэж заах ёстой гэж тэмдэглэсэн байдаг. Учир нь эдгээр шинж нь тус гэмт хэргийн чухал бүрэлдэхүүн юм. Цаашилбал хууль “иргэдийн эрх ашигт үлэмж хэмжээний хохирол учруулсан” (Эрүүгийн хуулийн 266.1) гэдгийг хэмжихэд ашиглах объектив хэмжээс тусгасан байх ёстой.

Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд дараах байдлаар хохиролын хэмжээ тооцох аргыг заасан байдаг: Гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг бага бус, тавиас дээш нэг зуун хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг үлэмж, нэг зуун хорин таваас дээш хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг их, хоёр зуугаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг онц их гэж тооцон хохиролын хэмжээг тодорхойлно<sup>12</sup>.

Монгол Улс асуулгад хариулахдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийн сэдэлт нь шунахай болон ашиг олох сэдэлт байдаг гэж хариулсан. Албаны эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийн хувьд “шунахайн” сэдэлт нь төрийн байгууллагаас хөрөнгө, мөнгө өөртөө олж авах буюу бусад этгээдэд шилжүүлэх гэж тодорхойлогдсон. Харин “бусад ашиг олох” гэдэг нь мөнгөн бус ашиг олох үйлдлийг хэлнэ. Эцэст нь “албан эрх мэдэл” гэдгийг сонгуульт болон томилолтын албан тушаалтанд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрх, үндсэн чиг үүргийн нэгдлийг ойлгоно.

Энэ нь хуулийн зүйлд байсан хамгийн тодорхойгүй нэр томъёонуудыг (“албаны эрх мэдлээ урвуулан ашиглах” болон “үлэмж хэмжээний хохирол”) тодорхой болгодог.

Гэсэн хэдий ч айлчлалын үеэр Монгол Улсын албан тушаалтнууд “ашиг олох буюу өөр бусад хувийн сэдэлтээр” гэх нэр томъёоны тайлбарыг асуухад ойлгомжгүй хариулт өгсөн. Тэд бүр Эрүүгийн хуулийн 263.1 дүгээр хэсэгт “ашиг олох” гэж бичигдээгүй гэдгийг хэлсэн.

## **Мөнгө угаах**

Анхны Үнэлгээний тайлан хууль хэрэглэх, хэрэгжүүлэх явцад хуулийн тодорхой байдал, урьдчилан тооцоолж болох боломжийг хангахын тулд мөнгө угаах гэмт хэргийг хуульчилсан Монгол Улс Эрүүгийн хуулийн 166<sup>1</sup> дугаар зүйлдээ “хууль бус үйлдэл” болон “хариуцлага хүлээхээс зайлсхийх” гэх нэр томъёог нарийн тодорхойлох ёстой гэж тэмдэглэсэн.

Монгол Улсын төрийн байгууллагууд мөнгө угаах гэмт хэргийг (2014 оны 1 дүгээр сард нэмэлт өөрчлөлт орсон Эрүүгийн хуулийн 166<sup>1</sup> дүгээр зүйл) харилцан адилгүй байдлаар орчуулсан. Монгол Улсын Санхүүгийн мэдээллийн албаны баталгаажуулсан, хамгийн зөв байх магадлалтай орчуулгыг орчуулгыг дор дурдав:

---

<sup>12</sup> [110 ам доллартай тэнцэж байсан 2013 оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ]-г ашиглан эдгээр хохиролын хэмжээг тодорхойлвол: 110 - 5,500 ам доллар (“бага бус”), 5,500 – 13,750 ам доллар (“үлэмж”), 13,750 – 22,000 ам доллар (“их”), 22,000 ам доллараас их (“онц их”).

“166<sup>1</sup>.1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1</sup>.2. Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1</sup>.3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.-д зааснаар “мөнгө угаах” гэж илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилснийг ойлгоно.

Монгол Улс нь мөнгө угаахтай тэмцэх үндсэн стандартуудыг олон улсын хэмжээнд тодорхойлсон Вейн болон Палермогийн конвенц болон Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсон.<sup>13</sup>

Айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар “хөрөнгийг хувиргасан, шилжүүлсэн” үйлдлүүдийг Эрүүгийн хуулийн 166<sup>1</sup> дугаар зүйл хамруулж чадсан гэж мэдэгдсэн.

Мөн Монгол Улсын Эрүүгийн хуульд 155 дугаар зүйл бий (Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах). Монгол Улсын төрийн байгууллагууд 155 дугаар зүйлийг бүгдийг хамарсан ерөнхий хууль бөгөөд 166<sup>1</sup> дугаар зүйл нь нарийвчилсан зохицуулалт гэж мэдэгдсэн. Иймд тухайн үйлдэл нь 166<sup>1</sup> дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангаж чадахгүй үед 155 дугаар зүйл ашиглагдана. Жишээ нь хөнгөн гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг худалдах гэх мэт.

Мөнгө угаах гэмт хэрэг үүсгэн шалгаж, яллахын тулд суурь гэмт хэргүүдэд заавал хэрэг үүсгэсэн байх шаардлагагүй гэдгийг тодорхой болгохын тулд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, практикт өөрчлөлт хийх ямар нэг алхам хийгдээгүй.

Цаашилбал мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүдэд холбогдсон байх нь 166<sup>1</sup> дүгээр зүйлээр хэрэг үүсгэх үндсэн нөхцөл болох нь батлагдсан юм. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл суурь гэмт хэргүүдэд холбогдсон байх тухай шаардлагад ямар нэг өөрчлөлт оруулаагүй.

##### ***5) Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Конвенцын 20 дугаар зүйлд нийцүүлэх зорилгоор***

---

<sup>13</sup> Монгол Улс 2008 онд Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг ийг хууль бусаар худалдаалын эсрэг НҮБ-ын конвенц (1988 оны Венийн Конвенц), НҮБ-ын Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенцод (2001 оны Палермо) мөн 2006 онд Авлигын эсрэг конвенцод тус тус нэгдэн орсон.



**“Хууль бусаар хөрөнгөжих” зөрчлийг дахин авч үзэх.**

Анхны Үнэлгээний тайлан Монгол Улсыг “хууль бусаар хөрөнгөжих” (Эрүүгийн хуулийн 270<sup>1</sup> дугаар зүйлийг хавсралтаас харна уу) гэмт хэргийг хуульчилсныг нь сайшаасан. Гэхдээ тус зүйлийн томъёолол нь хууль бусаар хөрөнгөжих үйлдлийг мөрдөн шалгахад үр дүнтэй байж чадахгүй байх боломжтой. Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь тухайн албан тушаалтны бодит хөрөнгө болон хууль ёсны орлого хоёрын зөрүү бөгөөд үүний тодорхой жишээг Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын<sup>14</sup> 20 дугаар зүйлээс харж болно. Албан тушаалтныг хууль бус аргаар орлого олсныгоо батлахыг шаарддаг шинж нь тус гэмт хэргийг авлигын гэмт хэрэгтэй адил болгодог. Үндсэндээ эдгээр хоёр гэмт хэрэг хоёул хууль бусаар хөрөнгөжих үйлдлийг гэмт хэрэг гэж тооцдог.

Үнэлгээний тайлан гарснаас хойш тус заалтад өөрчлөлт ороогүй.

Энэхүү хангалтгүй байдал нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 22 дугаар зүйлийн 22.9-т хэвээр байгаа:

“Төрийн албан хаагч өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж, нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлаж, дөрвөн зуун тооцооны нэгжээс арван дөрвөн мянган ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар гэрийн хорионд байлгах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

Энэхүү томъёолол нь олон улсын стандартуудтай ерөнхийдөө нийцэж байгаа.

**б) Хяналтын үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөлийг боломжтой болгосон үйлдэлд хариуцлага хүлээлгэх, хуулийн этгээдийн хариуцлагыг тухайн хэрэгт шалгагдаж байгаа хувь хүний хэргийн илрүүлэлт, яллах ажиллагаа болон тухайн хувь хүний хэрэгт холбогдсон байдлаас үл хамааран бие даасан байлгах зэргийг оролцуулаад тэнцвэртэй, хангалттай залхаан цээрлүүлэх ял шийтгэл оногдуулах замаар авлигын гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулах үр дүнтэй хариуцлагын арга замыг бий болгох.**

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 8 болон 20 дугаар зүйлүүд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээж болно гэж заасан байдаг. Эрүүгийн хуулийн тусгай ангийн ганцхан заалт л хуулийн этгээдийг хариуцлага хүлээх боломжтой гэж заасан – 166<sup>1</sup>.3 дугаар заалт. Мөнгө угаах (тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу 33,000-55,000 ам.доллараар торгох ял шийтгэлтэй).

Ийм учраас Монгол Улс зөвлөмжийг авч хэрэгжүүлээгүй. Цаашилбал хуулийн этгээдийн хариуцлагыг мөнгө угаах гэмт хэрэгт хэрхэн хүлээлгэх нь тодорхойгүй бөгөөд ямар нэгэн журам заасан хуулийн заалт Эрүүгийн хуульд байхгүй. Мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулж байгаа мөнгөн торгуулийн хэмжээ нь олон улсын стандартуудад<sup>15</sup> заасны дагуу хангалттай

<sup>14</sup> Тодруулбал НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 20 дугаар зүйлд “эд хөрөнгө нь их хэмжээгээр өссөн боловч түүнийгээ хууль ёсны орлого гэж үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй байгаа төрийн албан тушаалтан”-ыг заасан байдаг.

<sup>15</sup> Хуулийн этгээдийн хариуцлага болон үндэстний хууль тогтоомжид олон улсын стандартыг хэрэгжүүлэх зөвлөмжийг дараах OECD/ACN-ийн нийтлэлээс харж болно: “Liability of legal persons for corruption in Eastern Europe and Central Asia”, 2015, [www.oecd.org/corruption/acn/ACN-Liability-of-Legal-Persons-2015.pdf](http://www.oecd.org/corruption/acn/ACN-Liability-of-Legal-Persons-2015.pdf) (Англи хэл дээр), [www.oecd.org/corruption/acn/ACN-Liability-of-Legal-Persons-2015-RUS.pdf](http://www.oecd.org/corruption/acn/ACN-Liability-of-Legal-Persons-2015-RUS.pdf) (Орос хэл дээр).

залхаан цээрлүүлсэн шинжтэй биш байна.

Айлчлалын үеэр Монгол Улсын төрийн байгууллагууд Эрүүгийн хуулийн 166<sup>1.3</sup>. дугаар хэсэг практикт ашиглагдаагүйг баталгаажуулсан.

Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Хуулийн этгээдэд ял оногдуулах” гэх бүлэг байдаг. Тус бүлэгт дурдсанаар тухайн хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгчийн ганцаар буюу хамтран гаргасан шийдвэр нь эсхүл тухайн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжийг хангаж байвал хуулийн этгээдэд хариуцлага оногдуулж болно. Хуулийн этгээдэд хариуцлага оногдуулсан тухайн үйлдэлд оролцсон иргэдийг хариуцлагаас чөлөөлөхгүй.

Дараах төрлийн ялыг хуулийн этгээдэд ногдуулж болно: 10,000 - 6,666,000 ам доллараар торгох, нэгээс найман жил хүртэл хугацаагаар тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах, эсхүл татан буулгах.

Хяналтын багт өгсөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зааснаар тодорхой төрлийн гэмт хэргийн хувьд л хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэнэ. Жишээ нь Шинэчилсэн найруулгын 18.9 дэх хэсэгт заасны дагуу мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь хасах ял шийтгэнэ. Мөн хуулийн этгээдийг 666,666 - 6,666,000 ам доллараар торгох ял шийтгэж болно. Харамсалтай нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар авлигын хэрэгт хуулийн этгээд хариуцлага хүлээхгүй.

Хяналтын багт өгсөн хуулийн төслийн зүйл заалтуудаас харахад хуулийн этгээдэд хариуцлага оногдуулах гэмт хэргийн эзлэх хувь нь олон улсын авлигын эсрэг стандартуудад нийцэхгүй байна гэж дүгнэж болно. Нэгдүгээрт төсөл нь авлигын гэмт хэргүүдийг хамраагүй. Хоёрдугаарт, энэ нь хуулийн этгээдийн удирдагч нь доод түвшиний ажилтан, албан хаагчдынхаа үйл ажиллагааг хянаж чадаагүйн улмаас авлига өгөх боломжийг бүрдүүлсэн үед хуулийн этгээдэд хариуцлага оногдуулдаггүй. Гуравдугаарт, хуулийн этгээдийн хариуцлагын бие даасан байдлын баталгаа байхгүй. Энэ нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19.1 дүгээр зүйлд тусгагдсан (Хуулийн этгээдийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн этгээдийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаатай зэрэг явагдана). Үр дүнд нь тухайн гэмт хэрэгт холбогдсон эрх зүйн этгээдийн хариуцлага нь хуулийн этгээдийн хариуцлагаас тусдаа бодитойгоор бие даасан байлаа ч гэсэн хуулийн этгээдийн хариуцлага нь процессын хувьд эрх зүйн этгээдийг мөрдөн шалгаж байгаа ажиллагаатай холбогддог. Энэхүү шаардлага нь хууль сахиулагчид иргэдэд хэрэг үүсгэн шалгах боломжгүй нөхцөлд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх гэсэн хичээл зүтгэлийг талаар болгодог (жишээ нь тухайн иргэн нас барсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс өмнө оргон зайлсан, өөр бусад шалтгааны улмаас эрүүгийн хариуцлагад татах боломжгүй болсон гэх мэт). Хуулийн этгээдийг гадаад улстай холбоотой авлигын хэрэгт хариуцлага хүлээлгэхэд тулгарч болох шаардлагагүй саад тотгороос зайлсхийхийн тулд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын ВиЖиБи нь өөрсдийн Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсон улс орнууд нь эрх зүйн этгээд хэрэгт шалгагдаж, ял шийтгэгдсэн тохиолдолд тухайн хэрэгт холбогдсон хуулийн этгээдийн хариуцлагыг хязгаарлахгүй байх ёстой гэдэг шаардлага тавьсан<sup>16</sup>. Цаашилбал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад “төлөөлөх эрх бүхий этгээд” гэдэг нь юуг илэрхийлж байгаа, ямар хэлбэрийн хуулийн этгээдүүдийг хамруулж байгаа, торгуулийн хэмжээг хэрхэн тодорхойлох, хуулийн этгээд хариуцлагаас мултрахын

<sup>16</sup> Эх сурвалж: Section B of Annex I to the 2009 Recommendation of the Council for Further Combating Bribery of Foreign Public Officials in International Business Transactions.



тулд гаргаж болох хамгаалалтыг тодорхойлоогүй.

Монгол Улсын Хууль зүйн яам үнэлгээний тайлангийн төсөлд өгсөн тайлбартаа авлига бол эрх зүйн этгээдийн үйлддэг идэвхитэй үйлдэл бөгөөд хуулийн этгээд авлигад зориулан мөнгө гаргах үед шийдвэрийг нь үргэлж хувь хүн гаргаж байдаг гэж маргасан.

Хууль зүйн яам давхар ял шийтгэл оногдуулах эрсдэлийг бодолцож үзээд үүнээс шалтгаалан хуулийн этгээдийн хариуцлагыг цөөн хэдхэн хэрэгт оногдуулахаар шийдсэн гэдгээ мэдэгдсэн. Мөн яам хуулийн этгээдийн хариуцлага нь хуулийн этгээдийн санхүүгийн нөхцөл байдалд нөлөөлж болох тухай мэдэгдсэн.

Хяналтын баг хуулийн этгээдийн хариуцлагын үндсэн логик, мөн чанартай харшилж байгаа эдгээр тайлбарыг хүлээн зөвшөөрч чадахгүй. Эрх зүйн этгээдэд ял шийтгэл оногдуулах нь үр дүнгүй, дийлэнх авлигын хэргээс хамгийн их ашиг хүртдэг, удирдлага хяналтын үйлдэл эсхүл эс үйлдэхүйгээрээ авлигад чиглэл өгч, боломж олгож, дэмжлэг өгдөг компанийг хариуцлагаас хамгаалдаг гэдэг нь батлагдсан. Хуулийн этгээд бол үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, ажилтнуудаас тусдаа бие даасан эрх үүрэгтэй, тусдаа этгээд учраас өөрийн “үйлдэл, эс үйлдэхүйн” хариуцлагыг хүлээх ёстой. Авлига болон мөнгө угаах гэмт хэрэгт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх нь олон хэм хэмжээний (Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцыг оролцуулаад) дагуу зайлшгүй байх ёстой байдаг тогтсон практик юм. Мөн эдгээр хэм хэмжээнүүд нь хуулийн этгээдийн хариуцлага нь хүчинтэй л байвал тухайн улсад оногдуулах хариуцлагын мөн чанар (эрүү, иргэн, захиргааны) болон хэлбэрийг өөрсдөө сонгох боломжийг олгодог. Цаашилбал улс орнууд зөвхөн залхаан цээрлүүлсэн ч биш, мөн тэнцвэртэй буюу хуулийн этгээдийг санхүүгийн хувьд хүнд байдалд оруулахгүйгээр гаргасан зөрчилд нь шийтгэл оногдуулах шийтгэлийн системийг бий болгох ёстой.

Хяналтын баг нь Монгол Улсын төрийн байгууллагуудыг хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх гэсэн анхдагч хүчин чармайлтад нь сайшаалтай хандаж байгаа боловч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох зүйл заалтуудыг IAP-ийн зөвлөмж болон олон улсын стандартуудад<sup>17</sup> нийцүүлэн дахин шинэчлэн найруулахыг санал болгож байна.

## Дүгнэлт

Авлигын зөрчилийн Монгол Улсын хуулийн зүйл заалтууд нь олон улсын стандарт болон IAP-ийн зөвлөмжүүдэд нийцээгүй байна. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд дээр дурдсанчлан хэд хэдэн чухал зүйл заалт байхгүй байна. Тухайлбал: (i) хээл хахуулийн санал, амлалт, тухайн санал амлалтыг хүлээн зөвшөөрсөн үйлдэл, хээл хахууль авах хүсэлт зэргийг гэмт хэрэгт тооцох, (ii) биет бус болон мөнгөн биш ашиг тусыг багтаасан “авлигын” тодорхойлолт нэвтрүүлэх, (iii) хууль бус нөлөөлөл болон хувийн салбар дахь авлигыг зүй зохистой, тодорхой гэмт хэрэгт тооцох, болон (iv) хуулийн этгээдэд оногдуулах үр дүнтэй хариуцлага бий болгох зэрэг юм. Монгол Улс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж байгаа. Энэ нь тодорхойлсон сул талуудыг засаж залруулах, Монгол Улсын Эрүүгийн хуулийн авлигатай холбоотой зүйл заалтуудыг бэхжүүлэх маш сайн боломж юм. Гэсэн хэдий ч одоогийн хууль тогтоомжид байгаа сул талуудыг засаж залруулахын тулд хяналтын багийн судалсан хуулийн төсөл маш их өөрчлөгдөх хэрэгтэй.

Хүчин төгөлдөр хэвээр үлдсэн 2.1.-2.2. дахь зөвлөмжүүдийг Монгол Улс **хэсэгчлэн**

---

<sup>17</sup> Холбогдох олон улсын стандартуудыг дараах зөвлөмжөөс харна уу: Policy Recommendations in the OECD/ACN Study on Liability of Legal Persons for Corruption in Eastern Europe and Central Asia, 2015, [www.oecd.org/corruption/acn/ACN-Liability-of-Legal-Persons-2015.pdf](http://www.oecd.org/corruption/acn/ACN-Liability-of-Legal-Persons-2015.pdf).

**биелүүлсэн байна.**

## 2.3. Албан тушаалтны тодорхойлолт

### 2.3-р зөвлөмжүүд

- 1) *Авлигын гэмт хэрэгт хамааралтай бүхий л төрийн болон өөрөө удирдах байгууллагын ажилтан болон бусад нийтийн эрх зүйн эрх үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчид, сонгуулиар эрх олж авдаг албан тушаалуудын жагсаалтыг эрүүгийн хуульдаа тусгаж өгөх.*
- 2) *Олон улсын стандартад нийцүүлэн гадаад улсын албан тушаалтны оролцож болох авлигын гэмт хэргийг хуульчилж, тэдгээр албан тушаалуудыг Эрүүгийн хуульдаа тодорхой тусгах.*

*1) Авлигын гэмт хэрэгт хамааралтай бүхий л төрийн болон өөрөө удирдах байгууллагын ажилтан болон бусад нийтийн эрх зүйн эрх үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчид, сонгуулиар эрх олж авдаг албан тушаалуудын жагсаалтыг эрүүгийн хуульдаа тусгаж өгөх.*

Үнэлгээний тайлан Монгол Улсын Эрүүгийн хууль болон бусад тайлбар хийсэн эх сурвалжуудын (Улсын дээд шүүхийн 23 дугаар тогтоолыг оролцуулаад) аль нь ч хээл хахуулийн гэмт хэрэгт ашиглагдаж байгаа “албан тушаалтан” гэх ойлголтыг тайлбарлаагүй гэж үзсэн. Гэхдээ Эрүүгийн хуулийн 263 болон 265 дугаар зүйлийн тайлбарт зарим нэг тайлбарууд бий. 263 дугаар зүйлийн тайлбарт “төрийн албан тушаалтан” гэдэгт төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна, мөн 265 дугаар зүйлийн тайлбарт “төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан” гэдэгт төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна гэж тайлбарласан.

Хэдийгээр Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд заасан тодорхойлолт бусад зүйл ангиудад хэрэглэгдэх боломжтой боловч энэ нь олон улсын стандартад нийцдэггүй. Учир нь энэ нь удирдах, зохион байгуулах албан тушаалтнуудыг л хамаарч байдаг тул туслах ажилтнуудыг хамааруулж чаддаггүй (жишээ нь нарийн бичиг, туслах, бичээч, шуудан зөөгч, жолооч, архивын ажилтан гэх мэт).

Ийм учраас өмнөх зөвлөмж хэрэгжээгүй бөгөөд хүчин төгөлдөр байна: Авлигын гэмт хэрэгт хамааралтай албан тушаалын жагсаалтыг Эрүүгийн хуульд тусгаж, тус ойлголт нь илүү өргөн цар хүрээтэйгээр төрийн байгууллагын ажилтнуудыг болон төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа хувийн хэвшлийн болоод төрийн байгууллагын албан тушаалыг жагсаах ёстой<sup>18</sup>.

Монгол Улсын төрийн байгууллагууд “төрийн албан тушаалтан”-ыг тодорхойлоход бэрхшээлтэй болох үед оролцогчид Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд заасан ангиллыг ашиглаж болно гэж мэдээлсэн. Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйл төрийн албан тушаалыг 1) төрийн улс төрийн; 2) төрийн захиргааны; 3) төрийн тусгай (шүүгч, прокурор, дипломатч гэх мэт); болон 4) төрийн үйлчилгээний гэж ангилсан.

Төрийн албан хаагч гэх ойлголтыг 11 дүгээр зүйлд тайлбарласан: “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ”. Гэхдээ өмнө нь

<sup>18</sup> Тодорхойлолтыг ACN/IAP Summary report for 2009-2013-аас харна уу, 66-р хуудас.

дурдсанчлан энэ нь хангалттай биш бөгөөд эрүүгийн хуулийг өөр салбарын хуультай төсөөтэй хэрэглэхийг Эрүүгийн хуулийн 3.2-т хориглосон. Хууль тодорхой байх зарчмын дагуу эрүүгийн эрх зүйд ашиглагдаж байгаа бүхий л нэр томьёо нь тодорхой тодорхойлогдсон, эсхүл өөр хуулиас иш татсан тодорхой ишлэлтэй байх ёстой.

Монгол Улсын төрийн байгууллагууд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь “албан тушаалтан” гэх ойлголтыг тун өргөн цар хүрээтэй тодорхойлсон бөгөөд төрийн албан хаагчид, хувийн хэвшлийн албан тушаалтнууд, гадаад улсын албан тушаалтан, хоёрдогч (туслах) албан тушаалтнуудыг багтааж “хөдөлмөрийн гэрээгээр үүрэг хүлээсэн бүхий л албан тушаалтныг” багтаасан гэж тайлбарласан. Гэсэн хэдий ч хяналтын багт өгсөн хуулийн төсөл нь тэдний хэлсэн үгтэй нийцээгүй бөгөөд хуулийн төсөлд дурдсанаар хоёр төрлийн албан тушаалтан авлигын хэрэгт холбогдох боломжтой бөгөөд тэдгээр нь “хууль, захиргааны акт, гэрээний дагуу үүрэг хүлээсэн этгээд” болон “төрийн албан хаагч” юм.

Ерөнхийдөө Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь “албан тушаалтан” гэх ойлголтын нарийвчилсан тодорхойлолтыг нэвтрүүлж, авлигын хэрэгт холбогдох боломж бүхий албан тушаалтнуудыг тодорхойлоогүй. Төсөл боловсруулагчид “хууль, захиргааны акт, гэрээний дагуу үүрэг хүлээсэн этгээд”, “төрийн албан хаагч”, “улс төрийн нөлөө бүхий этгээд”, “хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан” гэх нэр томьёо ашигласан боловч эдгээр нэр томьёог тайлбарлаагүй.

***2) Олон улсын стандартад нийцүүлэн гадаад улсын албан тушаалтны оролцож болох авлигын гэмт хэргийг хуульчилж, тэдгээр албан тушаалуудыг Эрүүгийн хуульдаа тодорхой тусгах.***

Монгол Улсын Эрүүгийн хууль гадаад улсын албан тушаалтны холбогдсон авлигын хэргийг гэмт хэрэгт тооцоогүй гэж Үнэлгээний тайлан тэмдэглэсэн. Монгол Улсын төрийн байгууллагууд хяналтын асуулгад хариулахдаа гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийг заасан. Энэ заалтын дагуу гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон гадаадын иргэнд ямар нэг онцгой байдлаар хандахгүй.

Энэ тайлбарыг хангалттай гэхэд хэцүү. Нэгдүгээрт, авлигын хэрэгт холбогдох “албан тушаалтны тодорхойлолт” байхгүй гэх ерөнхий асуудал бий (дээрхийг харна уу). Хоёрдугаарт, албан тушаалтан гэх ойлголт нь гадаад улсын албан тушаалтныг хамаарч байгаа гэдэгт баталгаа байхгүй.

Олон улсын стандартууд улс орнуудыг гадаад улсын авлигын хэрэгт зориулан шинэ тусдаа гэмт хэрэг хуульчлах замаар, эсхүл гадаадын албан тушаалтнуудыг хамруулахын тулд авлигын хэргээр эрүүгийн хариуцлагад татагдах боломжтой албан тушаалын тодорхойлолтыг дэлгэрүүлэх замаар гадаад улсын албан тушаалтнуудын авлигыг гэмт хэрэгт тооцохыг зөвшөөрдөг. Гадаадын албан тушаалтны авлигыг гэмт хэрэгт тооцсон Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний улс орнууд хоёр дахь замыг сонгож, албан тушаалтны тодорхойлолтыг дэлгэрүүлж гадаадын албан тушаалтныг багтаасан<sup>19</sup>. Гэхдээ авлигын гэмт хэрэгт холбогдох боломжтой албан тушаалтнуудын тодорхойлолтод гадаад улсын албан тушаалтныг нарийвчлан дурдсан байх ёстой.

Айлчлалын үеэр Монгол Улсын төрийн байгууллагууд удаа дараа одоогийн Эрүүгийн хууль

<sup>19</sup> Эх сурвалж: ACN/IAP Summary report for 2009-2013, cited above, 67-68 дугаар хуудас.

гадаад улсын албан тушаалтнуудад зориулсан ямар нэгэн онцгой зохицуулалтгүй гэж мэдэгдсэн. Эрүүгийн хуулийн 13.1. дэх хэсгийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бүхий л гэмт хэрэгт ял онооно. Мөн тэд 14.4. болон 14.5. дахь хэсгүүдийн дагуу Монгол Улсын хилийн гадна гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний үйлдсэн гэмт хэрэгт Монгол Улсад байцаан шийтгэх ажиллагаа явуулж болно гэж үргэлжлүүлэн тодруулсан. Гэхдээ энэ нь зөвхөн тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн улстай холбогдох олон улсын гэрээтэй тохиолдолд л боломжтой юм. Үгүй бол эрүүгийн хэргийг түдгэлзүүлнэ. Дээр дурдсанчлан энэхүү арга зам нь хангалтгүй юм.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь гадаад улсын албан тушаалтнуудын талаар хоёр зүйл анги нэвтрүүлсэн. 22.3 дугаар хэсэг (Гадаад улсын болон олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах) болон 22.6 дугаар хэсэг (Гадаад улсын болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах).

22.3 дахь хэсгийн тайлбарт "энэ зүйлд заасан олон улсын байгууллагын албан тушаалтан гэдэгт олон улсын, эсхүл Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын ажилтан, эсхүл тухайн байгууллагыг төлөөлөх, эсхүл тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий, эсхүл тухайн байгууллагаас томилогдсон хүнийг ойлгоно" гэж заасан. Гэхдээ энэхүү тайлбар нь олон улсын төрийн бус байгууллагын албан тушаалтныг хамруулаагүй. Мөн гадаад улсын төрийн албан тушаалтныг ч гэсэн хамруулаагүй.

Зүйл ангийхаа гарчгийг үл харгалзан (дээрхийг харна уу) Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22.6 дугаар хэсэг гадаад улсын болоод олон улсын байгууллагын албан тушаалтнуудын идэвхитэй болон идэвхигүй авлигын хэргийг хамаарсан. Гэхдээ энэ зүйл гэмт хэргийн субъектыг тодорхойлоогүй. Мөн энэ зүйлд дээр дурдсан дутагдалтай талууд байсаар байгаа ("хээл хахууль", шууд бус хээл хахууль, хээл хахууль өгөх санал болон амлалтыг хүлээн зөвшөөрсөн үйлдэл зэргийг тодорхойлсон зүйл байхгүй).

Монгол Улс 2.3 дахь зөвлөмжийг **хэрэгжүүлээгүй** бөгөөд тус зөвлөмж хүчинтэй хэвээр байна.

## 2.4. - 2.5. Ял шийтгэл болон хөрөнгө албадан хураах

### 2.4.-ээс 2.5.-р зөвлөмжүүд

- 1) Авлигын гэмт хэргүүдийн ял шийтгэлийг дахин авч үзэх замаар тэднийг үр дүнтэй, тэнцвэртэй, залхаан цээрлүүлсэн шинжтэй байгаа гэдгийг баталгаажуулах.
- 2) Авлигын гэмт хэргүүдийн ял шийтгэл болон хууль хэрэглээний статистикыг түүвэрлэж, шинжилгээ хийх замаар тэднийг хэр үр дүнтэй байгааг тогтоох (тэнсэн харгалзах ял хэр тогтмол хэрэглэгдэж байгаа, хүнд гэмт хэргийн хувьд хорих ял үндсэн ял байгаа эсэх гэх мэт).
- 3) Эд хөрөнгө албадан хураахтай холбоотой зүйл заалтуудыг засах замаар авлига болон авлигатай холбоотой бүхий л гэмт хэргийн өөрчлөгдсөн, холилдсон хөрөнгө, тэдгээрийн үндсэн дээр бий болсон ашиг, үнэ цэнэд үндэслэсэн хөрөнгө хураах ажиллагааг оролцуулаад гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зүйлсийг заавал хураадаг болох; Хөрөнгө хураах ажиллагааны (эрүүгийн эсхүл иргэний журмаар) нотолгооны бэрхиээлийг өөрчилж, өргөжүүлсэн хөрөнгө хураах зарчмыг нэвтрүүлэх.

*1) Авлигын гэмт хэргүүдийн ял шийтгэлийг дахин авч үзэх замаар тэднийг үр дүнтэй, тэнцвэртэй, залхаан цээрлүүлсэн шинжтэй байгаа гэдгийг баталгаажуулах.*

Үнэлгээний тайланд дурдсанчлан, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргүүдийн ял шийтгэл (доорх хүснэгтийг харна уу) нь тэнцвэртэй, залхаан цээрлүүлсэн шинжтэй биш байна. Учир нь:

- 1) Хэдийгээр торгох ял (сонгох ял) нь олон авлигын хүнд гэмт хэрэг болон өөр олон гэмт хэргийн хувьд боломжтой боловч торгуулийн хэмжээ нь хангалттай залхаан цээрлүүлсэн биш байна.
- 2) Хөрөнгө хураах ял нь цөөн тооны гэмт хэргийн хувьд хэрэглэх боломжтой – хүндрүүлэн нөхцөлтэй идэвхигүй хээл хахууль, хүндрүүлэх нөхцөлтэй мөнгө угаах болон эд хөрөнгө завших гэмт хэрэг (эд хөрөнгө хураах ялын хэсгийг харна уу).
- 3) ялын төрлүүд тэнцвэртэй ял оногдуулах боломжийг олгодоггүй (жишээ нь их болон онц их хэмжээний авлигын хэрэгт хоёуланд нь адил ял шийтгэдэг, мөн хүндрүүлэх нөхцөлтэй идэвхитэй болон идэвхигүй бүхий л авлигын хэрэгт ганцхан зүйл байдаг гэх мэт.).
- 4) Зарим гэмт хэргийн ял хэтэрхий бага (жишээ нь авлига зуучилсан гэмт хэрэгт 5,500 ам доллар хүртэл мөнгөөр торгох, гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэдэг.).

**Хүснэгт 14. Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу авлига болон авлигатай холбоотой гэмт хэргүүдэд оногдуулах ял**

	Торгох ял	Албадан хөдөлмөр лүүлэх	Тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах (Үндсэн болон нэмэгдэл ялын чанартай)	Эд хөрөнгө хураах	Баривчлах	Хорих
<b>Хээл хахууль авах (268.1 дүгээр хэсэг)</b>	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	5 жил хүртэл
Хээл хахууль авах (268.2 дугаар хэсэг: давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд , түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль <sup>20</sup> авсан)	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм (гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг)	Үгүй	5-10 жил
<b>Хээл хахууль өгөх (269.1 дүгээр хэсэг)</b>	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	Үгүй	5 хүртэл жил
Хээл хахууль өгөх (269.2 дугаар хэсэг: давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд , түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн)	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	5-8 жил
<b>Хээл хахууль зуучлах (270.1 дүгээр хэсэг)</b>	550 – 5,500 ам доллар	Үгүй	Үгүй	Үгүй	1-3 сар	Үгүй

<sup>20</sup> Их хэмжээний хээл хахууль хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 125-200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх бөгөөд энэ нь ойролцоогоор 13,500-21,500 ам доллартай тэнцэнэ. Онц их хэмжээний нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200 буюу түүнээс дахин нэмэгдүүлсэнтэй буюу 21,500 ам доллараас илүү их.

Хээл хахууль зуучлах (270.2 дугаар хэсэг: Давтан буюу албан тушаалын байдлаа ашиглаж)	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	Үгүй	5 жил хүртэл
<b>Хууль бусаар хөрөнгөжих</b> (270 <sup>1.1</sup> дүгээр хэсэг)	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	Үгүй	3 жил хүртэл
Хууль бусаар хөрөнгөжих(270 <sup>1.2</sup> дугаар хэсэг: онц их хэмжээгээр)	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	Үгүй	3-8 жил хүртэл
Албаны эрх мэдлээ урвуулан ашиглах (263.1 дүгээр хэсэг)	550 – 5,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	1-3 сар	Үгүй
Албаны эрх мэдлээ урвуулан ашиглах (263.2 дугаар хэсэг)	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	Үгүй	5 жил хүртэл
<b>Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх</b> (264.1 дүгээр хэсэг)	550 – 5,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	1-3 сар	Үгүй
Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх (264.2 дугаар хэсэг)	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	3-6 сар	5 жил хүртэл
<b>Мөнгө угаах</b> (166 <sup>1.1</sup> дүгээр хэсэг)	5,610 – 27,500 ам доллар	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	5 жил хүртэл
Мөнгө угаах (166 <sup>1.2</sup> дугаар хэсэг)	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	5-10 жил
Мөнгө угаах (166 <sup>1.3</sup> дугаар хэсэг)	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	10-15 жил
<b>Бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх</b> (150.1 дүгээр хэсэг)	550 – 5,500 ам доллар	Үгүй	Тийм (нэмэгдэл ял)	Үгүй	1-3 сар	Үгүй



Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх (150.3 дугаар хэсэг)	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	5-10 жил
<b>Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах</b> (148.1 дүгээр хэсэг)	550 – 5,500 ам доллар	Тийм	Үгүй	Үгүй	1-3 сар	Үгүй

\*Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бодож ам долларт хөрвүүлэв.

Монгол Улсын төрийн байгууллагууд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь ял шийтгэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ гэж мэдэгдэж байгаа боловч анхны үнэлгээ хийгдсэнээс хойш ямар нэг өөрчлөлт хийгдээгүй байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хянаж үзсэн хяналтын баг нь төсөл боловсруулагчид нь зарим авлигын хэргийн ялын залхаан цээрлүүлэх чадварыг бууруулж, хорих ялын хугацаа болон торгуулийн хэмжээг бууруулсан байна гэж үзэж байна. Жишээ нь, хүндрүүлэх нөхцөлгүйгээр хээл хахууль авсан гэмт хэргийн торгох ялын дээд хэмжээ нь 27 500 ам доллар байгаа бол Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан адил гэмт хэргийн ялын дээд хэмжээ нь 14,000 ам доллар болтлоо буурсан байна.

Үүнээс гадна, Засгийн газар Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эд хөрөнгө хураах ялтай холбоотой заалтуудыг гаргаж өгөөгүй. Иймд хуулийн төсөл батлагдсанаар бүхий л авлигын болоод хээл хахуулийн гэмт хэрэгт зориулсан үр дүнтэй эд хөрөнгө хураах механизм бий болох эсэх нь тодорхойгүй.

**2) Авлигын гэмт хэргүүдийн ял шийтгэл болон хууль хэрэглээний статистикийг түүвэрлэж, шинжилгээ хийх замаар тэднийг хэр үр дүнтэй байгааг тогтоох (тэнсэн харгалзах ял хэр тогтмол хэрэглэгдэж байгаа, хүнд гэмт хэргийн хувьд хорих ял үндсэн ял байгаа эсэх гэх мэт).**

Монгол Улсын төрийн байгууллагууд авлигын олон гэмт хэргийн хувьд ялыг хэрхэн хэрэглэж байгаа тухай статистик мэдээ гаргаж өгсөн (Хавсралт 2-ыг харна уу). Тус мэдээ ёсоор 2012-2014 онд нийт 9 иргэн тэнсэн харгалзах ял авсан. Өмнө нь санал болгож боловч энэхүү статистик мэдээний дүн шинжилгээ нь бэлэн байгаагүй.

**3) Эд хөрөнгө албадан хураахтай холбоотой зүйл заалтуудыг засах замаар авлига болон авлигатай холбоотой бүхий л гэмт хэргийн өөрчлөгдсөн, холилдсон хөрөнгө, тэдгээрийн үндсэн дээр бий болсон ашиг, үнэ цэнэд үндэслэсэн хөрөнгө хураах ажиллагааг оролцуулаад гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зүйлсийг заавал хураадаг болох; Хөрөнгө хураах ажиллагааны (эрүүгийн эсхүл иргэний журмаар) нотолгооны бэрхшээлийг өөрчилж, өргөжүүлсэн хөрөнгө хураах зарчмыг нэвтрүүлэх.**

Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу Эрүүгийн хуульд заасан бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг албадан гаргуулж болно. Үүний адилаар Эрүүгийн хуульд заасан бол гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг (хэрвээ гэмт хэрэгтний өмчлөлд байгаа бол) хурааж болно. Гэсэн хэдий ч дээр дурдсан ял шийтгэлийн хүснэгтэд заасанчлан хүндрүүлэх нөхцөлтэй мөнгө угаах болон бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийн хувьд л эд хөрөнгө хураах ял шийтгэж болно. Мөн хүндрүүлэх нөхцөлтэй идэвхигүй хээл хахуулийн хэрэгт “хууль бусаар олсон хөрөнгийг хурааж” болно.

Олон улсын стандартууд бүхий л авлига болон холбоотой гэмт хэргүүдээс олсон орлого болон тухайн гэмт хэрэг үйлдсэн эд зүйлсийг бүгдийг хураахыг шаарддаг бөгөөд Үнэлгээний тайланд зааснаар Монгол Улсын зохицуулалт нь эдгээр стандартуудын шаардлагад хүрээгүй байна. Холбогдох заалтууд нь өөр эд хөрөнгөд хувирсан орлого (авлига авч олсон орлогоор авсан орон сууц гэх мэт) болон хууль ёсоор олсон эд хөрөнгөтэй холилдож нэгдсэн (хувирсан эсхүл холилдсон орлого) орлогыг шууд хамааруулж, нуусан, утсан, үрж зарцуулсан, гуравдагч этгээдэд дүр эсгэн шилжүүлсэн хөрөнгийг хураах үнэ цэнэд үндэслэсэн эд хөрөнгө хураах ажиллагаа явуулах боломжийг олгох хэрэгтэй. Мөн гэмт хэрэг үйлдэж олсон орлогоос олсон ашгийг (авлига өгч олж авсан тусгай зөвшөөрлийн дагуу олсон ашиг, авлигаар оруулсан хөрөнгө оруулалтын ашиг гэх мэт) хураах ч гэсэн боломжтой байх ёстой.

Эцэст нь Монгол Улсын Эрүүгийн хууль авлигаар авсан орлого нь зөвхөн гэмт хэрэгтний нэр дээр бүртгэлтэй үед л эд хөрөнгийг хураадаг болох нь харагдаж байна. Эд хөрөнгө хураах энэхүү зохицуулалт нь эд хөрөнгөө хураалгахгүйн тулд авлигаар олсон орлогоор авсан эд хөрөнгөө гуравдагч этгээдэд шилжүүлэх буюу гуравдагч этгээдийн нэр дээр бүртгүүлэх залилан мэхэлсэн шинжтэй үйлдлийг нь дэмжиж байна.

Үнэлгээний тайлан гарснаас хойш хуульд ямар нэг өөрчлөлт ороогүй.

Үүнээс гадна Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлд процессийн хөрөнгө хураалт гэж нэрлэгдэх зохицуулалт байх бөгөөд үүний дагуу “гэмт хэрэг үйлдэж олсон орлого болон түүнтэй адилгаж болох эд хөрөнгийг” хураадаг. Энэ мэт хөрөнгө болон орлого нь эд мөрийн баримт гэж тооцогдох бөгөөд эдгээрийг хууль ёсны өмчлөгчид нь эргүүлэн өгөх ёстой. Гэхдээ хэрвээ тухайн эд хөрөнгийн өмчлөгчийн тодорхойлох боломжгүй бол тэдгээр хөрөнгийг хураана.

Айлчлалын үеэр Монгол Улсын төрийн байгууллагууд Эрүүгийн хуулийн 268.2 дугаар хэсэгт заасан “хууль бус орлогыг хураах” ажиллагаа нь Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд заасантай адил гэж баталсан.

Монгол Улсын төрийн байгууллагууд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлд заасан процессын эд хөрөнгө хураах арга хэмжээ нь Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд заасан эд хөрөнгө хураах ялтай хэрхэн нийцэж байгааг тодорхой тайлбарлаж чадаагүй. Хэрвээ шүүх хууль бус орлого олсныг нь тогтоох юм бол тэд Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авч хэрэглэнэ гэж мэдэгдсэн.

Практикт гэмт хэрэг мөрдөн шалгах, яллах ажиллагааны явцад өөр бусад этгээдийн нэр дээр бүртгэгдсэн гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгийг таньж олох, хураахад хүндрэл тулгардаг. Гэхдээ мөрдөн байцаалтын явцад хууль бус орлогын эх үүсвэрийг тогтоож чадвал тэдгээр хөрөнгө, орлогыг битүүмжилж, тэднийг хураах ажиллагааг баталгаажуулах боломжтой. Энэ тохиолдолд асуудлыг дийлэнхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний маргаан (Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 15 дугаар бүлэг) үүсгэх замаар шийдвэрлэдэг. Тус ажиллагааны дагуу шүүх хууль бусаар олж авсан эд хөрөнгийг хууль бус өмчлөгчөөс авч, хууль ёсны өмчлөгчид буцааж олгоно. Энэ тохиолдолд шүүх хууль бус орлогыг хууль ёсны өмчлөгчид нь эргүүлэн өгөх цорын ганц эрх зүйн эх сурвалж болох Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88.1.4. дэх заалтыг хэрэглэх хандлагатай байдаг. Ямар ч тохиолдолд хууль бус орлогыг хууль ёсны өмчлөгчид нь буцааж өгөөгүй бол төрийн өмчлөлд шилжүүлэх ёстой.

Хууль бусаар олсон эд хөрөнгө, орлогыг эд хөрөнгийн эх үүсвэрийг олж мэдээгүй гуравдагч этгээд шударгаар олж авсан бол тухайн эд хөрөнгийг албадан хурааж болохгүй. Хэрвээ тухайн эд хөрөнгийн өмчлөлийн талаар маргаан гарвал сонирхогч этгээд тусдаа иргэний маргаан үүсгэж болно.

Монгол Улс 2.4.-2.5. дахь **зөвлөмжүүдийг биелүүлээгүй** бөгөөд тус зөвлөмжүүд хүчин төгөлдөр хэвээр байна.

## 2.6. Халдашгүй дархан байх эрх болон хөөн хэлэлцэх хугацаа

### 2.6.-р зөвлөмжүүд

- 1) *Халдашгүй дархан эрх эдлэх албан тушаалтны жагсаалтыг хумиж, эрх хэмжээг нь багасгаж ардчилсан улсад шаардлагатай хэмжээнд хүргэх замаар халдашгүй дархан эрхийн системийг дахин авч үзэх; үлдэж буй халдашгүй дархан эрх нь үр дүнтэй, зөвхөн албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд үйлчилж, гэмт хэрэг үйлдэж байх үедээ баригдсан бол үйлчлэхгүй байх, халдашгүй дархан эрхтэй этгээдийн хувьд хэрэгжүүлэх үр дүнтэй мөрдөн шалгах аргыг зөвшөөрөх; тодорхой шаардлага нөхцөл биелсэн тохиолдолд халдашгүй дархан байх эрхийг түдгэлзүүлэх түргэн шуурхай, үр дүнтэй журам бий болгох.*
- 2) *Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх; авлигын бүх гэмт хэрэгт тухайн хэргийн ангилалаас үл хамааран тогтсон урт хугацааны хөөн хэлэлцэх хугацааг ягштал баримтлах; хангалттай урт хөөн хэлэлцэх хугацаа тогтоох; хөөн хэлэлцэх хугацааг тухайн хүн халдашгүй дархан эрх эдлэх хугацаанд болон ял оноох эсхүл бусад үйл ажиллагааны хугацаанд түр зогсоох заалтыг хуулинд тусгаж өгөх асуудлыг хянан үзэх.*

*1) Халдашгүй дархан эрх эдлэх албан тушаалтны жагсаалтыг хумиж, эрх хэмжээг нь багасгаж ардчилсан улсад шаардлагатай хэмжээнд хүргэх замаар халдашгүй дархан эрхийн системийг дахин авч үзэх; үлдэж буй халдашгүй дархан эрх нь үр дүнтэй, зөвхөн албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд үйлчилж, гэмт хэрэг үйлдэж байх үедээ баригдсан бол үйлчлэхгүй байх, халдашгүй дархан эрхтэй этгээдийн хувьд хэрэгжүүлэх үр дүнтэй мөрдөн шалгах аргыг зөвшөөрөх; тодорхой шаардлага нөхцөл биелсэн тохиолдолд халдашгүй дархан байх эрхийг түдгэлзүүлэх түргэн шуурхай, үр дүнтэй журам бий болгох.*

Үнэлгээний тайланд дурдсанчлан Монгол улсын Үндсэн хуулиар бараг бүх өндөр албан тушаалтан халдашгүй дархан эрхтэй байна: Улсын их хурлын гишүүд (29 дүгээр зүйл), Ерөнхийлөгч (36 дугаар зүйл), Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд (42 дугаар зүйл). Харин халдашгүй дархан байх эрхийг хүчингүй болгох журмын талаар тодорхой удирдамж байхгүй. Цаашилбал зарим төрийн байгууллагын албан хаагчдад дараах хуулиудын дагуу халдашгүй дархан эрх олгосон байна: Шүүхийн тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Тагнуулын байгууллагын тухай хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Улсын их хурлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, Төв банкны тухай хууль, Аудитын тухай хууль, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль. Үнэлгээний тайлан авлигын эсрэг хууль тогтоомжоос хамгаалах халдашгүй дархан байх эрхийг төрийн өндөр албан тушаалтнуудад олгох нь тэдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг тууштай үгүй хийдэг гэсэн дүгнэлтэд хүрсэн. Халдашгүй дархан байдлыг хүчингүй болгох журмыг тодорхойлоогүйгээс болж энэхүү сул тал бий болдог.

Хяналтын асуулгад өгсөн хариултдаа Монгол Улсын төрийн байгууллагууд дараах төрийн өндөр албан тушаалтнууд халдашгүй дархан эрх эдэлдэг гэж хариулсан. Үүнд: Ерөнхийлөгч (Үндсэн хуулийн 36 дугаар зүйл), Улсын их хурлын гишүүд (Үндсэн хуулийн 29 дүгээр зүйл), Яамдуудын сайдууд (Үндсэн хуулийн 42 дугаар зүйл), Дипломат төлөөлөгчид (Дипломат албаны тухай хуулийн 8 дугаар зүйл). Төрийн байгууллагуудын хариултад дурдсанаар халдашгүй дархан байх эрх нь тухайн албан тушаалтныг үүрэгт ажлаа гүйцэтгэж

байхад л хүчин төгөлдөр байна. Хэрвээ халдашгүй дархан эрх эдэлж байгаа этгээд гэмт хэрэг үйлдэж байх явцдаа баригдвал эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шууд эхлүүлж болохгүй. Тухайн этгээдийн халдашгүй дархан эрх түдгэлзсэн тохиолдолд л мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж болно.

Нээлттэй байгаа мэдээллийн дагуу халдашгүй дархан байх эрхэд ямар эрхүүд ордог, тэдгээрийг хэрхэн хүчингүй болгох журам нь тодорхойгүй байна.

2012-2014 онд Улсын Их хурлын гишүүн, Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүний халдашгүй дархан байх эрхийг хүчингүй болгосон тохиолдол гараагүй. Мөн хугацаанд гурван прокурор, дөрвөн шүүгч, Үндсэн хуулийн цэцийн шүүгч нэг, Улсын их хурлын гурван гишүүнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ. Тэднээс хоёр прокурор, нэг шүүгч нь албан ёсоор буруутай тогтоогдсон байна (тэдний холбогдсон хэрэг нь авлигын хэрэг мөн эсэх нь тодорхойгүй). Улсын ерөнхий прокурорын тушаалаар хоёр прокурорын эрхийг түдгэлзүүлсэн. Шүүхийн ерөнхий зөвлөл болон Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн цэцийн гишүүний эрхийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан бөгөөд тус байгууллагууд хүсэлтийг авмагцаа Ерөнхийлөгчид дамжуулсан боловч хүсэлтийг хангахаас татгалзжээ.

Айлчлалын үеэр Монгол Улсын төрийн байгууллагууд халдашгүй дархан эрх нь үүрэгт ажлаа гүйцэтгэж байх хугацаанд буюу ээлжийн амралт, бүх нийтийн амралт, долоо хоногийн амралтын өдрүүдэд ч гэсэн хүчинтэй байдаг гэж мэдэгдсэн. Халдашгүй дархан байх эрх нь бүхий л төрийн байгууллагаас хамгаалах бөгөөд тухайн этгээд албан үүрэгтэйгээ холбоогүйгээр амралтын өдөр гэмт хэрэг үйлдсэн байсан ч халдашгүй дархан эрх хүчинтэй байсаар байна. Энэхүү тайлбараас харахад халдашгүй дархан байх эрх нь уян хатан биш, харин хязгааргүй бүрэн эрх болж таарч байна.

Төрийн байгууллагууд халдашгүй дархан эрх нь ерөнхийдөө мөрдөн шалгах явцад саад болдоггүй боловч яллах ажиллагаанд саад болдог гэж тэмдэглэсэн. Мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж болох ч халдашгүй дархан эрхтэй этгээдийг байцааж, нүүрэлдүүлэн байцааж, үзлэг хийж, эсхүл өөр байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй. Мөн мөрдөн байцаагч нь өөр нотлох баримт олж, түүнийгээ халдашгүй дархан эрхийг цуцлах үндэслэл болгон ашиглаж болно. Түүнчлэн хэрвээ мөрдөн шалгагдаж байгаа этгээд халдашгүй дархан эрх эдэлдэг албан тушаалд сонгогдож, эсхүл томилогдож ажиллаж байгаа бол тухайн этгээдэд холбогдуулан шалгаж байгаа хэргийг түдгэлзүүлнэ. Гэсэн хэдий ч хөөн хэлэлцэх хугацаа тасалдахгүй.

Хууль сахиулагч байгууллагуудын төлөөлөгчид практикт тэд Улсын их хурлын гишүүд оролцоогүй л бол халдашгүй дархан эрхийг хүчингүй болгох ажиллагаанд асуудалтай тэр бүр тулгараад байдаггүй гэж мэдэгдсэн. Авлигатай тэмцэх газрын ажилтнууд халдашгүй дархан эрхийг нь түдгэлзүүлэх хүсэлтийг нь хангаагүйгээс Улсын их хурлын гишүүнд үүсгэсэн эрүүгийн хэргээ түдгэлзүүлсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн.

Халдашгүй эрх эдэлж байгаа албан тушаалтнуудын халдашгүй байдлыг цуцлах тогтсон ерөнхий журам байхгүй. Ихэнх тохиолдолд мөрдөн байцаагч халдашгүй эрхийг түдгэлзүүлэх хүсэлтийг Улсын ерөнхий прокурорын газарт гаргах замаар халдашгүй эрхийг хүчингүй болгох ажиллагаа эхэлдэг бөгөөд холбогдох хуулиар зохицуулдаг.

Ерөнхийлөгчийн халдашгүй дархан эрх: Монгол Улсын төрийн байгууллагуудын гаргаж өгсөн материалд Монгол Улсын Үндсэн хуулийн 36 дугаар зүйлд зааснаас өөр Ерөнхийлөгчийн халдашгүй дархан байдлыг тодорхойлсон заалт байхгүй байна. 1. Ерөнхийлөгч УИХ-д ажлаа хариуцна. 2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар

огцруулна.

Улсын их хурлын гишүүдийн халдашгүй дархан байдал: Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлд Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй дархан байдлыг хуулиар хамгаална гэж заасан байдаг. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.

Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 6.9. – 6.16. дугаар зүйлүүдэд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй дархан байдлыг цуцлах журмыг заасан. Мөрдөн байцаагчаас хүсэлт хүлээн авсан даруйдаа Улсын Ерөнхий прокурор “Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналаа Улсын Их Хуралд гаргана.” Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдэж байх үедээ баригдаж, гэмт хэргийн газар нотлох баримттай баривчлагдсан бол дээр дурдсан саналыг гаргаж болно. Хэрвээ гишүүн баривчлагдсан бол эрх бүхий байгууллага энэ тухай Улсын Их Хурлын даргад 3 цагийн дотор мэдэгдэнэ. Улсын Их Хурал Улсын ерөнхий прокурорын саналыг хүлээн авсны дараа ажлын 2 өдрийн дотор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг нууцаар санал хурааж, энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэсэн шийдвэрийг Улсын Их Хурал гаргасан бол баривчлагдсан гишүүнийг нэг цагийн дотор суллана.

Мөн цаг хугацаанд дээр дурдсан журмыг үл харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2011 онд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй дархан эрхийг түдгэлзүүлэх журмыг үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн тухай хяналтын багт мэдэгдсэн. Ийм учраас 2011 оноос хойш Улсын Их Хурлын гишүүд халдашгүй дархан эрхээ тус эрхийг түдгэлзүүлэх хүчин төгөлдөр журамгүйгээр үнэмлэхүй эдэлж байна – энэ нь хүлээн зөвшөөршгүй нөхцөл байдал юм.

Өөр бусад эх сурвалжийн дагуу хууль сахиулагчид хэрэг мөрдөн шалгах зорилгоор Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх хүсэлтийг Улсын Их Хуралд удаа дараа гаргасан боловч Үндсэн хууль гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх эрхийг Улсын Их Хуралд олгосон учир тэдгээр хүсэлт хангагдаагүй байна. “Үр дүнд нь зарим тохиолдолд Улсын Их Хурлын гишүүдийн эсрэг хууль үйлчилдэггүй гэсэн сэжиг бий болоод байна. Үнэндээ өөр бусад пост-социалист улсуудад гэмт хэрэгтнүүд халдашгүй дархан эрх олж авахын тулд улс төрд ордог тул ийм эрсдэл байж болох юм.”<sup>21</sup>

Сайдуудын халдашгүй дархан эрх: Монгол Улсын Үндсэн хуулийн 42 дүгээр зүйлд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн халдашгүй дархан байдлыг хуулиар хамгаална гэж заасан байдаг. Сайдуудын эрх зүйн байдал болон бүрэн эрхийг 1993 оны 5 дугаар сард батлагдсан Засгийн газрын тухай хуулиар зохицуулдаг. Тус хуулийн 25.2.6. дахь заалтад Ерөнхий сайдын халдашгүй дархан эрхийг дараах байдлаар тодорхойлсон: “Ерөнхий сайдыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, бие, орон сууц, албан тасалгаа, уналгад нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно”. Энэхүү халдашгүй дархан эрх нь хэтэрхий өргөн цар хүрээтэй байгаа бөгөөд бүхий л төрлийн хуулийн хариуцлагыг хамаарч байна. Тус зүйл нь халдашгүй дархан эрхийг түдгэлзүүлэх

---

<sup>21</sup> Эх сурвалж: “The Role of the Constitution of Mongolia in Consolidating Democracy: An Analysis”, report prepared under the project “Support to Participatory Legislative Process” implemented jointly by the Parliament of Mongolia and the UNDP, Ulaanbaatar, 2015 оны 5 дугаар сар, 52 дугаар хуудас, [www.undp.org/content/mongolia/en/home/library/democratic\\_governance/RoleoftheConstitutionofMongoliaInConsolidatingDemocracy.html](http://www.undp.org/content/mongolia/en/home/library/democratic_governance/RoleoftheConstitutionofMongoliaInConsolidatingDemocracy.html).

анхан шатны журмыг агуулсан байна. Холбогдох хууль сахиулах байгууллага нь Ерөнхий сайдыг эрүүгийн хариуцлагад татахын тулд Улсын Их Хурлаас зөвшөөрөл авах хэрэгтэй. Харамсалтай нь хууль цааш дэлгэрүүлсэн зохицуулалт агуулаагүй учир тодорхойгүй хэвээр үлдэж байна.

Засгийн газрын тухай хуулийн 25.3.5.-д Засгийн газрын бусад гишүүд (сайдууд)-ийн халдашгүй дархан эрхийг тодорхойлсон. Тус хуульд сайдыг "гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар л баривчилж болно" гэж заасан. Энэ тухай Ерөнхий сайдад 24 цагийн дотор мэдэгдэх ёстой. Бусад тохиолдолд сайдыг эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, бие, орон сууц, албан тасалгаа, уналгад нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. Ерөнхий сайдын халдашгүй дархан эрхтэй төстэй байдлаар 25.3.6. дахь заалт сайдын халдашгүй дархан эрхийг түдгэлзүүлэх тодорхой журам тусгаж өгөөгүй. Авлигатай тэмцэх газрын төлөөлөгч Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр сайдуудыг яллах боломжгүй гэж нэмж хэлсэн.

Шүүгчдийн халдашгүй дархан эрх: Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль шүүгчийн халдашгүй дархан эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг тусгасан байдаг. Тус хуулийн 17 дугаар зүйл Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн эрүүгийн хариуцлагад татагдсан шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ. Шүүгчийн бүрэн эрхийг энэхүү үндэслэлээр түдгэлзүүлснээр шүүгчийн халдашгүй дархан эрх ч мөн түдгэлзэнэ. Цаашид хэрхэн зохицуулах тухай болон шүүгчийн халдашгүй дархан байх бүрэн эрхийн тухай асуудлууд тодорхойгүй байна. Авлигатай тэмцэх газрын ажилтан одоогийн байдлаар шүүгчид хэрэг үүсгэн шалгаж байгаа бөгөөд түүний халдашгүй дархан эрхийг түдгэлзүүлэх хүсэлтийнхээ хариуг хүлээж байгаагаа мэдэгдсэн юм.

Прокурорын халдашгүй дархан эрх: Прокурорын халдашгүй дархан эрх болон түүнийг хэрхэн түдгэлзүүлэх журмыг Прокурорын байгууллагын тухай хуулиар тодорхойлдог. Бүхий л прокурорын халдашгүй дархан эрх нь адилхан цар хүрээтэй.

Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр, бусад прокурорыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, уналга болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. Прокурорыг зөвхөн гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилж болно. Энэ тохиолдолд баривчилгааны тухай Улсын ерөнхий прокурорд 48 цагийн дотор мэдэгдэнэ. Харин Улсын ерөнхий прокурор болон түүний орлогчийг баривчилсан бол энэ тухай Ерөнхийлөгчид 48 цагийн дотор мэдэгдэнэ. Ерөнхийлөгч эсхүл Улсын ерөнхий прокурор мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ. Прокурорын байгууллагын тухай хуулийн 36.3. дугаар хэсэгт зааснаар прокурорын хяналтын ажлыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр шалгаж болохгүй гэж прокурорын халдашгүй дархан эрхийн цар хүрээг тэлснийг тэмдэглэх нь зүйтэй.

Дипломат ажилтны халдашгүй дархан байдал: Дипломат албаны тухай хууль дипломат ажилтны халдашгүй дархан эрхийн цар хүрээг, мөн халдашгүй дархан эрхийг цуцлах журмыг ч гэсэн тодорхойлдоггүй. Харин оронд нь тус хууль дипломат ажилтнууд "Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцод заасан" халдашгүй дархан эрхийг эдэлнэ гэж заасан.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн байцаан шийтгэх хууль дипломат халдашгүй дархан эрхийг шаардлагатай хэмжээнд тодорхойлоогүй бөгөөд дипломат дархан эрх эдэлж байгаа этгээдүүд зөвхөн өөрсдийн хүсэлт буюу зөвшөөрлийн дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд татагдан орж болно гэж заасан.

2) Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх; авлигын бүх гэмт хэрэгт тухайн хэргийн ангилалаас үл хамааран тогтсон урт хугацааны хөөн хэлэлцэх хугацааг ягштал баримтлах; хангалттай урт хөөн хэлэлцэх хугацаа тогтоох; хөөн хэлэлцэх хугацааг тухайн хүн халдашгүй дархан эрх эдлэх хугацаанд болон ял оноох эсхүл бусад үйл ажиллагааны хугацаанд түр зогсоох заалтыг хуулинд тусгаж өгөх асуудлыг хянан үзэх.

Бусад Истанбулын Авлигын эсрэг төлөвлөгөөний улсуудын адилаар Монгол Улсад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн гэмт хэрэг оноох ялын төрөл, хэмжээнд үндэслэсэн хүнд хөнгөний ангилалаас шалтгаалдаг. Доор дурдсан хүснэгтэд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан авлигатай холбоотой гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацааг харуулав.

**Хүснэгт 15.** Авлигатай холбоотой гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа

Гэмт хэрэг	Гэмт хэргийн ангилал	Хөөн хэлэлцэх хугацаа
<b>Хээл хахууль авах</b> (268.1 дүгээр хэсэг)	Хүндэвтэр	5 жил
Хээл хахууль авах (268.2 дугаар хэсэг: хясан боогдуулах замаар, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, давтан үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авах.)	Хүнд	20 жил
<b>Хээл хахууль өгөх</b> (269.1 дүгээр хэсэг)	Хүндэвтэр	5 жил
Хээл хахууль өгөх (269.2 дугаар хэсэг: зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн эсхүл давтан үйлдсэн)	Хүнд	20 жил
<b>Хээл хахууль зуучлах</b> (270.1 дүгээр хэсэг)	Хөнгөн	1 жил
Хээл хахууль зуучлах (270.2 дугаар хэсэг: давтан эсхүл албан тушаалынхаа байдлаа ашиглаж үйлдсэн бол)	Хүндэвтэр	5 жил
<b>Хууль бусаар хөрөнгөжих</b> (270 <sup>1</sup> .1 дүгээр хэсэг)	Хүндэвтэр	5 жил
Хууль бусаар хөрөнгөжих (270 <sup>1</sup> .2 дугаар хэсэг: их хэмжээгээр орлого олсон нь тогтоогдсон бол)	Хүнд	20 жил
<b>Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах</b> (263.1 дүгээр хэсэг)	Хөнгөн	1 жил
Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах (263.2 дугаар хэсэг)	Хүндэвтэр	5 жил
<b>Төрийн албан тушаалтан эрх мэдлээ</b>	Хөнгөн	1 жил



хэтрүүлэх (264.1 дүгээр хэсэг)		
Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх (264.2 дугаар хэсэг)	Хүндэвтэр	5 жил
Мөнгө угаах (166 <sup>1</sup> .1 дүгээр хэсэг)	Хүндэвтэр	5 жил
Мөнгө угаах (166 <sup>1</sup> .2 дугаар хэсэг)	Хүнд	20 жил
Мөнгө угаах (166 <sup>1</sup> .3 дугаар хэсэг)	Онц хүнд	30 жил
Бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх (150.1 дүгээр хэсэг)	Хөнгөн	1 жил
Бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх (150.3 дугаар хэсэг)	Хүнд	20 жил
Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах (148.1 дүгээр хэсэг)	Хөнгөн	1 жил

2014 онд Үнэлгээний тайлан гарснаас хойш дээрхтэй холбоотой ямар нэг өөрчлөлт хийгдээгүй.

Хяналтын багт хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал хөгжиж байгааг нотлох ямар нэгэн шинж тэмдэг ажиглагдаагүй. Төрийн байгууллагууд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар уртасгасан хөөн хэлэлцэх хугацаа болон хөөн хэлэлцэх хугацаа тасалдах үндэслэлүүдийг нэвтрүүлсэн гэж мэдэгдэж байгаа. Жишээ татвал Шинэчилсэн найруулгад заасан шаардлагын дагуу халдашгүй дархан эрх эдэлж байсан хугацаа хөөн хэлэлцэх хугацаанаас хасагдана. Гэсэн хэдий ч төрийн байгууллагуудын өгсөн материалыг шалгаж үзээд хяналтын баг эдгээрийн хуулийн үндэслэлийг олж чадаагүй. Төрийн байгууллагууд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад авлигатай холбоотой гэмт хэргүүдэд гэмт хэргийн ангиллаас нь үл хамааран шууд тогтоож өгөх хөөн хэлэлцэх тусгай хугацааг зааж өгч чадаагүй, бүр энэ сонголтыг харгалзаж ч үзээгүй. Үнэн хэрэгтээ хөөн хэлэлцэх хугацааг уртасгаагүй бөгөөд зарим тохиолдолд бүр богиносгосон. Жишээ нь хүндрүүлэх нөхцөлтэй хээл хахууль авах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 20 жил байсныг 12 жил болгож бууруулсан. Хөөн хэлэлцэх хугацаа тасалдах үндэслэлийг шинээр нэвтрүүлсэн гэж хэлсэн боловч энэ нь нотлогдоогүй.

2012-2014 оны хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр шүүх хээл хахуулийн нэг хэргийг хэрэгсэхгүй болгож, прокурор найман хэргийг хэрэгсэхгүй болгосон гэж төрийн байгууллагууд мэдэгдсэн. Энэ нь бидний өмнөх дүгнэлтийг баталгаажуулж байна.

**Дүгнэлт:** Ерөнхийдөө Монгол Улс дахь авлигын гэмт хэрэгт яллахаас хамгаалах халдашгүй дархан байх эрх нь агуулгын хувьд өргөн цар хүрээтэй бөгөөд тус эрхийг олон тооны төрийн албан тушаалтанд олгож байна. Халдашгүй дархан эрх эдэлж байгаа албан тушаалтнуудын эрхийг түдгэлзүүлэх үр дүнтэй журам тогтоосон зохицуулалт байхгүй бөгөөд халдашгүй дархан эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий этгээд нь энэ төрлийн хүсэлтийг шийдвэрлэхдээ дур зоргоор шийдвэр гаргаж байна. Халдашгүй дархан эрх нь хангалттай уян хатан зохицуулалтгүй байна. Иймд халдашгүй дархан байх эрх нь авлигын гэмт хэргийг Монгол Улсад мөрдөн шалгаж, гэмт хэрэгтнийг яллахад том саад тотгор болж байна. Магадгүй энэ

нь цөөн тооны авлигын онц ноцтой хэрэгт мөрдөн байцаалт явуулж ирсний шалтгаануудын нэг байх. Энэхүү өргөн цар хүрээтэй халдашгүй дархан эрх ямба нь ял шийтгэл хүлээхгүй байх хандлагыг дэмжиж, хууль сахиулагч агентлагуудын идэвхи чармайлтыг мохоож байна. Эдгээрийг нэн яаралтай олон улсын стандартууд болон хамгийн сайн туршлагад нийцүүлж засаж залруулах хэрэгтэй. Халдашгүй дархан эрхтэй холбоотой дийлэнх асуудлууд нь хуулиар зохицуулагддаг бөгөөд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаас хялбар<sup>22</sup>.

Авлигын гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа нь Монгол Улсад авлигын гэмт хэргүүдийг үр дүнтэй яллах ажиллагаанд саад болж байгаа бас нэг хүчин зүйл юм. Хөөн хэлэлцэх хугацаа нь хэтэрхий богино учраас хэргийн материал бүрдүүлэхэд хангалттай хугацаа өгдөггүй. Ялангуяа ээдрээ түвэгтэй хэргийн хувьд (дийлэнх авлигын хэргүүд ээдрээ түвэгтэй байдаг). Мөн хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэгтнийг яллах буюу өөр бусад процессын арга хэмжээ авахад, мөн тухайн этгээд халдашгүй дархан эрх эдэлж байхад тасалддаггүй.

Монгол Улс 2.6. дахь зөвлөмжийг биелүүлээгүй бөгөөд тус зөвлөмж хүчин төгөлдөр хэвээр байна.

---

<sup>22</sup> Монгол Улсын судлаачдын дүгнэлтийг харна уу: Хэрвээ Улсын Их Хурлын гишүүдийн эдэлж байгаа халдашгүй дархан эрхийн цар хүрээг багасгах арга хэмжээг хэрэгжүүлж, зөвхөн албан үүргээ гүйцэтгэж байхад нь л хамгаалдаг болговол Монгол Улсын ардчилсан систем хүчирхэгжинэ. Энэ нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын хэрэгжилтийг шалгасан олон улсын мэргэжилтнүүдийн тайланд нийцнэ. Бид Улсын Их Хурлын гишүүдийн халдашгүй дархан эрхийг хуульчилсан Үндсэн Хуулийн 29-р зүйлийг хүчингүй болгох буюу багасгах хэрэгтэй. Монгол Улсын хөгжлийн энэ шатанд улс төрийн хүчин зүйлээс шалтгаалж яллахаас авлига болон албан тушаалаа урвуулан ашиглах гэмт хэргийн эрсдэл нь илүү өндөр. Хамгийн багадаа, авлигын хэрэгт холбогдсон этгээдүүдэд халдашгүй дархан эрх нь хэрэгжихгүй байхаар хуульчилж болно. Өөр нэгэн боломжит шинэчлэл нь Үндсэн Хуулийн 29.3-т заасан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэдэг жишгийг таслан зогсоох юм. Үндсэн Хуульд зааснаар халдашгүй дархан эрхийг хуулиар зохицуулах тул Үндсэн Хуульд нэмэлт өөрчлөлт оруулалгүйгээр том ажил хийж болно. Гэхдээ энэ асуудалд нэмэлт судалгаа хэрэгтэй. Бид үүнтэй төстэй анализыг өөр төрийн албан тушаалтны халдашгүй дархан эрхэд ашиглаж, энэхүү шинэчлэлийг холбогдох хуулиудыг өөрчлөх замаар хэрэгжүүлж болно гэж үзэж байна. Дараах нийтлэлээс иш татав: “The Role of the Constitution of Mongolia in Consolidating Democracy”, 56 дугаар хуудас.

## 2.7. Олон улсын хамтын ажиллагаа болон эрх зүйн харилцан туслалцаа

### 2.7.-р зөвлөмжүүд

- 1) *Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах чиглэлээр олон улсын эрх зүйн туслалаа харилцан үзүүлэх хүрээнд үр дүнтэй ажиллагааг хангах, ялангуяа Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарах; шууд хамтран ажиллах олон төрлийн хэлбэрийг дэмжих, тухайлбал агентлаг хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах; хулгайлагдсан хөрөнгийг эргүүлэн авах болон бусад гэмт хэргийн талаар олон улсын хэмжээнд хамтран ажиллахад дотоодын байгууллагуудын үүргийг тодорхой болгох.*
- 2) *Төрийн захиргааны төв байгууллага дахь олон улсын хамтын ажиллагаа хариуцсан салбар нэгж бүрийн ажилтан, албан хаагчид бүр орчуулагч болон харилцаа холбооны шаардлагатай төхөөрөмжийг оролцуулаад боломж бололцоогоор хангагдсан, сайтар бэлтгэгдсэн, практикт ажиллаж байгаа мөрдөн байцаагч, прокуроруудтай амархан холбогддог байгаа гэдгийг баталгаажуулах.*
- 3) *Авлигатай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах, яллах ажиллагаанд ашиглагдах боломжтой олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслийн практик хэрэглээ болон тулгарч буй асуудлуудтай холбоотой мэдээ мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэх.*
- 4) *Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын 53 дугаар зүйлд заасны дагуу хулгайлдагдсан хөрөнгийг шууд эргүүлэн авахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хууль тогтоомжид тусгах ба эргүүлэн авах нөхцөл болон эргүүлэн өгөх журмыг конвенцын 57 дугаар зүйлд заасны дагуу боловсруулах.*

*1) Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах чиглэлээр олон улсын эрх зүйн туслалаа харилцан үзүүлэх хүрээнд үр дүнтэй ажиллагааг хангах, ялангуяа Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарах;*

Айлчлалын үеэр төрийн байгууллагууд хууль бус үйлдлийг төрийн албан хаагч сайн дураар эрх бүхий байгууллагад мэдэгдэх журмаас (whistleblowers protection act) бусад Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын бараг бүхий л зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэж мэдэгдсэн. Гэсэн хэдий ч тус мэдэгдэлийг баталгаажуулах нотлох баримтыг хяналтын багт өгөөгүй.

2010 – 2011 онд эрх зүйн харилцан туслалцаа болон хууль хэрэгжүүлэх хамтын ажиллагаатай холбоотой хийгдсэн Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын тайлан нь Монгол Улсад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг санал болгосон:

- 1) Хүсэлтэд тухайн асуудлын сэдэв, мөрдөн шалгах ажиллагааны шинж чанар, тус хүсэлтийн холбогдох яллах, эсхүл шүүн таслах ажиллагаа явуулж байгаа үүрэг хүлээсэн байгууллагын үйл ажиллагаа болон нэрийг дурдсан байх;
- 2) Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа нь дараах ажиллагаануудыг хийлгэх боломжтой байлгах: мэдээлэл, нотлох нотлох баримт, мэргэжилтний үнэлгээ

гаргуулах; холбогдох баримт бичиг болон мэдээ тайланг гаргуулах; гэмт хэргийн ул мөрийг мөрдөх, тогтоох; гэмт хэргийн эх үүсвэртэй хөрөнгийг тогтоох, битүүмжлэх, олж илрүүлэх; болон хөрөнгийг буцаан гаргуулах;

3) Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг Монгол Улсад мөрдөгдөж байгаа мөрдөн шалгах, яллах, шүүх ажиллагааны журамд нийцүүлэх;

4) Эрх зүйн харилцан туслалцаа хүссэн хүсэлтийг хангахаас татгалзах буюу хэрэгжүүлэхийг хойшлуулахынхаа өмнө хүсэлт гаргасан улстай заавал зөвлөлдөх;

5) Хүсэлт гаргасан улсад нотлох баримт гаргаж өгөхийг зөвшөөрсөн гэрч, шинжээч, болон бусад этгээдэд хүсэлт гаргасан улсад тэднийг мөрдөн шалгахгүй, яллахгүй, шүүх ажиллагаанд татан оруулахгүй байх баталгаа, хамгаалалт гаргаж өгч,

6) Ирсэн мэдээллийн нууцлал болон Монгол Улсын Банкны тухай хуульд заасан нөхцөл шаардлагыг тодорхойлж, эрх зүйн харилцан туслалцаа нь аливаа банкны нууцлалд хамаарч, тус хүсэлт хангагдахгүй үлдэх нөхцөлд хүргэхгүй байх;

7) Зөвхөн тусгайлсан зохицуулалт байгаа тохиолдолд хэрэгжүүлэх буюу тухайн нотлох баримт, мэдээлэл, үйл ажиллагааны үндсэн зорилгыг болон тухайн зорилгын хүрээнд нотлох баримт ашиглагдаж болно гэдгийг тодорхойлсон зүйл заалт бий болгох;

8) Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын 46 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэлээр мэдэгдэх;

9) Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын 48 дугаар зүйлийн тус конвенцод заасан гэмт хэргүүдийг илрүүлэхэд ашиглагддаг арга барил, арга хэрэгслийн талаарх мэдээллийг солилцох ажиллагааг оролцуулаад хууль хэрэгжүүлэх хамтын ажиллагаагаа сайжруулах;

Энэ салбар дахь Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын сонгож болох заалтуудыг харгалзан үзээд Монгол Улсад дараах алхмуудыг авч хэрэгжүүлэх дотоодын үйл ажиллагааг сайжруулахыг санал болгосон:

1) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцыг харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны хууль зүйн эх сурвалж болгож Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх;

2) Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын 46 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн дагуу таньж олуулах, мэдүүлэг өгөх болон бусад хэлбэрээр нотлох баримт цуглуулахад шаардлагатай байгаа хүнийг Монгол Улс руу буюу Монгол Улсаас шилжүүлэхийг зөвшөөрсөн дэлгэрэнгүй хуулийн зохицуулалтыг бий болгох;

3) Мэдүүлэг өгөх этгээд шүүх хуралд оролцох боломжгүй буюу оролцоход тааламжгүй байвал дүрстэй дуудлага хийх замаар хуралд оролцохыг зөвшөөрөх;

4) Монгол Улсын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийг өөрсдийн санаачилгаар хүсэлт гаргасан улсад олон нийтэд нээлттэй биш төрийн бүртгэл, баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх боломжтой болгох;

5) Харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг он сарын дагуу гүйцэтгэх тал дээр гарын авлага гаргах;

- 6) Монгол Улсын болоод гадаад улсын хууль сахиулагч агентлагуудын шууд хамтын ажиллагааг бий болгох;
- 7) Тусгай мөрдөн шалгах техник ашиглах, олон улсын хэмжээнд тус зардлыг хэн хариуцах тал дээр гэрээ байгуулах, эсхүл тохиролцоонд хүрэх;
- 8) Дээр дурдсан гэрээ эсхүл тохиролцоо байхгүй бол хэргээс хэрэгт тусгай мөрдөн шалгах техник ашиглах.

Хяналтын багт өгсөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинжилгээнээс харахад Нэгдсэн ондэстний дайгууллагын Авлигын эсрэг конвенцын тайлангийн заавал тусгах болон тусгаж болох зөвлөмжүүд хүчин төгөлдөр хэвээр байна. Сүүлийн жилүүдэд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй.

***шууд хамтран ажиллах олон төрлийн хэлбэрийг дэмжих, тухайлбал агентлаг хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах; хулгайлагдсан хөрөнгийг эргүүлэн авах болон бусад гэмт хэргийн талаар олон улсын хэмжээнд хамтран ажиллахад дотоодын байгууллагуудын үүргийг тодорхой болгох***

Төрийн байгууллагуудын гаргаж өгсөн мэдээллийн дагуу Хууль зүйн яам болон Улсын прокурорын ерөнхий газар нь эрх зүйн хамтын ажиллагааг гардан хэрэгжүүлэх байгууллагууд юм. Холбогдох хуулиуд нь эдгээр хоёр байгууллагад харилцан эрх зүйн туслалцах ажиллагаа болон олон улсын хуулийн хамтын ажиллагааг хариуцан гүйцэтгэх эрх олгосон. Гэсэн хэдий ч Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсны дараа Хууль зүйн яам тэргүүлэх чиг үүрэгтэй оролцож эхэлсэн. Авлигатай тэмцэх газарт олон улсын хамтын ажиллагаа, харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг дааж хэрэгжүүлдэг тусгай нэгж байхгүй. Монгол Улс 20 гаруй улстай харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан боловч тэдгээр гэрээг дахин шинэчлэх шаардлагатай байна. Улсын прокурорын ерөнхий газрын Олон улсын хамтын ажиллагааны алба нь олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцааны ажлыг гардан хэрэгжүүлдэг.

Практикт, шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаагч эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг боловсруулж удирдлагатаа танилцуулдаг. Дараа нь тус хүсэлтийг Улсын прокурорын ерөнхий газар руу эсхүл Хууль зүйн яам руу шилжүүлнэ. Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцын шаардлагын дагуу Улсын прокурорын ерөнхий газрын боловсруулсан гарын авлагыг мөрдөн байцаагчид харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт боловсруулах үедээ ашигладаг.

Сүүлийн үед эрүүгийн гэмт хэргийн бүхий л талыг хамаарсан мэдээллийг аюулгүй, түргэн солилцохын тулд дагуу зохих байгууллагууд, агентлагууд, үйлчилгээний шууд хамтын ажиллагааны сувгуудыг улам илүү ашиглаж байгаа. Энэхүү ажлын хүрээнд Улсын прокурорын ерөнхий газар Нэгдсэн үндэстний байгууллагын Авлигын эсрэг конвенцод нэгдсэн улс орнуудын (ОХУ, Өмнөд Солонгос, Польш, Чех, Гонг Конг, Узбекистан, Хятад, АНУ, Казакстан гэх мэт) утасны дугаар, имэйл хаяг, факсын дугаарыг багтаасан холбоо барих хаягийн мэдээллийг олж авсан.

Олон улсын хамтын ажиллагаатай холбоотойгоор Улсын ерөнхий прокурорын газар дараах эрхтэй:

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг зохих этгээдэд дамжуулах, гэмт хэрэг болон ялтныг шилжүүлэх;
- Улсын прокурорын ерөнхий газарт олон улсын хамтын ажиллагаа хариуцан ажиллаж

байгаа ажилтан болон прокурорын албанд ажиллаж байгаа бусад ажилтнуудад сургалт зохион байгуулах;

- Харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг түргэн шуурхай, үр дүнтэй удирдлага, зохицуулалтаар хангах;
- Харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Утасны дугаар, имэйл хаяг, факсын дугаарыг багтаасан тухайн өдрийн байдлаарх холбоо барих мэдээллийг гаргаж өгч, тэдгээр мэдээллийг конвенцод нэгдэн орсон улсуудын хувьд нээлттэй байлгах замаар төрийн захиргааны төв байгууллагуудын харилцаа холбоог хялбарчлах;
- Сайн туршлага болон практикт тулгарч буй асуудлын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх.

***2) Төрийн захиргааны төв байгууллага дахь олон улсын хамтын ажиллагаа хариуцсан салбар нэгж бүрийн ажилтан, албан хаагчид бүр орчуулагч болон харилцаа холбооны шаардлагатай төхөөрөмжийг оролцуулаад боломж бололцоогоор хангагдсан, сайтар бэлтгэгдсэн, практикт ажиллаж байгаа мөрдөн байцаагч, прокуроруудтай амархан холбогдох боломжтой эсэхийг баталгаажуулах.***

Төрийн байгууллагуудын мэдэгдсэнээр Улсын прокурорын ерөнхий газрын олон улсын хамтын ажиллагаа хариуцсан албанд шаардлагатай харилцаа холбооны хэрэгсэл, ажлын байр, тоног төхөөрөмж болон ажилтнуудаа бэлтгэхэд хангалттай санхүүгийн эх үүсвэрийг гаргаж өгсөн байна. Тус алба нь нийт дөрвөн ажилтантай (Албаны дарга, 2 прокурор болон нарийн бичиг).

Холбогдох прокуроруудад эрх зүйн харилцан туслалцах ажиллагаатай холбоотой асуудлууд дээр хэд хэдэн сургалт хийсэн тухай Монгол Улс мэдээлсэн. Жишээ нь 2014 оны 5 дугаар сард зохион байгуулсан сургалтанд 47 прокурор оролцсон; мөн 2014 оны 9 дүгээр сард зохион байгуулсан сургалтанд хууль хүчний байгууллагын 30 ажилтан хамрагдсан байна.

Түргэн шуурхай, үр дүнтэй эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх зорилгоор Улсын прокурорын ерөнхий газрын Олон улсын хамтын ажиллагааны алба "Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт боловсруулж, бэлтгэх гарын авлага" гаргасан. 2014 оны 3 дугаар сард тус гарын авлагыг прокурорын бүхий л байгууллагуудад тараасан. Мөн цаг үед Улсын прокурорын ерөнхий газартай хамтран Хууль зүйн яам эрүүгийн хэрэг дээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт боловсруулах, илгээх, хэрэгжүүлэхэд зориулсан гарын авлага бэлтгэж байна. Гарын авлагыг бэлэн болсон даруйд Хууль зүйн яам Улсын прокурорын ерөнхий газрын Сургалтын албатай хамтран эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаатай холбоотой сургалтыг мөрдөн байцаагчдын дунд зохион байгуулахаар төлөвлөж байна.

2012 онд Монгол Улс Дэлхийн банкны Хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох ажиллагаанд нэгдэн орсон бөгөөд холбогдох төлөөлөгч нь жилд хоёр удаа семинарт хамрагддаг. Оролцогчдод эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт бэлтгэх, хэрхэн орон нутгийн агентлагуудтай хамтран ажиллах тал дээр хичээл ордог.

***3) Авлигатай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах, яллах ажиллагаанд ашиглагдах боломжтой олон улсын хамтын ажиллагааны арга хэрэгслийн практик хэрэглээ болон***

***тулгарч буй асуудлуудтай холбоотой мэдээ мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэх.***

Төрийн байгууллагууд авлигатай холбоотой хэргүүдэд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт 2012 онд тавьж, 2013 онд наймыг, 2014 онд дөрвийг илгээсэн гэж мэдэгдсэн. Харин 2012-2014 онд авлигатай холбоотой туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт хүлээж аваагүй байна.

Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг хэрэгжүүлэхэд Улсын прокурорын ерөнхий газарт тулгарч байсан асуудлууд:

- Зарим улс руу илгээсэн эрүүгийн хэрэгт туслалцаа хүссэн хүсэлтэд хариу өгөхдөө удаж байсан, харилцаа холбоо нь сул байсан.
- Эрх зүйн туслалцаа хүссэн албан бичгийг албан ёсны хэл рүү хөрвүүлэх нь үндсэн асуудал болж байсан. Орчуулгыг баталгаат орчуулгын холбоогоор хийлгэх эсхүл бие даасан орчуулгын алба байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэр байхгүй.
- Хууль хүчний байгууллагуудын байгууллага хоорондын хамтын ажиллагаа сул. Жишээ нь: прокурорууд мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьдаг учраас мөрдөн шалгах бүхий л ажиллагааг тэд үнэлж дүгнэх ёстой. Гэтэл эрх зүйн олон тооны харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтүүдийг бэлтгэх ажиллагаа мөрдөн байцаагчдын хангалтгүй үйл ажиллагааны улмаас хоцорч байна.
- Төрийн захиргааны төв байгууллага дахь албан хаагчид тогтмол солигддог учир мэргэшсэн ажилтнуудын дутагдал өөр нэгэн асуудал юм.
- Мөрдөн байцаагчид болон прокурорууд нь Олон улсын болоод гадаад улсын хуульд нийцүүлэн эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт бичих мэргэжлийн чадваргүй байгаа бөгөөд энэ нь хүсэлт хэрэгжихгүй байх нийтлэг шалтгаан юм.
- Прокурорууд болон мөрдөн байцаагчдад хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох, эрх зүйн харилцан туслалцаатай холбоотой асуудлуудаар нэмэлт сургалтууд орох шаардлагатай.

***4) Нэгдсэн Үндэстний байгууллагын Авлигын эсрэг Конвенцын 53 дугаар зүйлд заасны дагуу хулгайлагдсан хөрөнгийг шууд эргүүлэн авахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хууль тогтоомжид тусгах ба түүнчилэн эргүүлэн авах нөхцөл болон эргүүлэн өгөх журмыг Конвенцын 57 дугаар зүйлд заасны дагуу боловсруулах.***

Зөвлөмжөөр санал болгосон алхмуудыг Монгол Улс авч хэрэгжүүлээгүй байна. Цаашилбал, төрийн байгууллагууд бичгээр өгсөн мэдээллээрээ Монгол Улс эд хөрөнгө буцаан олгох тал дээр хууль тогтоомжгүй, эд хөрөнгийг буцаан олгох, худалдах асуудлууд дээр ямар нэг журамгүй гэдгээ баталгаажуулсан. Эд хөрөнгө буцаасан тохиолдол гарч байгаагүй.

Монгол Улс 2.7. дахь зөвлөмжийг хэсэгчлэн биелүүлсэн бөгөөд тус зөвлөмжүүд хүчин төгөлдөр хэвээр байна.

## 2.8. Хуулийн хэрэглээ, тайлбар, журам

### Үнэлгээний тайлан 2.8.-р зөвлөмжүүд

- 1) *Эрүүгийн хууль болон практикт байх авлигын гэмт хэргийн тайлбарыг тодорхой болгох замаар гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдлийг шууд бус нотлох баримтаар тогтоож, завдалтыг заавал шууд нотлох баримтаар нотлох шаардлагыг үгүй болгох.*
- 2) *Мөрдөн байцаагчид болон прокуроруудыг санхүүгийн мөрдлөгө хийж, шууд бус нотлох баримтыг ашиглах чадвартай болгож мэргэшүүлэх; албан байгууллагын доторх эсхүл хөлсөөр ажиллах мэргэшсэн мэргэжилтнийг ашиглахыг дэмжих.*
- 3) *Хууль хүчний байгууллагын ажилтнуудад банк, санхүү, худалдааны мэдээлэлд нэвтрэх эрх олгох.*
- 4) *Авлигын хэргүүдийг цуглуулан дүн шинжилгээ хийх замаар ямар төрлийн авлигын хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгах, ял шийтгэл оноох хандлагатай байгааг болон практикт тулгарч байгаа бэрхшээлүүд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох; гэмт хэргүүдтэй холбогдолтой мэдээлэл цуглуулах, бүртгэх болон дүн шинжилгээ хийх аргачлалыг сайжруулж, статистик мэдээллийн санг сайжруулах.*

*1) Эрүүгийн хууль болон практикт байх авлигын гэмт хэргийн тайлбарыг тодорхой болгох замаар гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдлийг шууд бус нотлох баримтаар тогтоож, завдалтыг заавал шууд нотлох баримтаар нотлох шаардлагыг үгүй болгох.*

Үнэлгээний тайланд дурдсанчлан Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдлийг шууд бус нотлох баримтаар тогтоохыг зөвшөөрдөггүй. Шууд нотлох баримт нь завдсан үйлдэлд тэр бүр байдаггүй, заавал үйлдэл дээр нь барих шаардлагатай байдаг бөгөөд болоод өнгөрсөн үйлдэлд авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахаас хязгаарлаж байна. Шууд бус нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхгүй байх нь хэрэг үүсгэн шалгахад шаардлагагүй саад тотгорыг бий болгодог.

Төрийн байгууллагууд шууд бус нотлох баримт нь мөрдөн байцаагч нарт өргөнөөр ашиглагддаг, гэхдээ зөвхөн шууд нотлох баримтыг дэмжихэд ашиглагддаг гэж мэдэгдсэн. Гэмт хэргт буруутнаар тооцоход шууд бус нотлох баримт хангалтгүй, хуульд заасны дагуу шууд бус нотлох баримт нь бусад нотлох баримттай цогц хэлбэрээр үнэлэгдэх ёстой байна.

*2) Мөрдөн байцаагчид болон прокуроруудыг санхүүгийн мөрдлөгө хийж, шууд бус нотлох баримтыг ашиглах чадвартай болгож мэргэшүүлэх; албан байгууллагын доторх эсхүл хөлсөөр ажиллах мэргэшсэн мэргэжилтнийг ашиглахыг дэмжих.*

Айлчлалын үеэр Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөгчид тус байгууллага нь дийлэнхдээ мөнгөний тайлан, сэжиг бүхий хэлцэл, хөрөнгө орлогын мэдүүлэг, болон бусад санхүүгийн холбогдох мэдээллийг цуглуулж боловсруулах замаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагуудыг хэрэгжүүлж ажилладаг гэж мэдэгдсэн. 2006 онд байгуулагдсан цагаасаа хойш санхүүгийн мэдээллийн алба нь нийт 5 сая мэдэгдэл хүлээж авсан. 100,000 ам доллараас өндөр үнийн дүнтэй



хэлцлийг мэдэгдэх шаардлагатай байдаг. Зөвхөн өөрсдийн үзэмжээр Санхүүгийн мэдээллийн алба нь сэжиг бүхий хэлцлийн мэдээллийг зохих төрийн байгууллага руу илгээдэг. Өнөөдрийг хүртэл тэдний цөөнх нь л Авлигатай тэмцэх газарт хүргэгдсэн. Тодорхой хэлцлийг сэжиг бүхий гэж үзэхийн тулд Санхүүгийн мэдээллийн алба тусгай дүн шинжилгээ хийдэг. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцдаа Санхүүгийн мэдээллийн албаны мэргэжилтэн холбогдох мэдээллийн санд шүүлт хийж, улсын бүртгэлийн дугаарыг шалгаж, бусад санхүүгийн байгууллагуудтай холбогдож, баримт мэдээлэлд үндэслэсэн судалгаа хийж бусад шаардлагатай арга хэрэгслийг ашигладаг.

Санхүүгийн мэдээллийн алба нь хууль хүчний байгууллагад өөрийн мэдээллийн санг шүүхийн шийдвэргүйгээр ашиглуулдаг болохыг тэмдэглүүштэй. Санхүүгийн мэдээлэл өгөхөд энгийн хүсэлт л хангалттай. Энэ тал дээр Санхүүгийн мэдээллийн алба нь холбогдох агентлагуудтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж харилцаагаа зохицуулдаг.

Санхүүгийн мэдээллийн албатай хамтран ажиллах тал дээр хууль хүчний байгууллагуудын төлөөлөгчид Санхүүгийн мэдээллийн албанаас авсан мэдээллээс эрүүгийн хэрэгт нотлох баримт болгон ашиглаж чаддаггүй гэж мэдэгдсэн. Санхүүгийн мэдээллийн албанаас авсан мэдээллийг шалгаж, баталгаажуулж чадвал бусад эд мөрийн баримтын хамт эрүүгийн хэрэг үүсгэн шалгах үндэслэл болдог байна.

Төрийн байгууллагууд прокурорууд болон мөрдөн байцаагчдад зориулсан санхүүгийн мөрдлөгөтэй холбоотой сургалт зохион байгуулагдаж байгаагүй гэж тайлбарласан. Гэхдээ санхүүгийн салбар дахь төрийн оролцоог тогтоож, тус салбарт гарч буй асуудлуудыг хэлэлцэж, үнэлэлт өгч, бусад бүхий л холбогдох хууль хэрэгжүүлэх арга хэмжээ, мөрдөн байцаалтыг хянадаг Хамтын ажиллагааны зөвлөл удаа дараа дээр дурдсан асуудал дээр хурал зохион байгуулж байсан. Хамтын ажиллагааны зөвлөлд бараг бүх холбогдох яамдууд болон бусад төрийн байгууллагууд төлөөлөлтэй. Гэхдээ хуулийн шаардлагаас шалтгаалан Авлигатай тэмцэх газрын төлөөлөл тус зөвлөлд байдаггүй.

### **3) Хууль хүчний байгууллагын ажилтнуудад банк, санхүү, худалдааны мэдээлэлд нэвтрэх эрх олгох.**

Төрийн байгууллагуудын мэдэгдсэнээр Авлигатай тэмцэх газар дээр дурдсан зохих хүсэлтийг үйлдэж, прокуророор батлуулснаар банкны мэдээлэлд нэвтрэх эрхтэй байна. Яаралтай тохиолдолд Авлигатай тэмцэх газар нэн даруй банкны мэдээлэлд нэвтрэх буюу гаргасан хүсэлтдээ хариу авах эцсийн хугацаа зааж өгөх боломжтой. Цаашилбал мөрдөн байцаагчид шаардлагатай мэдээлэлтэй биечлэн танилцаж болно. Үүнтэй адил журмаар татвар болон гаалийн мэдээллийг авч болдог.

Хууль сахиулагч байгууллагад тулгардаг хамгийн том бэрхшээл нь хэрэгт холбогдсон тухайн албан тушаалтны харьяа байгууллагаас мэдээлэл гаргуулах юм. Жишээ нь хэрвээ тухайн хэрэгт татварын байцаагч холбогдсон бол татварын мэдээлэл авахад бэрхшээл үүсдэг.

### **4) Авлигын хэргүүдийг цуглуулан дүн шинжилгээ хийх замаар ямар төрлийн авлигын хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгаэх, ял шийтгэл оноох хандлагатай байгааг болон практикт тулгарч байгаа бэрхшээлүүд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох; гэмт хэргүүдтэй холбогдолтой мэдээлэл цуглуулах, бүртгэх болон дүн шинжилгээ хийх аргачилалыг сайжруулж, статистик мэдээллийн санг сайжруулах.**

Төрийн байгууллагуудын мэдэгдсэнээр, Авлигатай тэмцэх газрын хэвлэлийн төлөөлөгч нь шалгагдаж байгаа, шилжүүлсэн, ялласан хэргүүд болон холбогдох гомдлын талаар мэдээ гаргаж, хэвлэлийн бага хурал хийдэг байна. Авлигатай тэмцэх газар мөн эрүүгийн хэргийн

статистик мэдээ гаргадаг. Практикт ямар асуудал гарч, түүнийг хэрхэн шийдвэрлэж болохыг тогтоох зорилгоор нотлогдсон, мөрдөн байцаалт явуулсан, ялласан авлигын гэмт хэргийн хандлагыг тогтоох судалгаа хийгдээгүй нь харагдаж байна.

**Өршөөлийн хууль.** Иргэний нийгмийн төлөөллүүд авлигын гэмт хэрэгт яллахад тун чухал нөлөөг бий болгох саяхан батлагдсан хуулийг дурдсан. Өршөөлийн хууль 2015 оны 8 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан. Транспэрэнси Интернэшнл Монгол байгууллагын мэдэгдсэнээр тус хууль нь Авлигатай тэмцэх хараат бус агентлагийн мөрдөн шалгаж байгаа 55 хэргийн 45-ийг нь өршөөгдсөн гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгох юм байна. Тус гэмт хэргүүд нь 32 тэрбум төгрөгтэй ("16.2 сая ам доллар") холбогдоно. Транспэрэнси Интернэшнлийн үзэж байгаагаар энэ хуулийг батлахыг Авлигатай тэмцэх газраар шалгагдаж байгаа хүмүүс болон ерөнхийлөгч асан Н.Энхбаяр батлуулахаар зүтгэж байгаа бөгөөд энэхүү санал зөрөлдөөнтэй хуулийг Улсын Их Хурлын дарга З.Энхболд дэмжсэн юм байна. Транспэрэнси Интернэшнлийн ерөнхий нарийн бичгийн дарга болон Транспэрэнси Интернэшнл Монгол нь тус хуулийг буруутгаж, Ерөнхийлөгчийг хориг тавь хэмээн мэдэгдэл гаргасан.<sup>23</sup>

Ерөнхийлөгч тус хуульд хэсэгчилэн хориг тавьж, тус хоригийг 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурал хүлээн авсан. Хоригийн үйлчлэлээр Өршөөлийн тухай хууль авлигатай холбоотой, албаны эрх мэдлээ урвуулан ашигласан, хууль бусаар хөрөнгөжсөн, бусдын эд хөрөнгийг завшсан, үрэгдүүлсэн, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан гэмт хэргүүдэд хамаарахгүй болсон. Гэсэн хэдий ч Улсын Их Хурал энэхүү хуулийг тэр чигээр нь орхиогүй, хэлэлцэхээр төлөвлөж байгаа нь илэрхий байна<sup>24</sup>.

Авлигын хэрэгт холбогдсон этгээдүүдийг хариуцлагаас чөлөөлөх гэсэн энэхүү оролдого нь хяналтын багийн анхаарлыг татсан бөгөөд харин Ерөнхийлөгчийн хориг болон түүний зөвшөөрсөн Улсын Их Хурлын үйлдлийг таатайгаар хүлээж авсан. Улсын Их Хурал тус хуулийг батлахдаа хаалттай хуралдаанаар хэлэлцсэн сэтгэл зовниулсан асуудал юм. Энэхүү хуулийг Авлигатай тэмцэх газрын хүчийг сулруулах гэсэн оролдого гэж харж болохоор байгаа бөгөөд энэ мэт үйлдэл нь Монголд аль хэдийн хандлага болсон ба бүхий л оролцогчдын анхаарлын төвд байх ёстой асуудал юм. Хяналтын баг авлигын хэрэгт яллахаас хамгаалах халдашгүй дархан эрх олгох, эсхүл шалгагдаж байгаа хэргийг хэрэгсэхгүй болгох өршөөлийн хуулиас татгалзахыг зөвлөж байна.

Монгол Улс 2.8. дахь зөвлөмжийг хэсэгчлэн биелүүлсэн бөгөөд тус зөвлөмжүүд хүчин төгөлдөр хэвээр байна.

---

<sup>23</sup> Эх сурвалж: [www.transparency.org/news/pressrelease/president\\_should\\_veto\\_new\\_law\\_granting\\_amnesty\\_for\\_corrupt\\_officials](http://www.transparency.org/news/pressrelease/president_should_veto_new_law_granting_amnesty_for_corrupt_officials).

<sup>24</sup> Эх сурвалж: statement by the TI, TI Mongolia and UNCAC Coalition, 2015 оны 10 дугаар сарын 8, [www.transparency.org/news/pressrelease/international\\_organisations\\_call\\_on\\_mongolian\\_parliament\\_to\\_withdraw\\_corruption\\_law](http://www.transparency.org/news/pressrelease/international_organisations_call_on_mongolian_parliament_to_withdraw_corruption_law).

## 2.9. Авлигын эсрэг мэргэшсэн хууль сахиулагч байгууллага

### 2.9.-р зөвлөмжүүд

- 1) *Дотоод хяналт шалгалтын албыг засгийн газрын агентлагуудад, ялангуяа хууль хэрэгжүүлэгч агентлагуудад байгуулах асуудлыг авч үзэх, авлигатай тэмцэх хууль хэрэгжүүлэх агентлагуудын нөөц бололцоо болон чадавхыг бэхжүүлэх асуудлыг авч үзэх.*
- 2) *Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажил үүргийн зааг ялгааг тодорхой болгож, агентлаг хоорондын хамтын ажиллагаа, ажил үүргийн хуваарийн зүй зохистой механизмтай байх.*
- 3) *Хэвлэл мэдээлэл болон олон нийтийн бусад эх сурвалжид нийтэлж байгаа мэдээлэл нь үйлдэгдсэн байх боломжтой авлигын гэмт хэргийн эсрэг мөрдөн шалгах ажиллагаа хийх үндэслэл болж байх.*

*Дотоод хяналт шалгалтын албыг засгийн газрын агентлагуудад, ялангуяа хууль хэрэгжүүлэгч агентлагуудад байгуулах асуудлыг авч үзэх, авлигатай тэмцэх хууль хэрэгжүүлэх агентлагуудын нөөц бололцоо болон чадавхыг бэхжүүлэх асуудлыг авч үзэх.*

Энэхүү зөвлөмжтэй холбоотойгоор ямар нэг үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй.

*Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажил үүргийн зааг ялгааг тодорхой болгож, агентлаг хоорондын хамтын ажиллагаа, ажил үүргийн хуваарийн зүй зохистой механизмтай байх.*

Төрийн байгууллагууд Монгол Улсад авлигатай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах цорын ганц агентлаг нь хараат бус Авлигатай тэмцэх газар гэж мэдэгдсэн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26 болон 27 дугаар зүйлүүдэд заасны дагуу Авлигатай тэмцэх газар нь Эрүүгийн хуулийн 263 (Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах), 264 (Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх), 265 (Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах), 266 (Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх), 268 (Хээл хахууль авах), 269 (Хээл хахууль өгөх) 270 (Хээл хахууль зуучлах), 270<sup>1</sup> (Хууль бусаар хөрөнгөжих), 166<sup>1</sup> (Мөнгө угаах) дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг. Өөр бусад агентлагийн оролцоотой холбоотой мэдээлэл өгөөгүй.

Авлигатай тэмцэх газар нь газар нутгийн харьяалалгүйгээр дээр дурдсан гэмт хэргүүдийг мөрдөн шалгах эрхтэй бөгөөд ямар ч этгээдэд (энгийн иргэн, прокурор, шүүгч, Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгч гэх мэт) эрүүгийн хэрэг үүсгэн шалгах эрхтэй гэж цааш тодруулсан. Эдгээр эрх мэдлүүдийн заримыг нь 2014 оны нэг сард хуульчилсан. Авлигатай тэмцэх газрын харьяаллын хэргийг өөр байгууллага илрүүлсэн бол тус хэргийг холбогдох хэргийн материалын хамт нэн даруй Авлигатай тэмцэх газарт шилжүүлнэ. Хэрвээ харьяаллын зөрчил гарвал (нэг хэргийг хоёр буюу түүнээс дээш зүйл ангиар шалгаж байгаа бол) Улсын прокурорын ерөнхий газар холбогдох байгууллагууд (Авлигатай тэмцэх газар, цагдаа, Тагнуулын ерөнхий газар гэх мэт)-ын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг гаргана. Ажлыг хэсгийг дийлэнхдээ прокурор ахална. Авлигатай тэмцэх газар харьцангуй цөөн мөрдөн байцаагчтай (2014 онд 54 байсныг 2015 онд 30 болгож бууруулсан), бүс нутаг хариуцсан нэгж байхгүй учраас Авлигатай тэмцэх газар ялангуяа цагдаагийн албатай буюу бүс нутгийн хэмжээнд өөр байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай болдог. Энэ

асуудал дээр Авлигатай тэмцэх газар хэд хэдэн байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Авлигын хэргүүдийн мөрдөн шалгах ажиллагааг Улсын прокурорын ерөнхий газар хянаж, удирддаг. Мөн прокурорууд мөрдөн шалгах зарим нэг ажиллагааны зөвшөөрөл өгч мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг. Нөгөөтэйгүүр прокурорууд нь шүүн таслах ажиллагаанд яллах чиг үүрэгтэй оролцдог. Зөвхөн авлигын гэмт хэрэг дээр ажиллах тусгай чиг үүргийн прокурорууд байхгүй. Аливаа прокурорт гэмт хэргүүд газар нутгийн харьяаллын дагуу хувиарлагддаг. Улсын прокурорын ерөнхий газар нь Авлигатай тэмцэх газарт мөрдөн байцаалттай холбоотой тодорхой заавар өгч болох бөгөөд Авлигатай тэмцэх газар санал нэгдэхгүй байсан ч тэдгээр зааврыг дагаж биелүүлэх үүрэгтэй.

2014 онд шинээр нэвтрүүлсэн бүхий л авлигын хэргийг мөрдөн шалгах эрхийг Авлигатай тэмцэх газарт өгсөн өөрчлөлт нь сайшаалтай алхам болжээ. Ийм учраас Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах эрх мэдлийг бууруулж, бүхий л мөрдөн шалгах эрхийг цогцлоосон шинэ байгууллага байгуулах санал Улсын Их Хуралд өргөн баригдсан байгаа тухай мэдээ нь хяналтын багт түгшүүр бий болгож байна. Энэхүү шийдвэр Авлигатай тэмцэх газрын гаргасан ажлын амжилтыг бууруулж, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагын авлигын эсрэг мэргэшлийг үгүй хийх болно. 2015 оны 6 дугаар сард Монгол Улсын ерөнхий сайд асан Авлигатай тэмцэх газрыг татан буулгахыг зөвлөж мэдээлэл гаргасан.


**3) Хэвлэл мэдээлэл болон олон нийтийн бусад эх сурвалжид нийтэлж байгаа мэдээлэл нь үйлдэгдсэн байх боломжтой авлигын гэмт хэргийн эсрэг мөрдөн шалгах ажиллагаа хийх үндэслэл болж байх.**

Авлигатай тэмцэх газрын ажилтнууд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 167.2 дахь хэсгийн дагуу тэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэн шалгах эрхтэй гэдгээ мэдэгдсэн. Энэ мэт мэдээлэл нь дийлэнхдээ шалгагдаж, батлагдсан тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх үндэслэл болно. Гэсэн хэдий ч практикт мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээллийг зүй зохистой шалгаж чаддаггүй. Учир нь тэдний олон нийттэй харилцах утсанд хэтэрхий олон гомдол ирдэг.

Монгол Улс 2.9. дэх зөвлөмжийг **бүрэн гүйцэд биелүүлсэн.**

## **2.9.-р шинэ зөвлөмжүүд**

- 1) Авлигаар мэргэшсэн хүчний байгууллагын чадамж, нөөц бололцоог өсгөхийн тулд төрийн байгууллагуудад, тэр дундаа хууль хүчний байгууллагуудад хараат бус дотоод шалгалтын алба байгуулах.**
- 2) Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах Авлигатай тэмцэх газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх. Тухайлбал мөрдөн байцаагчдын тоог нэмэгдүүлж, бүс нутгуудад мөрдөн шалгах хэсэг нэгж байгуулах.**
- 3) Авлигын эсрэг хэргүүдэд прокурорыг үр дүнтэй нарийвчлан мэргэшүүлж, тухайн прокуроруудад хараат бус байдлын тусгай баталгаа олгох.**
- 4) Прокурорын үргэлжилсэн оролцоог хангах – Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавихаас шүүхийн шатанд төрийн нэрийн өмнөөс яллах ажиллагаа хүртэл.**



### 3. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

#### 3.2. Төрийн албаны шударга байдал

*Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.2.*

- 1) Улс төрийн болон мэргэжлийн төрийн албаны зааг ялгааг тодорхой гаргах; төрийн бүх албан хаагчдыг ил тод, ур чадварт суурилсан зарчмаар томилох болон дэвшүүлэх, төрийн албан тушаалтны цалин, урамшууллын систем шударга, нээлттэй, үнэн зөв байх,*
- 2) Төрийн албан тушаалтанд хориглох болон хязгаарлах заалтуудыг хянан үзэж, бүх төрлийн ашиг сонирхлын зөрчлийг хуульд бүрэн хамруулж мөрдөх.*
- 3) Хууль зөрчсөн тохиолдолд ял шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгууллагыг тодорхой томилох, журмыг нарийвчлан тодорхойлох, хуулийг дагаж мөрдөөгүй тохиолдолд үр дүнтэй ял шийтгэл оногдуулах.*
- 4) Хөрөнгө орлогын мэдүүлэг авах тогтолцоонд улс төрийн албан тушаалтныг оролцуулан бүх төрийн албан хаагчдыг хамруулах; хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах үр дүнтэй механизмыг бий болгох, үр дүнг юуны өмнө интернетэд байршуулдаг байх. Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй болон худал мэдүүлэг өгсөн албан тушаалтанд хүлээлгэх үр дүнтэй, дахин ийм байдал гаргахгүй талаас ял шийтгэл авах.*
- 5) Авлигын гэмт хэргийн талаар заавал мэдээлдэг болох, шүгэл үлээгчийг хамгаалах арга хэмжээ авах.*

#### *1) Улс төрийн болон мэргэжлийн төрийн албаны зааг ялгааг тодорхой гаргах*

Монгол улсад төрийн үйлчилгээг Монгол улсын Үндсэн Хууль, Төрийн Албаны Тухай Хууль (ТАТХ) болон бусад хуулийн баримт бичгээр зохицуулдаг. Төрийн Албаны Тухай Хуульд зааснаар төрийн албыг дараах байдлаар дөрөв ангилдаг: төрийн улс төрийн алба (сонгогдсон албан тушаалтнууд болон тэдний зөвлөх, туслахууд); төрийн захиргааны алба (төвийн болон орон нутгийн засгийн газар болон гүйцэтгэх байгууллагын албан тушаалтнууд, Улсын Их Хурал (парламент), Ерөнхийлөгч, Засгийн Газар, шүүх байгууллагууд, Үндсэн Хуулийн Цэц, прокурорын байгууллагууд, яамд, зохицуулах байгууллагууд, орон нутгийн удирдлагууд болон бусад олон нийтийн байгууллагуудад ажиллаж байгаа албан тушаалтнууд); төрийн тусгай алба (дипломат алба, шүүхийн болон бусад тусгай газрын албан тушаалтнууд); төрийн үйлчилгээний алба (боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлаг болон бусад улсын төсвөөс санхүүждэг олон нийтийн байгууллагын тогтмол үйл ажиллагааг хангаж, төрийн үндсэн үйлчилгээг хүргэж, үйл ажиллагаанд туслах үүрэгтэй, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулж буй албан тушаалтнууд). Төрийн захиргааны алба болон төрийн тусгай албыг төрийн жинхэнэ алба гэнэ.

ТАТХ-ийн 6-р зүйлд төрийн улс төрийн албан тушаалтан нь сонгогдсон, эсхүл сонгуулийн үр дүнд томилогдсон албан тушаалтнууд байна хэмээн тодорхойлж, уг албан тушаалтанд

ерөнхийлөгч, ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, ерөнхийлөгчийн зөвлөхүүд, улсын их хурлын дарга, улсын их хурлын дэд дарга, улсын их хурлын гишүүд, ерөнхий сайд, засгийн газрын гишүүд, засгийн газрын сайд нар болон ерөнхий сайд, орон нутгийн дарга нарын зөвлөхүүд хамаарагддаг. Хэдийгээр энэ зүйлийн 6.1.16-д "Хуульд заасан бусад албан тушаал" хэмээн тодорхойлсон боловч бусад хууль болон албан тушаалын талаар тодорхойлоогүй байдаг.

ТАТХ-ийн 6.2-р зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно хэмээн тодорхойлсон байна.

ТАТХ -ийн 7-р зүйлд төрийн захиргааны албан тушаалын талаар тодорхой тайлбарыг оруулсан байна. Энэ зүйлд мөн төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын талаар оруулсан.

Төрийн албаны төв байгууллагын бүтэц, үүрэг нь Монголын төрийн мэргэжлийн үйл ажиллагаа болон улс төрийн нөлөөг хооронд нь тусгаарлахад чухал үүрэгтэй юм. Төрийн албаны төв байгууллага нь захиргааны болон тусгай албанд нэр дэвшигчдийг сонгох, төрийн албатай холбоотой маргаан шийдвэрлэх, Төрийн Албаны Шинэтгэлийн Стратегийн хэрэгжилтийг төлөвлөх, зохицуулах, энэ чиглэлээр төрийн байгууллагуудын нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах, төв байгууллагын жинхэнэ албан хаагчдын мэргэшил болон гүйцэтгэлийг үнэлэх, арга зүйн зааварчилгаагаар хангах чухал үүрэгтэй.

Төрийн Албаны Төв Байгууллага нь дарга болон зургаан гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүдийн хоёр нь орон тооны, дөрөв нь орон тооны бус гишүүд байна. Зөвлөлийн орон тооны 2 гишүүнийг Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар тус тус нэр дэвшүүлнэ. Эдгээр албан тушаалтнуудыг 6 жилийн хугацаагаар Улсын Их Хурлаас сонгоно. Зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно. Орон тооны бус хоёр гишүүнд дараах албан тушаалтан байна: Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Дэд дарга, Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга нар байна. Төрийн албаны удирдах байгууллагыг ийм бүрэлдэхүүнтэй байлгах нь Монгол улсын төрийн албанд улс төржих байдлын эрсдэл бий болгож байна. Тийм ч учраас иргэний нийгэм болон олон улсын байгууллагуудаас төрийн хэвшилд тулгарч буй гол сорилт нь улс төржилт хэмээн онцолсон байдаг.

Монгол улсын ерөнхийлөгч ТАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 7 сард Улсын Их Хуралд өргөн барьсан бөгөөд Монгол улсын эрх бүхий байгууллагуудын үзэж байгаагаар энэхүү шинэчилсэн найруулга нь улс төрийн болон мэргэжлийн албан тушаалтнуудыг зааг ялгааг илүү тодорхой болгосон байна. Хяналтын хэсэг хуулийн шинэчилсэн найруулгад үнэлгээ хийгээгүй болно.

***төрийн бүх албан хаагчдыг ил тод, ур чадварт суурилсан зарчмаар томилох болон дэвшүүлэх***

Төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоонд засгийн газрын болон гүйцэтгэх байгууллагын бүх орон тоог хамруулна. ТАХТ-ийн 17-р зүйлд төрийн жинхэнэ албан тушаалд авах талаар заасан байдаг бөгөөд хуульд заасан шаардлагыг хангаж байгаа Монгол улсын бүх иргэн төрийн албаны мэргэжлийн шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд нөөцийн жагсаалтад бүртгэгдэнэ. Төрийн жинхэнэ албанд сул орон тоо гарсан тохиолдолд төрийн жинхэнэ албанд ажиллаж буй өөр албан хаагчийг томилно, харин тохирох албан хаагч байхгүй тохиолдолд нөөцийн жагсаалтаас хамгийн өндөр шалгуур хангасан хүнийг сонгоно.

Энэхүү систем нь авлигын эрсдэлийг бий болгож байгаа бөгөөд төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох байдлыг шаардлагагүй байдлаар хязгаарлаж байна. Төрийн албаны зөвлөл мэдэгдэл авахаар бүртгүүлсэн хүмүүст сул орон тоо гарсан талаар мэдэгдэл хийж, сул орон тоо бүхий байгууллага нөөцийн жагсаалтаас албан хаагчийг сонгоно. Ажилтан авах байгууллагын эрх бүхий хүн сул орон тооны мэдэгдэлд хариу явуулсан, нөөцийн жагсаалтын хүмүүсээс сонгож, уулзалтын цаг товлон. Харин нөөцийн жагсаалтаас сонголт хийх үйл явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл тусгаагүй байна.

Хэдийгээр Монгол улсын төрийн алба төрийн албаны ажилчдыг ур чадварт нь тулгуурлан сонгох механизмтай боловч төрийн албан албан хаагчид улс төрийн холбоонд үндэслэн сонгодог гэх ойлголт нийтлэг байдаг. Монгол улсад улс төрийн албан хаагчид төрийн албаны мэргэшлийн шалгалт өгөх албагүй байдаг. Хууль тогтоомжийн дагуу улс төрийн өндөр албан тушаалтны ангилалд орох, эсхүл ижил түвшний алба хашиж байсан төрийн албан хаагч тухайн байгууллагын шийдвэрээр Төрийн Албаны Төв Байгууллагын нөөцийн жагсаалтад орж болно. Энэхүү заалт нь мэргэжлийн төрийн үйлчилгээний чадварт тулгуурлан сонгох үндсэн зарчмыг дордуулж байгаа бөгөөд, энэ заалтыг хасах хэрэгтэй.

2014 онд олон нийтийн шалгалтаар ойролцоогоор 1600 шалгуулагч тэнцсэн бөгөөд хамгийн өндөр оноотой шалгуулагчид ажлын байранд томилогдсон байна. 606 хоосон ажлын байрыг нөөцийн жагсаалаас бүрдүүлсэн бөгөөд энэ нь нийт элсэгчдийн ойролцоогоор 40% нь юм. Сонгуулийн дараах жилүүдэд буюу 2012 болон 2013 онуудад тус тус 351 болон 443 элсэгчдийг нөөцийн жагсаалтаас ажлын байранд томилсон байна.

Монгол улсын эрх бүхий байгууллагын мэдээллээр 2014 оны эцэст нийт 183,601 төрийн албан хаагч байгаагийн 2,985 нь улс төрийн албан хаагч, 19,522 нь захиргааны албан хаагч, 35,070 нь төрийн тусгай албан хаагч байсан бөгөөд 126,024 нь үйлчилгээний албан хаагчид байсан байна. 2014 онд 19,969 албан хаагч төрийн албанаас гарсан байна. Төрийн албанаас гарсан хүмүүс урт хугацааны эмчилгээ хийлгэх, нас барсан, суралцах, тэтгэвэрт гарах, сайн дураар гэх мэт шалтгааны улмаас гарсан байна. Монгол улсын төрийн албаны хүний нөөцийн эргэлт өндөр байгаагаас төрийн байгууллагуудын институцийн хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Төрийн Албаны Тухай Хуульд төрийн албан хаагчдын тушаал дэвших талаар заагаагүй байна. Харин 19 дүгээр зүйлд гүйцэтгэлийн үнэлгээ болон 20 дугаар зүйлд зэрэг дэвийн талаар тодорхойлсон нь тушаал дэвших талаар зарим нэг чиглэл болсон байна. Үнэлгээний үр дүнд суурилан тушаал дэвшүүлнэ. Зэрэг дэв олгох нь ажлын гүйцэтгэл болон бусад хэд хэдэн шалгууртай байдаг. Үнэлгээг Төрийн Албаны Төв Байгууллагын журмын дагуу тогтооно.

Төрийн жинхэнэ албан хаагчдыг гүйцэтгэлийн үнэлгээний системээр үнэлэх бөгөөд төрийн албаны ажилчдыг гүйцэтгэлийн гэрээгээр үнэлнэ. Төрийн албаны ажилчдын гүйцэтгэлийн үнэлгээг гүйцэтгэлийн гэрээнд дараах байдлаар тодорхойлсон байна: 90-100 оноо авсан бол "А" эсхүл "Маш сайн", 80-90 оноо авсан бол "В" эсхүл "Сайн", 70-80 оноо авсан бол "С" эсхүл "Хангалтгүй", 60-70 оноо авсан бол "D" эвсэл "Хангалтгүй", 0-60 оноо авсан бол "F" эсхүл "Муу" үнэлгээ авна.

Хуульд зааснаар төрийн жинхэнэ албан тушаалтны мэргэшил болон гүйцэтгэлийн түвшний үнэлгээний үр дүн нь төрийн албаны ажилтны тушаал дэвших, зохих түвшний сургалтанд хамрагдах, зэрэг, дэв олгох, цалин нэмэх, шагнал, урамшуулал олгох, албан тушаал бууруулахын үндэслэл болно. Гэсэн хэдий ч эдгээртэй холбоотой шийдвэрүүдийг удирдах албан тушаалтан өөрийн үзэмжээр гаргадаг бөгөөд энэхүү журмыг хэрэгжүүлэх механизмыг



бүрэн хөгжүүлэх хэрэгтэй.

25.1.1 -р зүйлд "хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн" тохиолдолд төрийн албанаас халах үндэслэл болно гэж заасан байна. Монгол Улсын Дээд Шүүхийн 2010 оны 8-р тогтоолоор "албан үүргээ хангалтгүй биелүүлсэн" гэдгийг дараах байдлаар тодорхойлсон: "албан үүргээ хангалтгүй биелүүлсэн" гэдгийг ажлын байрны тодорхойлолт болон албаны чиг үүрэгт тусгагдсан, хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааг гүйцэтгэсэн боловч чанарын хувьд доголдуулсан, хугацаа хэтрүүлсэн, тогтоосон журмыг зөрчсөн зэргээр зохих ёсоор биелүүлээгүй байхыг ойлгоно. Үнэлгээг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр хийнэ. Мөн түүнчлэн энэхүү үнэлгээг хийх хуулийн үндэслэл нь тодорхой бус байгаа юм (ТАТХ-д тодорхойлоогүй).

***төрийн албан тушаалтны цалин, урамшууллын систем шударга, нээлттэй, үнэн зөв байх,***

Монгол улсын төрийн албаны ажилчдын цалин, урамшууллын систем нь төвөгтэй, ойлгомжгүй байна. Цалинд үндсэн цалингаас гадна ажлын нөхцөл, төрийн албанд ажилласан жил, зэрэг, цол, докторын зэрэг болон мэргэжлийн бусад нөхцөлийг харгалзан үзэж нэмэгдэл олгодог. Хэдийгээр ТАТХ-д ижил албан тушаалтай төрийн албан хаагчдын цалингийн хэмжээ ижил байна хэмээн тодорхойлсон боловч удирдах албан тушаалтын шийдвэрээс шалтгаалан цалингийн хэмжээ өөр байдаг. Жишээлбэл, төрийн албаны ажилчдын урамшуулал нь үндсэн цалингийн 40% хүртэл байж болдог бөгөөд нэмэлт цалин авах боломжтой. Хэдийгээр Төрийн Албаны Зөвлөл урамшуулал олгох системийг сайжруулж, гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлана гэсэн боловч урамшуулал олгох талаар тодорхой, ойлгомжтой зарчим байхгүй бөгөөд удирдах албан тушаалтны шийдвэрээс хамаардаг.

**Дүгнэлт:** Зөвлөмжийн дагуу томоохон өөрчлөлтүүд хийгдээгүй. Улс төрийн болон мэргэжлийн төрийн үйлчилгээний хоорондын ялгаа бага, төрийн жинхэнэ албан хаагчдын томилгоо улс төржсөн, олонх тохиолдолд өргөдөл гаргагчдын чадвар, боловсролын хэмжээнд тулгуурлаагүй байна. Ярилцлагад орсон томоохон албан тушаалтнууд улс төрийн эх баригч намын өөрчлөлт төрийн удирдлагад бүхэлд (79-90 хувьд) нь өөрчлөлт оруулдаг бөгөөд зөвхөн дээд түвшний удирдлагад ч бус, дунд, доод түвшний удирдлагад өөрчлөлт ордог нь төрийн удирдлагад маш сөрөг үр дагавартай байдаг хэмээсэн юм. Энэ асуудал орон нутгийн засаг захиргаа, төрийн компаниудад ч мөн байдаг байна. Төрийн Албаны Зөвлөлийн бүтэц нь улс төрийн хамааралтай албан тушаалтнуудаас бүрдсэн учраас томоохон асуудлыг бий болгож байна. Төрийн албаны ажилчдын урамшуулал цалин нь тодорхой, ойлгомжтой дүрэм, журмаар зохицуулагддаггүй бөгөөд үнэн зөв шалгуурт ч үндэслээгүй байна.

***2) Төрийн албан тушаалтанд хориглох болон хязгаарлах заалтуудыг хянан үзэж, бүх төрлийн ашиг сонирхлын зөрчлийг хуульд бүрэн хамруулж мөрдөх.***

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль (Сонирхлын Зөрчлийн Тухай Хууль)-д томоохон хуулийн цоорхой байдаг бөгөөд энэ нь хуулийг үр дүнтэй байдлаар хэрэгжүүлэхэд саад болдог. Жишээлбэл, "хувийн ашиг сонирхол" гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. "Хувийн ашиг сонирхол" гэдэгт хамааралтай этгээдийн мөнгөн болон мөнгөн бус ашиг тус, эсхүл давуу талыг (Хуульд зааснаар ашиг сонирхолд бус) оруулахаас гадна мөн албан тушаалтантай хувийн, бизнесийн болон улс төрийн харилцаатай байгаа эсхүл байсан хувь хүн, хуулийн этгээдийг ч мөн оруулах нь чухал юм. Түүнчлэн, "нийтийн ашиг сонирхол" гэдгийг нийтийн албан тушаалтанд хүлээлгэж буй олон нийтийн итгэл хэмээн тодорхойлсон

байдлыг мөн эргэж харах хэрэгтэй. Мөн хуульд хамааралтай этгээдийн хоёр тусдаа тодорхойлолт байгаа нь үр дүнтэй бус юм: "хамаарал бүхий этгээд" болон "нэгдмэл сонирхолтой этгээд".

Төрийн албанаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалтуудын талаар Хуульд тусгахдаа төрийн албан тушаалтан нь урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллахыг хязгаарласан боловч ирээдүйн ажил олгогчтой хэлэлцээр хийхийг хориглоогүй байна. Хуульд хоёр жилийн хугацаатай хязгаарлалт тавьсан нь үндэслэлгүй юм. Жишээлбэл, Хуульд албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж заасан байна.

Мөн энэ Хууль нь илэрхий сонирхлын зөрчлийн талаар тусгаагүй бөгөөд хамаарал бүхий этгээдтэй хамтран ажиллах талаар хязгаарлалт байхгүй байна.

Ялангуяа, өндөр эрсдэл бүхий салбаруудад (жишээлбэл, төрийн худалдан авалт, лиценз болон бусад) тусгайлан заасан зохицуулалт хязгаарлалт байхгүй бөгөөд төрийн албан тушаалтны улс төрийн харилцаатай (төрийн алба нь улс төржих магадлалтай учраас энэ асуудал нь маш чухал юм) холбоотой асуудлуудыг тусгаагүй байгаа юм. Тиймээс энэхүү Хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад анхааралтай хандах хэрэгтэй.

Сонирхлын зөрчлийн тухайн хуульд зааснаар төрийн албаны ажилчид болон төрийн албанд нэр дэвшүүлсэн хүмүүс хувийн ашиг сонирхлын мэдүүлэг бөглүүлнэ. Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хороо нь Авлигатай тэмцэх газрын санал болгосны үндсэн дээр хувийн ашиг сонирхлын мэдүүлэг бөглөх албан тушаалтнуудын жагсаалтыг баталдаг.

Мөн томилгоо хийх эрх бүхий байгууллага эсхүл албан тушаалтан нийтийн албанд нэр дэвшигчийн урьдчилсан байдлаар ирүүлсэн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай Тэмцэх Газарт илгээнэ. Авлигатай Тэмцэх Газар урьдчилсан байдлаар ирүүлсэн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг ажлын 10 хоногт шалгаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд тухайн нэр дэвшигчтэй үүсч болох болзошгүй ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэнэ. Томилох байгууллага, албан тушаалтан нь тухайн иргэнийг нийтийн албанд авсан тохиолдолд сонирхлын зөрчил үүсч болзошгүйг тогтоосон тохиолдолд нэр дэвшигчийн томилохоос татгалзах үүрэгтэй.

Албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нь олон нийт, байгууллагуудад нээлттэй бөгөөд албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй. Энэ Хуулийн дутагдалтай тал нь мэдүүлгийг интернетэд байршуулдаггүйд оршино. Ашиг сонирхлын зөрчил гаргасан тохиолдолд оногдуулах ял шийтгэлийн талаар энэ зөвлөмжийн ял шийтгэл хэсэгт дурдсан.

**Дүгнэлт:** Монгол улсад ашиг сонирхлын зөрчлийг зохицуулсан тодорхой заалт байдаг бөгөөд хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч энэхүү системийн үр дүнг нэмэгдүүлэхийн тулд хуулийн цоорхойг арилгаж зохицуулалтыг сайжруулах нь чухал юм. Ялангуяа сонирхлын зөрчлийн тодорхойлолтыг эргэн харах хэрэгтэй.

**3) Хууль зөрчсөн тохиолдолд ял шийтгэл хүлээлгэх эрх бүхий байгууллагыг тодорхой томилох, журмыг нарийвчлан тодорхойлох, хуулийг дагаж мөрдөөгүй тохиолдолд үр дүнтэй ял шийтгэл оногдуулах.**

Монгол улсын Авлигын эсрэг хууль болон Сонирхлын зөрчлийн тухайн хуульд авлигын эсрэг хуулийг зөрчсөн тохиолдолд шийтгэлийн талаар оруулсан байдаг. Авлигын эсрэг хуульд заасан ял шийтгэлүүд нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хуулийг зөрчих, хөрөнгийн мэдүүлгийн хуулийг зөрчихтэй холбогдсон байдаг. Авлигаас урьдчилсан сэргийлэх арга хэрэгсэлд эрх бүхий албан тушаалтны авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэх талаар тодорхойлсон байдаг. Түүнчлэн, дээр дурдсан нөхцөлд сахилгын шийтгэлээ биелүүлээгүй албан тушаалтанг шүүхээс сарын цалинг 1-50 дахин нугалсан хэмжээний төгрөгийн торгуул оногдуулна.

Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагад, Хуулийн 33-р зүйлд: (1) Авлигатай Тэмцэх Газарт аливаа "авлигатай холбоотой мэдээлэл" хүргүүлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, (2) мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн зүйл заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох; (3) удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох гэж заасан байна. Хуульд хориглох зүйлүүдийг (Авлигын эсрэг хуулийн 7.1-р зүйл) дараах байдлаар тодорхойлсон байна: албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх; бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах; албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах; төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах; албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах; албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх; албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх; үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг (Авлигын эсрэг хуулийн 13.8-р зүйл) дор дурдав.

Хуульд хэрэглэсэн зөрчил, шийтгэлийн хэллэгүүд нь одоо харьцангуй тодорхой болсон ("авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй", "мэдүүлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд албан тушаал бууруулах", "удаа дараа зөрчсөн этгээдийн төрийн албанаас халах" г.м).

Авлигын эсрэг хуулийн 7.1-д тусгасан олон зөрчлүүдийг Эрүүгийн Хуульд ч мөн тусгасан бөгөөд Хуульд тодорхойлсоноор 33-р зүйлд тусгасан шийтгэлүүд нь эрүүгийн хариуцлага хүлээхээргүй бол хүлээлгэнэ гэж тодорхойлсон. 7.1-д заасан зөрчлүүд нь хамгийн ноцтой зөрчлүүд (авлига авах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих г.м) бөгөөд эрүүгийн хэрэг үүснэ. Авлигын эсрэг хуулийн 33-р зүйлд заасан шийтгэлүүд нь сахилгын шинж чанартай бөгөөд эрүүгийн шийтгэл хүлээлгэх байсан ч хүлээлгэнэ. Эдгээр шийтгэлүүд нь эрүүгийн шийтгэлүүдийн хоёрдахь үр дагавар бөгөөд эрүүгийн шийтгэлийг орлохгүй юм. Эдгээр хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд албан тушаалаас халах, тодорхой хугацаагаар төрийн алба хашихыг хориглох шийтгэлтэй.

Авлигын эсрэг хуулиас гадна сонирхлын зөрчлийн зохицуулалтуудыг зөрчсөн тохиолдолд

нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулиар мөн шийтгэл оногдуулж болно. Хуульд хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг мөрдүүлж, ашиг сонирхлын мэдүүлгийг хүлээн авч, бүртгэх, баталгаажуулах явцад төрийн байгууллагын удирдлага авлигын шинжтэй зөрчил илрүүлвэл Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна. Энэ хуульд мөн хэрвээ нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулиар эрүүгийн ял шийтгэл оногдуулахгүй бол Хуулийн заасан тохиолдолд шүүх байгууллага захиргааны шийтгэл оногдуулж болох талаар заасан. Эдгээр шийтгэлүүд нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлэх, байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг орно. Үүнээс гадна ашиг сонирхлын тухай зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд Хуульд заасан дараах арга хэмжээг авна: албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, албан тушаалаас бууруулах эсхүл халах.

Ял шийтгэлтэй холбоотой бүх шийдвэрийн талаарх мэдээллийг интернетэд байршуулахыг зөвлөмж болгож байна. Ингэх нь төрийн албан хаагчдын шударга байдлыг дээшлүүлэх арга юм.

Статистик. Хэдийгээр Монгол улсад авлигатай холбоотой шийтгэлийн талаар нэгдсэн статистик мэдээлэл байхгүй ч АТГ өөрийн эрх мэдлийн хүрээнд дараах мэдээллийг өгсөн. 2014 онд төрийн албанд нэр дэвшигчдийн нийт 13,226 урьдчилсан мэдүүлэг ирсэн бөгөөд үүнээс АТГ 3,344 мэдүүлгийг сонирхлын зөрчилтэй хэмээн тодорхойлж, 1,000 мэдүүлгийг шалгах боломжгүй учраас ажил олгогчруу буцаан хүргүүлсэн. Түүнчлэн АТГ-т урьдчилсан мэдүүлэг хүргүүлэх шат дарааллыг алгасч хууль бусаар олгосон 1,225 томилгооны шийдвэрийг хүчингүй болгож, нэр дэвшигч өөрийн эрх мэдлийн хүрээнд сонирхлын зөрчил бүхий үйлдэл гаргасан нөхцөл байдлын талаарх 162 дүгнэлтийг ажил олгогч байгууллагад хүргүүлсэн. 2015 оны эхний хагаст төрийн албанд 4,910 нэр дэвшигчдийн 4,784 -г баталгаажуулсан байна.

2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээс 45 худал мэдүүлэг, 45 сонирхлын зөрчилтэй холбоотой хууль тогтоомжийн зөрчил илрүүлсэн. Ял, шийтгэл оногдуулсан 90 тохиолдолоос 27 албан хаагч албан тушаалаас халагдаж, 5 албан хаагч тушаал буурч, 41 албан хаагчийн цалинг 3 сарын хугацаанд 30% бууруулж, 17 албан хаагч сануулга авсан. 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээс 29 худал мэдүүлэг, 36 сонирхлын зөрчилтэй холбоотой хууль тогтоомжийн зөрчил илрүүлсэн. Ял, шийтгэл оногдуулсан 65 тохиолдолоос: 8 албан хаагч албан тушаалаас халагдаж, 1 албан хаагч тушаал буурч, 30 албан хаагчийн цалинг 3 сарын хугацаанд 30% бууруулж, 15 албан хаагч сануулга авсан байна.

**Дүгнэлт:** Зөвлөмжийн энэ хэсгийг хэсэгчлэн хэрэгжүүлсэн байна. Авлигын эсрэг хуулийн зүйл заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх ял шийтгэл сул бөгөөд үр дүн багатай байна. Ноцтой зөрчлүүдэд сахилгын шийтгэл оногдуулж байгаа байна. Ял шийтгэл оногдуулах тодорхой шат дараалал байхгүй байна. Ашиг сонирхлын зөрчлийн тухайн хуульд ял шийтгэлийн талаар илүү тодорхой заасан боловч ял шийтгэл оногдуулсан тоон мэдээлэл дутмаг байгаа учраас хуулийн үр дүнтэй байдлыг үнэлэхэд хүндрэлтэй байна.

**4) Хөрөнгө орлогын мэдүүлэг авах тогтолцоонд улс төрийн албан тушаалтныг оролцуулан бүх төрийн албан хаагчдыг хамруулах;**

Авлигын эсрэг хуульд (10.1-р зүйлд) хуулийн 4.1-р зүйл заасан этгээд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах шаардлагатай хэмээн заасан байна. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын нэмэлт жагсаалтыг батална. Энэхүү жагсаалтыг Улсын Их Хурлын 2012 оны шийдвэрээр "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам" болгож баталсан. Энэхүү журамд мөн хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргах шаардлагагүй албан тушаалтнуудыг жагсаалтыг оруулсан байна.

Монгол улсын хууль журмаар хэд хэдэн мэдүүлгийн маягтыг бүрдүүлдэг: "Албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт", "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт", "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт", "Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг".

Мэдүүлэг хийх систем нь ярвигтай бөгөөд төрийн албан хаагчдын хийх шаардлагатай мэдүүлгийн тоог нэгтгэх шаардлагатай. Түүнчлэн, Хуульд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах ёстой албан тушаалтныг сонгох шалгуурыг тодорхойлоогүй (зохицуулалтад өндөр эрсдэл бүхий албан тушаал, газар зэрэг хүчин зүйлийг оруулаагүй).

Журмаар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах ёстой албан тушаалтнуудын жагсаалтыг баталдаг. Саяханаас жагсаалтыг багасгаж ойролцоогоор 180,000 албан тушаалтны 19% нь буюу 34,632 албан тушаалтан тухайн мэдүүлгийг гаргаж байна.

Хөрөнгийн мэдүүлгийн систем нь төвлөрсөн бус байдаг бөгөөд дараах байгууллага, албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэл, хадгалалтыг хариуцан ажиллаж байна: Авлигатай Тэмцэх Газар (Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг); Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо (Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг); Шүүхийн ерөнхий зөвлөл (Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг); тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг); бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан, мөн Сонгуулийн Ерөнхий Хөрөө, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод (Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ болон Иргэдийн Төлөөлөгчийн хурлын бүх шатны нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг).

Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчид албан тушаалд томилогдсон эсхүл сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргасны дараа албан тушаалдаа байх хугацаанд жил бүрийн 2 сарын 15-наас өмнө өөрчлөлтийг мэдэгдэнэ.

Төрийн байгууллагын удирдлага мэдүүлгийн бүртгэл, хяналт болон хадгалалттай холбоотой үүргийн удирдлагын эсхүл хуулийн хэлтэсийн холбогдох ажилтанд даалгаж (суурь цалингийн 40 хүртэл хувиар ажлын хөлс бодож олгоно) ажилтан дараах үүрэгтэй байна: а) мэдүүлгийн үйл явцын гүйцэтгэлийн тайлан гаргах; б) мэдүүлгүүд холбогдох журмын дагуу байгаа эсэхийг хянах; в) хууль, журам зөрчсөн болохыг илрүүлсэн бол өөрийн эрх мэдлийн хүрээнд мэдэгдэх, эсхүл АТГ-т шалгуулахаар шилжүүлэх үүрэгтэй. Хариуцсан байгууллага, албан тушаалтан мэдүүлгүүдийг хүлээн авч дууссанаас хойш 14 хоногийн дотор

гүйцэтгэлийн тайланг мэдүүлэг гаргасан албан тушаалтны нэрсийн жагсаалтын хамт АТГ-д хүргүүлнэ. Энэ хооронд Сонгуулийн Ерөнхий Хороо сонгогдсон нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг сонгуулийн санал хураалт дууссанаас 14 хоногийн дотор Авлигатай Тэмцэх Газарт хүргүүлнэ.

АТГ-ын Хяналт Шалгалт, Дүн Шинжилгээний Хэлтэс улс орон даяарх Хөрөнгө, Орлогын Мэдүүлгийг цуглуулж, ангилдаг. Төрийн байгууллага болон салбарын ойролцоогоор 1,550 эрх бүхий албан хаагчид мэдүүлгийг цуцлуулж, хянадаг.

Хөрөнгө орлогын мэдүүлгийн нийт гаргалтын хувь өндөр байдаг. 2014 онд бүртгэлтэй 51,584 төрийн албан хаагчдаас 51,579 (99.99%) мэдүүлэг авсан. 51,573 албан хаагч (99.98%) хуульд заасан хугацаанд мэдүүлгээ хүргүүлсэн бол 6 албан хаагч (0.01%) хоцорц, 5 албан хаагч (0.01%) мэдүүлгээ гаргаагүй байна. Авлигын эсрэг хуульд зааснаар 11 албан хаагчид шийтгэлийн арга хэмжээ авсан бөгөөд үүний 6-д нь шийтгэл оногдуулсан байна. Шийтгэлийн талаарх статистик мэдээллийг доорхоос харна уу.

### Хүснэгт 16. Монгол улсын хөрөнгө, орлогын мэдүүлгийн гаргалт

		2009	2010	2011	2011	2012	2013
		Хөрөнгө орлогын мэдүүлэг	Хөрөнгө орлогын мэдүүлэг	Хөрөнгө орлогын мэдүүлэг	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг
Нийт мэдүүлгийн тоо		54604	56832	58251	45858	47142	51584
Үүнээс	Хоцорсон	15	49	25	7	22	6
	Мэдүүлээгүй	136	69	64	96	15	5
Цаг хугацаандаа мэдүүлсэн хувь		99.75	99.87	99.89	99.79	99.97	99.99

### *хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах үр дүнтэй механизмыг бий болгох, үр дүнг юуны өмнө интернетэд байршуулдаг байх*

Авлигатай Тэмцэх Газар хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалган шинжлэхээс гадна холбогдох байгууллага, албан тушаалтан хөрөнгө оруулгын мэдүүлгийн бүртгэх, хадгалах, хянах зааврыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаж буй этгээдийг ажиглах, мөрдөх талаар мэдээллээр хангадаг. АТГ нь мөн иргэдийн бүртгэлийн сан, авто хэрэгслийн сан болон хуулийн этгээдийн бүртгэлийн сан зэрэг төрийн электрон мэдээллийн сантай холбогдсон байдаг. АТГ-аас мэдүүлгээ цаг хугацаанд нь гаргаагүй, эсхүл зориудаар худал мэдүүлэг гаргасан албан хаагчдад шийтгэл оногдуулдаг. Авлигын эсрэг хуульд зааснаар АТГ хүлээн авсан гомдлын дагуу эсхүл өөрийн шалгалтын төлөвлөгөөны хүрээнд хяналт, шалгалт явуулдаг. 2013, 2014 болон 2015 оны эхний хагаст АТГ-ын хяналт, шалгалтаар баталгаажуулсан тус тус 363, 361 болон 272 мэдэгдэл байсан. 2014 онд баталгаажуулсан нийт мэдэгдлийн тоо 2,528 байсан.

Гэсэн хэдий ч Хуульд шалгалтын төлөвлөгөөний аргачлалын талаар дэлгэрэнгүй заагаагүй бөгөөд авлигын өндөр эрсдэл бүхий албан тушаал, газарт өндөр ач холбогдол өгөх талаар тодорхойлоогүй байдаг. Монгол улсад авлигатай холбоотой хийгдэж байсан олон судалгаа байдаг бөгөөд энэхүү судалгааг ашиглан авлигын өндөр эрсдэлтэй албан тушаал, газрыг тодорхойлж болно.

Улсын Их Хурлын дэргэдэх Хууль Зүйн Байнгын Хороо нь Авлигатай Тэмцэх Газрын ахлах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгах үүрэгтэй байдаг. Улсын Их Хурлын Ёс Зүйн Дэд Хороо Улсын Их Хурлын гишүүдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгаж, эрүүгийн мөрдлөг шаардлагатай зөрчлийг холбогдох байгууллагад шилжүүлдэг. Хэрвээ Улсын Их Хурлын гишүүн мөн Засгийн газрын гишүүн бол АТГ хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгадаг.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэл хариуцсан албан хаагчид мэдүүлгийг бүрэн, зөв бөглөж, хугацаандаа хүргүүлсэн эсэхийг шалгаж, удирдамжийн дагуу өөрчлөлт хийлгүүлэх эрхтэй бөгөөд зөрчил гарсан тохиолдолд өөрийн эрх мэдлийн хүрээнд шалгалт явуулж эсхүл АТГ-т шалгуулахаар хүргүүлнэ.

Ерөнхийдөө АТГ-аас гадуурх баталгаажуулалтын механизмын үр дүнтэй байдал, үр дагавар нь тодорхой биш бөгөөд үр дүн багатай байдаг. Үүнтэй холбоотой статистик мэдээлэл байхгүй байна (УИХ болон шүүх засаглалын гишүүдийн мэдүүлгийн баталгаажуулалтын үр дүн ч мөн адил).

Харин хуульд хөрөнгө, орлогын мэдүүлгийг нь Засгийн Газрын Мэдээ сонинд жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан хэвлэж, интернетэд байршуулах албан хаагчдын жагсаалтын талаар тусгасан байдаг. Авлигын эсрэг хуулийн 14-р зүйлд дараах албан тушаалтнууд мэдүүлгээ хэвлэлд байршуулна хэмээн заасан байдаг: Монгол Улсын Ерөнхийлөгч; Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн; Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд; Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний орлогч, гишүүн; Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга; Улсын ерөнхий прокурор, түүний орлогч; Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга; Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга; Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга; Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга; Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга; Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн; Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга; Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн; Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга; Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн; Ерөнхий аудитор, түүний орлогч; Засгийн газрын агентлагийн дарга; аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга; аймаг, нийслэлийн Засаг дарга нар байна.

Одоогийн интернетэд тавигдсан хөрөнгө, орлогын мэдүүлэг нь дутмаг бөгөөд аль болох дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх хэрэгтэй, ялангуяа авлигын өндөр эрсдэлтэй албан тушаал, газарт ажиллаж байгаа хүний мэдүүлэг байх хэрэгтэй.

***Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй болон худал мэдүүлэг өгсөн албан тушаалтанд хүлээлгэх үр дүнтэй, дахин ийм байдал гаргахгүй талаас ял шийтгэл авах***

Авлигын эсрэг хуульд мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаагүй, хожимдож гаргасан эсхүл буруу мэдээлэл гаргасан бол дараах шийтгэл ноогдуулахаар заасан:

1. Сануулах - нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол;
2. Албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах - зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол;
3. Албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах - зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол;
4. Албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах - нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол;

Хөрөнгө, орлогын мэдүүлгүүдийг бүртгэж, хянах үүргээ биелүүлээгүй албан хаагчид тусдаа шийтгэл оногдуулна.

Хуульд худал мэдээлэл хэзээ өгсөн тохиолдолд сануулга, цалин бууруулах, албан тушаал бууруулах, албан тушаалаас огцруулах талаар тодорхой заагаагүй байна. Мөн дутуу мэдээлэл өгөх нь худал мэдээлэлд тооцогдох эсэх нь тодорхой бус байгаа бөгөөд дутуу мэдээлэл өгсөн тохиолдолд шийтгэл байхгүй гэж ойлгогдож байна.

**Дүгнэлт:** Монгол улсын хөрөнгө, орлогын мэдүүлгийн механизм, дэд бүтэц бий болсон байна. Гэсэн хэдий ч энэхүү механизм нь үр дүн багатай байгаа бөгөөд ялангуяа баталгаажуулалтыг сайн хийж чадахгүй байгаа. Интернетэд зайлшгүй байршуулах мэдүүлгийн жагсаалтыг илүү нэмэгдүүлэх зөвлөмж өгч байна. Ял шийтгэлийг чангатгах хэрэгтэй бөгөөд хөрөнгө, орлогын мэдүүлгийг буруу мэдүүлсэн тохиолдолд эрүүгийн ял, шийтгэл оногдуулдаг болох талаар судалж үзэх хэрэгтэй.

#### ***5) Авлигын гэмт хэргийн талаар заавал мэдээллэдэг болох, шүгэл үлээгчийг хамгаалах арга хэмжээ авах.***

Монгол улсын Авлигын тухайн хуульд албан хаагч албан үүргээ биелүүлэх явцдаа авлигатай холбоотой олж авсан ямар нэг мэдээллийг Авлигатай Тэмцэх Газарт даруй мэдэгдэнэ гэж заасан. Авлигатай тэмцэх хуулийн үүрэг, хариуцлага дараах албан тушаалтнуудад үйлчилнэ: а) төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан; б) төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан; в) улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан; г) сонгуульд нэр дэвшигч; д) эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан нар байна. Энэ заалтын хэрэгжилтийн талаарх мэдээлэл (дотоод болон гадны тайлан, тайлангийн үр дүн) байхгүй байна.

Шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалт байхгүй байна. Төрийн албан тушаалтнууд шүгэл үлээх боломжийг дэмжсэн санаачлага байхгүй байгаа бөгөөд шүгэл үлээсэн тохиолдлын талаарх статистик мэдээлэл байхгүй байна. Шүгэл үлээгчийг хамгаалах системтэй байх нь чухал гэдгийг иргэний нийгмийн төлөөлөгчид онцолж байсан.



## Дүгнэлт

Монгол улсын төрийн алба улс төржсөн хэвээр байгаа бөгөөд улс төрийн болон мэргэжлийн ажилтны хоорондын зааг ялгаа бодит байдалд муу байна. Төрийн албан хаагчдыг тушаал дэвшүүлэхэд чадвар, боловсролд суурилсан хандлага хэрэгжихгүй байна. Төрийн албаны зөвлөлийн бүтэц нь томоохон асуудал дагуулж байна. Урамшууллыг хэрхэн олгох талаар тодорхой, нээлттэй журам батлах хэрэгтэй.

Монгол улс авлигын эсрэг хориг, хязгаарлалт, сонирхлын зөрчил болон хөрөнгийн мэдүүлгийн талаар цогц зохицуулалтыг бий болгосон байна. Гэсэн хэдий ч эдгээр зохицуулалт нь хоорондын уялдаа холбоо бага бөгөөд дагаж мөрдөхөд хэтэрхий төвөгтэй байгаа учраас дээрээс доош чиглэсэн нэгдмэл зохицуулалттай байх нь зүйтэй. Авлигын эсрэг үндсэн хоёр хуульд (Авлигын эсрэг хууль болон Сонирхлын зөрчлийн тухай хууль) шинэчлэл хийхийг зөвлөж байгаа бөгөөд магадгүй энэ хоёр хуулийг нэг хууль болгон нэгтгэж хязгаарлалт, үүрэг хариуцлага, процесс болон шийтгэлийг тодорхой болгох хэрэгтэй.

Мөн хөрөнгийн мэдүүлгийн системийг хялбарчилж, АТГ-т мэдүүлгийг хүлээн авах, баталгаажуулах эрх мэдлийг төвлөрүүлэхийг зөвлөж байна. Бүх эсхүл ихэнх мэдүүлгийг албан журмаар интернетэд байршуулах ажлыг эхлүүлэх хэрэгтэй. Сонирхлын зөрчлийн тодорхойлолтыг олон улсын стандартын дагуу дэлгэрүүлэх хэрэгтэй.

Ерөнхийдөө сүүлийн үнэлгээний тайлангаас хойш холбогдох журам, үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт хийгдээгүй байна.

Монгол улс Зөвлөмж 3.2 –г **хэсэгчлэн биелүүлсэн** бөгөөд зөвлөмж хэвээр үлдэнэ.

### **3.3. Ил тод байдлыг хөхиүлэн дэмжих ба төрийн албаны үзэмжээр хандах явдлыг бууруулах**

#### *Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.3.*

- 1) Хуулийн төсөл болон бусад акт, журамд авлигын эсрэг шалгалт хийдэг журам нэвтрүүлэх*
- 2) Төрийн захиргааны холбогдолтой хэргийг зохицуулах захиргааны журмын актыг олон улсын стандартад нийцүүлэн батлах*
- 3) Захиргааны холбогдолтой гомдлыг шийдвэрлэхэд дагаж мөрдөж байгаа журам болон практикийг (захиргааны шийдвэрийг эсэргүүцэж давж заалдахаас өмнө, шүүхийн үйлдэх болон эс үйлдэхүй) хянан үзэж, төрийн захиргааны давж заалдах үр дүнтэй тогтолцоотой болохын тулд шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулах.*

#### *1) Хуулийн төсөл болон бусад акт, журамд авлигын эсрэг шалгалт хийдэг журам нэвтрүүлэх*

Авлигын эсрэг хуулийн 18.4.2-т авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл АТГ төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах, өөрчлөх шаардлага тавина. Монгол улсын эрх бүхий байгууллага энэхүү заалт нь бодит байдалд АТГ орон нутгийн төрийн эрх бүхий байгууллагуудад шалгалт хийдэг бөгөөд тухайн газар дээрх шалгалтын явцад АТГ-ын бүрэлдэхүүн авлигатай холбоотой зүйл заалт тухайн байгууллагын баталсан журам, дүрмэнд орсон эсэхийг шалгадаг. Авлигын эсрэг шалгалт нь тусдаа нэгж биш бөгөөд уг шалгалтыг хийх тогтсон хуваарь байдаггүй. 2013 онд АТГ 20 аймаг, 4 дүүрэгт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын үр дүнд 10 тушаал, шийдвэр хүчин төгөлдөр бус болохыг илрүүлсэн. Энэ шалгалтаар батлагдаагүй гэрээ, журмыг оруулаагүй.

Энэ шалгалтын дараа Монголын эрх бүхий байгууллагууд АТГ яамд, агентлагуудын бэлтгэж байсан хуулийн төсөлдээр санал, үнэлэлт өгсөн гэж хэлж байсан бөгөөд энэ нь ч тохиолдлын үйл явдал биш юм.

Монгол улсын Хууль зүйн яам Яамнаас гаргаж буй хэд хэдэн хуулийн төсөл дээр Яамнаас 2010 оны 10 сард баталсан дараах аргачлалын дагуу шалгалт хийсэн: Хуулийн төслийн үр дүнг төсөөлөх аргачлал, Хуулийн төслийн үр дүнг хэмжих аргачлал мөн Хуулийн төслийн зардлыг тооцох аргачлал. Эдгээр аргачлалуудын нэг нь (үр дүнг хэмжих аргачлал) тухайн хуулийн төсөл авлига, хүнд суртал бий болгох зүйл, заалт агуулж байгаа эсэхийг тодорхойлох авлигын эсрэг шалгалтын аргачлалтай (4-р бүлгийн 4.10.13-р заалт) байсан. 2011 оны 5 сард Сангийн яамнаас баталсан өөр аргачлалаар зохицуулдаг “захиргааны журмын бэлтгэлийн явц дахь нөлөөллийн шинжилгээ”-д авлигын эсрэг шалгалт хийдэг бусад акт журмууд орсон байдаг. Гэсэн хэдий ч Захиргааны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулиуд 2016 оны 7 сарын 1 болон 2016 оны 2 сарын 10-с тус тус хэрэгжих эхлэх үед хуульд авлигын эсрэг шалгалтын шинэ зохицуулалт орох учраас өмнө нь дурдсан аргачлалууд хүчингүй болох юм. Яамны мэдэгдсэнээр холбогдох хуулийн 12-р зүйлд засгийн газар төсөл хэлбэрээр боловсруулагдаж байгаа хуулийн үр дүнг үнэлэх аргачлал боловсруулна гэж заасан бөгөөд Захиргааны хуулийн 61.6-р зүйлд нөлөөллийн

шинжилгээ хийх аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасан.

Авлигын эсрэг үнэлгээг одоогийн болон батлагдах хуулийн төсөлд оруулсанд хяналтын баг сайшаалтай хандаж байна. Ерөнхийдөө энэ хэлбэрийн шалгалт нь ерөнхий нөлөөллийн шинжилгээний нэгж хэсэг байх боловч нарийн зохицуулалт хийж, хууль, журмын төсөл нь авлигыг бий болгох, бий болгосон тохиолдолд яг хэрхэн бий болох (авлигатай холбоотой хүчин зүйлсд үндэслэн) талаарх шинжилгээгээр хангах хэрэгтэй.

Тиймээс хуулийн төсөл болон бусад чухал ач холбогдолтой хууль, журмуудад системийн үнэлгээ хийж авлига бий болгож болохуйц заалтыг хасч байх зөвлөмж гаргаж байна. Энэ шалгалтыг АТГ-ын мэргэжилтнүүдээр хийлгэж болно. Мөн байнга ашиглагддаг журмуудыг тогтмол шалгаж, авлига бий болгож байгаа заалтыг хүчингүй болгож байх хэрэгтэй.

## ***2) Төрийн захиргааны холбогдолтой хэргийг зохицуулах захиргааны журмын актыг олон улсын стандартад нийцүүлэн батлах***

Монгол улс 2002 оны 12 сард Захиргааны Хэрэг Хянан Шийдвэрлэх Тухай Хууль баталсан. Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Иймд энэхүү хуулийн зохицуулалт нь захиргааны болон шүүхийн журмаар гомдлыг авч үзэх ажиллагааны хүрээнд хязгаарлагддаг.

Захиргааны Ерөнхий Хууль 2015 оны 6 сарын 19-нд батлагдаж, 2016 оны 7 сарын 1-нээс мөрдөгдөж эхэлнэ. Хуулийн зүйл, заалтууд байхгүй байгаа учраас өмнөх Зөвлөмжид хэрхэн нийцэж байгааг үнэлэх боломжгүй байсан. Түүнчлэн хяналтын баг Засгийн газраас төрийн удирдлагын журам болон захиргааны гомдол хянан шийдвэрлэх шүүхийн журмын тусдаа зохицуулалт хийх гэж байгааг сайшаасан. Эхнийхийг Захиргааны Ерөнхий Хуулиар, харин дараахыг нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

## ***3) Захиргааны холбогдолтой гомдлыг шийдвэрлэхэд дагаж мөрдөж байгаа журам болон практикийг (захиргааны шийдвэрийг эсэргүүцэж давж заалдахаас өмнө, шүүхийн үйлдэх болон эс үйлдэхүй) хянан үзэж, төрийн захиргааны давж заалдах үр дүнтний тогтолцоотой болохын тулд шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулах.***

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулинд заасны дагуу захиргааны актын (захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан аливаа хууль зүйн акт, үйлдэл, эс үйлдэл гэж ерөнхийлөн тодорхойлдог) эсрэг нэхэмжлэлийг урьдчилсан шатанд хянаж шийдвэрлүүлэхээр буюу шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө тухайн захиргааны акт гаргасан байгууллага, албан тушаалтны харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргах шаардлагатай байдаг. Нэхэмжлэгч нь шууд харьяалагдах дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэртэй санал нийлэхгүй, эсхүл харьяалагдах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй, эсхүл шууд харьяалагдах дээд шатны байгууллага, албан тушаалтан холбогдох хуульд заасан хугацаанд (30 өдөр) багтааж гомдлыг хянан шийдвэрлээгүй тохиолдолд тус тус нэхэмжлэгч нь захиргааны хэргийн шүүхэд хандаж болох юм. Захиргааны актыг гаргасан байгууллага, албан тушаалтан нь аливаа байгууллага, албан тушаалтанд харьяалагддаггүй тохиолдолд захиргааны шүүхэд шууд хандаж болно. Урьдчилсан шатанд хянаж шийдвэрлэх энэхүү механизм нь аливаа захиргааны актын эсрэг нэхэмжлэл гаргах процесст саад учруулдаг эсэх талаар судлахыг Монголын төрийн байгууллагуудад зөвлөсөн.

Шинэ Захиргааны ерөнхий хуулинд үүнтэй төстэй шаардлагыг тусгасан байдаг (дээд талыг харна уу). Гомдол хянан шалгах ажиллагаа нь дор дурдсан дэс дараагаар явагдана: 1. Төрийн байгууллага өөрийн шийдвэрийг цуцлах боломж 2. Төрийн байгууллага өөрийн харьяа байгууллагын шийдвэрийг цуцлах боломж 3. Зөрчил шийдвэрлэх тусгай хороонд гомдол гаргах (хэрэв байвал) 4. Захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах.

Хууль зүйн яамны хэлснээр Захиргааны ерөнхий хуулийн төслийг бэлдэх ажлын хүрээнд Засгийн газар гомдол гаргах журам, процессыг, ялангуяа урьдчилсан хянан шийдвэрлэх ажиллагаа, давж заалдах шүүхэд хандах хөөн хэлэлцэх хугацаа нь гомдол гаргах, шийдвэрлэх ажиллагаанд саад болдог эсэх талаар судалсан.

Ийм учир Монгол Улс нь зөвлөмжийг хэсэгчлэн биелүүлсэн гэж үзэж байна. Зөвлөмж 3.3-ийг **хэсэгчлэн биелүүлсэн** байгаа бөгөөд зөвлөмж хүчинтэй хэвээр үлдэх юм.

### 3.4. Төрийн санхүүгийн хяналт ба аудит

#### Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.4.

- 1) Монголын Үндэсний Аудитын газрын зохион байгуулалт болон үйл ажиллагааны бие даасан байдлыг олон улсын стандартад нийцүүлэн бэхжүүлэх, ялангуяа төсөв, ажилчдын цалин хөлс тогтоох асуудлын бие даасан байдлыг хангах. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын зөвшөөрөлтэй хэвлэн нийтэлж байх. Ерөнхий аудитор болон ерөнхий аудиторын орлогчийн хувьд ур чадварын зарчимд тулгуурласан өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг нэвтрүүлэх.
- 2) Санхүүгийн удирдлага болон хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлж, улсын секторын удирдлагуудын энэ талаарх мэдлэгийг сайжруулах. Төсвийн санхүүжилтын хяналт болон аудитын хэсэгт дотоод болон гадаад аудит, санхүүгийн хяналт, шинжилгээний зааг, ялгааг үр дүнтэй тодорхойлох зорилгоор хийх шинэчлэлийн үндсэн чиглэлүүдийг тодорхойлох
- 3) Яам болон төсөвт байгууллагын хэмжээнд хяналт шалгалтын ажил үүргийн давхардлаас зайлсхийх, энэ ажлыг дотоод аудитын ажил үүргээс салгах.
- 4) Дотоод аудитын эрхлэх ажил үүргийг нарийвчлан тодорхойлсон, дотоод аудитын нэгжийн зөвлөх болон баталгаажуулах үүрэг, бие даасан байдал, шударга үйл ажиллагааг онцолсон хоёрдогч зохицуулалттай болох. Ингэхдээ аудитын нэгж нь зөвхөн санхүү болон хууль тогтоомжийн хэрэгжилтээс гадна байгууллагын тогтолцоо болон гүйцэтгэлд анхаарал хандуулсан байх нь зүйтэй.
- 5) Сангийн яаманд уялдаа, зохицлыг олох үүрэг бүхий нэгжийн чадамжийг бэхжүүлж, ажил үүргийг нь тодорхой болгох, ингэснээр улсын секторын дотоод аудит болон санхүүгийн удирдлага, хяналт шалгалтын ажлын хэрэгжилтийг уялдуулан зохицуулах.

#### Санхүүгийн удирдлага ба хяналт

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль (2002 он) болон Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль (1992 он) -н цоорхойг арилгахын тулд 2012 оны 1 сард Монгол улсын Төсвийн тухай хуулийн (ТТХ) шинэчилсэн найруулгыг баталсан. Энэ хуулийн зорилго нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөв боловсруулах үйл явцыг сайжруулах замаар Монгол улсын төсвийн удирдлагыг бэхжүүлэхэд чиглэж байсан. ТТХ нь (i) төсвийн дунд хугацааны бүрдлийг сайжруулж, төсвийн тогтвортой байдлыг хангах, (ii) төсвийн цогц байдлыг сайжруулах (iii) хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөв боловсруулах үйл явцыг сайжруулах, (iv) санхүүгийн удирдлагын үр бүтээлтэй байлгах (v) орон нутгийн засаг захиргааны санхүүгийн нөөц, эрх мэдлийг нэмэгдүүлэх (vi) төсвийн оролцоогоор дамжуулан хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудтай байсан.

ТТХ-иар нийслэл болон аймгийн засгийн газрууд суурь боловсрол, эрүүл мэнд, хот төлөвлөлт, барилга, нийгмийн даатгалын үйлчилгээнүүд, усан хангамж, цэвэр, бохир ус, нийтийн тээвэр, хотын зам, гүүр болон гудамжны гэрэлтүүлэг, хог хаягдал зэрэг хотын захиргааны ажлуудыг ч мөн бие даан хариуцах болсоноор орон нутгийн засаг захиргааны эрх мэдэл нэмэгдсэн. Эдгээр орон нутгийн хөрөнгө оруулалт, санхүүжилтыг төв засгийн газрын нэгдсэн татвараас олгодог бөгөөд санхүүжилтын хэмжээ нь орон нутгийн хүн ам, хүн

амын нягтаршил, алслагдсан байдал, орон нутгийн засаг захиргааны хэмжээ, орон нутгийн хөгжил зэргээс шалтгаалдаг.

Орон нутгийн засаг захиргааны эрх мэдэл нэмэгдсэнээс гадна ТТХ-д төсвийн бэлтгэл, төсөвлөлт, дотоод хяналт, дотоод болон гадаад аудит зэрэг өөр өөр түвшний төсвийн захирагч нарийн үүрэг, хариуцлагыг дахин тодорхойлж өгсөн. Төрийн Аудитын тухай хууль (ТАТХ) болон засгийн газрын дотоод аудитын зохицуулалттай хавсарсанаар ТТХ нь Монгол улсын төсвийн удирдлага болон хяналтын зохицуулалтын үндсэн суурь нь болж байна. ТТХ хүчин төгөлдөр болоод хэдхэн жил өнгөрч байгаа учраас орон нутгийн төсвийн захирагч нарын түвшинд хариуцлага, хяналтыг сайжруулах нь засгийн газрын анхаарлаа хандуулах асуудлуудын нэг болж байна.

## **Гадаад аудит**

Төрийн Аудитын тухай хуулиар (2003) Монгол улсын Аудитын дээд байгууллага (АДБ) болох Монголын Үндэсний Аудитын Газар (МҮАГ) -г байгуулсан. МҮАГ нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд гадаад аудит хийх эрх бүхий байгууллага байна. ТТХ-д зааснаар төсвийн хариуцлагатай байдлыг орон нутгийн засаг захиргаадруу шилжүүлсэнээр ТАТХ-ийг 2013 онд шинэчилж МҮАГ-ийн санхүүжилт болон хүний нөөцийн удирдлагын бие даасан байдлыг нэмэгдүүлсэн.

ТАТХ-ийн шинэчилсэн найруулгаар МҮАГ шинэ бүтэцтэй болж, орон нутгийн төрийн аудитын салбарууд урьдынх шиг харьяалагдах орон нутгийн эрх бүхий байгууллагад бус Монгол улсын Ерөнхий Аудитортуу шууд тайлагнадаг болсон. Энэхүү байгууллагын босоо бүтэцээр бүх шатны төрийн аудитортууд өөрсдийн үйл ажиллагаа, техник чиглэлийг Ерөнхий Аудитороос авч, эрх бүхий төв байгууллагад эргээд тайлагнадаг болсон нь АДБ-ыг улсын төвлөрсөн бус төсвийн хэрэгжилтийг дэмжих, хариуцлагатай байдлыг сайжруулах, илүү үр дүнтэй хяналт хийх боломжийг бий болгосон.

ТАТХ-ийн шинэчилсэн найруулга нь Улсын их хурал болон МҮАГ-ийн хоорондох харилцааг дараах байдлаар ойртуулж өгсөн: i) төсвийн хариуцлагатай байдлыг сайжруулахын тулд УИХ-ын Байнгын хороод аудитын дүгнэлтэд үндэслэн үүссэн нөхцөл байдлыг залруулахад шаардлагатай үндсэн алхмуудыг тусгасан тогтоол гаргаж, ii) санхүүгийн бие даасан байдлыг сайжруулахын тулд МҮАГ-ийн жилийн төсвийг Төсвийн байнгын хорооноос шууд баталдаг болсон. Гэсэн хэдий ч МҮАГ өөрийн төсвийг хүсэлтийг засгийн газар болон УИХ-аас өмнө хамгаалж үлдэх онцгой эрх мэдэл байхгүй.

ТАТХ-ийн шинэчилсэн найруулгаар Төсвийн байнгын хороо Ерөнхий Аудиторын хүргүүлсэн МҮАГ-ийн хувь хүний болон байгууллагын төлөвлөгөөг баталдаг. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос МҮАГ-т баталж өгсөн байнгын орон тоо нь 389 байдаг. Баталсан ажилчдын тоо нь хүрэлцээгүй байдаг бөгөөд МҮАГ-аас зарим тохиолдолд бие даасан аудитортуудыг ажиллуулах шаардлагатай болдог. Төрийн аудитортуудын цалин, урамшууллын хэмжээг Засгийн газраас баталдаг бөгөөд төрийн албан хаагчдын хязгаарт байдаг - энэ нь МҮАГ-ийн бие даасан байдалд нөлөөлж буй бас нэгэн хүчин зүйл юм.

МҮАГ-ийн хөндлөнгийн аудит хийх эрх нь санхүүжилтын эх үүсвэр хаанаас гэдгээс үл хамааран УИХ-аас бусад төрийн бүх байгууллагуудад үйлчилдэг. УИХ-д зөвхөн санхүүгийн тайлангийн аудит хийдэг бөгөөд УИХ-ын хүсэлтээр МҮАГ-аас өөр аудит хийж болно. МҮАГ нь Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Холбоо (АДБОУХ) болон Аудитын Дээд Байгууллагуудын Азийн Холбоо (АДБАХ) -ны гишүүн байгууллага юм. МҮАГ Олон улсын Нягтлан Бодогчдын Холбоо болон Олон улсын Дээд Аудитын Стандартын Байгууллагуудын Олон Улсын Аудит болон Хянан Шалгах Стандартын Зөвлөлийн

боловсруулсан Олон Улсын Аудитын Стандартыг дагаж мөрддөг.

АДБОУХ -н Олон Улсын Хөгжлийн Санаачлага байгууллага МҮАГ-ийн 2013 оноос 2018 оны стратеги төлөвлөлтийн боловсруулалтанд туслалцаа үзүүлсэн. Удаах нь байгууллагад сайн стратегийн чиглэл олгодог бөгөөд сүүлийн жилүүдэд МҮАГ-ийн үйл ажиллагааг хууль, эрх зүйн орчин, аудитын аргачлал, стандарт, УИХ-ын бусад оролцогч талуудтай хамтран ажиллах зэрэг систем, үйл явцын хувьд сайжруулах алхмуудыг авч хэрэгжүүлж байна. ТАТХ-ийн шинэчилсэн найруулгад Ерөнхий Аудиторын орлогчийн албан тушаалыг байхгүй болгосон учраас байгууллагын удирдлагыг Ерөнхий Аудитор дангаар гүйцэтгэж байна. Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно. Одоогийн Ерөнхий Аудиторыг 2012 онд томилсон бөгөөд өмнөх Ерөнхий Аудитор 2009 оноос 2012 оны хооронд албан үүргээ гүйцэтгэж өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн. Ерөнхий Аудиторыг чадвар, боловсролд суурилсан, өсрөлдөөнт механизмаар сонгон шалгаруулах хэрэгтэй гэсэн өмнөх удаагийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй харагдаж байна.

Төсвийн байнгын хорооноос томилсон бие даасан аудитын компани МҮАГ-т аудит хийдэг бөгөөд МҮАГ нь УИХ-ын байнгын хороонд өөрийн үйл ажиллагааг жил бүр тайлагнадаг. МҮАГ-ийн 2014 оны тайлангаар МҮАГ 248 гүйцэтгэлийн аудит, 4543 санхүүгийн тайлангийн аудит, 187 нийцлийн аудит хийсэн бөгөөд нийт 4978 аудит хийсэн ба аудитын тайлангууд нь МҮАГ-ийн веб хуудсанд олон нийтэд нээлттэй тавигдсан байна.

ТТХ-д тусгасан сахүүгийн тайлант жилийн дараа хийгдсэн санхүүгийн аудитаас гадна УИХ-ын Төсвийн байнгын хороо МҮАГ-ийн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын жил бүрийн төлөвлөгөөг гаргадаг. Мөн Төсвийн байнгын хороо МҮАГ-ийн аль тайланг УИХ-д танилцуулахыг шийддэг. Энэ нөхцөл нь МҮАГ-ийн бие даасан байдлын талаарх асуудал дахин тавигдахад хүргэж байна.

### **Дотоод аудит болон санхүүгийн хяналт шалгалт**

ТТХ -д Монгол улсын төрийн байгууллагуудад дотоод аудитын нэгж үүсгэх хуулийн орчинг бий болгосон. Энэхүү шинэ дотоод аудитын функ нь 2004 онд бий болж 2006 оноос хэрэгжиж байгаа Мониторинг ба Үнэлгээний нэгжтэй хавсарсан байдлаар ажиллах юм. Дотоод аудиторуудын олонхыг Мониторинг ба Үнэлгээний нэгжээс шилжүүлсэн бол зарим аудиторууд хоёр нэгжид зэрэг ажиллаж байна.

ТТХ хүчин төгөлдөр болоод хэдхэн жилийн дотор бүх яамд дотоод аудитын нэгжтэй болсон бөгөөд нийт 46 яамд болон агентлагууд дотоод аудитын нэгжтэй болсон байна. Үүнээс гадна, яамд бүрт дотоод аудитын хороог байгуулсан. Төрийн дотоод аудит нарт Сангийн Яам чиглэл, зааварчилгаагаар хангах хуулийн үүрэг хүлээсэн. Энэ үүргийг Яамны өөрийн дотоод аудитын хамт Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод Аудит, Мониторинг ба Үнэлгээний хэлтэс гүйцэтгэдэг. Сангийн яам Монгол улсын Олон Улсын Дотоодын Аудитын Холбоонд байгууллагын гишүүн байдлаар төлөөлдөг. Засгийн газраас 2012 онд Дотоод Аудитын Дүрэм, 2014 онд Дунд Хугацааны Стратегийг баталсан. Дотоод Аудитын Дүрэмд яамд болон агентлагуудын дотоод аудитын нэгжүүд нь холбогдох төсвийн захирагч, эвсэл Дотоод Аудитын Хороонд тайлагнана хэмээн заасан байна. Тиймээс дотоод аудитын нэгж нь бие даасан зарчимд тулгуурлах зорилготой юм. Засгийн газраас Дотоод Аудитын Тухай Хууль батлах гэж байгаа бөгөөд одоогийн байдлаар хуулийн төсөл бэлэн болсон.

Сангийн яамны дотоод аудиторууд бусад яамдын дотоод аудиторуудтай хамтран ажлын

байран дээрх сургалт зохион байгуулж байна.

Эдгээр аудитуудын талаас олонх нь урьдчилан тохирсон төлөвлөгөөний дагуу системийн аудитууд байсан бөгөөд төрийн байгууллагуудын эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явцын үр дүнг сайжруулах, шалгах зөвлөмжид үндэслэсэн.

Хэдийгээр Монгол улсын аудитын стандарт нь олон улсын стандарттай нийцэж байгаа ч төрийн олон шинэ байгууллагуудын дотоод аудитын нэгж болон аудиторуудад эдгээр аудитын стандарт болон зөвлөмжүүдийн ойлголт, хэрэглээний талаар нэгдсэн мэдээлэл өгөх хэрэгтэй. Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандартыг Монгол хэлрүү орчуулсан. Дээр дурдсан стандартуудтай нийцсэн төрийн байгууллагуудын дотоод аудитын зөвлөмжийг төрийн байгууллагуудын аудиторуудад тараасан. Эдгээр баримт бичигт үндэслэн хэд хэдэн дотоод аудитын сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Гэсэн хэдий ч төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн хөгжил нь Олон Улсын Стандартын зайлшгүй байх ёстой хэд хэдэн түвшинд хүрээгүй хэвээр байна. Богино хугацаанд ихээхэн амжилтанд хүрсэн боловч Монгол улсын төрийн байгууллагуудын дотоод аудитын хөгжил анхан шатандаа л байгаа бөгөөд энэ нэгжийг бүрэн хөгжүүлэхэд олон зүйл хийх шаардлагатай байна.

ТТХ-ийн гүйцэтгэлийг бүрэн дэмжиж ажиллахын тулд 2014 оны 10 сард Засгийн газрын Яамдууд журам гаргаж Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газарт байсан санхүүгийн хяналт, шалгалтын нэгжийг Сангийн Яаманд (8 албан тушаалтныг шилжүүлсэн), салбарын яамдуудад (37 албан тушаалтныг шилжүүлсэн) болон орон нутгийн төсвийн захирагч (117 албан тушаалтныг шилжүүлсэн) нарт шилжүүлсэн. Сангийн яаманд Санхүүгийн Хяналт Шалгалтын Хэлтэсийг Төсвийн Хяналт, Эрсдэлийн Удирдлагын Газрын харьяа хэлтэсээр байгуулж Дотоод Аудит, Хяналт Шинжилгээ, Үнэлгээний хэлтэстэй зэрэгцээ үйл ажиллагаа явуулах байдлаар зохион байгуулсан. Харин салбаруудын яамд болон орон нутгийн төсвийн захирагчдад санхүүгийн хяналт, шалгалтын нэгжийг урьд нь байсан дотоод аудит болон Мониторинг ба Үнэлгээний нэгжийн оронд байгуулсан. Дотоод аудит болон Мониторинг ба Үнэлгээний нэгжийн албан тушаалтнуудын тоо хангалттай бус байсан учраас эдгээр нэгжүүдэд ажиллаж байсан албан тушаалтнууд санхүүгийн хяналт, шалгалтын нэгжийн үүргийг давхар гүйцэтгэж байсан нь энэ шинэчлэлийн зорилго, аргачлал, хүлээгдэж буй үр дүнгийн талаар эргэлзээ төрүүлж эхэлсэн. Цаашилбал, ТТХ-ийн 69.4-р зүйлд "Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна" гэж заасан нь дотоод аудитын болон санхүүгийн хяналт, шалгалтын үүрэг, хариуцлагын хоорондын ялгааг бүрхэгдүүлсэн байна. Тиймээс өөр өөр түвшний засгийн газрын нэгжүүдэд чанартай аудитын болон зөвлөх үйлчилгээг тогтмол хүргэхийн тулд эдгээр нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо, нийцлийг сайжруулах хэрэгтэй

**Дүгнэлт.** Төрийн санхүүжилтын хяналт болон аудитыг сайжруулах зорилгоор Монголд хийсэн томоохон шинэчлэлүүдийг авч үзвэл Монгол улс Зөвлөмж 3.4 –г **ихэнхийг дагаж мөрдсөн** байна.

#### ***Шинэ зөвлөмж 3.4.***

- 1) Төрийн хэвшлийн дотоод хяналт, санхүүгийн удирдлага болон аудитын үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд засгийн газрын уялдаа холбоо болон зохицолыг нэмэгдүүлэх.***
- 2) Төрийн хэвшлийн дотоод хяналт болон санхүүгийн шинжилгээний функцийг зааг ялгааг тодорхой гаргаж, давхардуулахаас зайлсхийх. Төвийн болон орон нутгийн төрийн байгууллагуудын дотоод аудитын нэгжийн бие даасан байдлыг хадгалах.***



- 3) *Дотоод Аудитын Тухай Хуулийг олон улсын стандартын дагуу баталж, хэрэгжүүлэх.*
- 4) *Монголын Үндэсний Аудитын Газрын институцийн болон үйл ажиллагааны бие даасан байдлыг олон улсын стандартын дагуу сайжруулах, ялангуяа төсөв болон ажилчдын хөдөлмөрийн хөлстэй холбоотой асуудлын бие даасан байдлыг сайжруулах.*

### 3.5. Төрийн худалдан авалт

#### Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.5.

- 1) Хуульд орхигдуулсан, зөрүүтэй болон өөр хоорондоо нийцэхгүй байгаа заалтуудыг хянан үзэх, хэтэрсэн чөлөөлөлтүүдийг хумих, албан тушаалаа урвуулан ашиглах эсхүл авлигын боломжуудыг хаах (худалдан авалтыг багцлан хуваах, гэрээний нөхцөлд тохируулга хийх, хамааралтай этгээдийн журам гэх мэт), худалдан авалт хийж байгаа агентлагуудад худалдан авалтын журам, хэрэгслүүдийн талаар өгөх материалыг баяжуулах.
- 2) Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах шалгуурыг боловсронгуй болгох, үнэлгээний субъектив заалтуудыг хасах, өөрчлөлт оруулах.
- 3) Төрийн худалдан авалтын ил тод байдлыг хангахын тулд худалдан авалттай холбоо бүхий бүх мэдээллийг хэвлэн нийтлэх: үүнд худалдан авалтын үр дүн болон гэрээг оруулах. Худалдан авалтын мэдээлэл болон цахим худалдан авалтын мэдээлэл бүхий Засгийн газрын нэг оролттой /single entry/ вэб-порталыг бий болгох. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн механизмаар дамжуулан үзүүлж байгаа хөнгөлөлтүүд болон улсын хөрөнгийг хэрхэн ашиглахтай холбогдсон мэдээллийг хэвлэн нийтлэх.
- 4) Холбогдох байгууллагуудын хараат бус байдал, тэдний үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мөн үйл ажиллагааны шударга зарчмыг баталгаажуулах замаар хяналтын механизмыг бэхжүүлэх
- 5) Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судлах, хязгаарлалтын тогтолцоог олон улсын сайн туршлага, стандартад нийцүүлэн боловсруулах.
- 6) Цахим худалдан авалтыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн хөгжүүлэх.

1) Хуульд орхигдуулсан, зөрүүтэй болон өөр хоорондоо нийцэхгүй байгаа заалтуудыг хянан үзэх, хэтэрсэн чөлөөлөлтүүдийг хумих, албан тушаалаа урвуулан ашиглах эсхүл авлигын боломжуудыг хаах (худалдан авалтыг багцлан хуваах, гэрээний нөхцөлд тохируулга хийх, хамааралтай этгээдийн журам гэх мэт), худалдан авалт хийж байгаа агентлагуудад худалдан авалтын журам, хэрэгслүүдийн талаар өгөх материалыг баяжуулах.

Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хууль (ХАТХ) – ийн шинэчилсэн найруулгыг 2011 онд баталж 2013 оны 1 сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Энэ хуульд зааснаар худалдан авалтын мэргэжлийн байгууллага болон Засгийн газрын Худалдан авах ажиллагааны газар (ХААГ) –н үйл ажиллагааг 2012 оны 10 сард эхлүүлсэн. Хуульд зааснаар ХААГ нь худалдан авалтын үйл ажиллагааг хариуцах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байх юм. Тиймээс ХААГ нь

томоохон төслийн (жишээлбэл бүх хоорондын зам, цахилгаан станц) бүх худалдан авалтыг хариуцах, яамдын худалдан авч буй тогтмол хэрэглэдэг зүйлсийн (жишээлбэл ажлын байрны хангамж) худалдан авалтын гэрээ байгуулах ажлыг хариуцан хийдэг. Орон нутгийн засаг захиргаа нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ мөн нэгдсэн төсвөөс санхүүжилттэй орон нутгийн төслүүдийн (сургууль, эмнэлэг г.м) худалдан авалтыг хариуцдаг.<sup>29</sup>

Сангийн яам Засгийн газрын худалдан авалтын бодлого, аргачлал, хяналт болон Хуульд заасан эрх бүхий байгууллагын гүйцэтгэлийг хангадаг.

Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хуулийн шинэчилсэн найруулга болон хуулийн хэрэглээг харахад Монгол улсад төрийн худалдан авалтын ил тод байдлаар хоёр жилд томоохон амжилтанд хүрсэн байна. Интернет худалдан авалтын хэрэглээг нэмэгдүүлсэн нь оролцооны түвшинг сайжруулж, ерөнхий ил тод байдал болон систем дэх мэдээллийн нээлттэй байдлыг дэмжсэн.

Түүнчлэн хуульд заасан чөлөөлөлт (ялангуяа Монгол улсын Хөгжлийн Банкны (ХБ)-ны санхүүжилттэй худалдан авалтын гэрээнүүд) болон нийт худалдан авалтын хэмжээг харвал төрийн худалдан авалтын багагүй хувь нь хуулийн хэрэгжилтээс гадуур хийгдэж байна. Жишээлбэл, ХБ-ний 2015 онд хэрэгжүүлсэн хоёр төслийн боломжит худалдан авалтын хэмжээ 124.5 тэрбум төгрөг байсан бол Монгол улсын нийт худалдан авалт 2014 онд 1,046.7 тэрбум төгрөг байсан байна.

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулж чөлөөлөлтийг арилгах эсхүл хамгийн бага түвшинд аваачих хэрэгтэй. Эсхүл (хэдийгээр энэ сонголт нь таатай биш боловч) нэмэлт хууль баталж Хуулийн чөлөөлөлтөд ордог худалдан авалтыг аль болох нээлттэй тендер эсхүл бусад өрсөлдөөнд үйл явцаар шалгаруулдаг болох хэрэгтэй. Ингэснээр худалдан авалтын үйл явц эдийн засгийн хувьд өгөөжтэй, үр дүнтэй, ил тод болох бөгөөд авлига үүсэх нөхцөлийг бууруулна. Мөн төрийн болон хувийн түншлэлийн гэрээнд онцгой анхаарал хандуулж, шударга, өрсөлдөөнт байдлаар хэрэгжиж байгааг нягтлах хэрэгтэй. Тусгайлсан хуулиар зохицуулалт хийх нь үр дүнтэй байж болно.

ХААГ-ийн өгсөн мэдээллээр 2013 оноос 2015 оны хоорондох төрийн худалдан авалтыг (зөвлөх үйлчилгээг хүртэл) нээлттэй тендерийн үйл ажиллагаагаар шалгаруулсан. Түүнчлэн 2014 онд 1,935 гэрээг нээлттэй тендерээр олгосон бол 1,560-г харьцуулалтын аргаар, 581-г шууд гэрээлэх арга, үлдсэн 15-г хязгаарлагдмал тендерээр олгосон байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд тендерийн тоо, гэрээ хэлэлцээрийн тоо мөн нийт тендерийн хэмжээ буурч байна. 2013 онд 1,663.7 тэрбум төгрөгийн тендер зарлагдсан бол 2014 онд 37 хувиар буурч 1,046.3 тэрбум төгрөг болсон байна. Гэсэн хэдий ч тендерийн оролцооны түвшин өндөр байна. 2014 онд ХААГ нийт 475 тендерийг улсын хэмжээнд зарласан бөгөөд үүнд нийт 1,644 аж ахуйн нэгж, байгууллага оролцсон байна.

Гэсэн хэдий ч Хуульд заасан өрсөлдөөнт худалдан авалтын үйл ажиллагааны жагсаалтыг

---

<sup>29</sup> 2015 оны 4 сард Дэлхийн Банкнаас гаргасан Монгол улсын Төрийн байгууллагын зарлага, санхүүгийн шударга байдлын талаарх тайланг дараах холбоосын 17-р хуудаснаас авна уу: <https://openknowledge.worldbank.org/handle/10986/22093>.

өргөтгөх шаардлагатай бөгөөд эдийн засгийн хөгжлийг дэмжиж, тендерт оролцох зардлыг хамгийн бага түвшинд байлгаснаар өрсөлдөөнийг дэмжих худалдан авалтын илүү үр дүнтэй зохицуулалт хийх хэрэгтэй байна. Энэ шинэчлэл нь Монгол улсын интернет худалдан авалтын систем хурдацтай хөгжиж байгаа тохиолдолд маш чухал юм. Одоогийн үйлчилж буй хуульд худалдан авалтын зарим аргачлалын талаар зохих мэдээллийг тусгаагүй байна. 2011 оны НҮБ-ын Олон Улсын Худалдаа Эрх Зүйн Комиссийн Загвар Хуулийг холбогдох зохицуулалтыг шинэчлэхэд суурь болгон ашиглаж болох юм. Хуульд тусгасан зарим зохицуулалтууд нь олон улсын сайн туршлагад нийцэхгүй байгаа учраас эргэж харах хэрэгтэй байна.

Хуулийн үг хэллэгт зөрчилдөөнтэй, хоорондоо нийцэхгүй заалтуудыг сайжруулах (зарим нэг нь Англи хэлэнд буруу орчуулагдсанаас үүссэн байх магадлалтай).

Хуулийн 8.6-р зүйлд худалдан авалтыг газрууд бүтээгдэхүүн, үйлчилгээг хэсэгчилж болох талаар заалт оруулсан нь үр дүнг бууруулсан, явц дунд хуурах, мэхлэх байдал гарч болзошгүй учраас ийм эрсдэлийг бууруулахын тулд зохицуулалтыг шинэчлэх хэрэгтэй.

Тендер шалгаруулалтанд дотоодын бараа, бүтээгдэхүүнийг илүүд үзэх хандлага нь тендерийн үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд энэ зохицуулалтыг чангатгах хэрэгтэй. Дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэж байгаа эсэхэд гүйцэтгэлийн явцад баталгаажуулалт хийдэггүй. Мөн худалдан авалтын тендерт гадны байгууллага орох нь маш бага байдаг. Сүүлийн 3 жилийн хугацаанд ердөө л 6 гадны компани тендерт оролцож 30,000 төгрөгийн үнэ бүхий ажлын гэрээ байгуулсан байна.

Хуулийн 47.3 –т холбоотой этгээдийн хязгаарлалтуудыг оруулсан байна. Тендерийн үр дүнд сөрөг өөрчлөлт оруулахгүй тулд энэ хязгаарлалтыг өргөтгөж, тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдэд худалдааны давуу тал бий болгох хэрэгтэй.

## ***2) Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах шалгуурыг боловсронгуй болгох, үнэлгээний субъектив заалтуудыг хасах, өөрчлөлт оруулах.***

Хуульд 2011 онд нэмэлт өөрчлөлт оруулж “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” хэмээн заасан. 2014 оноос ХААГ үнэлгээний хорооны гишүүнээр төрийн бус байгууллагын төлөөлөгчөөс сонгож байгаа бөгөөд төрийн бус байгууллагын төлөөлөгч мөн олон нийтийн хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Хороонд байгаа ТББ-ийн төлөөлөгчид ХААГ – тай сонирхлын зөрчлөөс ангид байх гэрээ байгуулдаг.

Үнэлгээний хорооны гишүүдийг дурын байдлаар сонгох замаар бүрдүүлдэг. Ингэснээр тендерт үнийн санал өгсөн аж ахуйн нэгжүүдийн үнэлгээнд хувийн нөлөө оруулах байдлыг хязгаарладаг. ТББ-ын гишүүдийг дурын байдлаар сонгохоос өмнө ХААГ болзошгүй эрсдэлийг үнэлэхийн тулд ТББ-ын гишүүдийн давхар ажил эрхлэлтэд судалгаа явуулдаг. Зарим тохиолдолд ТББ-ийн гишүүн, эсхүл тэргүүн нь тендерт оролцогч компанийн ажилтан байдаг учраас сонирхлын зөрчил үүсдэг. Ийнхүү сонирхлын зөрчил үүсэх тохиолдолд ТББ-

ын гишүүнийг хорооны гишүүнээр элсүүлдэггүй. Ажлын байранд хийсэн уулзалтын явцад сонирхлын зөрчлөөс үүдэн хорооны гишүүнээс түтгэлзүүлсэн тохиолдолд байхгүй гэж мэдэгдэж байсан.

Хууль болон “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам” (Сангийн яамны 2014 оны 9 сарын 30-ны 212 тоот тушаалаар баталсан) –д худалдан авалтын үнэлгээний хороо ил тод, өрсөлдөгчдөд тэгш боломж олгох, үр дүнтэй, бүтээмжтэй, хариуцлагатай байх зарчмуудыг баримтална гэж заажээ.

Үнэлгээний хорооны гишүүн нь худалдан авалтын чадварын гэрчилгээ (А3) – тэй байх бөгөөд сонирхлын зөрчлөөс ангид байх зорилгоор ажлын байрны талаар мэдээллээ хүргүүлдэг. 2014 онд ХААГ нийт 2,699 хүнд худалдан авалтын чадварын гэрчилгээ олгож, нэрсийн жагсаалтыг веб хуудсандаа байршуулсан байна.

Мөн үнэлгээний хорооны гишүүдийг сонгохдоо мэргэжлийн шалгуур тавьдаггүй учраас тендерийн баримт бичгийн зохисгүй материал, техник үзүүлэлт шаардах, тендерийн үнэлгээг мэргэжлийн бус түвшинд гүйцэтгэх нөхцөл бий болж болзошгүй. Харин бодит байдалд хорооны гишүүдийг сонгохын тулд худалдан авалтын мэдлэгээр мэргэжлийн шалгуур тавьдаг талаар дурдсан. Хуульд энэ зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй.

Хуульд үнэлгээтэй холбоотой зарим заалтууд хувийн шинж чанартай байгаа учраас авлигын үндэс болох магадлалтай.

Тендерийн баримттай холбоотой нэмэлт тодруулга авах, тендер зарлах талаар хуульд тусгасан заалтууд нь цаг хугацааны хязгаарлалтаас үүдэж үр дүнд өөрчлөлт оруулах боломжийг бий болгож байна. Мөн хязгаарлагдмал тендер болон зөвлөх сонгон шалгаруулах хугацаа нь бодит байдалд хангалттай биш байгаа учраас тендерийн үр дүнд өөрчлөлт оруулах магадлалтай. Бусад улсын туршлагыг харахад тендерт бэлтгэх богино хугацаа өгөх нь нийтлэг жишиг болсон байна.

Худалдан авалтын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд болгохын тулд шинэ ажлууд хийх хэрэгтэй байна. Мөн худалдан авалтанд оролцох хүний нөөцийг чадавхжуулах хэрэгтэй.

***3) Төрийн худалдан авалтын ил тод байдлыг хангахын тулд худалдан авалттай холбоо бүхий бүх мэдээллийг хэвлэн нийтлэх: үүнд худалдан авалтын үр дүн болон гэрээг оруулах. Худалдан авалтын мэдээлэл болон цахим худалдан авалтын мэдээлэл бүхий Засгийн газрын нэг оролттой /single entry/ вэб-порталыг бий болгох. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн механизмаар дамжуулан үзүүлж байгаа хөнгөлөлтүүд болон улсын хөрөнгийг хэрхэн ашиглахтай холбогдсон мэдээллийг хэвлэн нийтлэх.***

Засгийн газрын худалдан авах ажиллагааны газар 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод болгох” зорилтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд онлайн худалдан авалтын системийг шат шатаар сайжруулах замаар Газрын үйл ажиллагааг бэхжүүлж байна.

ХААГ болон орон нутгийн худалдан авалтын агентлагууд улирал болон жилийн худалдан авалтын төлөвлөгөө, зардлын тооцоолол, тендерийн баримт бичгүүд болон тендерийн сонгон шалгаруулалтын талаар өөрийн веб хуудас ([www.e-tender.mn](http://www.e-tender.mn)), худалдан авалтын электрон систем ([www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn)), Засгийн газрын худалдан авалтын веб хуудсанд ([www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)) байршуулж олон нийтэд мэдээлдэг. ХААГ-ийн Захирлын 2014 оны 4 сарын 21-ний өдрийн тушаалаар тендерт оролцогч компаниудын мэдээллийг мөн оруулдаг болсон. 2014 онд ХААГ тендерийн сонгон шалгаруулалтын бүх үйл явц, тендерт шалгарсан компанийн талаарх мэдээллийг интернет худалдан авалтын систем болох [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn) –д байршуулсан. ХААГ-ийн тендерийн төсвийг мөн системд оруулсан байна. Тендер болон зөвлөх үйлчилгээний мэдэгдлүүдийг “Өдрийн сонин”, “Зууны мэдээ сонин”, “UB Post” болон [www.e-tender.mn](http://www.e-tender.mn), [www.e-procurement.mof.gov.mn](http://www.e-procurement.mof.gov.mn) сайтуудад тогтмол нийтэлдэг.

Шилэн дансны хуульд зааснаар газруудын худалдан авалт болон санхүүжилттэй холбоотой мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайт болох <http://shilendans.gov.mn>, мөн [www.e-tender.mn](http://www.e-tender.mn), [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn), [www.e-procurement.mof.gov.mn](http://www.e-procurement.mof.gov.mn) сайтуудад байршуулдаг.

Дээрх арга хэмжээнүүд нь сайшаалтай бөгөөд интернет худалдан авалтын системийг цаашид ч дэмжин, хөгжүүлэх хэрэгтэй.

Засгийн газрын худалдах авах газрын захирлын 2014 оны 4 сарын 21-ний өдрийн No.В/69 тоот “Тендерийн үр дүнг мэдэгдэх журам”-ийн дагуу тендерийн үр дүнг олон нийтэд зарладаг. Харин тендерийн ямар ч хугацаанд тендерийн санал өгөгчдийн санхүүгийн чадамж, компанийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг хориглосон байна.

Тиймээс, Хуульд интернет худалдан авалтын зохицуулалтын оруулж, хурдацтай ашиглагдаж байгаа ч илүү өргөн хүрээний арга хэмжээ нэвтрүүлж, тендерийн үр дүн болон тендерт оролцогчдын үндсэн мэдээллийг цаг тухайд нь, бүрэн тайлагнаж байх хэрэгтэй.

***4) Холбогдох байгууллагуудын хараат бус байдал, тэдний үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мөн үйл ажиллагааны шударга зарчмыг баталгаажуулах замаар хяналтын механизмыг бэхжүүлэх***

Энэ талаар авсан арга хэмжээний талаар мэдээлэл байхгүй байна.

Хуулийн 7-р зүйлд гомдолын үе шатуудад холбогдох зохицуулалтын талаар дурдсан байна. Ерөнхийдөө гомдлын үйл явц нь худалдан авалтын аль хэсэг гэдгээс хамаардаг. Тендерийн материал өгөх хугацаа дуусахаас өмнө гаргасан гомдлыг ХААГ (гомдол хариуцсан орон тооны ажилчид), материал өгөх хугацаа дууссан боловч гэрээг шалгаруулахаас өмнө хүлээн авсан гомдлыг Сангийн яам (гомдол хариуцсан 12 орон тооны ажилчид), харин гэрээ зурагдсаны дараа хүлээн авсан гомдлыг шүүхээр шийдвэрлүүлнэ. Худалдан авалтын гэрээ хийгдэхээс өмнө ямар ч үе шатанд гомдлыг анхан шатны байгууллагад гаргана.

2014 онд Сангийн яам 560 гомдлын шалгасан бөгөөд 224 –г хүлээн авч, шийдвэрлэсэн.

Хуульд зааснаар Сангийн яам Худалдан авалтын хянан шалгагч нартай байна. Засгийн газраас 2015 оны 9 сард Худалдан авах ажиллагааг шалгах журмын дагуу (2015 оны 8 сард Засгийн газраас баталсан) албан тушаалтнуудаа томилж, хянан шалгах эрх мэдэл олгосон гэж мэдэгдсэн. Одоогийн байдлаар Сангийн яаманд худалдан авалтын 10 хянан шалгагч ажиллаж байгаа бөгөөд Яамны нарийн бичгийн дарга нь Ерөнхий хянан шалгагчаар томилогддог.

Худалдан авалттай холбоотой бүхий л шийдвэрүүдийн талаар захиргааны байгууллага болон шүүхэд хүсэлт, гомдол гаргаж болно. Үүнд худалдан авалтын арга хэрэгсэл орох бөгөөд Сангийн яам болох ХААГ шалгах эрхтэй. Зөвхөн үнийн санал өгсөн албан байгууллагууд л хүсэлт, гомдол гаргах эрхтэй. АТГ Авлигын эсрэг хууль зөрчигдсэн тохиолдолд худалдан авалттай холбоотойгоор шүүхэд хандах эрхгүй.

Тендерийн явц Хууль зөрчсөн тохиолдолд Хуульд шийдвэр гаргахад оролцсон төрийн албан хаагчдыг албан тушаалаас халах мөн / эсхүл санхүүжилтын гэрээг цуцлах зэрэг тодорхой ял, шийтгэлийн зохицуулалт оруулсан байна.

ХААГ ирж буй гомдлын тоо нэмэгдэж байгаа талаар мэдэгдсэн нь магадгүй системд итгэх итгэл нэмэгдэж байгаатай холбоотой байх. Сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 187 гомдол хүлээн авсан бөгөөд үүнээс 156 гомдлыг Сангийн яаманд хүргүүлж, 17 гомдлыг Шударга Өрсөлдөөн, Хэрэглэгчдийн Төлөөх Газарт, 10 гомдлыг шүүхээр, 4 гомдлыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.

Үүнээс гадна жилд хоёр удаа тендерийн үйл ажиллагааны шалгалт хийж, зөвлөмж гаргах байдлаар дотоод аудитын үйл ажиллагааны шударга байдлыг хангах арга хэмжээ авсан. Аудитыг ХААГ-ийн Хууль, Хяналтын хэлтэсийг хариуцдаг албан тушаалтнууд явуулсан.

Хуульд зааснаар олон тохиолдолд Шүүх байгууллага төсөвтэй холбоотой асуудал эрхэлсэн төрийн төв удирдах байгууллагын шийдвэрийг тендерийн үйл ажиллагаатай гомдолтой холбоотойгоор цуцлах эрх байдаггүй нь хөндөх ёстой нэг асуудал болж байна.

#### **Хүснэгт 17. Худалдан авалттай холбоотой гомдол шийдвэрлэсэн тоон мэдээлэл**

	2013	2014	2015 оны 6 сар	Нийт
Гомдлын тоо	56	81	50	187
<b>Гомдол хүргүүлсэн:</b>				
Шүүх	5	4	1	10
Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар	2	10	5	17
Сангийн яам	47	65	44	156
АТГ	2	2	0	4
<b>Гомдол шийдвэрлэсэн:</b>				0
Худалдан авагч байгууллагын шийдвэрийг	29	45	30	104

ЗӨВТГӨСӨН				
Тендерийг дахин явуулсан	20	27	16	63
Тендерийг цуцалсан	3	1	-	4
Мэдээлэл хангалтгүй	2	-	-	2
Шалгагдаж байгаа	2	-	-	2
Техникийн үзүүлэлтийг өөрчлөх шийдвэр гарсан	-	3	3	6
Бусад	2	-	-	2

**5) Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судлах, хязгаарлалтын тогтолцоог олон улсын сайн туршлага, стандартад нийцүүлэн боловсруулах.**

2014 оны үнэлгээнээс хойш ямар нэг арга хэмжээ аваагүй байна.

Хязгаарлалтын тогтолцоог сайжруулж худалдан авалтын ажиллагаанаас тендерт оролцогчдыг хасах бодитой үндэслэлтэй байх хэрэгтэй. Хасагдсан компаниудын мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулах хэрэгтэй. Хязгаарлалтын систем нь авлигатай холбоотой эрүүгийн ял шийтгэл болон бусад зөрчилтэй уялдаатай байх хэрэгтэй.

Зохицуулалтыг зөрчсөнөөр Хуульд заасан тавигдах торгуулийн хэмжээ нь улсын эдийн засагт ялангуяа худалдан авагч байгууллагуудад учруулж буй хор хөнөөлтэй харьцуулахад маш бага байна. Тиймээс торгуулийн хэмжээг эргэж харах хэрэгтэй.

**6) Цахим худалдан авалтыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн хөгжүүлэх**

Өмнө дурдсанаар ХААГ төрийн худалдах авах ажиллагааг электронжуулж, худалдан авалтыг олон нийтийн хяналттайгаар ил тод явуулах байдлаар 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан алхмуудыг хэрэгжүүлж байна.

Худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт, шинжилгээ, мэдээллийн системийг (<http://pmmis.e-procurement.mof.gov.mn>) 2011 оноос эхлүүлсэн. Энэхүү төслийг e-Bidding, e-Shopping Mall, e-Catalogue зэрэг дэд систем нэвтрүүлэхийн тулд Samsung SDS компаниудын ([www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn)) тусламжтайгаар хэрэгжүүлсэн. 2013 оны 1 сард Сангийн яам интернет тендер явуулах хүсэлтийг хүлээн авсан.

2014 онд ХААГ-ийн зохион байгуулсан тендерийн хамгийн багадаа 80 хувийг, орон нутгийн эрх бүхий байгууллагуудын зохион байгуулсан тендерийн хамгийн багадаа 10 хувийг электрон системд шилжүүлэхээр төлөвлөсөн. ХААГ бүх тендерийг электрон системээр явуулсан. 2014 онд нийслэл, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд болон Хан-Уул дүүрэг нийт тендерийн 37 хувийг электрон системээр явуулсан.


Улс даяар 2014 онд нийт 475 тендер явуулж, 1,644 аж ахуйн нэгж, байгууллагууд оролцсон. Эдгээр тендерүүдээс ХААГ 132 төсөлд 199 тендерийг зохион байгуулж, 957 аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулсан. Тендерийн сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn) веб хуудасны “Тендерийн урилга” зэснээс авах боломжтой.



Албаны хүмүүсийн мэдэгдсэнээр электрон худалдан авалтын систем нэвтрүүлсэн нь тодорхой үр дүнд хүрсэн: нээлттэй, үр дүнтэй, шударга байдлыг нэмэгдүүлж, тендерийн сонгон шалгаруулах явц ил тод болж, зардалыг бууруулж, төсвийн үр дүнгүй байдлыг багасгаж, худалдан авалтын хяналтыг сайжруулж, тендер шалгаруулалтын явцад шаардлагатай мэдээллийг хурдан солилцож, иргэдэд хүнд сурталгүй үйлчлэх боломжийг бий болгосон.

Электрон худалдан авалтын шинэчлэлийн хүрээнд Засгийн газар “электрон худалдан авалт – 2” төслийг 1.5 тэрбум төгрөгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. “электрон худалдан авалт – 2” төсөл нь дараах модулуудыг дэмжсэн худалдан авалтын нэгдсэн систем юм: Худалдан авалтын төлөвлөлт болон тайлагнал; e-Bid; e-Store; e-Category System; e-Contract, e-худалдан авалтын систем, e-тайлагналын систем, Портал, мэдээлэл солилцооны дэд систем, ухаалаг утасны аппликейшин. “электрон худалдан авалт – 2” системийн явц сайн байгаа бөгөөд одоогийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### Дүрслэл 5. Худалдан авалтын электрон системийн ашиглалт



Эх сурвалж: Монгол улсын эрх бүхий байгууллагын мэдээлэл

Интернет худалдан авалтын системийн хөгжүүлэлт нь маш сайшаалтай зүйл болсон. Төрийн бүх худалдан авалтыг интернет системээр шалгаруулах нь ил тод байдлыг ихээхэн нэмэгдүүлж, авлигын эрсдэлийг бууруулна. Цаашдын системийн хөгжүүлэлт нь Нээлттэй Тоон мэдээ / Нээлттэй гэрээ хэлэлцээрийн зарчмыг, олон улсын сайн туршлагын хамт мэдээллийн нээлттэй байдалд төвлөрөх хэрэгтэй.

## Дүгнэлт

Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хуулийн шинэчилсэн найруулгыг 2011 онд баталсан нь төрийн худалдан авалтын эрх зүйн зохицуулалтыг ихээхэн сайжруулсан бөгөөд авлига үүсэх боломжийг хязгаарлахын тулд нэмэлт өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй. Төрийн бүх худалдан авалтыг ХАТТ-аар зохицуулах, эсхүл худалдан авалтын сонгон шалгаруулалтыг өрсөлдөөнтэй болгохуйц тусгай зохицуулалт хийх хэрэгтэй. Үүнд Монгол улсын Хөгжлийн Банкны санхүүжилттэй худалдан авалт болон төсвийн санхүүжилттэй бусад худалдан авалтууд орно.

Ярилцагчдын хэлж байснаар Монгол улсад төрийн худалдан авалтанд авлига нийтлэг байдаг, ялангуяа томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүдэд авлига байдаг гэж байсан юм. Энэ асуудал нь төр болон хувийн түншлэл, мөн концессын гэрээнд ч байдаг.

ХААГ байгуулсан нь эерэг алхам боловч энэ Газрын гүйцэтгэх худалдан авалтын цар хүрээ аажмаар багассаар байна. Учир нь худалдан авалтуудыг илүү хяналт сул, дагавар ашиг сонирхол үүсч болох яамдуудад илүү хийгдэж байгаа учраас ХААГ-ийн эрх мэдлийг нэмэгдүүлж, хүний нөөцийг чадавхжуулах хэрэгтэй байна.

Интернэт худалдан авалтын систем нэвтрүүлсэн нь сайшаалтай дэвшил бөгөөд цаашид бүх шатанд нэвтрүүлж бүрэн электрон, ил тод систем болох хэрэгтэй. Түүнчлэн интернет худалдан авалтын системийг хялбарчил нэг цэгээс төрийн худалдан авалтын холбогдох бүх үйлчилгээг авах боломжтой болгох хэрэгтэй.

Худалдан авалтын үйл ажиллагаанд иргэний нийгмийн мэргэжилтнүүдийг оролцуулсан нь сайшаалтай бөгөөд цаашид ч хөгжүүлэх хэрэгтэй. Мөн худалдан авалтын хорооны гишүүдийн сонирхлын зөрчилтэй холбогдох заалтуудад ч эдгээр мэргэжилтнүүдийн оролцоо чухал бөгөөд хууль, журмыг зохих байдлаар мөрдүүлж, хяналт хийх хэрэгтэй. АТГ энэ чиглэлээр илүү эрх мэдэлтэй байх хэрэгтэй бөгөөд ялангуяа худалдан авалтын үйл ажиллагаанд сонирхлын зөрчил үүссэн эсхүл бусад авлигын эсрэг хууль, тогтоомж зөрчигдсөн тохиолдолд шүүхэд хандах эрхтэй байх хэрэгтэй.

Хяналтын механизмыг ерөнхийд нь чангатгах хэрэгтэй бөгөөд ялангуяа гомдлыг хүлээн авч шалгадаг нэгжүүдийн тоог хамгийн багад байлгах хэрэгтэй. Гомдол гаргах механизм нь Засгийн газраас бие даасан байх хэрэгтэй бөгөөд ил тод байдлыг дээд зэргээр хангах хэрэгтэй. Хяналт болон Аудитыг дараагийн шатанд гаргах хэрэгтэй. Ялангуяа Сангийн яамны худалдан авалтын шинжээчид мөрдөн шинжлэх зохих эрх мэдэлтэй байх хэрэгтэй. Гомдлын үйл явцыг интернетэд байршуулж, интернет худалдан авалтын цогц системийн нэг хэсэг болгох хэрэгтэй.

Худалдан авалтын системийг цаашдын хөгжүүлэлтийг Хуулийн хэрэглээ, хэрэгжилтэнд төвлөрүүлж, худалдан авалтын мэргэжилтний чадамжийг дээшлүүлж, олон улсын сайн туршлагад нийцсэн худалдан авалтыг туршлагыг нэвтрүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Монгол улс Зөвлөмж 3.5-г хэсэгчлэн биелүүлсэн байна.

### *Шинэ зөвлөмж 3.5.*

*1) Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах Тухай Хуульд дараах шинэчлэлийг хийх хэрэгтэй:*

- Монгол улсын Хөгжлийн Банкны санхүүжилттэй худалдан авалтын гэрээнүүдийг болон авто замын салбарыг оруулах.*
- Худалдан авалтын нээлттэй, өрсөлдөөнт байдлыг бууруулж болзошгүй учраас ажил, бүтээгдэхүүн, үйлчилгээг шаардлагагүй нөхцөлд хуваахыг хориглох*
- Дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээг илүүд үзэх байдлыг багасгах*
- Олон улсын сайн туршлагын дагуу хуульд цагийн хязгаарлалтыг хялбарчлах*
- Үнэлгээний хорооны гишүүдийн мэргэжлийн чадамжийг чадавхжуулах*
- Хамааралтай этгээдийн дүрмийг өргөтгөх*

*1) Төрийн болон хувийн түншлэлийг эргэж харах, концесс шалгаруулалтын үйл явцыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох*

*2) Интернет худалдан авалтын системийг өргөтгөж бүх шатны худалдан авалтыг хамруулах. Худалдан авалтын нэгдсэн хуудас нээж, интернет худалдан авалт болон худалдан авалтын талаарх мэдээллийг ил тод байлгах*

*3) Худалдан авалтын гэрээтэй холбоотой үндсэн мэдээллийг хэвлэн нийтлэх*

*4) Шалгалтын механизмыг сайжруулж, холбогдох нэгжүүдийн бие даасан байдлыг зохих хэмжээгээр хангах, үйл ажиллагаанд нь ил тод байдлыг нэвтрүүлж, үйл явцын шударга байдлыг баталгаажуулах.*

*5) Торгуулийн хэмжээг эргэн харж урьдчилан сэргийлэх системийг болон улсын сайн туршлагын дагуу хөгжүүлэх*

### 3.6 Мэдээллийн хүртээмж

#### Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.6.

- 1) *Улсын төсвөөс санхүүждэг төрийн хуулийн байгууллага, аж ахуйн нэгжүүд эсхүл төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагууд ил тод байдал болон мэдээлэл хүртээмжтэй байх шаардлагад хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх.*
- 2) *Ямар ч ангиллын мэдээлэл бүрэн хэмжээгээрээ нээлттэй байх шаардлагаас чөлөөлөгдөхгүй байх нөхцөлөөр хангах; улсын нууцтай холбоотой болон бусад мэдээллийн хүртээмжтэй байхад тавьж байгаа хязгаарлалт нь зөвхөн хуульд суурилсан байх, шаардлага, боломж хоорондоо нийцтэй байх ба учруулж болох хохирол болон учирч болох хохирол болон нийгмийн ашиг сонирхлыг үүссэн нөхцөл тус бүрээр олон улсын сайн туршилагад тулгуурлан авч үзэх. Хуульд, ялангуяа авлига болон улсын мөнгө, хөрөнгөтэй холбогдсон хууль зөрчсөн үйлдлүүдийн талаарх аливаа мэдээллийг нээлттэй байлгахад ямар нэг хязгаарлалт тавихгүй байх заалтыг оруулах.*
- 3) *Мэдээлэл авах хүсэлттэй холбогдсон журмаас шаардлагагүй зүйлүүдийг нь хасаж, журмыг аль болох хялбар, тодорхой болгох*
- 4) *Төрийн албан хаагчдын зүгээс мэдээлэл авах эрхийн тухай заалтыг зөрчсөн тохиолдолд оноох захиргааны шийтгэлийг чангатгах*
- 5) *Мэдээлэл авах эрхийг мөрдөн хэрэгжүүлэхэд хяналт тавих зохих санхүүгийн эх үүсвэртэй, эрх мэдэлтэй бие даасан механизмыг бий болгох ба энэ механизм нь нууц мэдээллийн хүртээмжийн талаар болон дагаж мөрдөх журам гаргах эрх мэдэлтэй байх.*
- 6) *Гүтгэх болон доромжлох хэргийг гэмт хэрэг гэж тооцохгүй байх; нэр төрд халдсан гэх үндэслэлгүй шүүхийн маргаанаар мэдээлэл авах эрхийг ямар нэг байдлаар хаан боогдуулахгүй байх үр дүнтэй заалтыг иргэний хуулиар хангаж өгөх.*
- 7) *Төсвийн нээлттэй индекс 2012 –р Монголд өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх замаар төсвийн ил тод байдал, хяналт болон олон нийтийн оролцоог сайжруулах.*

2011 оны 6 сард Монгол улсын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай тусгай хууль (Мэдээлэл авах эрхийн тухай хууль) батлагдсан. Энэ нь төрийн байгууллагад байгаа мэдээллийг авахад зохицуулалт бий болгосон үндсэн хууль бөгөөд бусад холбогдох хуулиуд нь Төрийн Нууцын Тухай Хууль (1995), Төрийн Нууцын Жагсаалт Батлах Тухай Хууль (2004) болон Байгууллагын Нууцын Тухай Хууль (1995) байна. Монгол улсын Мэдээлэл авах эрхийн тухай хууль нь дэлхийн мэдээлэл авах эрхийн 54-т жагссан (95

орноос)<sup>30</sup>.

**1) Улсын төсвөөс санхүүждэг төрийн хуулийн байгууллага, аж ахуйн нэгжүүд эсхүл төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг байгууллагууд ил тод байдал болон мэдээлэл хүртээмжтэй байх шаардлагад хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх.**

Монгол улсын Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн үйлчлэх хүрээ нь дараах байгууллагад хамаарна: Улсын Их Хурлын Тамгын газар; Ерөнхийлөгчийн Тамгын газар; Засгийн газрын Хэрэг эрхлэх газар; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба; төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага; бүх шатны шүүх, прокурорын байгууллага; Улсын Их Хурлаас байгуулдаг /Засгийн газраас бусад/ байгууллага; нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын алба, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд; төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд; төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага; олон нийтийн радио, телевизийн байгууллага.

Харин энэ Хуульд “Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуулын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад энэ хууль үйлчлэхгүй” гэж заасан байдаг. Энэ заалт нь хэвлэн нийтлэх эсхүл тодорхой хүсэлтийн дагуу мэдээлэл авахтай холбоотой эсэх нь тодорхой биш байгаа юм. Ямар ч тохиолдолд энэхүү Үнэлгээний Тайлангаар хууль үйлчлэхгүй байдлыг ийм өргөн агуулгаар тодорхойлох нь зохисгүй юм – онцгойлон хасахгүйгээр төрийн бүх байгууллагууд нээлттэй байж, мэдээлэл авах боломжоор хангах хэрэгтэй. Мөн хууль үйлчлэхгүй хэсэг нь байгууллагад бус мэдээллийн агуулгад төвлөрсөн байх хэрэгтэй бөгөөд энэ зохицуулалтыг мэдээлэл авах хязгаарлалтын талаар ерөнхий журмаар зохицуулах хэрэгтэй.

Тамгийн газраас гадна Улсын Их Хурал болон Ерөнхийлөгч энэхүү хуульд хамрагдах хэрэгтэй. Учир нь УИХ болон Ерөнхийлөгчийн гаргасан аливаа хууль, эрх зүйн баримт бичиг энэ хуульд хамаарагдахгүй байна.

Энэ талаар ямар нэг өөрчлөлт хийгдээгүй байна.

**2) Ямар ч ангиллын мэдээлэл бүрэн хэмжээгээрээ нээлттэй байх шаардлагаас чөлөөлөгдөхгүй байх нөхцөлөөр хангах; улсын нууцтай холбоотой болон бусад мэдээллийн хүртээмжтэй байхад тавьж байгаа хязгаарлалт нь зөвхөн хуульд суурилсан байх, шаардлага, боломж хоорондоо нийцтэй байх ба учруулж болох хохирол болон учирч болох хохирол болон нийгмийн ашиг сонирхлыг үүссэн нөхцөл тус бүрээр олон улсын сайн туршилагад тулгуурлан авч үзэх. Хуульд, ялангуяа авлига болон улсын мөнгө, хөрөнгөтэй холбогдсон хууль зөрчсөн үйлдлүүдийн талаарх аливаа мэдээллийг нээлттэй байлгахад ямар нэг хязгаарлалт тавихгүй байх заалтыг оруулах.**

Энэ талаар шинэ заалт ороогүй байна.

**3) Мэдээлэл авах хүсэлттэй холбогдсон журмаас шаардлагагүй зүйлүүдийг нь хасаж,**

---

<sup>30</sup> Дараах холбоосоор дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү: [www.rti-rating.org/country\\_data.php](http://www.rti-rating.org/country_data.php). ‘Access Info’ болон ‘Хууль, Ардчилалын Төв’ ТББ нь үнэлгээг нэгтгэсэн.

## ***журмыг аль болох хялбар, тодорхой болгох***

Энэ талаар шинэ заалт ороогүй байна.

### ***4) Төрийн албан хаагчдын зүгээс мэдээлэл авах эрхийн тухай заалтыг зөрчсөн тохиолдолд оноох захиргааны шийтгэлийг чангатгах***

Мэдээлэл авах эрхийн тухай хуульд мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийг хуулийн зохицуулалтыг зөрчсөн төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн дагуу ял, шийтгэл оноож болох талаар заасан байна. Хариуцлагын арга хэмжээг тухайн төрийн албан хаагчийг томилсон зохих албан тушаалтанд оногдуулна. Мэдээлэл авах тухай зохицуулалтыг “удаа дараа эсхүл санаатайгаар” зөрчсөн төрийн албан хаагчийг албан тушаалаас нь хална. Тухайн албан тушаалтныг халаагүй тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд шүүхээс хөдөлмөрийн доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн торгуулийг оногдуулна.

Зөвлөмжид дурдсан мэдээллийг хүртээмжтэй байлгах зохицуулалтыг биелүүлээгүй тохиолдолд авах захиргааны ял шийтгэлийг нэвтрүүлээгүй байна.

### ***5) Гүтгэх болон доромжлох хэргийг гэмт хэрэг гэж тооцохгүй байх; нэр төрд халдсан гэх үндэслэлгүй шүүхийн маргаанаар мэдээлэл авах эрхийг ямар нэг байдлаар хаан боогдуулахгүй байх үр дүнтэй заалтыг иргэний хуулиар хангаж өгөх.***

Монгол улсын Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн Үндэсний Комисс (гомдол шийдвэрлэх байгууллага), эсхүл шүүхэд гомдол гаргаж болно. Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын Тухай Хуульд Комиссын гишүүн хүний эрх, эрх чөлөөтэй холбогдолтой зөрчлийн талаар шаардлага, зөвлөмж гаргана. Шаардлагыг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан долоо хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авсан бол гуч хоногийн дотор авсан арга хэмжээнийхээ тухай бичгээр хариу мэдэгдэнэ. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авахаас татгалзсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны талаар хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж болно. Комиссын гишүүн нь мөн гаргасан шаардлага, зөвлөмжөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэвлэн нийтлэх, мэдээлэх эрхтэй. Комиссын гишүүн шүүхэд хандсан тохиолдолд ямар шат дарааллаар асуудал шийдвэрлэгдэж, хууль, журмыг мөрдөхийн тулд ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байна. Үндэсний Комиссын төлөөлөгчтэй ажлын байран дээр нь уулзахад мэдээлэл авахтай холбоотой ямар ч гомдол гараагүй хэмээн мэдэгдсэн нь одоогийн зохицуулалт хангалтгүй байгааг харуулж байна.

Мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх зорилгоор бие даасан хяналтын механизм бүрдүүлээгүй байна.

### ***6) Гүтгэх болон доромжлох хэргийг гэмт хэрэг гэж тооцохгүй байх; нэр төрд халдсан гэх үндэслэлгүй шүүхийн маргаанаар мэдээлэл авах эрхийг ямар нэг байдлаар хаан боогдуулахгүй байх үр дүнтэй заалтыг иргэний хуулиар хангаж өгөх.***

Энэ талаар шинэ заалт ороогүй байна.

Монгол улсын Эрүүгийн Хуульд гүтгэх, доромжлох зэрэг хэд хэдэн гэмт хэргийн талаар заасан байна:

- 110-р зүйлд Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх (ойролцоогоор 2,200-с 5,500 ам.доллар) хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 111-р зүйлд Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол 110-р зүйлтэй ойролцоо ял шийтгэлтэй, харин ноцтой байдлаар гүжирдсэн бол ял шийтгэлийн хэмжээ нэмэгдэнэ (Гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ, Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ).
- 231-р зүйлд Төрийн албан хаагч болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан олны өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас нэг зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 259-р зүйлд Хэргийг хянан хэлэлцэж шийдвэр гаргах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай холбогдуулж шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Албан ёсны мэдээллээр 7 хүнд 110-р зүйлээр, 21 хүнд 111-р зүйлээр, 1 хүнд 231-р зүйл ангиар ял шийтгэж, 259-р зүйлээр ял шийтгэл оногдуулаагүй байна (энэ статистик мэдээлэл хэдий хугацааг хамарч байгаа нь тодорхойгүй байна).

Хүнийг гүтгэх болон доромжлох зүйл заалтууд нь хэрэгждэг болох нь тодорхой байна. Тайлангийн явцад ярилцагч тал Ерөнхий Сайд нэгэн сонингийн эсрэг шүүхэд зарга гаргасан<sup>31</sup>, мөн веб хуудас Засгийн газрын эсрэг ноцтой мэдээлэл гаргасны дараа хаагдсан талаар дурдсан. Хэвлэл мэдээллийн эсрэг гэмт хэргийн шинж чанартай гүтгэлэг болон олон тооны иргэдийн зарга нь хэвлэлийн эрх чөлөө болон авлигын наймаатай холбоотой

---

<sup>31</sup> 2013 онд Тэргүүн сонины редактор болон хоёр сэтгүүлч нэр хүндийг гутаан доромилж, ял шийтгэл хүлээсэн. Ерөнхий сайн Норовын Алтанхуяг 2012 оны тэдний эсрэг мэдүүлэг гаргаж энэ хэрэг 2013 оны 12 сард Дээд шүүхээр шийдвэрлэгдсэн. Эх сурвалж: Freedom of the Press 2014, Freedom House, <https://freedomhouse.org/report/freedom-press/2014/mongolia>.

мэдээллийн үндсэн эх сурвалж болох эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Өмнө нь зөвлөсний дагуу Монгол улс даруй гүтгэх болон доромжлох хэргийг гэмт хэрэг гэж тооцохгүй байх мөн нэр төрд халдсан гэх үндэслэлгүй шүүхийн маргаанаар мэдээлэл авах эрхийг ямар нэг байдлаар хаан боогдуулахгүй байх үр дүнтэй заалтыг иргэний хуулиар хангаж өгөх хэрэгтэй.

Интернэдэд байршуулсан мэдээллийн агуулгад шүүлт хийдэг байдал нь мөн анхаарал татаж байна. 2013 оны 2 сард Мэдээлэл Харилцаа Холбооны Зохицуулах Газар (МХХЗГ) интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд програм суулгаж хэрэглэгчдийн оруулсан сэтгэгдлийг шүүж гүтгэлэг, доромжлол, хараал, заналхийлэл бүхий үг орсон бол устгах журам гаргасан. МХХЗГ-с энэхүү “хориотой үгсийн жагсаалт”-г гаргана. МХХЗГ-с гаргасан журмаар веб хуудасны администратор хэрэглэгчдийн оруулж байгаа санал сэтгэгдэл “хуулийн болон ёс зүйн стандартыг зөрчсөн тохиолдолд тухайн сэтгэгдлийг устгах ёстой” хэмээн заасан байна. Энэ зохицуулалт нь хэвлэлийн эрх чөлөө мөн авлигын хэрэгтэй холбоотой сэтгэгдлээ интернетээр илэрхийлэх байдалд сөрөг нөлөө үзүүлж, хяналт, шалгалт нэвтрүүлэх урьдчилсан алхам болсон гэж үзэж байна<sup>32</sup>.

***7) Төсвийн нээлттэй индекс 2012 –р Монголд өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх замаар төсвийн ил тод байдал, хяналт болон олон нийтийн оролцоог сайжруулах.***

2014 оны 7 сарын 1-д Монгол улс Шилэн Дансны Тухай Хуулийг баталж 2015 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль нь төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх зорилготой юм. Энэ хуулийн үйлчлэх хүрээ нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; төрийн өмчит үйлдвэрийн газар; хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани; улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага; төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байна.

Хуульд заасан байгууллага дараах мэдээллийг веб хуудсандаа мэдээлнэ: тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт (жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор), хагас жилийн төсвийн гүйцэтгэл (жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор), өмнөх оны төсвийн гүйцэтгэл (жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор), сар, улирлын гүйцэтгэл (дараа сарын 08-ны өдрийн дотор); дараа жилийн төсвийн төсөл (жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор) жилийн эцсийн санхүүгийн тайлан (дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор), хагас жилийн тайлан (08 дугаар сарын 15-ны өдрийн дотор); төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт (тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор), төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.

Дээр дурдсан мэдээллээс гадна Сангийн Яам дараах мэдээллийг гаргана: улсын төсөв,

---

<sup>32</sup> See negative evaluation of the measure in the Freedom House report “Freedom of the Press 2014” (cited above), Final Report of the OSCE/ODIHR Election Observation Mission of Presidential Elections in 2013, page 15, available at [www.osce.org/odihr/elections/105150](http://www.osce.org/odihr/elections/105150).



Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд (хагас жилийн байдлаар тухайн жилийн 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор); Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр; Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээллийг улирал бүр; улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр; нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (сар бүрийн 15-ны өдрийн дотор); төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан (дараа жилийн 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор); төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээллийг улирал бүр; концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт; концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл, улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоог улирал бүр гарган.

Хяналтын баг ажлын байран дээр хийсэн уулзалтуудаар Хуулийн заалт бүрэн хэрэгжиж байгаад таатай байсан. Сангийн яам хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж үүрэг хүлээсэн бөгөөд 2015 оны 1-р улирлын байдлаар 70%-тай байгаа (Энэ хууль нь төсвөөс санхүүждэг ойролцоогоор 7,000 аж ахуйн нэгжүүдэд хамааралтай) хэмээн мэдэгдсэн. 2015 оны 5 сард хуулийн хэрэгжилтийг шинжлэх хурал зохион байгуулагдсан. Нэгдсэн “шилэн данс”-ний веб хуудас 2016 оны 6 сараас эхэлж ажиллаж эхлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд Сангийн яам энэ веб хуудсыг ажиллуулна. Энэ веб хуудсанд 37 төрлийн мэдээллийг 19 загварын дагуу боловсруулж, тайлагнах юм. Үндэсний Аудитын Газар Хуулийн хэрэгжилтийн хянаж байгаа бөгөөд 2015 оны 5 сард хийсэн холбогдох аудитын тайлангаар хэрэгжилтийг хангалттай түвшинд байна хэмээн үзсэн (аудитын явцад зарим тохиолдолд тогтмол бус тайлагнал, буруу мэдээлэл оруулах зэрэг дутагдал гарч байсан бөгөөд зарим бүсд интернет холболт байхгүй зэрэг тохиолдол гарч байсан).

Энэ хуулийг баталсан явдал нь сайшаалтай бөгөөд бусад орнуудын хувьд жишиг болохуйц юм. Хуулийг зохистой, бүрэн хэрэгжүүлэх хэрэгтэй. Ярилцлага авсан иргэний нийгмийн байгууллагууд хэлэхдээ Хуулийн хүрээнд олон мэдээлэл нээлттэй болсон ч мэдээллийн чанар дутмаг, мөн ойлгоход хүндрэлтэй байгаа талаар дурдсан. Тиймээс Шилэн Дансны Тухай Хуулийн хүрээнд бий болсон мэдээллийг тоон мэдээллийн санд байршуулан боловсруулж, харагдах байдлын хэрэгсэл ашиглан ойлгоход илүү хялбар байдлаар үзүүлэх хэрэгтэй.

### **Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн ил тод байдал**

Ярилцагчдын хөндсөн хэд хэдэн асуудлуудын нэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн ил тод байдал байсан юм. Засгийн газар эсхүл засгийн газрыг дэмждэг бизнесийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслийг шууд болон шууд бус байдлаар эзэмшдэг тохиолдолд хэвлэл мэдээлэл авлигыг илчилж, хоточ нохойны үүргээ гүйцэтгэж чадахгүй. Тийм ч учраас авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд нөлөө бүхий нэвтрүүлгийн сувгуудтай байж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ил тод байх нь чухал юм. Монгол улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн ил тод байдал чухал болохыг Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (ЕАБХАБ) төлөөлөгчийн газар Хэвлэл

мэдээллийн эрх чөлөөний талаар дурдахдаа хэлсэн.<sup>33</sup>

ЕАБХАБ-ын тайланд дурдсанаар Монгол улсын хэвлэл, мэдээллийн зах зээлд улс төрийн олон ургалч үзэл байдаг бөгөөд хэвлэл мэдээллийн орчинд улс төрийн шууд болон шууд бус нөлөө ихээхэн байдаг гэжээ. Сэтгүүлчид мэдээллийн хөтөлбөрөөр мэдээлэл цацахын тулд мөнгө төлж эсхүл эзэмшигчийн оролцоотой байх нь нийтлэг үзэгдэл болсон талаар дурдсан байдаг.<sup>34</sup>

Үнэлгээний баг өмчлөлийн ил тод байдлыг шаардсан өөрчлөлтийг эрх зүйн зохицуулалтад даруй оруулах зөвлөмж гаргасан.<sup>35</sup> Энэхүү эрх зүйн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн бүтэц, шууд болон шууд бус эзэмшигч, томоохон хувьцаа эзэмшигчдийг олон нийтэд нээлттэй болгох үр дүнтэй механизм юм. Хуульд нэвтрүүлгийн зөвшөөрөл авахын тулд бүх түвшний эзэмшлийн бүтэц, дэлгэрэнгүй санхүүгийн тайлангаа тогтмол танилцуулах зэрэг зохицуулалт оруулах хэрэгтэй.<sup>36</sup>

### **Олборлох аж үйлдвэрийн ил тод байдал**

Монгол улсын засгийн газар 2005 оны 12 сард Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачлагад (ОҮИС) элсэн орсон бөгөөд 2007 оны 9 сард гишүүнээр бүртгэгдсэн. ОҮИС-ийн анхны тайлан 2006 онд гарсан бөгөөд хамгийн сүүлд 2015 онд гарсан. Монгол улсын хувьд 2010 онд ОҮИС-г “Биелүүлдэг” статустай болсон. ОҮИС-д дурдсанаар Монгол улс маш дэлгэрэнгүй тайлан гаргадаг бөгөөд тайлангууд нь хэд хэдэн орд газар, таваарын үйлдвэрлэлийн тоо баримт, одоогийн газрын тосны олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зураглал зэргийг агуулсан олборлох салбарын ерөнхий байдлыг сайн тусгасан байдаг.<sup>37</sup>

ОҮИС-н Монгол улсын тайлангийн агуулга нэмэгдсээр байгаа. Хамгийн сүүлийн тайланд 1617 компани орсон байна. Мөн түүнчлэн тайланд засгийн газрын байгууллага болон төрийн бус байгууллагуудад хийгдэж буй төлбөр, жил бүрийн уул уурхай болон хүрээлэн буй орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн байдал, олборлогч компаниуд болон орон нутгийн эрх бүхий байгууллагын хооронд хийсэн гэрээ, хэлэлцээр, үйл ажиллагаа явуулж буй 216 гаруй компаниудын 5-с дээш хувийг эзэмшдэг хувь хүмүүсийн талаар мэдээллийг оруулсан байна.<sup>38</sup>

Улсын Их Хурлын ажлын хэсэг Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төсөл дээр ажиллаж байгаа. Хяналтын баг энэхүү хуулийн төслийг санаачилж, зохих зохицуулалтад алгуур шилжиж байгааг сайшааж хүлээж авч байна. Энэхүү хуулийн төсөл ОҮИС-н стандарттай нийцсэн байх нь чухал бөгөөд гэрээ хэлэлцээрийн болон Монгол улсын өмчлөлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх юм.

<sup>33</sup> Мэдэгдлийг [www.osce.org/fom/155216](http://www.osce.org/fom/155216) холбоосоос.

<sup>34</sup> 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэрх ажиглалт дээрх холбоосны 15-р хуудаснаас авах боломжтой.

<sup>35</sup> Монгол улсын Ерөнхийлөгч өмчлөлийн ил тод байдлын зохицуулалт бүхий Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг өргөн барьсан болон 2013 онд эргүүлэн татсан.

<sup>36</sup> Холбогдох стандартуудыг дараах холбоосноос авна уу: [www.access-info.org/wp-content/uploads/TMO\\_Recommendations\\_05\\_November\\_2013.pdf](http://www.access-info.org/wp-content/uploads/TMO_Recommendations_05_November_2013.pdf).

<sup>37</sup> Эх сурвалж: <https://eiti.org/Mongolia>.

<sup>38</sup> Эх сурвалж: <https://eiti.org/news/mongolia-new-government-challenged-vulnerable-economy>.

## Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ)

Монгол улс 2013 онд НЗТ-т нэгдэн орж анхны 2014-с 2015 оны Үндэсний Үйл Ажиллагааны Төлөвлөгөөгөө хэрэгжүүлж байна.

Монгол улсын НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн зорилтууд нь: а) Төрийн үйлчилгээг сайжруулах б) төрийн байгууллагуудын ил тод байдлыг сайжруулах в) Шударга ёсыг бэхжүүлж, авлигыг бууруулах. Эдгээр зорилтуудын хүрээнд Монгол улс төсвийн ил тод байдлыг сайжруулж, төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлж, мөн шударга, тогтвортой бодлого явуулна. Ингэснээр Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох зорилготой юм.<sup>39</sup>

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд авлигын эсрэг дараах алхмуудыг хэрэгжүүлнэ, жишээлбэл:

- Гэмт хэргийн гаралтын “цахим газрын зураг”-ийг ажиллуулах
- Хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцооны нэгдсэн сан бүрдүүлж, холбогдох этгээдэд нээлттэй, хүртээмжтэй болгох
- Нийтийн албан хаагчдын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг санамсаргүй сонголтын аргаар шалгах арга нэвтрүүлэх
- Авлигын түвшин өндөртэй байгууллагуудын нийтийн албан тушаалтны хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг цахим мэдээллийн сүлжээнд байрлуулах

Үйл ажиллагааны төлөвлөгөөг цаг хугацаанд нь, бүрэн хэрэгжүүлэх хэрэгтэй.

Монгол улс Зөвлөмж 3.6 –г **хэсэгчлэн биелүүлсэн** бөгөөд зөвлөмж хүчинтэй хэвээр байна.

## 3.7. Улс төрийн авлига

---

<sup>39</sup> Эх сурвалж: [www.opengovpartnership.org/country/mongolia](http://www.opengovpartnership.org/country/mongolia).

*Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.7.*

- 1) Улс төрийн намын санхүүжилтын журмыг эргэн хянах ба намын санхүүжилтийн эх үүсвэрт боломжит хязгаарлалт, гишүүний татвар зэрэг хувь хандивт хязгаар тогтоох; мөнгөн хандивт тогтоосон хязгаараас илүү мөнгө хандивлахыг хориглох ба мөн нэргүй хандивыг хориглох.**
- 2) Намын санхүүжилтын ил тод байдлыг хангах ба санхүүгийн жилийн тайланд бүх хандивыг нарийвчлан тусгах (бага хэмжээнээс бусад) ба тайланд хандивлагч нэг бүрийг болон намын зардлыг тусгах; санхүүгийн ийм тайланд баримтлах стандартыг тогтоох ба тайланг интернетэд байршуулах.**
- 3) Сонгуулийн ажлын санхүүжилтийг нээлттэй болгох журмыг боловсронгуй болгох ба үүнд сонгуулийн өмнөх өдөр санхүүгийн тайланг хүргүүлж, нийтлэх замаар олон нийтийн хүртээл болгох асуудлыг оруулах.**
- 4) Хариуцах үүргийг тодорхой болгох, зохистой хөрөнгө, эрх мэдэлтэй болгох, ялангуяа зохих хариуцлага хүлээлгэх эрх мэдэлтэй болгох үүднээс намын санхүү болон сонгуулийн ажлын санхүүжилтэд хяналт тавих бие даасан механизмын тогтолцоог хянан үзэж боловсронгуй болгох.**

Улс төрийн нам болон санхүүжилтын зохицуулалтад сонгуулийн ажлаас гадуур болон холбоотой томоохон өөрчлөлт ороогүй байна. Монгол улсын эрх бүхий байгууллагуудаас УИХ-ын ажлын хэсэг улс төрийн намуудын санхүүжилтын ил тод байдлын талаар цогц өөрчлөлтийг хийхээр бэлтгэж байгаа хэмээн мэдэгдсэн. Энэ нь Истанбулын үйл ажиллагааны төлөвлөгөөний зөвлөмжүүдэд анхаарал хандуулж, холбогдох зохицуулалт, туршлагыг сайжруулах боломж юм. Дурдсан өөрчлөлтүүдийг иргэний нийгмийн нягт оролцоотойгоор ил тод байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй.

**1) Улс төрийн намын санхүүжилтын журмыг эргэн хянах ба намын санхүүжилтийн эх үүсвэрт боломжит хязгаарлалт, гишүүний татвар зэрэг хувь хандивт хязгаар тогтоох; мөнгөн хандивт тогтоосон хязгаараас илүү мөнгө хандивлахыг хориглох ба мөн нэргүй хандивыг хориглох.**

**Хувийн хандив**

Улс төрийн намын тухай хуульд намын орлого дараах зүйлсээс хамаарна: гишүүний татвар; гишүүн, талархан дэмжигч иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив; төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг; намын бэлгэдэл бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа эд юмс; намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны орлого; өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах буюу түрээслүүлж ашиглуулснаас олсон орлого; намын мөнгөн хөрөнгийг

банкинд хадгалуулсны хүү.

Намд зориулж нэг удаа өгөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс арван сая (ойролцоогоор 4,300 евро), иргэдээс нэг сая төгрөгөөс (ойролцоогоор 430 евро) хэтэрч болохгүй бөгөөд нэг хандивлагч намын нэг байгууллагад жилд 2-оос дээш удаа хандив өгөхийг хориглоно. Хуульд зааснаар нам хүлээн авсан хандивын талаар мэдээллийн гаргана (гаргах мэдээллийн цар хүрээг тодорхойлоогүй).

Дараах этгээдээс хандив авахыг хориглоно: арван найман насанд хүрээгүй Монгол Улсын иргэн; төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага; шашны байгууллага; олон улсын байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн; байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд; тодорхой нэр хаяггүй этгээд; дампуурсан болон банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд; хуулиар хориглосон бусад этгээд. Олон улсын байгууллага болон улс төрийн үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллага, сантай хамтран зохион байгуулах т, хэрэгжүүлэх төслийн санхүүжилт энэ заалтад хамаарахгүй.

Дурдсан хуулийн заалтууд намын санхүүжилтын эх үүсвэрийг тодорхой хэмжээгээр зохицуулж байгаа боловч хангалтгүй байгаа бөгөөд дараах байдлаар сайжруулах хэрэгтэй: Хуульд “хандив”-ийн тодорхойлолтыг оруулах хэрэгтэй бөгөөд “улс төрийн намд эдийн болон бусад хэлбэрийн давуу тал бэлэглэх аливаа зориуд үйлдсэн үйлдэл”<sup>25</sup> хэмээн тодорхойлж, албан газар, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажилтан, үнэгүй зар сурталчилгаа, үйл ажиллагааг ивээн тэтгэх, бараа бүтээгдэхүүн хөнгөлөлттэй үнээр зарах зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хандивуудыг зохицуулалтад оруулах хэрэгтэй.

- 1) Бүх хандив болон гишүүнчлэлийн төлбөрийг намын бүртгэлд бүртгэх хэрэгтэй.
- 2) Хандивын хязгаарлалтанд намаас гадна намтай шууд болон шууд бус хамааралтай, намын эзэмшилд байдаг этгээдийг оруулах хэрэгтэй.
- 3) Гишүүнчлэлийн төлбөрийн дээд хэмжээг хуулиар тогтоож, гишүүнчлэлийн төлбөр хэлбэрээр хандивт тодорхойлсон хязгаарлалтыг тойрч гарах боломжийг хаах хэрэгтэй.
- 4) Хуульд хандив болон хандивлагчийн талаарх мэдээллийг нийтлэх журмыг (ямар байдлаар, ямар мэдээлэл нийтлэх г.м) тодорхой болгох хэрэгтэй.
- 5) Төрийн байгууллага болон улсын өмчит компаниудаас хандив авахгүй байх хязгаарлалтыг тодорхой болгож төрийн болон орон нутгийн засаг захиргааны өмчлөлтэй бүх компаниудаас хандив авахгүй байхаар тодорхой болгох хэрэгтэй. Түүнчлэн өмнөх жил нь төрөөс худалдан авалт болон ижил төрийн механизмаар (экспортын зээл, төрийн татаас г.м) дамжуулан тодорхой хэмжээний төлбөр (жич: орлогын тодорхой хувийг) хүлээн авсан компаниудаас хандив хүлээж авахыг хориглох зөвлөмж гаргаж байна.

Хэдийгээр хуульд бүх хандивыг банкны дансаар дамжуулан хийнэ гэж заасан байгаа боловч

---

<sup>25</sup> Европын зөвлөлийн улс төрийн намууд болон сонгуулийн ажлын явцад илрүүлсэн авлигын зөвлөмжийн талаар дараах холбоосноос авна уу: [www.coe.int/t/dghl/monitoring/greco/general/Rec\(2003\)4\\_EN.pdf](http://www.coe.int/t/dghl/monitoring/greco/general/Rec(2003)4_EN.pdf)

бидний ажлын байран дээр уулзсан ярилцагчид бодит байдалд бэлэн мөнгөөр хандив өгөх нь элбэг бөгөөд энэ нь намын бүртгэл, дансанд бүртгэгддэггүй гэж хэлж байсан нь үр дүнтэй хяналт тавихад саад болж байна. Түүнчлэн намуудын санхүүгийн тайлан гаргах зохицуулалт бодит байдалд хэрэгжихгүй байгаа бөгөөд санхүүгийн тайлангаа гаргаагүй тохиолдолд хүлээлгэх ял шийтгэл байхгүй байна. Мөн хуулийн этгээд их хэмжээний хандивыг өөрсдийн ажилчдаар дамжуулан хуваах байдлаар хуульд заасан хязгаарлалтуудаас зайлсхийж байна.

### **Төрийн санхүүгийн дэмжлэг**

Улс төрийн намын тухай хуулийн 19-р зүйлд хоёр төрлийн санхүүгийн дэмжлэгийн талаар заасан байна: Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр<sup>26</sup> тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлнэ. Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна.

Зөвхөн Улсын Их Хуралд суудал бүхий намд (2012 оны сонгуулиар 5%-ийн босго давсан намууд) төрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн хэмээн заасан нь олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байгаа юм. Улс төрийн олон ургалч үзлийг дэмжихийн тулд Улсын Их Хурлын босго хязгаараас бага (босгоос 1-2% бага санал авсан намууд ч мөн) дэмжлэг авсан намуудад ч мөн төрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зөвлөж байна.

Улс төрийн намуудад олгох төрийн санхүүгийн дэмжлэгийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

Ерөнхийдөө олон улсын стандартын дагуу “улс төрийн намуудад олгох төрийн санхүүгийн дэмжлэг нь хувийн хандивын хэрэгцээг байхгүй болгохгүй, мөн нөлөөг нь сулруулахгүй байдлаар зохицуулалт хийгдэх хэрэгтэй”. Санхүүгийн дэмжлэг нь намууд зорилгодоо хүрэхэд тодорхой дэмжлэг болох боловч нөгөө талаас санхүүжилтын үндсэн эх сурвалж болж, төрийн санхүүгийн дэмжлэгээс хэт хамааралтай байдал бий болгохоос зайлсхийх хэрэгтэй.<sup>27</sup>

**2) Намын санхүүжилтын ил тод байдлыг хангах ба санхүүгийн жилийн тайланд бүх хандивыг нарийвчлан тусгах /бага хэмжээнээс бусад/ ба тайланд хандивлагч нэг бүрийг болон намын зардлыг тусгах; санхүүгийн ийм тайланд баримтлах стандартыг тогтоох ба тайланг интернетэд байршуулах.**

Энэ чиглэлээр өөрчлөлт хийгдээгүй байна.

<sup>26</sup> 1,000 төгрөг ойролцоогоор 0.43 евротой тэнцүү.

<sup>27</sup> 2010 оны Венецийн Комиссын улс төрийн намын удирдамжын талаар дараах линкийн 38-р хуудаснаас авах боломжтой: [www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2010\)024-e.y](http://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2010)024-e.y)

Улс төрийн намын тухай хуульд намын санхүүжилтыг нам өөрөө дотооддоо хянана хэмээн заасан байдаг. Намын төв байгууллага нь харьяа байгууллагын санхүүгийн тайлан гаргасны дараа нэгдсэн тайлан гаргана. Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

Намын дотоод дүрэм, мөрийн хөтөлбөр нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина. Намууд мөн татварын байгууллагад тайлан гаргаж өгдөг ба энэ нь татвартай холбоотой асуудлыг хөндөнө.

Тиймээс Монгол улсын хуульд намын санхүүжилтын гадаад хяналтын талаар зохицуулалт байхгүй байна. Хуульд намууд санхүүгийн болон аудитын тайлан бэлтгэж, жил бүрийн тайлан гаргаж, Авлигатай Тэмцэх Газар зэрэг төрийн бие даасан байгууллагаар баталгаажуулах зэрэг нарийвчилсан зохицуулалт оруулах хэрэгтэй.

Санхүүгийн тайлангийн талаарх зохицуулалт нь хэтэрхий ерөнхий бөгөөд хангалтгүй байна. Улс төрийн бүх намууд жил бүр санхүүгийн тайлангаа тодорхойлсон стандартын дагуу дээд шатны хяналтын байгууллагад (тодорхойлох хэрэгтэй) хүргүүлэх талаар Хуульд заах хэрэгтэй. Энэ тайланд намын нэгтгэсэн (намын эзэмшилд байдаг бүх байгууллагуудыг оролцуулна) орлого болон зардлын дэлгэрэнгүй задаргааг харуулсан байна. Намууд энэ тайлангаа өөрсдийн веб хуудас болон дээд шатны хяналтын байгууллагын веб хуудсанд мөн байршуулах хэрэгтэй.

***3) Сонгуулийн ажлын санхүүжилтийг нээлттэй болгох журмыг боловсронгуй болгох ба үүнд сонгуулийн өмнөх өдөр санхүүгийн тайланг хүргүүлж, нийтлэх замаар олон нийтийн хүртээл болгох асуудлыг оруулах.***

Энэ чиглэлээр өөрчлөлт хийгдээгүй байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) Тухайн сонгуулийн жилийн 3 сарын 1-нээр намын болон нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээг тодорхойлно гэж заасан.<sup>28</sup> Сонгуулийн ажлын хандивын хэмжээг хувь хүний хувьд хөдөлмөрийн доод хэмжээнээс 40 дахин их төгрөгийн (ойролцоогоор 5000 евро), хуулийн этгээдийн хувьд 25,000 еврогоор хязгаарласан. Хэд хэдэн этгээдээс хандив авахыг хориглосон бөгөөд энэ нь дээр дурдсан намын хандивын хориглосон этгээдтэй ойролцоо байна. Тодорхойлсон хязгаараас хэтэрсэн хандивыг (бага хэмжээний торгуулийн хамт) хураан авна. Улс төрийн намууд сонгуулийн өдрөөс 30 хоногийн дараа санхүүгийн тайлангаа гаргана. СЕХ зардлын тайлан, 1 сая төгрөгөөс дээш хандив өгсөн хувь хүн, 20 сая төгрөгөөс дээш хандив өгсөн хуулийн этгээдийг шалгаж, санал хураалтаас 45 хоногийн дотор олон нийтэд тайлагнана.

ЕАБХАБ-ийн Сонгуулийн Ажиглалтын Багаас хамгийн сүүлд 2013 оны ерөнхийлөгчийн сонгуулийн талаар тайлан гаргасан бөгөөд тайланд хэдийгээр Хуульд СЕХ намын болон нэр дэвшигчийн санхүүжилтэд төрийн аудит хийлгэх шаардлага гаргах эрхтэй боловч Хороо тайланд аудит хийгээгүй гэжээ. Энэ байдал нь Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай

---

<sup>28</sup> 2013 оны 6 сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар СЕХ сонгуулын зардлын дээд хэмжээг намын хувьд 2.7 сая евро, нэр дэвшигчийн хувьд 1.6 сая еврогоор тогтоосон.

хуульд заасан хяналтын механизмийн үр дүнтэй байдлыг бууруулж, сонгуулийн ажлын санхүүжилтэд олон нийтийн итгэл алдрах нөхцөлийг бүрдүүлж байна гэж Ажиглалтын Багаас дүгнэсэн байна. Ажиглалтын баг Монгол улсад дараах зөвлөмжийг гаргасан: улс төрийн сонгуулийн санхүүжилтын шударга байдалд итгэх олон нийтийн итгэл болон ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд СЕХ сонгуулийн санхүүжилтын зохицуулалтыг цаг хугацаанд нь гаргаж, сонгуулийн өмнөх болон дараах үйл явцад ил тод мөрдүүлэх хэрэгтэй.<sup>29</sup>

Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд СЕХ-ноос сонгуулийн жилийн 2 сарын 1-нээр эвсэлийн эсхүл намын сонгуулийн зардлын дээд хязгаар, мөн тухайн тойргийн хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан үзэж тойрог бүрт зарцуулах нэг нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хязгаарыг тогтоодог. СЕХ сонгуулийн санал хураалт дууссанаас 45 хоногийн дотор олон нийтэд зардлын тайлан болон 200,000 төгрөгөөс дээш хандив өгсөн хувь хүн, 500,000 төгрөгөөс дээш аж ахуйн нэгжүүдийн талаар мэдээлэл хүргүүлдэг.

Ажлын байран дээрх ярилцлагын үед эрх бүхий албан тушаалтнууд СЕХ хандивын хязгаарлалт (зөвшөөрөгдсөн хэмжээ болон эх үүсвэр) мөрдөгдөж байгаа эсэхийг шалгадаг бөгөөд намуудын болон нэр дэвшигчдийн хүргүүлсэн санхүүгийн тайланг тайлагнасан байна. СЕХ-д санхүүгийн тайлангуудыг нэг л хүн (нийт 40 ажилтнаас) хариуцдаг учраас зохистой баталгаажуулалт, хяналт хийгддэггүй нь тодорхой юм.

***4) Хариуцах үүргийг тодорхой болгох, зохистой хөрөнгө, эрх мэдэлтэй болгох, ялангуяа зохих хариуцлага хүлээлгэх эрх мэдэлтэй болгох үүднээс намын санхүү болон сонгуулийн ажлын санхүүжилтэд хяналт тавих бие даасан механизмын тогтолцоог хянан үзээж боловсронгуй болгох.***

Сонгуулийн Төв Байгууллагын тухай хуульд Сонгуулийн Ерөнхий Хороо нь нь улс төрийн нам, эсхүл, сонгуульд нэр дэвшигчдийн хүлээн авсан хандив, тусламжийн хэмжээ, зарцуулалт болон сонгуулийн сангийн зохицуулалтын тайлан, мэдээнд хяналт хийж, нийтэлдэг байгууллага юм.

СЕХ нь Хуульд заасны дагуу сонгуулийн санхүүгийн хяналтын талаар дараах эрх хэмжээтэй байна:

- нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад хяналт тавих;
- сонгуулийн хороодын санхүүгийн тайланг хянан шалгах;
- нам, эвсэл, нэр дэвшигчээс болон сонгуулийн хороодоос өөрийн эрх хэмжээний асуудлаар мэдээлэл авах;
- төрийн болон бусад байгууллага, хувь хүмүүс, иргэдээс сонгуулийн санхүүжилттэй холбоотой баримт бичгийг гаргуулан авна. Холбогдох хувь хүмүүс шаардсан баримт бичгийг гурван өдрийн дотор, эсхүл сонгууль хүртэл гурваас цөөн хоног үлдсэн тохиолдолд сонгуулийн өдөр хүргүүлэх;

---

<sup>29</sup> 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулын явц дахь ажиглалтын тайлангийн сүүлийн хувилбарыг дараах холбоосны 14-р хуудаснаас авна уу.



- сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх.

Хороо шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын ажлыг холбогдох хяналт шалгалтын байгууллага, түүний дотор төрийн аудитын байгууллагаар гүйцэтгүүлнэ.

Гэсэн хэдий ч бодит байдалд СЕХ өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлж, сонгуулийн санхүүжилтэд үр дүнтэй хяналт хийхгүй байна. СЕХ үйл ажиллагаагаа Хуулийн хэрэгжилтийн түвшинд авчрах хэрэгтэй. Ярилцсан зарим хүмүүс СЕХ-ны эрх мэдэл өргөн цар хүрээтэй мэт боловч бодит байдалд хянах эрх мэдэл нь маш хязгаарлагдмал бөгөөд хэд хэдэн албан ёсны шаардлага тавихаар л хязгаарлагддаг гэж байсан юм.

Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны (СЕХ-ны дарга, нарийн бичгийн дарга) байна. Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно. Хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно. Хорооны гишүүн нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч байхыг хориглоно.

СЕХ-ны гишүүдийн томилгоо нь хэтэрхий улс төржсөн бөгөөд УИХ-с ихээхэн хараат байдалтай байна. Сонгуулийн Төв Байгууллагын Тухай Хуульд СЕХ-ны гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдох, эсхүл огцрох хүсэлтээ өгснөөр албан тушаалаа хүлээлгэн өгч болно гэж заасан нь эерэг заалт байна. СЕХ-ны хоёр гишүүн л орон тооны гишүүд учраас улс төрийн санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд нөөц боломж дутмаг байна. Тиймээс СЕХ-ны бүх гишүүдийг орон тооны болгож, гишүүдийг сонгохдоо мэдлэг, чадварт нь үндэслэх, боломжтой бол нээлттэй өрсөлдөөний журмаар сонгох зөвлөмж гаргаж байна. Монгол улсын хувьд мөн СЕХ-ны нарийн бичгийн даргыг ажилчдын тооны хувьд нэмэгдүүлж сонгуулийн санхүүгийн тайланд аудит хийхэд хангалттай чадамжтай болгох хэрэгтэй.

Сонгуулийн зардлын зохицуулалтыг зөрчсөн нэр дэвшигчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан байгууллагыг таваас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, дансанд хуримтлагдсан хөрөнгийг хураан авна.

Ерөнхийдөө улс төрийн намуудын сонгуультай холбоогүй санхүүжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага Монгол улсад байхгүй байна. Энэ нь улс төрийн санхүүжилттэй холбоотой бүх зохицуулалтыг үр дүнгүй болгож байгаа бөгөөд энэ асуудлыг даруй хөндөх хэрэгтэй. Монгол улс санхүүжилтын хязгаарлалтын хуулийг мөрдүүлж, намуудын санхүүжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагыг томилох хэрэгтэй. Энэ байгууллага нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах бие даасан байдал болон нөөц бололцоотой байх

хэрэгтэй. Хяналтын багийн бодлоор энэ үүргийг АТГ-г оногдуулж болно.

## **Дүгнэлт**

Монгол улсын улс төрийн намын санхүүжилтын зохицуулалт сул байгаа бөгөөд ихэнх тохиолдолд хэрэгжихгүй байна. Энэ асуудлыг яаралтай хөндөх хэрэгтэй. Улс төрийн санхүүжилтыг үр дүнтэй байдлаар хянаагүй тохиолдолд улс төрийн авлига, засгийн газрын байгууллагуудад нөлөөлөх сонирхлыг бий болгоно. Намын санхүүжилтын талаар хэд хэдэн үндсэн зохицуулалт байгаа ч эдгээр зохицуулалтууд хэрэгждэггүй бөгөөд бодит байдалд

Намын санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй төрийн байгууллага байдаггүй. Ил тод байдлын шалгууруудыг биелүүлдэггүй бөгөөд намын санхүүжилт далд хэлбэртэй байсаар байна. Сонгуулийн ажлын санхүүжилтэд тавигдах шаардлагууд үр дүнгүй байгаа бөгөөд Сонгуулийн Ерөнхий Хороонд бүрэн хэрэгжилтийг хангаж ажиллах чадамж байхгүй байна. Ерөнхийдөө холбогдох зохицуулалтуудыг дахин сайтар нягталж үзэх хэрэгтэй. Тиймээс намын санхүүжилтын ил тод байдлын тухайн хуулийн төсөл нь сайшаалтай зүйл юм. Хуулийн төслийг иргэний нийгмийн оролцоотойгоор ил тод хэлэлцэх хэрэгтэй.

Монгол улс Зөвлөмж 3.7-г хэсэгчлэн биелүүлсэн бөгөөд зөвлөмж хүчинтэй хэвээр байна.  
**Шинэ зөвлөмж 3.7.**

- 1) Гишүүнчлэлийн төлбөрт хязгаар тогтоох замаар улс төрийн намын санхүүжилтын зохицуулалтын системийг сайжруулах, “хандив”-г өргөн хүрээгээр тодорхойлж, бүтээгдэхүүн үйлчилгээний бүхий хандивыг оруулах, хандивтай холбоотой хязгаарлалтад намын удирдлагад байдаг бүх аж ахуйн нэгжүүдийг оруулах, хандивын талаарх мэдээллийг түгээх журмыг нарийвчлах, төрийн худалдан авалт болон бусад төрийн эх үүсвэрээс мөнгө хүлээн авсан компаниудаас хандив авахыг хориглох.*
- 2) Улс төрийн намуудын хувийн болон төрийн санхүүжилтын харьцааг хадгалж, төрийн санхүүжилтын зарцуулалтад хязгаарлалт тавих. Олон нийтийн сонгуулиар тогтоосон босгоос бага ч гэсэн ирэгдийн дэмжлэгийг авч чадсан намуудад төрийн санхүүгийн дэмжлэг олгох.*
- 3) Жил бүр нэгтгэсэн дэлгэрэнгүй санхүүгийн тайлан гаргаж, бүх хандив (бага хэмжээтэйгээс бусдыг), хувь нэмэр, намын зардлын тайланг стандартын дагуу тайлагнаж, интернетэд байршуулах замаар намын санхүүжилтын ил тод байдлыг бий болгох.*
- 4) Сонгуулийн өмнөх өдөр дэлгэрэнгүй санхүүгийн тайлан гаргах замаар сонгуулийн ажлын санхүүжилтын нээлттэй байдлын журмыг сайжруулах*
- 5) Намуудын болон сонгуулийн ажлын санхүүжилтэд хяналт тавих, зохих эрх мэдэл, нөөц боломжтой, зохих ял шийтгэл оногдуулах чадамж бүхий бие даасан байгууллагыг цаг алдалгүй байгуулах. Улс төрийн намуудын санхүүжилтэд*

*хяналт тавих эрх мэдлийг Авлигатай Тэмцэх Газарт шилжүүлэх боломжийн талаар судлах. Сонгуулийн Ерөнхий Хороо бол ур чадварт тулгуурлан (боломжтой бол нээлттэй өрсөлдөөний зарчмаар) сонгосон байнгын орон тооны гишүүд бүхий мэргэжлийн, бие даасан байгууллага болгох.*

- б) УИХ-ийн гишүүдийн шударга байдал, ёс зүйн дүрмүүд, шийдвэр гаргалтын үйл явцыг шинэчлэх, дагаж мөрдүүлэх үр дүнтэй механизмыг бий болгох.*

### 3.8. Шүүх байгууллагын шударга зарчим

#### Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.8.

- 1) *Шүүгчдийг томилох болон халах асуудлыг улс төрийн институцийн /Ерөнхийлөгч, парламент/ оролцооноос салгаж, оронд нь шүүхийн ерөнхий зөвлөл шийддэг байх; шүүгчдийг томилохдоо ур чадварын зарчимд тулгуурлан, өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын тогтолцоотой болох асуудлыг авч үзэх; шүүгчдийн үндэсний сургууль дээр шүүгчдийг /томилохын өмнө болон томилолтын дараа/ эхний сургалтад заавал хамруулдаг байх системтэй болох*
- 2) *Шүүхийн бие даасан байдлын баталгааг улам боловсронгуй болгох үүднээс: ерөнхий шүүгчийг томилох эсхүл огцируулах асуудлыг холбогдох шүүхийн шүүгчид шийддэг болох; хэрэг хуваарилахдаа санамсаргүй /тохиолдлын/ байдлаар шүүгчдэд хуваарилдаг болгох, мөн хэрэг хуваарилалтын талаар гаргасан шийдвэрийг нийтэд нээлттэй хүртээмжтэй болгох*
- 3) *Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлэх, ялангуяа бүрэлдэхүүний дийлэнхи нь янз бүрийн шатны шүүхийн төлөөллийг хангасан байх ба шүүгчид өөрсдөө сонгодог байх зарчимтай болох*
- 4) *Шүүгчдийн цалин хөлс болон нэмэгдлийг шууд хуульд тусган оруулах; шүүгчдэд урамшуулал олгодог байдлыг зогсоох.*

*1) Шүүгчдийг томилох болон халах асуудлыг улс төрийн институцийн /Ерөнхийлөгч, парламент/ оролцооноос салгаж, оронд нь шүүхийн ерөнхий зөвлөл шийддэг байх*

Шүүх байгууллагын зохицуулалтад Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиуд орно. Эдгээр хуулиудын шинэчилсэн найруулга нь 2013 оны 4 сараас хэрэгжиж эхэлсэн. Монгол улсын эрх бүхий байгууллагууд сүүлийн үнэлгээний тайлангаас хойш шүүх байгууллагын хуульд томоохон өөрчлөлт ороогүй гэж мэдэгдсэн. Үүний хажуугаар Монгол улсын үндсэн хуулийн өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд шүүх байгууллагын засаглалын системийг хөндөх юм.

Бүх шүүгчдийг байнгын хугацаагаар тэтгэвэрт гарах хүртэл нь томилдог. Бүх шүүгчдийг Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс санал болгосны дагуу Монгол улсын Ерөнхийлөгч томилно. Харин Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл УИХ-аар батлуулна. Албан тушаалд томилогдохоос өмнө нэр дэвшигчдийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон Шүүхийн мэргэшлийн хороо сонгож, орон тооны зарлалыг Хорооны веб хуудсанд байршуулна. Шүүхийн мэргэшлийн хороо нэр дэвшигчдийг үнэлж, Ерөнхий зөвлөл нэр дэвшигч тус бүртэй ярилцлага хийж, санал хураан хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид танилцуулна. Ерөнхийлөгч Хорооны саналыг хүлээж авах албагүй бөгөөд нэр дэвшигчийг татгалзаж болно.

Шүүгчдийн томилгоонд улс төрийн институциуд (Ерөнхийлөгч болон УИХ) оролцож байгаа нь асуудал бий болгож байна. Ингэснээр шүүхийн бие даасан байдлыг алдагдуулж байна. Олон улсын стандарт, сайн туршлагын дагуу шүүгчдийг томилоход зохих байгууллага нь Шүүхийн Зөвлөл юм. Энэ тохиолдолд Шүүхийн Зөвлөлийн ихэнх гишүүд нь шүүхийн системийг төлөөлж байгаа өөр өөр түвшний шүүгчдийн дундаас сонгогдсон байвал зохино. Одоогийн байдлаар Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүх гишүүдийг Монгол улсын Ерөнхийлөгч томилдог.

Шүүгчдийг томилох, бүрэн эрхийг түтгэлзүүлэхэд улс төрийн байгууллагуудын оролцоог тусгаарлах талаар тодорхой зүйл хийгдээгүй байна. Хэрвээ улс төрийн байгууллагуудыг сонголын үйл явцаас бүрэн тусгаарлах боломжгүй бол нэр дэвшигчдийг танилцуулах үйл явцыг аль болох албан ёсны болгох хэрэгтэй. Ингэснээр үндсэн шийдвэрийг Шүүхийн Ерөнхий Зөвлөл гаргаж, улс төрийн байгууллага Зөвлөлийн шийдвэрийг хүндэтгэн үзэж, шүүгчдийг томилох, түтгэлзүүлэх (бас нэг хувилбар нь Ерөнхийлөгч Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс нэр дэвшигчийн татгалзаж болох боловч Зөвлөлөөс дахин оруулсан тохиолдолд зайлшгүй зөвшөөрөх зохицуулалт оруулах) шийдвэр гаргалтанд оролцуулахгүй байх боломжтой юм.

***шүүгчдийг томилохдоо ур чадварын зарчимд тулгуурлан, өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын тогтолцоотой болох***

2013 оны шинэчлэлийн дараа нийт шүүгчдийн тоо (Дээд Шүүхийн шүүгчдийн оруулаад) 390-с 690 болж нэмэгдсэн бөгөөд аймгийн шүүгчдийг оруулбал илүү нэмэгдэх магадлалтай. Ойролцоогоор 300 шүүгчийг шинээр элсүүлсэн бөгөөд 2-3 жилийн хугацаанд дахин 200 гаруй ажлын байр бий болоод байна.

Эрх бүхий байгууллагуудын хэлж байснаар томилгооны үйл явц нь ур чадварын зарчимд тулгуурладаг бөгөөд өрсөлдөөнтэй байдаг. Сонгохын тулд орон тооны талаарх мэдээллийг ШЕЗ, холбогдох шүүхийн байгууллага өөрийн веб хуудсандаа байршуулж мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарладаг. Ажлын орон тооны мэдэгдэлд тавигдах шалгуур болон хүргүүлэх баримтын талаар тусгасан байдаг. Өргөдөл гаргагчид Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн харьяа Шүүхийн Мэргэшлийн Хороо (ШМХ) өргөдөл гаргана. ШМХ хүлээн авсан мэдээллийг шалган, баталгаажуулж нэр дэвшигчдээс шалгалт авч, бусад үнэлгээнүүдийг хийдэг. Шалгалтанд мэргэжлийн чадвар, ёс зүй, кейс, Монгол хэлийн шалгалт, бичгийн болон илтгэх мөн мэдээллийн технологийн чадварууд ордог. Тусгай ёс зүйн шалгалт нь ёс зүйн стандартын талаар кейс шалгалт байх бөгөөд нэр дэвшигчийн ярилцлагад оруулж мөн хамтран ажиллагчдад судалгаа явуулдаг. ШМХороогоор дараагийн шатанд сонгогдсон нэр дэвшигчдийг ШЕЗ-д ярилцлагад оруулдаг. Өмгөөлөгчдийн холбоог мөн нэр дэвшигчдэд санал авах зорилгоор урьдаг. Шүүгч сонгон шалгаруулах журмыг Монгол улсын Ерөнхийлөгч баталдаг.

Дээр дурдсан сонгон шалгаруулалтын үйл явц зөвлөмжийн дагуу байгаа мэт харагдаж байна. Гэсэн хэдий ч нэр дэвшигчдийг үнэлэх алхмуудыг ач холбогдолыг тодорхой болгох хэрэгтэй. Шалгалтанд, ярилцлагад мөн хөндлөнгийн үнэлгээнд хэр их ач холбогдол өгөхийг тодорхой болгох хэрэгтэй.

Түүнчлэн томилогдсон шүүгчдийн адил, шүүгч шалгаруулах үйл явцыг улс төрийн байгууллага тодорхойлох нь зохисгүй юм. Үндсэн зохицуулалтыг тусгайлсан хуульд зааж, бусад зохицуулалтыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс баталсан журмаар зохицуулах хэрэгтэй.

Шүүгчийн сонгон шалгаруулалтын хамгийн том асуудал нь сүүлийн шатанд ШЕЗ өөрийн санал болгож буй нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид танилцуулахад бий болдог. Өмнө нь дурдсанаар Ерөнхийлөгч эцсийн шийдвэрийг гаргадаг байдал нь олон улсын стандартад нийцэхгүй бөгөөд ялангуяа Ерөнхийлөгч ШЕЗ-ийн томилгоог тайлбар хийлгүйгээр татгалзах эрхтэй байдаг нь зохисгүй юм. Хэдийгээр эрх барих байгууллагуудын мэдэгдэж байгаагаар 2015 онд Ерөнхийлөгч 3 нэр дэвшигчийг л татгалзсан гэсэн мэдээ байгаа (гэвч энэ нь Ерөнхийлөгчийн томилсон ШЕЗ-ийн гишүүдийн санал болгож буй нэр дэвшигчид учраас цөөн тооны байх магадлалтай).

Шүүхийн Мэргэшлийн Хороо 9 гишүүнтэй бөгөөд 4 гишүүн нь Дээд шүүхийн шүүгч, 2 гишүүн нь давж заалдах шатны шүүгч, 3 гишүүн нь хуулийн профессор байна. Хорооны гишүүдийн бүтцийг ШЕЗ-с тогтооно. ШМХ-ний гишүүд хагас цагаар ажилладаг бөгөөд ажилласан цагт үндэслэн цалин тооцдог. Шүүгчдийг сонгон шалгаруулж, үнэлэх ажил нь ихээхэн хугацаа шаарддаг бөгөөд ШМХ орон тооны гишүүдтэй болсон тохиолдолд сонгон шалгаруулалтын ажилд эерэг нөлөөтэй юм.

***шүүгчдийн үндэсний сургууль дээр шүүгчдийг /томилохын өмнө болон томилолтын дараа/ эхний сургалтад заавал хамруулдаг байх системтэй болох***

Шүүгчийн бэлтгэлийн Нэгтгэсэн Хөтөлбөрийг жил болгон боловсруулж, 11-12 сургалтаас бүрддэг. 2014 онд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн харьяа Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн гадны санхүүжилттэй 7 сургалтыг зохион байгуулсан. Шүүгчийн сургалтын хөтөлбөрт: шинэ шүүгчийн сургалт (шинэ шүүгч ажлаа эхлэхээс өмнөх 1 долоо хоногийн сургалт), хуулийн хэрэглээ, ур чадварын хөгжүүлэлт болон мэргэжлийн хөгжил зэрэг орно. Сургалтын хөтөлбөр болон төлөвлөгөөг [www.judininstitute.mn](http://www.judininstitute.mn) –с авах боломжтой. Шүүгчдэд авлигын эсрэг асуудлаар тусгай сургалт ордоггүй.

Шүүгчийн Ерөнхий Зөвлөлийн сургалтын арга барил олон улсын стандартад нийцэж байгаа боловч Зөвлөл өөрөө стандартад нийцэхгүй байна.

***2) Шүүхийн бие даасан байдлын баталгааг улам боловсронгуй болгох үүднээс: ерөнхий шүүгчийг томилох эсхүл огцруулах асуудлыг холбогдох шүүхийн шүүгчид шийддэг болох; хэрэг хуваарилахдаа санамсаргүй /тохиолдлын/ байдлаар шүүгчдэд хуваарилдаг болгох, мөн хэрэг хуваарилалтын талаар гаргасан шийдвэрийг нийтэд нээлттэй хүртээмжтэй болгох***

Энэ чиглэлээр өөрчлөлт хийгдээгүй байна.

Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Монгол улсын ерөнхийлөгч 6 жилийн хугацаатай томилно, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн, танхимын тэргүүнийг тухайн шатны шүүхийн Ерөнхий

шүүгчийн тус тус өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч томилно. ШЕЗ Ерөнхий шүүгчийн албан тушаалын шалгалтыг зохион байгуулж шалгарсан нэр дэвшигчдийг Ерөнхийлөгчид өргөн барьж, Ерөнхийлөгч томилно.

Үнэлгээний тайланд дурдсанаар Ерөнхийлөгчийн албан тушаал нь Шүүхийн Ерөнхий Зөвлөлд нөлөөлж байгаа учраас ихээхэн эрх мэдэлтэй байна. Олон улсын сайн туршлагын дагуу холбогдох шүүхүүд нь ерөнхий шүүгчээ сонгож, мөн эргүүлэн татах эрхтэй байдаг. Ингэснээр шүүхийн шийдвэрт нөлөөлөх (шүүгчдийн комисс, хэрэг хуваарилалт г.м аргаар дамжуулан) шууд бус болон далд эрх мэдэл болон шүүгчдэд нөлөөлөх (хуримтлалын санд нөлөө үзүүлэх, шүүгчдийн цалин болон бусад урамшуулал зэргээр) байдлыг хязгаарлах юм. Мөн Ерөнхий шүүгч шүүгчид сахилгын арга хэмжээ авах эрх мэдэл нь хязгаарлагдмал байгаа бөгөөд энэ байдлыг мөн засах хэрэгтэй.

Хэргийг шүүгчдэд автоматаар хуваарилах талаар хуульд заагаагүй байна. Гэсэн хэдий ч Монголын эрх бүхий байгууллагуудын мэдэгдэж байгаагаар шүүхэд энэ систем хэрэгждэг бөгөөд хэргүүдийг програм хангамжийн тусламжтайгаар хуваарилдаг. Шүүхийн шүүгчдийн зөвлөл тухайн хэргийг хуваарилах системийг хариуцдаг. Энэхүү зохицуулалт нь бодит байдалд хэрэгжиж байгаа ч өмнөх зөвлөмжийн дагуу хууль, журмаар тогтсон зохицуулалтад оруулах хэрэгтэй.

Зөвлөмжийн энэ хэсэг хэрэгжээгүй байна.

***3) Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлэх, ялангуяа бүрэлдэхүүний дийлэнхи нь янз бүрийн шатны шүүхийн төлөөллийг хангасан байх ба шүүгчид өөрсдөө сонгодог байх зарчимтай болох***

Шүүхийн захиргааны тухай хуулийн 13.1-р зүйлд зааснаар Ерөнхий зөвлөл нь дарга, дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг анхан шатны шүүхийн шүүгчдийн болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос нэг, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүний нэрийг тус тус санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилно. Ерөнхий зөвлөлийн одоогийн гишүүдийг дээр дурдсан зохицуулалтын дагуу 2013 оны 5 сард 3 жилийн хугацаатай томилсон. Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь ерөнхийдөө олон улсын стандартын дагуу байна.<sup>30</sup> Анхаарал хандуулах ёстой гол асуудал нь шүүгчдийн санал болгосон ШЕЗ-ийн гишүүдийн томилгоо нь Ерөнхийлөгч үзэмжээр шийдвэрлэгддэг байдал юм.

***4) Шүүгчдийн цалин хөлс болон нэмэгдлийг шууд хуульд тусган оруулах; шүүгчдэд урамшуулал олгодог байдлыг зогсоох***

Энэ чиглэлээр өөрчлөлт хийгдээгүй байна.

Үнэлгээний тайланд дурдсанаар шинэчлэлийн дараа Шүүхийн Ерөнхий Зөвлөл шүүгчдийн цалингийн хэмжээг тодорхойлох эрх мэдэлтэй болсон. Зөвлөл шүүгчийн цалингийн хамгийн бага түвшинг 2.7 сая төгрөгөөр (ойролцоогоор 1,190 евро), давж заалдах шүүхийн

---

<sup>30</sup> Дэлгэрэнгүй мэдээлэл авахын хүсвэл Европын Зөвлөлийн Яамдын Холбооны Зөвлөмжийг үзнэ үү.

шүүгчдийн цалинг 2.9 сая төгрөгөөр (ойролцоогоор 1,280 евро), Дээд шүүхийн шүүгчдийн цалинг 3.2 сая төгрөгөөр (ойролцоогоор 1,400 евро) тогтоосон. Мөн шүүгчдэд зэрэглэл болон “мэргэжлийн үйл ажиллагааны түвшин”-гээс хамааран үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар урамшуулал тооцож олгохоор тодорхойлсон. Тиймээс шүүгчийн нийт цалин урамшууллын хамт 5-6 сая төгрөг (ойролцоогоор 2,200-2,650 евро) байна. Ажлын байран дээрх уулзалтын үеэр албан тушаалтнууд урамшуулал цалинг тооцохдоо зөвхөн ажилласан жилд үндэслэдэг (эхний 5 жил ажилласны дараа шүүгчид жил бүр 2%-ийн нэмэгдэл авдаг) бөгөөд гүйцэтгэлийг үнэлэх аргачлал байхгүй байгаа талаар дурдсан.

Улсын Их Хурлаас шүүгчдийн цалинг хуульд шууд тусган оруулах талаар яригдаж байсан ч одоогийн байдлаар энэхүү өөрчлөлт ороогүй байна. Зөвлөмжийн энэ хэсгийг хэрэгжүүлээгүй байна.

### **Бусад асуудлууд**

Монгол улсын эрх баригчдын хэлж байгаагаар шүүхийн үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг бий болгохын тулд бүх мэдээллийн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн веб хуудсанд ([www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn)) байршуулж байгаа. Шүүх үйл ажиллагааг дүрсжүүлэх төхөөрөмж шүүхийн өрөөнүүдэд байршуулсан. Шүүх ажиллагааг дүрсжүүлээгүй л бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл шүүх ажиллагаанд биечлэн байж болох талаар дурдсан.

Монгол улсад шүүхийн төсвийг шууд Улсын Их Хуралд танилцуулах эрхтэй учраас Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн сайн туршлагатай байна. Гэсэн хэдий ч энэ нь төсөв танасан тохиолдолд шүүгчдийг хамгаалахгүй юм. Шүүхийн төсвийн эцсийн шийдвэрийг Улсын Их Хурал гаргах бөгөөд УИХ ихэнх тохиолдолд Засгийн газрын болон Хууль зүйн яамны байр суурийг дагадаг. Шүүх байгууллагын төлөөлөгчид дараах тоо, мэдээллээр хангасан: 2015 онд шүүх байгууллага 88 тэрбум төгрөгийн хүсэлт гаргасан ч 54 тэрбум төгрөг хүлээн авсан (хөрөнгө оруулалтын зардлыг 24 тэрбум төгрөгөөр танасан). Дээд шүүх төсөвт тусдаа хүсэлт гаргадаг боловч бүрэн хэмжээгээр батлагддаггүй байна (2015 онд 26 тэрбум төгрөгийн хүсэлт гаргасан боловч 3.9 тэрбум төгрөг хүлээн авсан). Хуульд шүүхийн төсвийг өнгөрсөн жилээс танаж болохгүй гэсэн заалт байгаа боловч бодит байдалд энэ заалт хэрэгжихгүй байна. Улсын нэгдсэн төсвийн байдлаас харахад төсөвт таналт хийгдэж байгаа нь ойлгомжтой боловч өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан нь шүүхийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлж байна.

### **Дүгнэлт**

Монгол улсын шүүхийн систем авлига, улс төрийн нөлөө, талын тал харах үзэлд өртөмтгий хэвээр байна. 2013 онд хэрэгжүүлсэн шинэчлэл чухал боловч хангалттай биш байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар шүүхийн бие даасан байдлыг хадгалж, шүүхийн үйл ажиллагаанаас улс төрийн нөлөөг тусгаарлах замаар институцид өөрчлөлт хийх боломжтой. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүтцийг олон улсын стандартын дагуу болгох хэрэгтэй. Шүүгчдийг томилох, эргүүлэн татах үйл явцыг Ерөнхийлөгч болон УИХ-аас хамааралгүй хийдэг болох хэрэгтэй. Шүүгчдийг ур чадварт суурилан сонгох байдал эхэлж байгаа бөгөөд цаашид дэмжих хэрэгтэй. Шүүгчдийг сонгох үйл явцыг ил тод, шударга байхад анхаарах хэрэгтэй.



Монгол улс Зөвлөмж 3.8 –г **хэсэгчлэн биелүүлсэн** бөгөөд зөвлөмж хүчинтэй хэвээр байна.

### 3.9. Хувийн хэвшил

#### Үнэлгээний тайлангийн Зөвлөмж 3.9.

- 1) Авлигын эсрэг шинэ стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа бизнесийн шударга зарчмыг хөхиүлэн дэмжих чиглэлд авах арга хэмжээг тусгайлан оруулах; тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулж, төрийн байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох; арга хэмжээ боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих ажилд бизнес түншүүдийг оролцуулах.
- 2) Авлигын хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хууль тогтоомж боловсруулах үйл явцад бизнесийн салбарын оролцоог хангах; авлигын эсрэг хууль тогтоомж, хөтөлбөрийг оролцуулан, хэрэгжүүлэхэд үр дүнтэй ажиллаж байгаа компаниудыг урамшуулдаг байх асуудлыг авч үзэх.
- 3) Компани болон бизнесийн холбоодыг шударга зарчмын эрсдлийн үнэлгээ хийхэд туслах, соён гэгээрүүлэх ажил зохиох, бизнесийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд зөвлөлөгөө, чиглэл өгөх.
- 4) Бизнесийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран авлигын эсрэг, шударга ёсыг бэхжүүлэх хамтарсан үйл ажиллагаа явуулах төсөл боловсруулан хэрэгжүүлэх, ялангуяа эрсдэлтэй салбаруудад анхаарах.
- 5) Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд компанийн засаглалыг бэхжүүлэх, ил тод байдлыг хангах, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх, авлигаас сэргийлэх чиглэлд цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- 6) Аж ахуйн нэгжүүдийг улсын бүртгэлд бүртгэх үед тэдгээр нэгжүүдийн ашгийг бодит хүртэгчидийг нээлттэй болгож, тэмдэглэлийг бүртгэлд оруулах.

*1) Авлигын эсрэг шинэ стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа бизнесийн шударга зарчмыг хөхиүлэн дэмжих чиглэлд авах арга хэмжээг тусгайлан оруулах; тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулж, төрийн байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох; арга хэмжээ боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих ажилд бизнес түншүүдийг оролцуулах*

Азийн Сан болон Сант Марал Сангийн 2015 оны 4 сард явуулсан хамтарсан олон нийтийн судалгаагаар Монгол улс дахь авлигын үндсэн шалтгааныг засгийн газрын дээд албан тушаалтнуудын ил тод бус байдал (19.5 хувь) болон улс төр болон бизнесийн сонирхлын нэгдэл (19.1 хувь) хэмээн онцолсон байна. Олон нийтийн онцолсон бас нэг шалтгаан нь “Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадны томоохон компаниуд авлигын хэрэгслийг байн байн хэрэглэдэг” (18.2 хувь) гэсэн байна.

Дээр дурдсанаар Монгол улсын эрх бүхий байгууллагууд Ерөнхийлөгчийн тамгын газар ажлын хэсэг байгуулж авлигатай тэмцэх шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх зорилготой байгаа гэж мэдэгдсэн. Энэ хөтөлбөрт АТГ, иргэний нийгэм болон бизнесийн төлөөлөгчид, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын, Ажилчдын Холбоо зэрэг оролцогч талууд байгаа юм. Шинэ хөтөлбөрийн төсөлд дурдсанаар Монгол улсад авлигын үндсэн шалтгаан нь төрийн албан хаагч болон бизнес эрхлэгчид томоохон улс төрийн нөлөө байдаг бөгөөд энэ нь сонирхлын зөрчлийг бий болгож хуулийн хэрэгжилтийг сулруулдаг байна. Авлигатай тэмцэх хөтөлбөрийн төсөлд дурдсанаар бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээний хүрэлцээ дутмаг байдаг учраас авлига бий болдог хэмээн мэдэгджээ.

Шинэ авлигатай тэмцэх хөтөлбөрийн төсөл нь төрийн, хувийн болон иргэний нийгмийн хоорондын түншлэлийн тулгуур зарчмуудад суурилсан. Төрийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд ил тод байдлыг дэмжих хэд хэдэн алхмуудыг төлөвлөсөн байгаа, жишээлбэл авлигын өндөр эрсдэлтэй байгууллагуудад электрон үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагааг нь хянах замаар эрсдэлийг бууруулах гэх мэт. Хувийн компаниудын хувьд энэхүү шинэ хөтөлбөр нь гэрээний үүргээ биелүүлээгүй хувь хүн болон албан байгууллагад оногдох шийтгэлийг чангатгах, мөн хар жагсаалтад орсон аж ахуйн нэгж, байгууллагуудыг электрон тендерийн үйл ажиллагаанд оролцохоос хориглох зэрэг арга хэмжээгээр нөлөөлөх юм. Мөн хувийн компаниудыг илүү ил тод болгох, хувийн хэвшилд ЭЗХАХБ болон НҮБ-ийн хөгжүүлсэн авлигаас урьдчилан сэргийлэх стандартуудыг нэвтрүүлэх, засгийн газрын тодорхой эрх мэдлийг хувийн байгууллагад шийлжүүлэх замаар хувийн хэвшлийн авлигыг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөөд байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой авлигын хувьд авлигын эсрэг шинэ хөтөлбөрийн төсөлд хэвлэл мэдээллийн салбарын хөрөнгө оруулагчдыг ил тод болгох, тухайн хэвлэл мэдээллийн байгууллагад нэг хөрөнгө оруулагч эсхүл холбоотой этгээдүүд нөлөөлөхгүй байдлаар салбарыг зохион байгуулах тодорхой алхмуудыг заасан байгаа.

Харамсалтай нь авлигын эсрэг шинэ хөтөлбөрийн төсөл нь хувийн хэвшлийн салбарын авлигын эрсдэл бүхий гол газруудад хэрэгжүүлэх чиглэл, төлөвлөгөө байхгүй байгаа юм. Жишээлбэл, авлигын эсрэг шинэ хөтөлбөрийн төсөлд дурдсанаар компаниудын хувьд бизнесийн үйл ажиллагаанд нь хамгийн их саад болж байгаа зүйлсийг дурдахад татварын хувь (52.1%), зээлийн хүртээмж (26.2%) болон өрсөлдөөн (21.5%), онцолсон татварын албадууд (30.6%), Улсын Мөрдөн Байцаах Газар (18.2%) болон гаалийн албадыг (11.8%) бизнес үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа албан байгууллагуудаар онцолсон.

Ажлын байран дээр бодит байдалтай танилцах явцад судалгаанд хамрагдагсад үнэлгээчдэд дараах зүйлийг хэлж байсан: “Хэдийгээр ямар ч салбарт эрсдэл үүсч болох боловч судалгаа болон арга зүйн сайжруулалтаас гадна эдгээр эрсдэлийн асуудлыг хөндсөн үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна”.

Мөн Монгол улсад бизнес эрхлэхийн тулд авах шаардлагатай төрөл бүрийн тусгай зөвшөөрлүүд бизнес эрхлэгчдийг ихээхэн бухимдуулдаг талаар үнэлгээчдэд хэлж байсан юм. Авах ёстой зөвшөөрлийн тоо нь хэтэрхий их бөгөөд нийт 956 тусгай ‘олон шат дараалал’ бүхий зөвшөөрөл байна. Засгийн газар болон Улсын Их Хурлаас энэ тоог хамгийн

багадаа 50 хувиар зорилготой ажлын хэсэг байгуулсан боловч эцсийн байдлаарх хуулийн төслийг УИХ дэмжээгүй. Авлигын эсрэг шинэ хөтөлбөрт энэ асуудлыг шийдвэрлэхүйц арга хэмжээ байхгүй байгаа.

Дүгнэхэд, хэдийгээр авлигын эсрэг хөтөлбөрийн төсөлд хувийн хэвшлийн авлигыг бууруулж, хувийн болон төрийн байгууллагуудын хоорондын уялдааг сайжруулах хэд хэдэн эерэг зохицуулалт орсон боловч авлигын түвшин анхаарал татахуйц өндөр байдаг газруудад зохих анхаарал хандуулаагүй байгаа нь харамсалтай. Үүнээс гадна үндэсний авлигын эсрэг хөтөлбөр нь хэрэгжиж эхлээгүй байгаа бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд илүү тодорхой аргачлал, механизм оруулж, хариуцах нэгж, хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхой зааж өгөх хэрэгтэй.

***2) Авлигын хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хууль тогтоомж боловсруулах үйл явцад бизнесийн салбарын оролцоог хангах; авлигын эсрэг хууль тогтоомж, хөтөлбөрийг оролцуулан, хэрэгжүүлэхэд үр дүнтэй ажиллаж байгаа компаниудыг урамшуулдаг байх асуудлыг авч үзэх***

Судалгааны асуулгад өгсөн хариултаар Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Ажилчдын Холбоо Эрүүгийн хуульд орж байгаа өөрчлөлтөд саналаа өгсөн байна. Гэвч шинээр орж байгаа өөрчлөлтүүдэд ахиц, дэвшил бага байна. Учир нь Хуулийн шинэ өөрчлөлтөөр төрийн байгууллагуудад хүнд суртал их байгаагаас ихэнх тохиолдолд аж ахуйн нэгжүүд санаатай болон санамсаргүй байдлаар авлигад холбогдохоос өөр аргагүй байгаа учраас авлигын хариуцлагаас чөлөөлөгдөх зохицуулалттай байгаа юм. Эрүүгийн хуулийн шинэ төсөлд аж ахуйн нэгжийн хүлээх хариуцлагыг тодорхойлоогүй бөгөөд энэ асуудлаар хувийн хэвшлийн байгууллагуудтай зөвлөлдөөгүй байна.

***3) Компани болон бизнесийн холбоодыг шударга зарчмын эрсдлийн үнэлгээ хийхэд туслах, соён гэгээрүүлэх ажил зохиох, бизнесийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэхэд зөвлөлөгөө, чиглэл өгөх***

Ажлын байран дээрх уулзалтын явцад олон нийтийг соён гэгээрүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх тал дээр ТАГ, Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Ажилчдын Холбоо хоорондоо нягт хамтарч ажилладаггүй хэмээн үнэлгээчдэд мэдэгдэж байсан. Эдгээр байгууллагуудын хооронд ойлголцлын санамж бичиг байгуулагдсан. Мөн АТГ-н Урьдчилан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэс энэ чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулж, бизнес эрхлэгчдийн төлөөллийг урьж оролцуулж байсан.

Азийн Сан зэрэг хэд хэдэн хандивлагч байгууллагуудын тусламжтайгаар хувийн хэвшлийн шударга зарчмыг хөхиүлэн дэмжсэн төсөл хэрэгжүүлж байсан бөгөөд авлигын талаар хэд хэдэн сургалт, семинар явуулсан.

Түүнчлэн, Аж Үйлдвэрийн Яамны Жижиг Дунд Үйлдвэрийн Газар авлигын талаар хэд хэдэн сургалт, семинар явуулсан бөгөөд энэ асуудалтай холбоотой гарын авлага тараасан.

Үүнээс гадна, Ажилчдын Холбоо үнэлгээчдэд АТГ-н Урьдчилан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэстэй 2009 оноос хойш нягт хамтран ажиллаж байгаа хэмээн хэлж байсан.

Өнгөрсөн жил тэд 21 аймагт очиж тэнд үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийн байгууллагуудын авлига, хүнд сурталын асуудлын талаар ярилцлага хийсэн. Мөн АТГ-тай хамтран авлигатай хэрхэн тэмцэх талаар мэдээлэл бүхий гарын авлага бэлтгэсэн бөгөөд 2015 оны дундуур тараах төлөвлөгөөтэй байна. Энэхүү гарын авлагад авлигын эсрэг олон улсын хурал, зөвлөгөөний талаарх мэдээлэл, нийгэм болон хувь хүнд нөлөөлж буй авлигын нөлөө мөн хувийн байгууллагууд дотоод хяналтыг сайжруулсанаар хэрхэн авлигыг даван туулж болох талаар зөвлөгөө өгсөн.

2014 онд Банкны Холбоо, Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Ажилчдын Холбоо авлигын эсрэг бүх бизнесийн байгууллагуудыг нэгтгэх зорилго бүхий авлигын эсрэг холбоо байгуулсан.

АТГ-ын урьдчилан сэргийлэх хэлтэсийн тусламжтайгаар 20 сургагч багшийг бэлтгэж компанийн шударга байдал болон нийгмийн хариуцлага ухамсарлах чадварыг хөгжүүлэхэд туслах юм.

Мөн АТГ-н Урьдчилан Сэргийлэх, Соён Гэгээрүүлэх Хэлтэс Трансперенси Интернешнлтай Ойлголцлын санамж бичиг зурсан. Зорилго нь бизнесийн байгууллагуудад шударга зарчмын үнэлгээ (хэдийгээр санамж бичгийн үндсэн зорилго нь АТГ-ын үнэлгээ, сайжруулалтанд чиглэсэн байсан боловч) болгоход оршиж байсан юм.

Мөн Монгол улс Тогтвортой Санхүүжилтын Хөтөлбөрийг Недерландын Хөгжлийн Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпораци, Монголын Банкны Холбоо болон Банк Санхүүгийн Академийн санаачлагаар хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрт Монголын 14 банк нэгдсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд банк хар жагсаалтад орсон компаниудад зээл олгохыг зогсоох, ил тод, найдвартай байдлыг дэмжих зэрэг банкны тогтвортой зарчмуудыг тодорхойлсон. Энэ хөтөлбөрийн хүрээнд 2014 оны эхэнд онцгойлсон салбарын чиглэлүүдийг (уул уурхай, барилга, аж үйлдвэр) боловсруулсан.

***4) Бизнесийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран авлигын эсрэг, шударга ёсыг бэхжүүлэх хамтарсан үйл ажиллагаа явуулах төсөл боловсруулан хэрэгжүүлэх, ялангуяа эрсдэлтэй салбаруудад анхаарах***

Ажлын байран дээр явуулсан судалгаагаар Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим тусдаа хувийн хэвшлийн авлигатай тэмцэх, байгууллагуудын нийгмийн хариуцлагыг сайжруулах зорилго бүхий албатай. Алт болон уул уурхайн холбоо маш хүчирхэг лобби бүлэгтэй учраас энэ салбарт онцгой анхаарал хандуулсан үйл ажиллагаа явуулдаг. Тодорхой баримт нотолгоо байхгүй учраас үнэлгээчдийн хувьд авч буй арга хэмжээ нь хэр үр дүнтэй болохыг тодорхойлох боломжгүй байна.

***5) Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд компанийн засаглалыг бэхжүүлэх, ил тод байдлыг хангах, дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх, авлигаас сэргийлэх чиглэлд цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх***

2014 онд АТГ төрийн бус байгууллагатай хамтран төрийн өмчит 44 компанид үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнд байгууллагын ил тод данс хөтлөлт болон худалдан авалтын

талаар зөвлөмжүүдийг өгсөн. Эдгээр зөвлөмжүүдийг төрийн өмчит компаниудын стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан. Энэ чиглэлээр өөр үйл ажиллагаа хийгээгүй.

**б) Аж ахуйн нэгжүүдийг улсын бүртгэлд бүртгэх үед тэдгээр нэгжүүдийн ашгийг бодит хүртэгчидийг нээлттэй болгож, тэмдэглэлийг бүртгэлд оруулах**

Энэ асуудалтай холбоотой ямар нэг үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Монгол улс Зөвлөмж 3.9 –г **хэсэгчлэн биелүүлсэн** бөгөөд зөвлөмж хүчинтэй хэвээр байна.

## ДУГНЭЛТ ХҮСНЭГТ

	Шинэ зөвлөмж	Өмнөх зөвлөмж	Өмнөд зөвлөмжийн үнэлгээ			
			Бүрэн	Ихэнхийг	Хэсэгчлэн	Мөрдлөггүй
<b>ТУЛГУУР 1. АВЛИГЫН ЭСРЭГ БОДЛОГО</b>						
Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг бодлогын баримт бичгүүд	Өмнөх зөвлөмж хүчинтэй	1.1.-1.2. Авлигатай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг бодлогын баримт бичгүүд				•
Авлигын талаарх судалгаа	Өмнөх зөвлөмж хүчинтэй	1.3. Авлигын талаарх судалгаа			•	
Авлигын эсрэг олон нийтийн оролцоо	Өмнөх зөвлөмж хүчинтэй	1.4.-1.5. Авлигын эсрэг олон нийтийн оролцоо, соён гэгээрүүлэх ба олон нийтийн боловсрол		•		
Соён гэгээрүүлэх ба олон нийтийн боловсрол	Өмнөх зөвлөмж хүчинтэй					
Бодлого болон уялдуулан зохицуулах байгууллагууд	Өмнөх зөвлөмж хүчинтэй	1.6. Авлигын эсрэг тусгай бодлого болон уялдуулан зохицуулах байгууллагууд			•	
<b>ТУЛГУУР 2. АВЛИГЫГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ НЬ</b>						
Зөрчил болон зөрчлийн бүрэлдэхүүн	Өмнөх зөвлөмж хүчинтэй	2.1-2.2 Зөрчил болон зөрчлийн бүрэлдэхүүн			•	
Албан тушаалтны тодорхойлолт	Өмнөх зөвлөмж хүчинтэй	2.3. Албан тушаалтны тодорхойлолт				•
Ял шийтгэл болон хөрөнгө албадан хураах	Өмнөх зөвлөмж хүчинтэй	2.4. - 2.5. Ял шийтгэл болон хөрөнгө албадан хураах				•
Халдашгүй дархан байх эрх болон хөөн хэлэлцэх хугацаа	Өмнөх зөвлөмж хүчинтэй	2.6. Халдашгүй дархан байх эрх болон хөөн хэлэлцэх хугацаа				•
Олон улсын хамтын ажиллагаа болон эрх зүйн харилцан туслалцаа	Өмнөх зөвлөмж хүчинтэй	2.7. Олон улсын хамтын ажиллагаа болон эрх зүйн харилцан туслалцаа			•	
Хуулийн хэрэглээ, журам	Өмнөх зөвлөмж хүчинтэй	2.8. Хуулийн хэрэглээ, тайлбар, журам			•	
Авлигын эсрэг мэргэшсэн хууль сахиулагч байгууллага	Шинэ зөвлөмж	2.9. Авлигын эсрэг мэргэшсэн хууль сахиулагч байгууллага		•		
<b>ТУЛГУУР 3. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ</b>						
Төрийн албаны шударга байдал	Өмнөх зөвлөмж хүчинтэй	3.2. Төрийн албаны шударга байдал			•	
Ил тод байдлыг хөхиүлэн дэмжих ба төрийн албаны үзэмжээр хандах явдлыг бууруулах	Өмнөх зөвлөмж хүчинтэй	3.3. Ил тод байдлыг хөхиүлэн дэмжих ба төрийн албаны үзэмжээр хандах явдлыг бууруулах			•	
Төрийн санхүүгийн хяналт ба аудит	Шинэ зөвлөмж	3.4. Төрийн санхүүгийн хяналт ба аудит		•		
Төрийн худалдан авалт	Шинэ зөвлөмж	3.5. Төрийн худалдан авалт			•	
Мэдээллийн хүртээмж	Өмнөх зөвлөмж хүчинтэй	3.6 Мэдээллийн хүртээмж			•	
Улс төрийн авлига		3.7. Улс төрийн авлига			•	
Шүүх байгууллагын шударга зарчим	Өмнөх зөвлөмж хүчинтэй	3.8. Шүүх байгууллагын шударга зарчим			•	
Хувийн хэвшил	Өмнөх зөвлөмж хүчинтэй	3.9. Хувийн хэвшил			•	

## Монгол Улсын Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсэг

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

#### 8 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчим

8.1. Эрүүгийн хариуцлагыг хувь хүнд хүлээлгэнэ.

*/Энэ хэсэгт 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

8.2. Гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ.

8.3. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

#### 20 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээх этгээд

20.1. Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

20.2. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

#### 32 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээр завдах

32.1. Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл буюу эс үйлдэхүйг санаатай хийсэн боловч тухайн этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзнэ.

32.2. Гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл буюу эс үйлдэхүйг бүрэн хийсэн гэж тухайн этгээд ойлгосон боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол төгссөн завдалт гэнэ.

32.3. Гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг бүрэн хийгээгүйгээ тухайн этгээд ойлгосон бөгөөд түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй бол төгсөөгүй завдалт гэнэ.

#### 33 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах

33.1. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн буюу завдсан этгээд гэмт хэргээ туйлд нь хүргэх боломжтойг ойлгож байсан боловч тийнхүү туйлд нь хүргэхээс сайн дураараа, төгс татгалзсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

33.2. Гэмт хэргээ туйлд нь хүргэхээс сайн дураараа татгалзахаас өмнө хийсэн үйлдэл, эс үйлдэхүй нь бие даасан өөр гэмт хэргийн шинжийг агуулсан байвал зөвхөн тэр гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

#### 39 дүгээр зүйл. Гэмт хэрэгт хамаарагсад



39.1.Нуун далдлагч, үл мэдээлэгчийг гэмт хэрэгт хамаарагсад гэнэ.

39.2.Гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүний хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг урьдчилан амлахгүйгээр санаатай нуух зэргээр гэмт хэргийн үл мөрийг арилгасан этгээдийг нуун далдлагч гэнэ.

39.3.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэнийг мэдсээр байж зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй этгээдийг үл мэдээлэгч гэнэ.

39.4.Энэ хуулийн тусгай ангид нэрлэж заасан гэмт хэргийг үл мэдээлсэн, нуун далдалсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

#### **49 дүгээр зүйл. Эд хөрөнгө хураах**

49.1. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.

49.2.Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана.

**/Энэ хэсэгт 2004 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/**

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

49.3.Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

#### **70 дугаар зүйл. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг**

эрүүгийн

хариуцлагаас

чөлөөлөх

70.1.Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдэж, сайн дураараа хэргээ илчилж ирсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

#### **110 дугаар зүйл. Доромжлох**

110.1.Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

#### **111 дүгээр зүйл. Гүтгэх**

111.1.Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

111.2.Гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

111.3.Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

#### **148 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах**

148.1.Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

148.2.Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.3.Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

#### **150 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх**

150.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

150.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, энэ хэргийн улмаас бусдад үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

150.3.Энэ хэргийн улмаас бусдад их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

#### **155 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг**

авах,

борлуулах

155.1.Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/*

*455.2./Энэ хэсгийг 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

#### **166<sup>1</sup> дүгээр зүйл. Мөнгө угаах**

166<sup>1</sup>.1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1</sup>.2. Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166<sup>1</sup>.3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

*/Энэ зүйлийг 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **170 дугаар зүйл. Хууль бусаар шан харамж авах**

170.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын ажилтан албан үүргийн дагуу ажил гүйцэтгэж үйлчилгээ үзүүлэх үүргээ далимдуулан хясан боогдуулах замаар удаа дараа буюу их хэмжээний шан харамж авсан нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

#### **231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон**

нийтийн

байцаагчийг

доромжлох

231.1. Төрийн албан хаагч болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан олны өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас нэг зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

*Тайлбар: Энэ хуулийн 230, 231 дүгээр зүйлд заасан Төрийн албан хаагч гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.*

*/Энэ тайлбарт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

#### **246 дугаар зүйл. Гэмт хэргийг үл мэдээлэх**

246.1. Энэ хуулийн тусгай ангийн 87.2/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар төрийн нууц задруулах/, 91/Хүнийг санаатай алах/, 96/Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 108/Хүн хулгайлах/, 112/Хүнийг барьцаалах/, 126.2; 126.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх/, 145.2; 145.3; 145.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг хулгайлах/, 146.2; 146.3; 146.4/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах /, 148.2; 148.3; 148.4/Хүндрүүлэх нөхцөл

байдалтайгаар бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх/, 150.2; 150.3/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх /, 147/Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 176/Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах/, 177/Зандалчлах/, 178<sup>1</sup> /Терроризм/, 225/Агаарын хөлөг авч зугатаах/, 268.2; 269.2; 270.2/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хээл хахууль авах, өгөх, зуучлах / -т заасан гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

#### **259 дүгээр зүйл. Шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн**

байцаагч, өмгөөлөгч, прокурор шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэх

259.1.Хэргийг хянан хэлэлцэж шийдвэр гаргах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай холбогдуулж шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

#### **ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ**

#### **АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ**

#### **263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу**

албан тушаалын байдлаа урвуулах

263.1.Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

263.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, уг хэргийн улмаас их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

*Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна.*

*/Энэ тайлбарыг 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

#### **264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх**



## **267 дугаар зүйл. Албан тушаалтны нэр барих**

267.1.Албан тушаалтан бус этгээд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтны нэр барьж үйл ажиллагаа явуулсан нь залилан мэхлэх гэмт хэргийн шинжгүй бөгөөд энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний ашиг олсон, эсхүл бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс гурван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

*[/Энэ зүйлийг 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)*

*[/Энэ зүйлийг 2008 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)*

## **268 дугаар зүйл. Хээл хахууль авах**

268.1.Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

268.2.Энэ хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд , түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*[/Энэ хэсэгт 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)*

## **269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх**

269.1.Албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

269.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**Тайлбар:** *[/Энэ тайлбарыг 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)*

## **270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах**

270.1.Хээл хахууль өгч авахад зуучилсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

270.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**Тайлбар:** Хээл хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

## **270<sup>1</sup> дүгээр зүйл.Хууль бусаар хөрөнгөжих**

270<sup>1</sup>.1.Нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

270<sup>1</sup>.2.Нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна онц их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ хуулийн 270<sup>1</sup> дүгээр зүйлд заасан эд хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл гэж үзнэ.

[/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

### **273 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын**

бусаар

зарцуулах

273.1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг:

273.1.1.зориулалтын бусаар зарцуулсан;

273.1.2.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр эд хөрөнгө худалдан авсан;

273.1.3.нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан;

273.1.4.зохиомол хомсдол бий болгох замаар бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн;

273.1.5. төрийн өмчийн болон төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан;

273.1.6.улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсанаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

273.2.Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

## **Монгол Улсын Авлигын эсрэг хууль**

### **АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1.Авлигын эсрэг хууль тогтоомж нь [Үндсэн хууль1](#), энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд авлигын эсрэг хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 2<sup>1</sup> дүгээр зүйл.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

2<sup>1</sup>.1.Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална.

*[/Энэ зүйлийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)*

### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“авлига” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

3.1.2.“ашиг хонжоо” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.3.“албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

3.1.4.“давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.5.”олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” гэж олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах арга хэмжээний цогцолборыг;



3.1.6. “авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;

3.1.7. “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажил” гэж Авлигатай тэмцэх байгууллагад хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт явуулж байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг;

3.1.8. “гүйцэтгэх ажил” гэж [Гүйцэтгэх ажлын тухай<sup>2</sup> хуулийн 2 дугаар зүйлд](#) заасан ажиллагааг;

3.1.9. “сонгуульд нэр дэвшигч” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг.

#### **4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд**

4.1. Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1. төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5. улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8. эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.

[/Энэ зүйлийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

#### **5 дугаар зүйл. Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа**

5.1. Энэ хуулийн 3.1.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах;

5.1.2. төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;

5.1.3. авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажилд сургалт, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах;

5.1.4.сургалтын байгууллагууд эрх зүйн болон ёс зүйн хичээлийн хүрээнд суралцагчдад авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх;

5.1.5.албан бус боловсролын байгууллага болон сургуулиас гадуурх сургалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу авлигын нийгмийн хор аюулыг суралцагчдад тайлбарлан таниулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлэх;

5.1.6. хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.

## **6 дугаар зүйл. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

6.1.1.[Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай<sup>3</sup> хуулийн 7 дугаар зүйлд](#) заасан нийтлэг үүрэг;

6.1.2. тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх;

6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

6.1.4. төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;

6.1.5. тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах;

6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг [Төрийн албаны тухай хууль<sup>4</sup>](#) болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх;

6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;

6.1.8.авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах;

6.1.9.төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах;

6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;

6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

6.1.12.бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах;

6.1.13.авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

6.1.14.энэ хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлд заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах.

[/Энэ заалтыг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

6.2.Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.

6.3.Шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын агентлаг байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

6.4. Энэ хуулийн 6.3-д заасан байгууллагын байранд улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.5.Авлигаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь [Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9,10](#) дугаар зүйлд заасан эрх, нийтлэг үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ:

6.5.1.төрийн бус байгууллага гишүүнийхээ ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж байх;

6.5.2.хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагааныхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх.

6.6.Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.

[/Энэ хэсэгт 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

6.7.Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.

6.8.Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

6.9.Энэ хуулийн 6.6-д заасныг зөрчсөн албан тушаалтныг шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

[/Энэ хэсэгт 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

## **7 дугаар зүйл.Хориглох зүйл**

7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:

7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

7.1.2.бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;

7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;

7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;

7.1.5.албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;

- 7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- 7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- 7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Тайлбар: Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.

[/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

## **8 дугаар зүйл. Авлигын тухай мэдэгдэх**

8.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй.

[/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

## **9 дүгээр зүйл. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх**

9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

9.2. Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах**

### **10 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах**

10.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/ хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.

10.2.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

[/Энэ хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

10.5.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.3, 10.4-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.

10.6.Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хороонд, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч сонгуулийн тойргийн хороонд, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд сонгуулийн хуульд заасан хугацаанд тус тус хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргана.

10.7.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.

[/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

## **11 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах**

11.1.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

11.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;

11.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

11.1.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;

11.1.4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;

11.1.5.бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.

11.2.Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн, сонгуулийн тойргийн хороо Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, холбогдох хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.

11.3.Энэ хуулийн 11.1.4, 11.1.5-д заасан хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

11.4.Энэ хуулийн 11.2-т заасан сонгуулийн хороо сонгуулийн нэгдсэн дүн гарсны дараа тухайн сонгуульд сонгогдогчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг санал хураалт дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлж, хадгалуулна.

11.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө.

[/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

## **12 дугаар зүйл. Захидал харилцааны нууцлал**

12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар Авлигатай тэмцэх газарт хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг [Хувь хүний нууцын тухай5](#) хуулиар зохицуулна.

12.2.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх үүрэг хүлээсэн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойшхи хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөл болон хуульд зааснаас бусад тохиолдолд мэдүүлэг гаргагчийн болон энэ хуулийн 12.1-д заасан мэдээллийг задруулах, ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасныг зөрчсөн албан тушаалтанд Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

12.4.Мэдүүлэг гаргагч тэтгэвэр тогтоолгох буюу албан тушаалаас огцрох, халагдах, чөлөөлөгдөх зэргээр бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд хөрөнгө, орлогынх нь мэдүүлгийг 5 жилийн хугацаанд хадгалах бөгөөд уг хугацаа дуусмагц түүнийг өөрт нь, хэрэв нас барсан бол эхнэр буюу нөхөр, эсхүл хууль ёсны өв залгамжлагчид нь шилжүүлж өгнө.

## **13 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл**

13.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 11.1.2-т зааснаас бусад албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.

13.2.Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо, энэ хуулийн 11.1.2-т заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тус тус өргөдөл, гомдолд үндэслэн шалгах бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил илэрвэл зохих байгууллагад шилжүүлнэ.

13.3.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

13.4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.

[/Энэ хэсгийг 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

13.5.Авлигатай тэмцэх газар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.

13.6.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар

тайлбар гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана.

13.7.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.

13.8.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:

13.8.1.нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

13.8.2.зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

13.8.3.зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалинтай тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

13.8.4.нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.

13.9.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.

[/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

#### **14 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг нийтэд мэдээлэх**

14.1.Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэн нийтлэх ба цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна:

[/Энэ хэсгийн “Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэн нийтлэх ба” гэснийг 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар хассан бөгөөд үүнийг 2016 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/](#)

14.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;

14.1.2.Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;

14.1.3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд;

[/Энэ заалтад 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

14.1.4. Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний орлогч, гишүүн;

14.1.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;

14.1.6.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;

14.1.7.Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч;

14.1.8.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;

14.1.9.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга;

14.1.10.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;

14.1.11.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;

14.1.12.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга;

- 14.1.13.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;
- 14.1.14. Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;
- 14.1.15.Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;
- 14.1.16. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;
- 14.1.17.Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;
- 14.1.18.Ерөнхий аудитор, түүний орлогч;
- 14.1.19.Засгийн газрын агентлагийн дарга;
- 14.1.20.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;
- 14.1.21.аймаг, нийслэлийн Засаг дарга.

14.2.Энэ хуулийн 14.1-д зааснаас бусад этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэг олон нийтэд нээлттэй байна.

14.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн хөрөнгө, орлогын сүүлийн 5 жилийн мэдүүлэг Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд тавигдах ба иргэд мэдээлэл авах боломжийг хангана.

14.4.Иргэд бичгээр, амаар, цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч болох бөгөөд тэдгээрт мэдээлэл өгөх журмыг Авлигатай тэмцэх газар батална.

14.5.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаар жил бүр олон нийтэд мэдээлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Авлигатай тэмцэх байгууллага, түүний бүрэн эрх**

#### **15 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газар**

15.1.Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, энэ хуульд заасан этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага мөн.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан газрын харьяанд авлигатай тэмцэхтэй холбогдсон судалгаа шинжилгээ хийх үүрэг бүхий бүтцийг байгуулж болно.

15.3.Авлигатай тэмцэх газрыг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

15.4.Авлигатай тэмцэх газар бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний тодорхойлолт, загвар, хэрэглэх журмыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.

15.5.Авлигатай тэмцэх газар тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

#### **16 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үндсэн зарчим**



16.1.Авлигатай тэмцэх газар нь нэгдмэл удирдлагатай, бие даасан байх бөгөөд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хараат бус, ил тод байх, нууцыг чанд сахих зарчмыг баримтална.

16.2.Аливаа албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

### **17 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын бүтэц**

17.1.Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог Улсын Их Хурал батлах бөгөөд урьдчилан сэргийлэх, судалгаа дүн шинжилгээний, хяналт шалгалтын, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлын, захиргааны чиглэлийн гэсэн үндсэн бүтэцтэй байна.

### **18 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх**

18.1. Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;

18.1.2.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;

18.1.3.авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх;

18.1.4.төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

18.1.5.авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;

18.1.6. авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх;

18.1.7.төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.

18.2.Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиглэлээр дараахь чиг үүрэгтэй:

18.2.1.хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт явуулах, гарын авлага, зааварчилгаа гаргах;

18.2.2.мэдүүлэг гаргагчийн амаар болон бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу мэдүүлгийг хэрхэн бөглөх, нэмэлт оруулах, бүртгэх, шилжүүлэх талаар урьдчилан зөвлөгөө өгөх, бичгээр хариу мэдэгдэх, асуулт хариултын нууцыг хадгалах.

18.3.Авлигатай тэмцэх газар чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллана.

18.4.Авлигатай тэмцэх газар дараахь бүрэн эрхтэй:

18.4.1.авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

18.4.2.авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

18.4.3.авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;

18.4.4.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;

18.4.5.авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

18.4.6.авлигын холбогдолтой өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах;

18.4.7.хуулиар харьяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

18.4.8.чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах;

18.4.9. өөрийн байгууллага, ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

18.4.10.гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад албан тушаалтан буюу иргэнд ил болсон нууцыг задруулахгүйн тулд уг этгээдээс бичгээр баталгаа гаргуулан авах, баталгааг зөрчсөн тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

18.4.11.хуулиар харьяалуулсан хэргийг шалгах явцад илэрсэн авлигын гэмт хэрэгтэй холбоогүй хууль зөрчсөн бусад үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх, энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

18.4.12.өөрийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлсэн гэрч, бусад этгээдийг шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтад авахуулах;

18.4.13.хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих этгээдийн жагсаалтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч хянах;

18.4.14.хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах;

18.4.15.мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих, шалгах, хугацаа хожимдуулсан буюу санаатай худал мэдүүлсэн этгээдэд холбогдох хуульд заасан арга хэмжээг авахуулахаар эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

18.4.16.хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар бичгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;

18.4.17.авлигатай тэмцэх асуудлаар гадаад орнуудын болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.

18.5.Авлигатай тэмцэх газар Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр тодорхой хэргийг цагдаа, тагнуулын байгууллагатай хамтран шалгаж болно.

18.6.Авлигатай тэмцэх газар нь тодорхой хэрэгт гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа [Эрүүгийн байцаан шийтгэх хууль](#), [Гүйцэтгэх ажлын тухай хууль](#), энэ хуульд заасан журмыг баримтална.

## **19 дүгээр зүйл. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид тавигдах шаардлага**

19.1.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн болон зохих нөхцөл, шалгуурыг хангасан, авлига, албан тушаалын хэргээр шалгагдаж сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй иргэнийг томилно.

[/Энэ хэсгийг 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

19.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ёс зүйн болон сахилгын дүрмийг Авлигатай тэмцэх газрын дарга батална.

19.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч зэрэг дэвтэй байх бөгөөд түүнийг олгох журмыг Улсын Их Хурал батална.

19.4.Авлигатай тэмцэх газрын захиргаа, үйлчилгээний ажилтны эрх зүйн байдлыг [Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль](#) болон хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

[19.5. /Энэ хэсгийг 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/](#)

## **20 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн тангараг**

20.1.Авлигатай тэмцэх газрын албан хаагч томилогдсон даруйдаа "Авлигатай тэмцэх газрын ажилтан би хэний ч нөлөөнд үл автан, зөвхөн хуульд захирагдан үнэнч шударгаар авлигатай тэмцэхээ батлан тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ." гэж Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөнө.

## **21 дүгээр зүйл. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа**

21.1.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.

21.2.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргад нэр дэвшигч энэ хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:

21.2.1.Авлигатай тэмцэх газрын даргад нэр дэвшигч нь төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, 45 нас хүрсэн, эрх зүйч мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын мэдлэг туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй;

[/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

21.2.2. Авлигатай тэмцэх газрын дэд даргад нэр дэвшигч нь төрийн албанд 10-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч мэргэжилтэй, гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын мэдлэг туршлагатай, сүүлийн 5 жил улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй.

21.3. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг зөвхөн нэг удаа улируулан томилж болно.

21.4.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн дарга, дэд дарга томилогдсоноор дуусгавар болно.

21.5.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нөхөн томилогдвол түүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 21.1-д заасан бүрэн эрхийн хугацаа дуустал үргэлжилнэ.

## **22 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг чөлөөлөх, түдгэлзүүлэх, огцруулах**

22.1.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг дараахь тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

22.1.1.өөрөө хүсэлт гаргасан;

22.1.2.биеийн эрүүл мэндийн байдлаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

22.1.3.бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон.

22.2.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол энэ өдрөөс эхлэн түүнийг албан тушаалаас нь огцруулсанд тооцно.

22.3.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга огцрох тухай хүсэлтээ Улсын Их Хуралд бичгээр гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Улсын Их Хурлын чуулганы үед гаргасан бол 21 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт гаргасан бол чуулган эхэлснээс хойш 21 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ.

22.4.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга гэмт хэрэгт холбогдсон, түүнчлэн энэ хуулийн 31.2-т заасны дагуу баривчлагдсан бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан бол уг саналыг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ.

22.5.Хуульд зааснаас бусад үндэслэлээр Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх буюу огцруулахыг хориглоно.

### **23 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын даргын бүрэн эрх**

23.1.Авлигатай тэмцэх газрын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдах;

23.1.2.Авлигатай тэмцэх газрыг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

23.1.3.эрх тэгш байх, харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт нь үл оролцох зарчмын үндсэн дээр гадаад улсын тусгай алба, байгууллагатай харилцан ажиллах;

23.1.4.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийг томилох, чөлөөлөх, зэрэг дэв, нэмэгдэл олгох, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

23.1.5.Авлигатай тэмцэх газрын дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар баталж мөрдүүлэх;

23.1.6.Авлигатай тэмцэх газрын хүний нөөц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргах;

23.1.7.гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажилтай танилцах;

23.1.8.Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу нууц арга, хэрэгсэл ашиглах зөвшөөрөл олгох;

23.1.9.гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах шийдвэр гаргах;

23.1.10.байгууллагынхаа ажилд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

23.1.11.хуульд заасан бусад бүрэн эрх.

23.2.Авлигатай тэмцэх газрын даргын түр эзгүйд түүний шийдвэрээр дэд дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

### **24 дүгээр зүйл. Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагчийн эрх**

24.1.Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт эрхэлсэн албан хаагч хуульд заасан журмын дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. [Гүйцэтгэх ажлын тухай хууль](#)д заасан гүйцэтгэх ажилтны эрх, үүргийг эдэлж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;

24.1.2. [Эрүүгийн байцаан шийтгэх хууль](#)д заасан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн эрх, үүргийг эдэлж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах;

24.1.3. аж ахуйн нэгж, байгууллагын байранд нэвтрэн орох;

24.1.4. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний банкинд байгаа данс, гүйлгээг шалгах, түр зогсоох;

24.1.5. хуульд заасан үндэслэл, журмын дагуу хөрөнгө битүүмжлэх;

24.1.6. албан тушаалтан, иргэнээс тайлбар гаргуулах, мэдүүлэг авах, түүнийг албадан ирүүлэх;

24.1.7. албан үүргээ гүйцэтгэх явцдаа хойшлуулшгүй тохиолдолд дипломат төлөөлөгч, төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтан, үүргээ гүйцэтгэж яваа эмнэлгийн түргэн тусламж, гал унтраах алба, техникийн ослын дуудлагынхаас бусад авто тээврийн болон холбооны хэрэгслийг өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр дайчлах, ашиглах;

24.1.8. албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх;

24.1.9. албан үүргээ гүйцэтгэх явцдаа зорчигч тээврийн болон холбооны хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх;

24.1.10. Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгт хамаарах бусад бүрэн эрх.

24.2. Галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газрын дарга хамтран батална.

24.3. Энэ хуулийн 24.1.7-д заасны дагуу хувийн өмчийн тээврийн хэрэгслийг ашигласан бол холбогдох хөлс болон гарсан зардлыг нөхөн төлнө.

## **25 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

25.1. Авлигатай тэмцэх газрын албан хаагч [Төрийн албаны тухай хууль](#) болон энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хориглох үйлдлээс гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

25.1.1. нам, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага, тэдгээртэй адилтгах бусад байгууллагын гишүүнээр элсэх, удирдах албан тушаалд сонгогдох, томилогдох;

25.1.2. албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон буюу өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;

25.1.3. удирдлагын тусгайлан өгсөн зөвшөөрөлгүйгээр албан ажлын-хаа талаар нийтэд болон бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл дамжуулах;

25.1.4. Авлигатай тэмцэх газрын даргын зөвшөөрөлгүйгээр албаны болон хувийн ажлаар гадаадад зорчих;

25.1.5. дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний зардлаар аялах, жуулчлах, амрах;

25.1.6. тогтоосон журмыг зөрчиж бусдаас бэлэг дурсгалын зүйл авах.

25.2. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид нь хоорондоо нэг гэр бүлийн буюу төрөл садангийн холбоотой байхыг хориглоно.

25.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүрэг гүйцэтгэж байх үедээ өөрт нь илэрхий болсон нууцыг үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.

## **26 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд тавих хяналт**

26.1.Улсын Их Хурал авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр мэдээлнэ.

[/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

26.2.Авлигатай тэмцэх газар [гүйцэтгэх ажлын тухай хууль](#) тогтоомжийг хэрхэн биелүүлж байгааг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо хянан шалгана.

26.3.Прокурорын байгууллага нь Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд [Гүйцэтгэх ажлын тухай хууль](#), [Эрүүгийн байцаан шийтгэх хууль](#), [Прокурорын байгууллагын тухай](#)8 хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавина.

## **27 дугаар зүйл. Олон нийтийн зөвлөл**

27.1.Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилго бүхий орон тооны бус олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэх газрын дэргэд ажиллана.

27.2.Олон нийтийн зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилно.

27.3.Олон нийтийн зөвлөлийн гишүүнд төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэхгүй.

27.4.Олон нийтийн зөвлөлийн гишүүн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хамаарах нууцыг задруулахыг хориглоно.

27.5.Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны баталгаа

## **28 дугаар зүйл. Улс төрийн баталгаа**

28.1.Авлигатай тэмцэх газрын байранд улс төрийн нам, эвсэл, холбоо, хөдөлгөөний болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

28.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албандаа хүндэтгэлтэй хандана.

## **29 дүгээр зүйл. Эдийн засгийн баталгаа**

29.1.Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

29.2. Авлигатай тэмцэх газрын төсвийг улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

— 29.3. Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

29.4. Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажлын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.

29.5. Авлигатай тэмцэх газрыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, албан хаагчийг орон сууцаар хангах, авлигатай тэмцэх үйл ажиллагааны явцад туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

29.6. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

29.7. Авлигатай тэмцэх газарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчид аминдаа орон сууц барих, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө.

29.8. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нь Засгийн газрын гишүүнтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.

### **30 дугаар зүйл. Нийгмийн баталгаа**

30.1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийг хуульд зааснаас бусад тохиолдолд ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

30.2. Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг, хэрэв хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг төр хариуцна.

30.3. Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан буюу албан үүрэгтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон бол түүний ар гэрт 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

30.4. Авлигатай тэмцэх газарт 10-аас доошгүй жил ажилласан албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол түүнд албан тушаалынх нь 36 сар хүртэл цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

30.5. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг тухайн байгууллагын төсвөөс төлнө.

30.6. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ээлжийн амралтын үндсэн хугацааг [Хөдөлмөрийн тухай](#) хуулиар тогтоох бөгөөд гүйцэтгэх ажил эрхэлсэн, түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажилласан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

30.7. Авлигатай тэмцэх газрын албан хаагч [төрийн албаны тухай хууль](#) тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэмжээс гадна энэ хуульд заасан баталгаагаар хангагдана.

30.8. Энэ хуулийн 30.7-д заасан баталгааг Авлигатай тэмцэх газрын албан хаагчид эдлүүлэхдээ ижил төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдлийг давхардуулж олгохгүй бөгөөд сонголтыг Авлигатай тэмцэх газрын албан хаагч өөрөө хийнэ.

30.9. Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд тооцно.

*/Энэ хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/*

30.10.Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтан тусгай ажиллагаанд оролцохдоо байгууллагын бэлгэ тэмдэг бүхий зориулалтын хувцас хэрэглэх бөгөөд уг хувцасны загварыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.

*/Энэ хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/*

### **31 дүгээр зүйл. Хууль зүйн баталгаа**

31.1.Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр, бусад албан хаагчийг Авлигатай тэмцэх газрын даргын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

31.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын талаар Улсын Их Хуралд, бусад албан хаагчийн талаар Авлигатай тэмцэх газрын даргад 48 цагийн дотор мэдэгдэнэ.

31.3.Авлигатай тэмцэх газрын албан хаагч гэмт хэрэгт холбогдсон, түүнчлэн энэ хуулийн 31.2-т заасны дагуу баривчлагдсан бөгөөд эрх бүхий байгууллагаас түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай санал тавьсан бол түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Авлигатай тэмцэх газрын дарга шийдвэрлэнэ.

31.4.Авлигатай тэмцэх газрын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна.

### **32 дугаар зүйл. Бусад баталгаа**

32.1.Авлигатай тэмцэх газрын албан хаагч эрдэм шинжилгээнийхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглоно.

32.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагч албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

32.3.Албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан Авлигатай тэмцэх газрын албан хаагч болон гэр бүлийнх нь гишүүдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

32.4.Бүрэн эрхийнхээ хүрээнд Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн, албан тушаалтан харьяалал харгалзахгүйгээр биелүүлэх үүрэгтэй.

32.5.Авлигатай тэмцэх газрын албан хаагч эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, даалгаврыг ёсчлон биелүүлснээс үүссэн хохирол, сөрөг үр дагаврыг тушаал, даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.

32.6. Авлигатай тэмцэх газрын байр төрийн хамгаалалтад байна.

32<sup>1</sup> дүгээр зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд

32<sup>1</sup>.1.Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:

32<sup>1</sup>.1.1.Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

32<sup>1</sup>.1.2.энэ хуулийн 32<sup>1</sup>.1.1-д зааснаас бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар;

32<sup>1</sup>.1.3.Олон нийтийн зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон гүйцэтгэх ажил явуулахаас бусад үйл ажиллагаанд хяналт тавих.



/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

### **33 дугаар зүйл. Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

33.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан дараах хариуцлага хүлээлгэнэ:

33.1.1. энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

33.1.2. энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;

33.1.3. энэ хуулийн 7.1-д заасныг удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;

33.2. Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.

/Энэ зүйлийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

### **34 дүгээр зүйл. Авлигын гэмт хэргийн улмаас учирсан үр дагаврыг арилгах**

34.1. Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох, хууль бус аливаа шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг [Иргэний хууль 10](#) болон холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

### **35 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

35.1. Энэ хуулийг 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

**Монгол Улсын нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль**

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ,  
АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино.

### 2 дугаар зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж

2.1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>[1]</sup> Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хангах зорилт бүхий Төрийн албаны тухай хууль<sup>[2]</sup>, Авлигын эсрэг хууль<sup>[3]</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."нийтийн ашиг сонирхол" гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг;

3.1.2."хувийн ашиг сонирхол" гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

3.1.3."ашиг сонирхлын зөрчил" гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;

3.1.4."нийтийн албан тушаалтан" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг;

3.1.5."хамаарал бүхий этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

3.1.6."нэгдмэл сонирхолтой этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.7."ашгийн төлөө үйл ажиллагаа" гэж компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг;

3.1.8."хандив" гэж нийтийн албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг;

3.1.9."бэлэг" гэж нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг;

3.1.10."бүтээлч ажил" гэж төлбөр, орлого олж байгаа сэтгүүл зүй, утга зохиолын болон урлагийн бүтээлийг.

3.1.11."ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг.

[/Энэ заалтыг 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

#### **4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд**

4.1.Энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна..

[/Энэ зүйлийг 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

#### **5 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

5.1.Нийтийн албан тушаалтан /цаашид "албан тушаалтан" гэх/-д тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн шаардлагын үндэслэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, албан тушаалтан хувийн ашиг сонирхлын байдлаа мэдүүлэх болон түүнийг шалгах ажиллагаа, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг энэ хуулиар зохицуулна.

#### **6 дугаар зүйл.Үйл ажиллагааны зарчим**

6.1.Албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина.

6.2.Албан тушаалтан нь хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ.

6.3.Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.

6.4.Албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ.

6.5.Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.

Хоёрдугаар бүлэг

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ**

## **7 дугаар зүйл.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг**

7.1.Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

7.2.Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй:

7.2.1.ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоож, мөрдүүлэх;

7.2.2.хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах;

7.2.3.ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх;

7.2.4.ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх;

7.2.5.ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх;

7.2.6.энэ хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх.

7.3.Энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна.

## **8 дугаар зүйл.Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах**

8.1.Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

8.2.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

8.3.Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно.

8.4.Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.

8.5.Дараах тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрч болно:

8.5.1.тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;

8.5.2.тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа.

8.6.Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

8.7.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан тушаалтны гаргасан энэ хуулийн 8.6-д заасан тайлбар болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн энэ хуулийн 8.4-т заасны дагуу шийдвэр гаргах бөгөөд шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

8.8.Албан тушаалтны энэ хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна.

## **9 дүгээр зүйл.Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх**

9.1.Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

9.2.Албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд дараах арга хэмжээг авна:

9.2.1.саналаас татгалзах;

9.2.2.санал тавьсан этгээдийг тодорхойлох;

9.2.3.тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг хадгалах ба энэ тухай өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх;

9.2.4.боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх;

9.2.5.болсон нөхцөл байдлын талаарх мэдэгдлээ боломжит хугацааны дотор өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагад бичгээр хүргүүлэх;

9.2.6.хариуцлага хүлээхээр зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх.

Гуравдугаар бүлэг

АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛАЛТ

## **10 дугаар зүйл.Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт**

10.1.Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.

## **11 дүгээр зүйл.Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт**

11.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.2.Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

11.3.Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны акт гаргахыг хориглоно.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан захиргааны акт гаргах хязгаарлалт нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй.

## **12 дугаар зүйл.Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох**

12.1.Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

## **13 дугаар зүйл.Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт**

13.1.Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан хязгаарлалт нь Улсын Их Хурлын гишүүний болон Засгийн газрын гишүүний нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд оролцоход хамаарахгүй.

## **14 дүгээр зүйл.Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт**

14.1.Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно.

14.2.Албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно.

14.3.Албан тушаалтан дараах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй:

14.3.1.өөртэй нь хамаарал бүхий этгээдийн өмнө;

14.3.2.өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хүртдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө;

14.3.3.албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө.

## **15 дугаар зүйл.Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт**

15.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно.

15.2.Хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглоно.

## **16 дугаар зүйл.Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт**

16.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан хориглолтод албан тушаалтанд албан үүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан үүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй.

16.3.Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, тайлагнах, зарцуулах журмыг Засгийн газар батална.

16.4.Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

16.5.Албан тушаалтны авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд түүнийг төрийн өмчид шилжүүлнэ.

16.6.Албан тушаалтан зургаан сарын цалингийн хэмжээнээс илүү гарсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зөрүүг өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авч болно.

16.7.Албан тушаалтан бэлэг авахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.

16.8.Энэ хуулийн 16.4-т заасан этгээдээс бэлэг авсан бол албан тушаалтан тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүргийг хоёр жилийн хугацаанд гүйцэтгэхгүй.

16.9.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.

16.10.Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг Засгийн газар батална.

16.11.Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх шагналыг энэ хуулийн 16.1-16.10-т заасан журмаар зохицуулна.

## **17 дугаар зүйл.Хандив авахтай холбогдсон хязгаарлалт**

17.1.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.

17.2.Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

17.3.Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

17.4.Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

17.5.Албан тушаалтан дараах тохиолдолд биечлэн, эсхүл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно:

17.5.1.хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;

17.5.2.өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;

17.5.3.өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.

## **18 дугаар зүйл.Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт**

18.1.Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.

18.2.Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн дараах ажил, албан тушаалыг давхар эрхэлж болно:

18.2.1.хууль болон олон улсын гэрээгээр зөвшөөрсөн ажил;

18.2.2.нийтэд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил;

18.2.3.багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;

18.2.4.хуульд заасан бол өөр өөрийн чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын болон Засгийн газрын албан тушаал;

18.2.5.хууль тогтоомжоор зөвшөөрсөн олон улсын байгууллага дахь албан тушаал.

18.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно.

18.4.Зэвсэгт хүчний албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно.

18.5.Энэ хуулийн 18.2-18.4-т зааснаас бусад албан тушаалтан дараах ажлыг давхар эрхэлж болно.

18.5.1.хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;

18.5.2.багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;

18.5.3.ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.

18.6.Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно.

*[/Энэ хэсгийг 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)*

18.7.Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг, түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно.

## **19 дүгээр зүйл.Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам**



19.1. Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.

19.2. Энэ хуулийн 19.1-д заасан танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

## **20 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт**

20.1. Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.

[/Энэ хэсэгт 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.

[/Энэ хэсгийг 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

[/Энэ хэсэгт 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.3. Энэ хуулийн 20.2-т заасан албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлнэ.

20.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.

20.5. Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.

## **21 дүгээр зүйл. Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт**

21.1. Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

21.1.1. урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;

21.1.2. урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;

21.1.3. урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

21.2.Энэ хуулийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдохоос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, контрактад хамаарахгүй.

*/Энэ хэсгийг 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

21.3.Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.

21.4.Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалт зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

## **22 дугаар зүйл.Бусад орлогын хязгаарлалт**

22.1.Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно.

22.2.Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа бол Засгийн газрын гишүүний цалин авна.

22.3.Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

22.3.1.шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;

22.3.2.холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;

22.3.3.холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;

22.3.4.холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ**

### **23 дугаар зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах**

23.1.Энэ хуулийн 4.1-д заасан нийтийн алба хашиж байгаа болон тэдгээр албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/ хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.

23.2.Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй.

23.3.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

23.4.Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан бол уг мэдүүлгийг гаргаж өгөөгүйд тооцно.

23.5.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

23.6.Авлигатай тэмцэх газар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг ажлын 10 өдөрт багтаан хянан үзээд тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

23.7.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол түүнийг тухайн албанд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан томилохоос татгалзах үүрэгтэй.

23.8.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийн маягт, түүнийг бүртгэх, хянан шалгах, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.

## **24 дүгээр зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хадгалах**

24.1.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг дараах байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд бүртгэж, хадгална:

24.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, түүнчлэн Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас томилогддог албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;

24.1.2.Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

24.1.3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон бүх шатны шүүхийн шүүгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;

24.1.4.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;

24.1.5.энэ хуулийн 24.1.2-24.1.4-т зааснаас бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтан.

24.2.Энэ хуулийн 24.1.4–24.1.5-д заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

24.3.Авлигатай тэмцэх газар хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд гаргаж өгнө.

25 дугаар зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг нээлттэй байлгах

25.1.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна.

25.2.Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

25.3.Албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хэрхэн бөглөх талаар байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт, зөвлөгөө нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай хуулиар<sup>[4]</sup> зохицуулна.

## **26 дугаар зүйл.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянан шалгах**

26.1.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 24.1.2-т зааснаас бусад хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.

26.2.Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо шалгана.

26.3.Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар шалгана.

*[/Энэ хэсгийг 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)*

26.4.Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.

26.5.Улсын Их Хурлын гишүүнээс бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл бүрэн гүйцэд гаргаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг шалгана.

26.6.Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу авлигын шинжтэй зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

26.7.Энэ хуулийн 24.1.2-т заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо шалгана.

26.8.Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ**

### **27 дугаар зүйл.Нийтийн албаны ёс зүйн дүрэм**

27.1.Албан тушаалтан өөрийн мэргэжил, салбар, байгууллагад даган мөрдөж байгаа ёс зүйн дүрэмд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллана.

27.2.Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй.

### **28 дугаар зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих этгээд**

28.1.Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:

28.1.1.нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаарх Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;

28.1.2.энэ хуулийн 28.1.1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар.

## **29 дүгээр зүйл. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

29.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дараах захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

29.1.1. Энэ хуулийн 7.3, 8.3, 19.2, 25.2, 26.6-д заасан үүргээ биелүүлээгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

29.1.2. Энэ хуулийн 16 дугаар зүйл, 22.3-т заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдээр хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар орсон албан тушаалаас чөлөөлөх;

29.1.3. Энэ хуулийн 20.2, 20.3, 20.5, 21.1-д заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох;

29.1.4. Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох баримт бичгийг энэ хуулийн 24.2-т заасан хугацаанд ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

29.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий албан тушаалтан дараах сахилгын шийтгэл хүлээлгэнэ:

29.2.1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах;

29.2.2. Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг зөрчсөн, энэ хуулийн 8.1, 8.2, 8.3, 9.1, 19.1, 21.3, 21.4-т заасан үүргээ биелүүлээгүй, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

*[/Энэ заалтад 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)*

29.2.3. Энэ хуулийн 10, 14, 17, 18 дугаар зүйл, 20.1, 20.4-т заасныг зөрчсөн, энэ хуулийн 9.2-т заасан арга хэмжээг аваагүй, энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй гэрээ, контракт байгуулсан, зөвшөөрөл олгосон, энэ хуулийн 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, энэ хуулийн 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаалыг нь бууруулах;

29.2.4. Энэ хуулийн 11, 12, 15, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, энэ хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах.

29.3. Шүүгчээс захиргааны хариуцлага хүлээлгэсэн нь тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

29.4. Энэ хуулийн 29.2-т заасан сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэнэ.

29.5. Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журмыг Авлигатай тэмцэх газар батална.

### **30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

30.1.Энэ хуулийг 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*/Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2012 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хориг тавьсан/*

*/Энэ хэсэгт 2012 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

Эрүүгийн хэргийн талаарх статистик мэдээ

Эрүүгийн хуулийн дагуу авлига, албан тушаалын гэмт хэрэгт шийтгэгдсэн төрийн албан хаагчид

№	Ял шийтгэл	ЭХ 263			ЭХ 264			ЭХ 265			ЭХ 266			ЭХ 268			ЭХ 269			ЭХ 270			ЭХ 273			ЭХ 270 <sup>1</sup>			Бусад		
		2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
1	Торгох	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
2	Албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах	2	0	0	1	0	0	1	0	0	0	0	0	2	5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
3	Эд хөрөнгө хураах	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4	Албадан ажил хийлгэх	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
5	Баривчлах	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
6	Хорих	2	0	0	1	0	0	1	0	0	0	0	0	5	9	6	7	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0
7	Түдгэлзүүлсэн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	4	3	2	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0
8	Гэм буруугүйд тооцогдсон ба хэрэгсэхгүй болсон	1	0	0	1	3	0	1	0	0	0	0	0	4	1	3	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
9	Өршөөлийн хуулиар өршөөл үзүүлсэн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Торгуулийн дундаж хэмжээ 2012 онд мэдээлэл байхгүй, 2013 онд 12.960.0 ₮, 2014 онд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-52 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байсан.

Хорих ялын дундаж хугацаа 2012 онд мэдээлэл байхгүй, 2013 онд 3,5 жил, 2014 онд 3 жил байв.

Авлигатай тэмцэх газрын бүтэц, зохион байгуулалт

